

НИЙТИЙН НОМЫН САНГУУДЫН ТАЙЛАН 2024(4)

УЛААНБААТАР ХОТ
2025 он



НИЙТИЙН НОМЫН САНГУУДЫН ТАЙЛАН 2024(4)

(Тайлангийн эмхэтгэл)

УЛААНБААТАР ХОТ

2025 он

ННА 78

DDC 020

Н 615

Нийтийн номын сангуудын тайлан 2024(4)

Эмхэтгэсэн: Б.Сарандэлгэр /Арга зүйч/

Хянасан: Т.Хайдав /МАЗЭШХ-ийн дарга/

ISBN 978-9919-9114-7-8

ГАРЧИГ

ГАРЧИГ.....	04
ӨМНӨХ ҮГ	05
ОРХОН АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН.....	06
ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН.....	14
ӨМНӨГОВЬ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН.....	33
СҮХБААТАР АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН.....	84
СЭЛЭНГЭ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН.....	127
СЭЛЭНГЭ АЙМГИЙН МАНДАЛ СУМЫН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН.....	170
ХАВСРАЛТ.....	211
ДҮГНЭЛТ.....	226

ӨМНӨХ ҮГ

Технологийн хөгжилт, мэдээллийн хязгааргүй өсөлтийн энэ үед ард иргэдийг соён гэгээрүүлэгч, номын сан, мэдээллийн байгууллагын хэрэгцээ шаардлага улам ихээр бий болж байна. Дээрх өсөлтүүд нь номын сангуудыг соёл, боловсролын шинэлэг хэлбэрээр үйлчилгээ үзүүлэхийг зүй ёсоор шаардаж байна. Энэ шаардлагад нийцэх, хүрч ажиллахын тулд аймаг, нийслэлийн номын сангууд бүхий л талаараа хичээнгүйлэн ажиллаж ирсний илрэл, ул мөрийг энэхүү тайлангаас үзэх болно. Өмнөх жилүүдэд тус тайлан 300-600 хуудас болдог байсан бол энэ жил 800 гаруй хуудастай болж байгаа нь үүнийг илтгэх нэгэн сэжиг болно. Өдий хэмжээний хуудастай номыг цахим файлд хөрвүүлэн уншихад ачаалал өгөх тул 200 хуудсаар нь салган 5 боть болгон нийтлүүлээ.

Өнгөрөгч 2024 он Монголын номын сангийн салбарт олон чухал, түүхэн үйл явдал болж өнгөрсний нэг нь Монгол Улсын Үндэсний номын сангийн салбар шинэ салбар ашиглалтад орж, номын санч- мэдээллийн ажилтнуудын сүүлийн 30 гаруй жилийн мөрөөдөл биелж, Монгол Улсын Соёлын яам, Монгол Улсын Үндэсний номын сан хамтран номын сангийн нэгдсэн системийг хөгжүүлэн, ашиглалтад хүлээн авснаар, аймаг орон нутгийн номын сангуудыг нэгдсэн системд холбон, албан хаагчдыг чадавхжуулах сургалтыг 21 аймгийн 216 номын санч мэдээллийн ажилтнуудад зохион байгууллаа. Энэ нь ном зүйн мэдээллийг автоматжуулж, үйл ажиллагаандаа орчин үеийн техник, технологийг нэвтрүүлж, электрон мэдээллийн нэгдсэн санг бий болгох, хүртээмж нэмэгдүүлэхэд бодит хувь нэмрийг оруулсан явдал мөн.

Эмхэтгэлийн төгсгөлд уламжлал ёсоор аймаг, нийслэлийн нийтийн номын сангуудын үйл ажиллагааны статистикийн зарим үзүүлэлтүүдийг хүснэгтээр хавсаргалаа.

Эдгээр мэдээллүүд номын сангуудыг үйл ажиллагааг эрчимжүүлэх, сайжруулахад нэмэр болно гэдэгт итгэлтэй байна. Тайлантай холбоотой санал, хүсэлтээ манай номын сангийн lavlagaanomzui@gmail.com хаягаар болон 70188882 утсаар ирүүлнэ үү.

МЭДЭЭЛЭЛ, АРГА ЗҮЙ, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

ОРХОН АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2024 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

НЭГ: НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Эрхэм зорилго. Илүү нээлттэй, чөлөөтэй, орчин үеийн үйлчилгээг ашиглан хүн бүрт мэдээлэл хүргэх замаар нийгэмд идэвхитэй, мэдлэгтэй ирэнийг төлөвшүүлэхэд оршино.

Зорилт 1: Төрийн үйлчилгээг ил тод, хурдан шуурхай, чанартай хүртээмжтэй болгох

/"Алсын хараа 2050" 5.3, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.2.1 /

Зорилт 2: Бүх нийтийн соёлын боловсрол, нийгмийн харилцааны соёлыг дээшлүүлэх олон талт арга хэмжээ, нөлөөллийн аяныг зохион байгуулж, тухайн орон нутгийн бүх шатны байгууллага, хувийн хэвшил, ТББ, иргэдийг уриалах" /Соёлын тухай хуулийн 23 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.2.2/

Зорилт 3: Номын сангийн орчин үеийн шийдэл бүхий тав тухтай тохилог орчин бий болгох

. ХОЁР. НОМЫН САНГИЙН САН ХӨМРӨГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТ:

2024 оны байдлаар номын сангийн сан хөмрөгийн ном бүрдүүлэлтээр нийт 285 нэр төрлийн, 374 ширхэг 8187220 төгрөгийн ном, 10 нэрийн сонин, 4 нэрийн сэтгүүлийг 1086200 төгрөгөөр авч баяжуулалт хийлээ. Үүнээс: улсын төсвөөр 129 нэр төрлийн 177 ширхэг 4141900 төгрөг, хандив тусламжаар 152 нэр төрлийн 197 ширхэг 4045320 мянган төгрөгийн ном шинээр авч номын техник ажлыг хийж танхимуудад хуваарилан олгосон байна. Нийт ном сонин сэтгүүлийг 9273420 төгрөгийн ном сонин сэтгүүл авсан байна

Танхимуудын хагас, болон ээлжит бус тооллогыг 4 удаа 1 хүн шинээр ажилд авсан болон сэлгэн ажилласан номын санчийн ном хүлээлцэх тооллого 5 удаа хийж 7 удаагийн тооллого хийгдэж тооллогын актыг үйлдэж алдагдсан 63 номыг нөхөн төлүүлсэн байна. Энэ онд номын сангийн уншлагын танхимын номын санчид нийт 701 ном сонин сэлбэн засаж цэгцэлсэн байна. Үүнээс 404 ном, "Зууны мэдээ", "Өдрийн сонин"-ы 297 багц сонин сэлбэн засаж, үдэж нааж багц болгон тавьсан байна. Мөн шинэ номын санд цахим хаалга тавигдсантай холбогдуулсан 2000 номонд шинээр ялтас байрлуулан хүүхдийн уншлагын танхим 50 номын ариутгал хийгдсэн байна.

ГУРАВ. НОМЫН САНГИЙН УНШЛАГА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:

Номын сангийн үйлчилгээ

2024 онд 7470 хүнд шинээр карт нээж 52158 байнгын ирэгсдэд 108778 ном олгож үйлчилсэн. Гэрээр ном олгох танхимаас 1683 иргэнд 19771 ном олгож 1138600 мянган төгрөгийн өөрийн орлого оруулсан байна. 2024 оны 5 сараас бид шинэ номын сан руу нүүлгэлтийн ажлыг зохион байгуулж өдөр тутмын уншлага үйлчилгээгээ хуучин байрандаа гадаад хэлний уншлагын танхимыг ажиллуулсанаар уншлага үйлчилгээний тоон мэдээ тасраагүй амжилттай хэрэгжиж ирсэн байна.

Уншигч, хэрэглэгчдийн судалж буй судалгааны ажилтай холбоотой ном, эх сурвалжуудыг санал болгон ажилласан. Нийт 171 уншигч, хэрэглэгчдэд 285

лавлагаа номзүйн үйлчилгээг тухай бүрд тогтмол үзүүлсэн ба үүнээс Амаар – 141, Цахим – 144, Сэдэвчилсэн – 93, Номзүйн – 192 лавлагаа өгч ажилласан.

Номын сангийн уншлагын танхимаар шинээр карт нээлгэсэн 7470 уншигчийн картыг нээж, номын сангийн программд шивж 52158 байнгын уншигч 108778 олгосон номыг программаар уншуулан бүртгэж, цаасаар уншигч, ирэгсэд ном олголтын өдөр тутмын бүртгэлийг тогтмол хөтөлж, сан хөмрөгт шинээр авсан 253 ширхэг номонд техник ажиллагаа хийж нэгбүрчилсэн бүртгэлд бичиж нэгдсэн бүртгэлээр тоо судалгааг гарган 18 нэрийн сонин 8 нэрийн сэтгүүлд сонин сэтгүүлийн карт хөтөлсөн байна.

Соёл олон нийтийн ажил

Энэ онд номын сангаас эсээ зохион бичлэгийн уралдаан, уулзалт ярилцлага, уншигчийн бага хурал, илтгэл, асуулт хариултын тэмцээн, яруу найраг, гар зургийн уралдаан зэрэг олон төрлөөр 68 удаагийн соёл танин мэдэхүйн ажил зохион байгуулагдаж 1561 хүүхэд хамрагдаж улсын төсвөөс 7.500 сая төгрөг зарцуулсан байна.

Орхон аймгийн хэмжээнд “Үндэсний номын баяр-2024” хавар номын баярыг “Илүү их уншъя”, намрын номын баярыг “Үндэсний бичиг соёлоо эрхэмлэн дээдэлъе” уриатайгаар 2024 оны 05,09 дугаар сард зохион байгууллаа

Хавар намрын номын баяраар тэргүүний уншигч анги хамт олноор 10 анги, тэргүүний уншигч Д.Нацагдорж тэмдэгтэн 10 хүүхдийг шалгаруулан 2 удаагийн номын баяраар нийтийн номын сан, соёлын төвийн номын санч нар талбай дээр 20 гаруй нэр төрлийн “Алтан хонх” танин мэдэхүйн АХА асуулт хариултын тэмцээн хийгдэж 2500 гаруй хүүхэд хамрагдсан байна. Намрын номын баярын нээлтээр аймгийн Боловсролын газартай хамтран Ерөнхий боловсролын 1,4,5,8,14 дугаар сургуулийн 1000 хүүхэд Их зохиолч Д.Нацагдоржийн “Миний нутаг” шүлэг нийтээр уншлаа. Мөн Улаанбаатар хотоос 13 зохиолч, 6 хэвлэлийн газар 3 өдөр дараалан зохиолчийн гарын үсэгтэй номын үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, нийтийн номын сангийн 4 танхимаас 12 нэр төрлийн соёл олон нийтийн ажлыг анги, насны ангиллаар 2 номын сангийн байр болон Амарын талбайд зохион байгууллаа. Уралдаан тэмцээн, тайз майхны зардалд 10,0 сая төгрөгийг аймгийн ЗДТГ-аас гаргасан байна

Үндэсний бичиг үсгийн баярыг 2024 оны 5 дугаар сарын эхний долоо хоногт зохион байгуулж аймгийн ЗДТГ, Боловсрол шинжлэх ухааны газрын дэргэдэх Хэлний бодлогын зөвлөлтэй хамтран зохион байгуулж монгол бичгээр хурдан зөв унших уралдаан 3 насны ангиллаар, хичээнгүй цэвэр бичих уралдаан 3 насны ангиллаар кириллээс үндэсний бичигт хөрвүүлэх уралдаан 2 насны ангиллаар, бүтээлийн уралдаан 2 насны ангиллаар тус тус зохион байгуулагдаж 370 хүүхэд 30 гаруй насанд хүрэгчид хамрагдсан байна. Мөн төрийн байгууллагын ажилтан албан хаагчдын дунд “Алтан хонх” тэмцээн зохион байгуулж энэхүү тэмцээнд нийт 35 хүн хамрагдсан байна.

Ном уншилтыг сайжруулах чиглэлээр:

Ном сурталчлах хамгийн өргөн хэрэглэгддэг тохиромжтой арга нь үзүүлэн таниулах арга юм. Номыг үзүүлэн таниулах аргаар сурталчлах ажлын хэлбэрүүд нь номын үзэсгэлэн, зурагт хуудас, ханын сонин, санамж өгөх номзүйн жагсаалт гэсэн төрлүүдээр гаргадаг. Энэ онд номын сангийн уншлагын танхимууд байгууллагаас гаргасан графикт заагдсан Үндсэн хуулийн өдөр, Март, Цэргийн баяр, Хүүхдийн номын өдөр, үндэсний бичиг үсэг, номын өдрүүдээс гадна төлөвлөгөөт бус цаг үеийн асуудал тэмдэглэлт өдрүүдээр 43 удаа 1702 номоор, монгол бичгийн бүтээл хүүхдийн гар зургийн бүтээл, тэргүүний уншигч анги хамт олны хийсэн бүтээлч ажлын 53 бүтээлээр сэдэвчилсэн 29 удаа шинэ номын 79 удаагийн үзэсгэлэн гаргасан байна.

Алслагдсан хэрэглэгчдийн үйлчилгээг зохицуулсан байдал:

Мааньтын хорих ангийн ажилчид, хүмүүжигч нарт зөөврийн номоор үйлчлэн, тэдний дунд “Алтан хонх”, АХА танин мэдэхүйн тэмцээн уралдаан хийж нийт хүн хамрагдсан байна., Мөн аймгийн цагдаа, дотоодын цэргийн ангиудын “Номтой нөхөрлөө аяны хүрээнд Цагдаагийн газар, Дотоодын 816,821 дүгээр царгийн анги, Онцгой байдлын газарт 5 удаагийн зөөврийн номын сан, Алтан хонх АХА тэмцээн, “Хүүхдийн номонд хөтлөхүй”, “Соёл гэж юу бэ” сургалтыг зохион байгуулж нийт 320 гаруй хүн хамрагдсан байна.

Зөөврийн үйлчилгээ зохион байгуулсан эсэх:

Зөөврийн номын сангийн үйлчилгээг аймгийн бүх багийн нутаг дэвсгэр дээр орших байгууллага, сургууль, цэцэрлэгийн хүсэлтээр нас насны ангилалд зориулагдсан номоор үйлчилдэг. Энэ онд төрийн болон бусад 27 байгууллагад 48 удаа 1286 номоор 1591 хүнд зөөврийн номын сангийн үйлчилгээг хүргэсэн.

Хүүхдэд номын сангийн үйлчилгээ үзүүлсэн байдал:

Номын чанга уншлага, үлгэрийн цаг, номын тойм зэрэг аман ярианы аргууд номын болон зохиогч, хэвлэн нийтлэгчдийн мэдээг дамжуулах уншигчдын уншлагыг удирдан бие дааж болосвроход нь ихээхэн үүрэгтэй бөгөөд амьд үг ашиглан явуулдаг сурталчилгаа юм. Энэ онд номын сангийн уншлагын танхимуудаас сургуулийн өмнөх боловсролын болон бага ангийн сурагчдад жилийн байдлаар 77 удаа чанга уншлага, 2 удаагийн номын тойм, 19 удаа үлгэрийн цаг хийгдэж 2424 хүүхэд хамрагдсан байна. Дэлхийн номын өдөр нь жил бүрийн 04 сарын 02 / Дэлхийн хүүхдийн номын өдөр/ 04 сарын 23 / Дэлхийн номын өдөр/ болгон тэмдэглэдэг. Энэхүү өдрөөр аймгийн номын сангийн нийтийн уншлагын танхимаас Эрдэнэт цогцолбор сургуулийн 1 курсын оюутнуудын дунд зохиолч уншигчдын уулзалт, аймгийн Шүүхийн тамгын газрын номын санд аргазүйн зөвлөгөө өгч тэдний дунд “АХА” тэмцээн зохион байгуулсан байна. Мөн Хүүхдийн уншлагын танхимаас бүтэн өдрийн турш өдөрлөг зохион байгуулж хүүхдийн зохиолч Ханс Андерсаны “Нугасны муухай дэгдээхэй” зохиолоор номын хэлэлцүүлэг зохион байгууллаа

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд номын сангийн үйлчилгээ:

Мөн зорилтот бүлгийн иргэдэд номыг гэрт нь хүргэж өгч зөөврөөр уншуулах ажлыг хийдэг бөгөөд давхардсан тоогоор 38 удаа 16 хүнд 152 ном зөөврөөр олгож үйлчилсэн байна.

Номын сан болон номын сангийн үйлчилгээнд дүн шинжилгээ хийсэн:

2024 онд аймгийн Нийтийн номын сан нь шинэ номын сан ашиглалтад орж 9 сараас номын сангийн уншлага үйлчилгээг 2 газар зохион байгуулсан байна. Хуучин буюу урт цагааны номын сангийн байранд хүүхдийн уншлагын танхимыг ажиллуулахын зэрэгцээ гадаад хэлний танхимыг нийтийн зориулалтаар үйлчилгээг хийж гэрээр ном олголтыг давхар хариуцан ажилласан байна. Шинэ номын сангийн байранд нийтийн уншлагын танхим, гэр бүлийн уншлагын танхим гэрээр ном олгох танхим ажиллаж шинээр үйлчилгээний хүртээм нэмэгээгүй байна.

ДӨРӨВ. ЛАВЛАГАА, НОМЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Уншигч, хэрэглэгчдээс ирсэн лавлагааны хүрээнд төрөл бүрийн номзүйг цаасаар болон цахимаар бэлдэж, зарим уншигч, хэрэглэгчдэд тухайн мэдээллийг хэвлэн гаргаж үйлчилсэн. Мөн цаг үе, тэмдэглэлт үйл явдалтай уялдуулан номзүйн бүтээгдэхүүн боловсруулж мэдээлэл номзүйн үйлчилгээг цаасаар болон цахим хаягаар дамжуулан хүргэсэн. Уншигч, хэрэглэгчдийн судалж буй судалгааны ажилтай холбоотой ном, эх сурвалжуудыг санал болгон ажилласан. Нийт 171 уншигч, хэрэглэгчдэд 285 лавлагаа номзүйн үйлчилгээг тухай бүрд тогтмол үзүүлсэн ба үүнээс Амаар – 141, Цахим – 144, Сэдэвчилсэн – 93, Номзүйн – 192 лавлагаа өгч ажилласан..

Номын сангийн цахим хуудсаар “Номын цахим хэлэлцүүлэг” – г 5 удаа хийж, QRcode ашиглан номын танилцуулга болон шинэ номын мэдээг бэлтгэсэн ба нийт 36 удаа 144 номын танилцуулга бэлтгэсэн байна. Мөн тэмдэглэлт өдрүүдийг тохиолдуулан номын танилцуулгыг QRcode ашиглан 10 удаа 40 номын мэдээллийг хүргэсэн. “Эрдэнэт” сонины 1976, 1977, 1980, 1981, 198 оны дугааруудыг сар сараар нь www.Pubhtml.com ашиглан цахимаар унших боломжтойгоор хөрвүүлэн цахим хаяг дээр байршуулсан 15,000 гаруй хүнд уншигдсан байна

2024 онд ирсэн шинэ номын мэдээг цаас болон цахим хэлбэрээр бэлтгэн гаргасан. Номын сангийн Lib4U программаас шинээр ирсэн 253 ширхэг номын картыг хэвлэн гаргаж каталогийн шүүгээнд төрөл анги, үсэг дарааллын дагуу байршуулсан. Хуучин каталот редакц хийсэн. Орхон аймагт хэвлэгдсэн 285 ширхэг ном хэвлэлээр картын сан зохион байгуулж каталогийн шүүгээнд төрөл анги болон үсэг дарааллын дагуу байршуулсан.

ТАВ. НОМЫН САНГУУДЫН ОРОН НУТАГ СУДЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Үндэсний тогтмол хэвлэлийн нэгдсэн санд “Өнөөгийн Эрдэнэт”, “Шинэ мэдээ” сонины 2024 оны 1 – 11 сарын дугаарыг ZOTERO программд шивж оруулсан ба нийт 316 мэдээ оруулсан байна. Уг мэдээг хөрвүүлэн МҮНС – д хагас жил болон жилийн эцсийн мэдээг нийт 2 удаа өгсөн ба үндэсний орон нутгийн тогтмол хэвлэлийн өгүүллийн санд нэмэгдсэн болно. Тэгш ой тохиож буй зохиолч болон монголын түүхэн хүмүүс цувралыг бэлтгэн нийт 11 хүний намтар номзүйг бэлтгэн цахим мэдээллийн бааз бий болгон, цахим хаягаар хүргэсэн.

ЗУРГАА. НОМЫН САНГИЙН МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Шинэ ашиглалтанд барилга байгууламжинд орон нутгийн төсвөөс 250,0 сая төгрөг, улсын төсвөөс 292,0 сая төгрөгийн тавилга, техник тоног төхөөмжийн тендер зарлагдаж худалдан авах шатандаа явагдаж байна. жилийн байдлаар аймгийн Баян-Өндөр сумын хөрөнгө оруулалтаар 17,0 сая төгрөгийн дотор гадна хаягжилт, угтах үйлчилгээний хэсгийн текийг хийгдсэн байна.

ДОЛОО. АРГАЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Жаргалант соёл мэдээлийн төвийн номын сан, аймгийн шүүхийн Тамгын газрын номын сан, ЕБС-ийн 4, 20 дугаар сургуулийн номын санч нарт арга зүйн зөвлөгөө өгч хийж гүйцэтгэх ажлыг чиглэлийг албан тоотоор хүргүүлэн ажилласан байна. Арга зүйн зөвлөгөөгөөр гарсан зөрчлийн дагуу Жаргалант сумын номын санч үндсэн дансанд байгаа номоо санхүүтэй тулгах, номын сангийн өдөр тутмын болон

нэгбүрчилсэн бүртгэлийг 45000 төгрөгөөр номын сангийн ангиллын номыг 100,0 төгрөгөөр худалдан авч ажилдаа хэрэгжүүлэн ажилласан байна.

НАЙМ. ХҮНИЙ НӨӨЦИЙН АСУУДАЛ:

Нийт 27 ажилтан албан хаагчийн хувийн хэрэг хөтлөгдөж байгаа бөгөөд шинээр орсон 5 хүний хувиын хэргийн бүрдлийг хийж СУГ-аас ирсэн шалгалтын мөрөөр ажилчдын албан тушаалын картыг шинэчлэн хөтөлж хүний нөөцийн программд дутуу оруулсан албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээ зэргийг гүйцээн оруулан хавтас хэрэгт дутуу материалыг гүйцээх зэрэг ажлыг хийж гүйцэтгэлээ.

Их эмч Э.Түвшинжаргалын эрүүл мэндийн сургалт, Баясгаланбаатар бясалгал хийхийн ач холбогдол, Аймгийн хэмжээний ХАБЭА-н сургалтанд ажилтан Д.Отгонцэцэг, Шүдний эрүүл ахуй, МҮНС-ийн нээлтэнд оролцож, мэдээллийн нэгдсэн сангийн сургалтанд 5 хүн,

Коха номын сангийн программын сургалтанд 12 хүн Морин хуур худалдаж авч зуны амралтаар морин хуурын сургалт 6 хүн, ОБГ-ын сургалтын мэргэжилтэн Болорцэцэг галын аюулын сургалт 20 хүн, ХГБХТ-ийн мэргэжилтэн Уянга Жендерийн сургалтанд 20 хүн Дархан хотод болсон хойд бүсийн зөвлөгөөнд 8 хүн Улаанбаатар хотын номын сангийн зөвлөгөөнд 1 хүн, нийт 12 сургалтанд давхардсан тоогоор 101 хүн хамрагдсан байна.

СУАЖЗГ-ын дотоод хяналтын газраас ирсэн шалгалтаар гарсан зөрчлийн дагуу дутуу байсан материалыг нэмж бүрдүүлэх, албан тушаалын картын зөв бүрдүүлэх ажилласан жилийн нэмэгдлийг тооцох зэргийг нэмж бүрдүүлсэн байна. Нийт 27 хүний хавтас хэрэг хадгалагдаж байна.

Номын санд ажиллагсдад тулгарч буй бэрхшээл, цаашид авах арга хэмжээний талаар:

Номын сангийн үйл ажиллагааны чиглэлийг сайн тодорхойлж өгөх Нийтийн номын сангийн үйлчилгээ, үйл ажиллагааны үлгэрчилсэн загварыг гарган мөрдүүлэх. Уламжлал болгон зохион байгуулдаг Д.Нацагдорж тэмдэгтний журам Занданшатар сайдын гаргасан уншлагын тухай журмыг тодорхой болгож чиглэл өгөх

- Электрон хэлбэрээр гарах номын тоо өсөхийн хэрээр тэдгээрийг унших, ашиглах, хадгалах хэрэгслүүд шинэчлэгдэн улам боловсронгуй болж уншигчдад олон сонголтууд бий болгох.
- Номын сан хөмрөгт байгаа ганц хувьтай номын жагсаалт, сан хөмрөгт буй цахимжуулах шаардлагатай номын тоо, цахим сан хөмрөгийг нэмэгдүүлэх.
- Цахим мэдээллийн сан үүсгэх техник тоног төхөөрөмжийн судалгаа хийж, техникийн тодорхойлолтын гаргаж нэвтрүүлэх.
- Ном хэвлэлийг цахим хэлбэрт оруулах аргачлалыг нэвтрүүлэх.
- “Цахим ном бэлтгэхэд хэрэглэгддэг программ
 - Дэвтэрчлэн харуулах програмын лиценз
 - Оффис програмын лиценз
 - Зурган файлыг текст хэлбэрт шилжүүлэх програмын лиценз гэх мэт лицензтэй программ ашиглах.

9. ТӨСӨВ, САНХҮҮГИЙН АСУУДАЛ:

2024 онд 452350,3 мянган төгрөгийн төсвийн санхүүжилт авсанаас өөрийн орлогын биелэлт 6046,0 мянган төгрөг болж Сангийн сайдын 74 дүгээр тушаалыг үндэслэн 3714,0 мянган төгрөгийн давсан орлогыг Номын баярын соёл танин

мэдэхүйн ажлын шагнал Нэг удаагийн тэтгэмж 6000,0 мянган төгрөг, Урсгал засвар зардал 1800,0 сая гаруй мянган төгрөгийг зарцуулан ажилласан байна. Нийт ажиллагсдын цалингийн сан 469577,8 төгрөгөөр батлагдсанаас үндсэн цалинд 450825,2 төгрөг зарцуулж ур чадвар үр дүн 21827,7 төгрөг, унаа хоолны зардалд 23257,0 төгрөг, илүү цаг, шөнийн нэмэгдэл 2829,4 Засгийн газрын 382 дугаар тогтоолын 4 хавсралтаар орон нутгийн нэмэгдэл 31233,9төгрөгийг тус тус олгосон.

- Дэлхийн гэр бүлийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх, ажилтан албан хаагчид гэр бүлийг хооронд нь танилцуулах, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, бие бялдрыг чийрэгжүүлэх зорилгоор гэрээр ном олголт, тогтмол хэвлэлийн танхимтай хамтран нийт ажилчид гэр бүлийн хамт нөхөрсөг волейболын тэмцээнийг 15 гэр бүл буюу 30 гаруй хүн оролцож байгууллагаас нийт 690,0 мянган төгрөг гаргасан байна.

10. БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА:

- 2023 оны үр дүнд суурилсан санхүүжилтээр нийт 2143,5 мянган төгрөгийн витаминжуулалт хийгдэж үүнд 20 хүн хамрагдан 107175 төгрөг ноогдсон байна
- Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан байгууллагын ажилчдын хүүхдүүдийг хооронд нь танилцуулж, СӨБ болон ЕБС-ийн 1-3 ангийн сурагчдын дунд “Миний ээж номын санч” гар зургийн уралдаан, 4-12 ангийн сурагчдын дунд “Funny day” хөгжөөнт тэмцээнийг зохион байгууллаа.
- Байгууллагын жилийн эцсийн тооллогыг 2024 оны 11 дүгээр сарын 1-5 хооронд эд хөрөнгийн тооллогын комиссын гишүүдтэй хамтран хийж гүйцэтгэлээ. Байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн хурлаар гаргасан актлах хөрөнгийн жагсаалтыг аймгийн өмчийн албанд нэг дүгээр улиралд гаргаж өгсөн боловч аймгийн өмчийн албанаас хариу ирээгүй тул дахин жилийн эцсийн тооллогын дүнг дахин хянаж 2025 оны нэгдүгээр улиралд багтаан гаргаж өгөх ажлыг хийж гүйцэтгэлээ.

11.ХАВСРАЛТ

НОМЫН БАЯРЫН НЭЭЛИЙН АЖИЛЛАГАА БОЛОН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ НОМЫН БАЯРЫН ӨДРҮҮДЭЭР ХИЙСЭН СОНА



Шилдэг АНИМЕ,





ОРХОН АЙМАГ ДАХЬ СОЁЛЫН БИЕТ БОЛОН БИЕТ БУС ӨВИЙН ӨНӨӨ БА ИРЭЭДҮЙ ИЛТГЭЛИЙН УРАЛДААН



ТЭРГҮҮНИЙ УНШИГЧ ШАЛГАРУУЛАЛТ



АРДЫН УРАН ЗОХИОЛЧ Д.ПҮРЭВДОРЖИЙН НЭРЭМЖИТ ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ТӨВ САНГИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

НЭГ. НОМЫН САНГИЙН АЛСЫН ХАРАА ЗОРИЛГО ЗОРИЛТ, ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Алсын хараа:

Номын сангийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, уншигчдад бие даан суралцах, хөгжих нээлттэй мэдээллийн төв болгон хөгжүүлнэ.

Зорилго:

Уншигч, иргэдэд мэдээлэл, мэдлэг олж авах орон нутгийн оюуны хөгжлийн нээлттэй мэдээллийн төв болох, цахим номын сангаар үйлчлэх

Зорилт: Техник технологийн шинэчлэл хийж, нэгдсэн сүлжээнд холбогдон цахим номоор иргэдэд үйлчилнэ.

ХОЁР. САН ХӨМРӨГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТ

Сан хөмрөгт 22902 нэр төрлийн 49152 номтой. 4 нэр төрлийн 47 нэгж сонин сэтгүүлтэй. Төрөл анги үсэг дарааллаар байрлагдсан. Номын сангийн стандартын дагуу байрлуулан танхимуудын захиалгын дагуу үйлчилж байна.



Фондын сан хөмрөгийг шинээр хэвлэгдэн гарсан шилдэг ном зохиолууд болон иргэд уншигчдын эрэлт хэрэгцээ, татгалзлын дагуу бүрдүүлж, “Соёл” “Оюу тайж” “Шуудан холбооны газар” “Интер” “Аз хур” хувь хүнээс номыг номын татгалзлын дагуу 10.651.0 сая төгрөгийн худалдан авалт хийгдлээ. Бэлэг хандивын журмаар 89 нэр төрлийн 141 ширхэг ном, худалдан авалтаар 204 нэр төрлийн 413 ширхэг номоор баяжилт хийн, уншигчдын захиалгаар буюу сүүлийн үед гарч байгаа шинэ салбарын шинжлэх ухааны болон шинэ 554 номоор сан хөмрөгийг нэмэгдүүлэн үндсэн дансанд бүртгэн, электрон каталогит оруулан танхимуудад хувиарлан олгосон.


Танхим хоорондын шилжүүлгээр

№	Шилжүүлсэн танхим	Хүлээн авсан танхим	Номын тоо	
1	Сан хөмрөг	Өргөө2	47	263
		Хүүхдийн уншлагын танхим	44	
		Боловсрол танхим	42	
		Гэрээр ном олгох	118	
		Лавлагаа	8	

		Өргөө-1	4	
2	Хүүхдийн уншлагын танхим	Гэрээр ном олгох	245	245
		Боловсрол танхим	34	
		Лавлагаа	10	
3	Гэрээр ном олгох	Хүүхдийн уншлагын танхим	25	52
		Боловсрол танхим	31	
		Өргөө 2	16	
Ном солилцоо,шилжүүлгээр				422

Урагдаж элэгдсэн уншигчийн шаардлага хангахгүй болсон нийт 526 номыг сэлбэн засаж үйлчилгээнд гаргасан.

Байгууллагын захирлын 2024 оны А/15 тоот тушаалаар ажлын хэсэг томилогдон сан хөмрөг болон танхимын тооллогыг нэг бүрчилсэн бүртгэлээр болон



программаар тоолон, дутагдсан болон уншигчийн гар дээр удсан номын судалгааг гаргаж 258 ширхэг номыг уншигчаас авах, номын санчдад үүрэг даалгавар өгч дотоод хяналт тавьж ажилласан.

Номын сангийн ариутгал халдваргүйжүүлэлтийг, мэргэжлийн байгууллагаар 6- 8 сард 2 удаа хийлгэн 350000 мянган төгрөгийг зарцуулсан байна.



Сан хөмрөгийн номонд судалгаа хийж, салбар шинжлэх ухааны хэрэгцээтэй номуудыг нөхөн бүрдүүлэлтээр авч фондын эргэлтийг сайжруулах ажлыг хийж байна.



ГУРАВ. НОМЫН САНГИЙН УНШЛАГА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- Хүүхдийн номын өргөө /салбар номын сан/
- Хүүхдийн уншлагын Ирээдүй танхим /1-5 дугаар анги/
- Боловсрол танхим /6-8 дугаар анги/
- Гэрээр ном олгох танхим - / насан хүрэгчид/
- Лавлагаа номзүйн танхим
- Интернет танхимаар уншигчдад номын сангийн үйлчилгээг танхимаар, гэрээр, цахимаар, зөөврийн үйлчилгээгээр нийт 2099 уншигч, 19897 ирэгсдэд 30847 ном олгож уншигчдын соёлын боловсролыг дээшлүүлэн ажиллалаа.

Зөөврийн номын сангийн үйлчилгээг 11 байгууллагад үзэсгэлэн гаргаж, 202 төрийн албан хаагчдыг хамруулж номын сангаа танилцуулан номыг олгосон байна.

Үүнд:

- Аймгийн нийгмийн даатгалын газар
- Улсын бүртгэлийн газар
- Халамж үйлчилгээний газар
- Байгаль орчны газар
- Татварын алба
- ЕБ-ын 1.4.5 дугаар сургууль
- Тэмүүлэл эрдэм сургууль
- Мэргэд цогцолбор сургууль
- Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар зэрэг байгууллагуудад очин төрийн албан хаагчдыг ном уншуулах зорилго тавин ажилласан.




Нийтээр тэмдэглэх баяр болон тэмдэглэлт өдрүүдээр сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 15 удаа гаргаж, агуулгын тайлбартайгаар цахимд сурталчлан нийт 1416 иргэн хүүхэд үзэсгэлэн үзэж 924 номыг дэлгэн харуулсан. Тэмдэглэлт өдрүүдийг дурьдвал:

- Үндсэн хуулийн өдөр-27
- Цагаан сар-өв соёл-18
- Түүхэн хүн -25
- Хавар-яруу найраг-36
- Эрхэмсэг ганган бүсгүйчүүд -32
- Монгол цэргийн өдөр-19
- Дэлхийн номын өдөр-50
- Үндэсний бичиг үсгийн баяр -148
- Бүх нийтийн соёлын боловсрол -31
- Монгол бахархлын өдөр-38
- Олон улсын театрын өдөр-70

- “Нэг ном эрхэм үйлс” аян-175
- Номын баяр-174
- Эх орончдын өдөр-19
- Төрийн шагналт зохиолчдын ойд -62



Цахим санд 314 гаруй номтой. Нийт 23 уншигч цахим санд байгаа номыг уншиж үйлчлүүлсэн. Мөн сурах бичиг ашиглаж бие даан суралцаж байна. Сумдын ойн болон орон нутгийн зохиолчдын номын эхийг авч, цахимд оруулахад бэлэн болоод байна.





Нэг ном-эрхэм үйлс аяны хүрээнд “Нүүр номоосоо гэрэлтэе” эвэнт арга хэмжээг 1 сарын турш зохион байгуулж номын сангаар үйчлүүлэх иргэдийн тоог нэмэгдүүлэх, гэр бүлээрээ ном уншихад уриалан, уншсан номоороо өглөөний уулзалт хэлэлцүүлгийг 13 удаа зохион байгуулсан.





Номын сангийн уншлага үйлчилгээг нэмэгдүүлэхэд “ Шинэ уншигч” “Номын жим” хөтөлбөрийг хэрэгжүүлэн ЕБ-ын сургуулийн 17 бүлгийн 510 сурагчид хамрагдан ном унших, тэмдэглэл хөтлөх, ойлгосноо ярих чадварт суралцсан байна. Бүтээлч уншлага аяныг аймгийн хэмжээнд зохион байгуулан, 41 анги хамт олон хамруулан, 1207 уншигч 12633 ирэгсдэд 17635 ном олгосон байна. /зураг/

Ангиараа ном унших, номын тухай хэлэлцүүлэг уулзалтыг 37 удаа зохион



байгуулжээ. Байнгийн уншигчийн тоо нэмэгдэж номын сангийн үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдлээ.

ДӨРӨВ. СОЁЛ ТАНИН МЭДЭХҮЙН АЖИЛ

Үндэсний хэл бичиг, түүнтэй холбогдолтой ёс заншил, уламжлал, өвийг судлах, сурталчлах, бичиг үсэг, ном судар бүтээдэг эд өлгийн түүхийг сурталчлан таниулж, уламжлан өвлүүлэх талаар олон нийтэд чиглэсэн олон талт үйл ажиллагааг зохион байгуулж, хүүхэд залуучуудад үндэсний бичгээ сурах хүсэл сонирхол төрүүлэх, эрмэлзэлд нь дэмжлэг үзүүлэх зэргээр өргөн олонд хүртээлтэй 11 ажил, уралдааныг өрнүүлэн 2100.000 мянган төгрөгийг зарцуулсан байна “Миний монгол бичиг” аяны хүрээнд “Хурдан зөв унших” “Хичээнгүй бичигтэн” “Алдаагүй зөв бичигтэн” “Цахим монгол бичигтэн”, “Уран дүрст бичлэг” “Бүтээл”-ийн уралдаан, “Монгол бичгийн номын үзэсгэлэн, “Монгол бичгийн унших цаг” зэрэгт 637 иргэд, багш, сурагчид, 31 байгууллагын 89 төрийн албан хаагч оролцож, Хүмүүн бичигтэн арга хэмжээтэй хамтран зохион байгуулж 19 сумын монгол бичгийн шилдгүүдийг тодруулсан үр дүнтэй ажил зохион байгуулсан.

“Илүү их уншья” бүтээлч уншлагын аяны хүрээнд “Номын сайн нөхөр-анги хамт олон” “Шилдэг уншигч-сурагч” “Шилдэг номын санч мэдээллийн ажилтан” “Үлгэрч хүүхэд” цахим, “Номын тусгал-зурагт гар зургийн,” Эх хэл үндэсний дархлаа” уран илтгэлийн уралдаануудыг зохион байгуулж 12633 ирэгсэд номын сангаар үйлчлүүлсэн байна.

Номын сангийн нийгэмд соён гэгээрүүлэх ач холбогдол, төгсөх ангийн сурагчдад мэргэжлээ сонгоход нь номын санч мэргэжлийн онцлогийг сурталчилах “Бид номын санч” арга хэмжээг зохион байгуулсан.

Өвөрхангай аймгийн хэмжээнд “Номын сайн нөхөр-анги хамт олон” нийт 18 ангийн бүтээл тодорхойлолт ирснээс нийт бага, дунд ангийн 9 бүлэг шалгарч, ангиараа амжилттай уншиж, номтой зөв харьцах соёлд суралцан ном унших дадалд суралцлаа. “Шилдэг уншигч сурагч” нийт 23 уншигчийг тодруулж, “Тэргүүний уншигч Д.Нацагдорж тэмдэгтэн” ном, үнэ бүхий зүйлээр шагналаа.

Үлгэрээр дамжуулан хүүхдийн уран яруу унших, дүрд хувирах төрсөн санаагаа илэрхийлэх чадварыг нэмэгдүүлэх, гэр бүлийн орчинд хүүхдийг хөгжүүлэх үүднээс “Үлгэрч хүүхэд” цахим уралдаанд цэцэрлэг 1-2 дугаар анги, 3-5 дугаар ангийн сурагчдын дунд 37 бичлэг Өвөрхангай төв номын сан цахим хуудсанд байршуулж, дүгнэсэн.

Орон нутгийн соёлын өв түүхийг сурталчилах зорилгоор “Ховор ном”, “Миний монгол бичиг”, “Хамгийн жижиг ном”-ын үзэсгэлэнг тус тус гаргаж нийт 158 номоор гаргасан.

Зохиолч уншигчийн уулзалтанд орон нутагт бүтээлээ туурвиж буй залуу яруу найрагчдыг оролцуулан “Үгийн гайхамшиг” сэдвээр ярилцлага хийн яруу найргийнхаа дээжээс уншигчиддаа толилуулж, орон нутгаас төрөн гарсан зохиолчдын шинэ уран бүтээлийг уншигчдад хүргэсэн.

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй “Соёл” “Оюу тайж” “Монгол шуудангийн алба” тай гэрээ хийн номын худалдаа зохион байгуулж, 3 сая төгрөгний номыг иргэд худалдан авсан. Номын баярыг угтсан ном соёлын нөлөөллийн ажил 8 ажил зохион байгуулж шагнал, үйл ажиллагааны зардалд 3204400 төгрөгийг зарцуулсан.

Тэргүүний уншигч анги /бага анги/

№	Байр	Сум	Сургууль	Анги	Ангийн багш
1	1-р байр	Арвайхээр	ЕБ-ын 2 сургууль	4а анги	Л.Пүрэвсүрэн
2	2-р байр	Бат -Өлзий сум	ЕБ-ын сургууль	2б	С.Оюунтуяа
3	3-р байр	Арвайхээр	ЕБ-ын 4-р сургууль	4а анги	Д.Наранцэцэг
4	3-р байр	Арвайхээр	ЕБ-ын Мэргэд сургууль	5а анги	Б.Мөнх-Адъяа

Идэвхтэй оролцсон анги

№	Сум	Сургууль	Анги	Багш
1	Арвайхээр	ЕБ-ын 2-р сургууль	3б	М.Алтанжин
2	Арвайхээр	ЕБ-ын 1-р сургууль	4б	Т.Хажидмаа
3	Арвайхээр	ЕБ-ын 2-р сургууль	4б	Б.Эрдэнэтуяа

Тэргүүний уншигч анги /дунд анги/

№	Байр	Сум	Сургууль	Анги	Ангийн багш
---	------	-----	----------	------	-------------

1	1-р байр	Арвайхээр	ЕБ-ын 2-р сургууль	6г анги	С.Дуламсүрэн
2	2-р байр	Зүүнбаян-Улаан сум	ЕБ-ын сургууль	8а анги	А.Бямбадулам
3	3-р байр	Арвайхээр	ЕБ-ын 4-р сургууль	6д анги	Б.Хишигсүрэн
4	3-р байр	Арвайхээр	ЕБ-ын 4-р сургууль	8б анги	Гүнсэнхорлоо

Идэвхтэй оролцсон анги

№	Сум	Сургууль	Анги	Багш
1	Арвайхээр	ЕБ-ын 4-р сургууль	8в	Санчирбал

Тэргүүний уншигч сурагч

1. 1-р анги

- Арвайхээр сумын ЕБ-ын 1-р сургуулийн 1г ангийн сурагч Г.Номин-Эрдэнэ

2-р анги

- Арвайхээр сумын ЕБ-ын Мэргэд сургуулийн 2б ангийн сурагч М.Мөнхнасан
- Арвайхээр сумын ЕБ-ын Мэргэд сургуулийн 2б ангийн сурагч У.Мөнххүслэн

3-р анги

- Арвайхээр сумын ЕБ-ын 2-р сургуулийн 3б ангийн сурагч Эрдэнэтулга овогтой Мөнхзаяа
- Арвайхээр сумын ЕБ-ын 2-р сургуулийн 3б ангийн сурагч Мөнхсайхан овогтой Мөнхзул

4-р анги

- Арвайхээр сумын ЕБ-ын 4-р сургуулийн 4а ангийн сурагч Ганбаатар овогтой Билэгжаргал
- Арвайхээр сумын ЕБ-ын 4-р сургуулийн 4б ангийн сурагч Баяржаргал овогтой Давгасүрэн

5-р анги

- Арвайхээр сумын ЕБ-ын Мэргэд сургуулийн 5а ангийн сурагч Галмандах овогтой Гэгээнсар
- Арвайхээр сумын ЕБ-ын Мэргэд сургуулийн 5а ангийн сурагч Нарантуяа овогтой Сүндэръяа

6-р анги

- Арвайхээр сумын ЕБ-ын 2-р сургуулийн 6г ангийн сурагч Сугаррагчаа овогтой Түвшинбаяр

8-р анги

- Арвайхээр сумын ЕБ-ын 4-р сургуулийн 8в ангийн сурагч Баян овогтой Төвшиндөл

9-р анги

- Арвайхээр сумын ЕБ-ын 1-р сургуулийн 9а ангийн сурагч Баясгалан овогтой Ууганбаяр

11-р анги

- Арвайхээр сумын ЕБ-ын Тэмүүлэл-Эрдэм сургуулийн 11б ангийн сурагч Г.Төгсжаргал

12-р анги

- Арвайхээр сумын ЕБ-ын 2-р сургуулийн 12а ангийн сурагч
М.Ариунзаяа

“Үлгэрч хүүхэд” уралдаан

1-2-р анги

1-р байр Нарийнтээл сумын ЕБ-ын сургуулийн 2б ангийн сурагч
М.Ариунтуяа

2-р байр Сант сумын ЕӨ-ын сургуулийн 2а ангийн сурагч Ө.Ичинхорлоо

3-р байр Арвайхээр сумын ЕБ-ын 4 дүгээр сургуулийн 2г ангийн сурагч
Э.Өсөх-Ирээдүй

/3-5/ ангийн төрөлд

1-р байр Бат-Өлзий сумын ЕБ-ын 1 сургуулийн 4д ангийн сурагч Б.Энэрэл

2-р байр Бат-Өлзий сумын ЕБ-ын 2 сургуулийн 3б ангийн сурагч

О.Сайнсанаа

3-р байр Бат-Өлзий сумын ЕБ-ын 2 дугаар сургуулийн 5а ангийн сурагч

Э.Амин-Эрдэнэ

“Номын тусгал- зурагт” уралдаан

1-р байр Нарийнтээл сумын ЕБ-ын 6а ангийн сурагч Э. Энхбишрэлт

2-р байр Арвайхээр сумын ЕБ-ын 1 дүгээр сургуулийн 7в ангийн сурагч

С.Мөнхсаруул

3-р байр Арвайхээр сумын ЕБ-ын 4 дүгээр сургуулийн 6д ангийн сурагч Т.

Норовсүрэн А. Отгонсүрэн

Тусгай байр Хархорин сумын ЕБ-ын 2 дугаар сургуулийн 5а ангийн сурагч

Б.Тэмүүлэн

“Эх хэл үндэсний дархлаа” уран илтгэлийн уралдаан

9-10-р анги

1-р байр- Арвайхээр сумын ЕБ-ын 4-р сургуулийн 9а ангийн сурагч
Б.Энхзул

11-12-р анги

1-р байр - Уянга сумын ЕБ-ын 2-р сургуулийн 11а ангийн сурагч
Э.Минжинсор

2-р байр -Есөнзүйл сумын ЕБ-ын сургуулийн 12а ангийн сурагч Ё.Цэнд-
Аюуш

“МИНИЙ МОНГОЛ БИЧИГ” УРАЛДААНЫ ШАЛГАРСАН СУРАГЧДЫН МЭДЭЭЛЭЛ

№	Овог нэр	Сургууль анги бүлэг	Байр	Тайлбар
Хурдан зөв уншлагын уралдаан /8-9 дугаар анги/				
1	Жанчивдолгор	ЕБ-ын 2 дугаар сургууль	I	121
2	А.Баярмаа	Хужирт сум	II	118
3	Ж.Гэрэлчулуун	ЕБ-ын 4 дүгээр сургууль	III	97
Хурдан зөв уншлагын уралдаан /10-12дугаар анги/				

1	Ц.Сайнбилэг	Мэргэд сургууль	I	142
2	Б.Мөнхдалай	Хужирт	II	142
3	Жанцалдиймаа	ЕБ-ын 1 дүгээр сургууль	III	135
Хичээнгүй бичигтэн				
1	О.Хандсүрэн	Арвайхээр	I	
2	О.Мөнхсоёл	Арвайхээр	II	
3	Э.Лхагвасүрэн	Арвайхээр	III	
Цахим монгол бичигтэн				
1	Энэрэл		I	
2	Ариунжаргал		II	
3	Жанцалдиймаа	ЕБ-ын 1 дүгээр сургууль	III	
Уран дүрст бичлэгийн уралдаан /ахлах анги/				
1	Б.Оюунханд		I	
2	Н.Мандуухай		II	
3	Ц.Сайнбилэг		III	
Уран дүрст бичлэгийн уралдаан /иргэд/				
1	Д.Баасанжав	Бат-Өлзий сум	I	
2	Б.Энхсүрэн	Арвайхээр	II	
3	Б.Долгормаа	Арвайхээр	III	
Бүтээлийн уралдаан /хүүхэд/				
1	Б.Отгонжаргал	ЕБ-ын 1 дүгээр сургууль	I	Муур багш
2	Б.Номин-Эрдэнэ	ЕБ-ын 2 дугаар сургууль 11д анги	II	Дөрвөн цаг
3	О.Өлзийбилэгт	Гучин-Ус сум 8а анги	III	Чингис
	Б.Мөнгөлдэй	ЕБ-ын 5-9а анги	тусгай	Эрдэм
Бүтээлийн уралдаан /иргэд/				
1	Б.Даваажаргал	Тэмүүлэл эрдэм	I	Үлэмжийн чанар
2	Ч.Гандөл	Номын хүрдэн	II	Хөшөөний бичвэр
3	Б.Пүрэвсүрэн	Санхүү аудит	III	Өвөрхангай нутаг
Бүтээлийн уралдаан /багш/				
1	Б.Цэрэн	ЕБ-ын 1 дүгээр сургууль	I	Тусгаар тогтнол
2	Түгжсүрэн	Тэмүүлэл эрдэм	II	Цэнхэр эрвээхэй
3	Б.Энх-Очир	Мэргэд сургууль	III	Есөн эрдэнийн орон



Намрын номын баяр

Монгол улсын Ерөнхийлэгчийн 158 дугаар зарлигийг хэрэгжүүлэх, хүүхэд залуусыг номтой нөхөрлүүлэх номын ач тусыг олон нийтэд сурталчилан таниулах зорилгоор 2024 оны 09 сарын 16 наас 09 дүгээр сарын 25 ныг дуустал номын баярын арга хэмжээг зохион байгууллаа. Номын баярыг ЕБ-ын мэргэд лаборатори сургууль, Алтан гадас одонт I II IV сургуулиудад нийт 870 сурагч багш нарыг хамруулсан байна. Номын баяраар:

- “Миний мэргэжил номын санч”
- “Ном уншихын гайхамшиг” сургалт
- Үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх “Сайхан бичигтэн”, “Хурдан уншигч” уралдаан
- Номын сангийн танилцуулга
- Аман өв, хэлц үг тайлбарлах, ертөнцийн гурав зүйр цэцэн үг хэн сайн мэдэх вэ уралдаан
- Танин мэдэхүйн АХА;
- Танин мэдэхүйн Алтан хонх тэмцээн;
- Шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэнг гаргаж, карт нээн номын сангийн үйлчилгээг ойртуулан ажиллалаа.

Үндэсний бичиг соёл "Номын өдрүүд-2024" номын баярт 3-5 ангийнхны дунд Аман өвөө хэрхэн сайн мэдэх вэ ? соёл танин мэдэхүйн уралдаан тэмцээнд нийт 198 сурагч оролцсон байна. .

1 -р сургууль:

- 1 байр: 5б ангийн сурагч Сумьяацэрэн
- 2 байр: 5б ангийн сурагч Мишээл

2 -р сургууль:

- 1 байр: 4г ангийн сурагч С. Зүмпэрэллхам
- 2 байр: 4г ангийн сурагч Б. Азжаргал .

Мэргэд сургууль :

- 1 байр: 3б ангийн сурагч А. Даваажаргал

2 байр: 3а ангийн сурагч Т. Бадамрагчаа

4-р сургууль:

1 байр: 5д ангийн сурагч З. Буянжаргал

2 байр: 5б ангийн сурагч М. Эрдэнэдаваа нар шалгарч талархал ном, хичээлийн хэрэглэгдэхүүн, бэлэг дурсгалын зүйлээр шагнаж урамшуулсан.

“Миний мэргэжил сайхан” арга хэмжээнд номын сан болон номын санч мэргэжлийн онцлогийг 12 дугаар ангийн сурагчдад сурталчилан таниулах сургалт мэдээллийн ажлыг хийлээ.

“Ном уншихуйн гайхамшиг” сургалтыг хийж хүүхдийг номтой нөхөрлүүлэх, номын ач тусыг таниулан, харилцан номын тухай ярилцлаа. Өөрийн уншсан номоо бусадтайгаа хуваалцсан 4 сурагчид номын сангаар үнэгүй үйлчлүүлэх эрхийн бичгээр шагнасан байна.

Иргэдийн бичиг үсгийн боловсролыг дээшлүүлэх ажлын хүрээнд байгууллага бүр дээр монгол хэл уран зохиолын багш нартай хамтран “Сайхан бичигтэн” “Хурдан зөв уншигч” багш ажилчдыг шалгаруулан талархал мөнгөн шагналаар шагнасан байна.

Багш ажилчдын дунд үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх "Сайхан бичигтэн" уралдаанд:

4 дүгээр сургууль

- I байрт: Бага ангийн багш Д. Нарантуяа
- II байрт: Бага ангийн багш Б. Цэнгэлбадам
- III байрт: Бага ангийн багш Г. Оюунбаяр
- Тусгай байрт: Бичиг хэргийн ажилтан М. Мөнгөнсүх

2 дугаар сургууль

- I байрт: Бага ангийн багш н. Мөнхтуяа
- II байрт: Математикийн багш н. Цэлмүүн
- III байрт: Математикийн багш Д. Сугар

1 дүгээр сургууль

- I байр: Технологийн багш Д. Оюунчимэг
- II байрт: Англи хэлний багш Д. Цэвэлмаа
- III байрт: Дуу хөгжмийн багш Одгэрэл тус тус шалгарсан байна.

Ном уншдаг номын баярт оролцсон уншигч хүүхдийнхээ дунд “АХА” “Алтан хонх тэмцээнийг сургууль бүр дээр хийж явуулж шагнал урамшлыг олголоо.

“Монгол бичиг” “Хэл шинжлэл” “Хүүхдийн уран зохиол” “Шинэ ном”-ын үзэсгэлэнгүүдийг нийт 380 номоор гаргасан байна.

Номын баярын хаалтын үйл ажиллагааг Мэргэд цогцолбор сургуультай хамтран Хүүхдийн номын өргөөнд зохион байгуулсан.

Үзүүлэн таниулах ажлын хүрээнд:

-Хамгийн жижиг ном 53, ном сан ном зүйн бүртгэлийн ном 35, Өвөрхангай аймгийн зохиолчдын номын 34, хүүхдийн номын 60, шинэ номын 45 номоор үзэсгэлэнг гаргаж уншигчдад танилцуулга ярилцлага хийсэн. Номын баяраар ирсэн уншигчиддаа кофе цайгаар дайлсан байна. “Сайхан бичигтэн” “Миний уншсан ном-уран зурагт” үзэсгэлэнгүүдийг дэлгэн иргэдэд танилцуулсан.

Танин мэдэх ажлын хүрээнд:

“Манай гэрийн номын сан” цуврал контент 2-ийг бэлтгэн цахим орчинд байршуулан 6125 хүнд хүргэсэн. Мөн гэрийн номын сантай 3 иргэнийг алдаршуулан Талархал ном мөнгөн шагналаар шагнасан.

Сургуулийн монгол хэл уран зохиолын багш нарын дунд “Үсэглэлийн хаад” монгол бичгийн тэмцээнийг зохион байгуулсан. Гол зорилго нь хүүхдийг ном уншуулах, номонд дуртай болгоход хамтран ажиллах саналыг танилцууллаа. Уралдаанд:

I байр Мэргэд цогцолбор сургуулийн МХУЗЗАН

II байр ЕБ-ын 2 дугаар сургуулийн МХУЗЗАН

III байр Тэмүүлэл эрдэм сургуулийн МХУЗЗАН шалгарч Талархал мөнгөн шагналаар шагнасан байна.

Зохиолч уншигчдын уулзалтыг Арвайн хүрээ утга зохиолын нэгдэлтэй хамтран нийт 20 зохиолч урьснаас 11 зохиолч оролцож, өөрийн бүтээсэн номын талаар ярьж, уншигчидтай уулзалт зохион байгуулж, яруу найргийн дээжээсээ хүргэсэн. Уулзалтанд СГЗүтгэлтэн С.Мөнхдалай гуай ирж оролцсон байна. Мөн ирсэн зохиолч хэвлэн нийтлэгчиддээ хүндэтгэл үзүүлсэн байна.

Мөн "OPEN-MIC-шүлэг" ийн чөлөөт арга хэмжээг зохион утга уянга яруу найргийн өөрийн мэддэг шүлгүүдээ хэлсэн байна. Хамгийн сайхан шүлэг олонд сонордуулсан 5 үзэгчийг тодруулан урамшууллаа.

"Номын жим" танилцах аялалыг ЕБ-ын 4 дүгээр сургуулийн Б.Наранчимэг багштай 2а анги, Б.Долгорсүрэн багштай 2д анги, Баасандулам багштай 4д анги, Жаргалмаа багштай 4а анги номын сантай танилцсан байна.

Байгууллагын номын санчдын дунд " Номын тэмдэглэл хөтлөх үзүүлэн



таниулах гарын авлага бэлтгэх" уралдааныг зарлан 10 дугаар сарын 15 нд дүгнэхээр удирдамж гаргасан ажилласан.

Номын санчдын сургалтанд хамрагдсан. Фондын зохион байгуулалт сэдвээр сургалт орсон.

Намрын номын баярт 1215 хүүхэд залуус иргэд оролцсон байна.

Үндэсний бичиг соёл "Номын өдрүүд-2024" Мэргэд сургууль Бага, дунд, ахлах, ЕБС-ийн 4-р сургууль



ЕБ-ын 2 дугаар сургууль



ЕБ-ын 1 дүгээр сургууль

Хаалтын үйл ажиллагаа:





Зохиолч уншигчдын уулзалт



Үсэглэлийн хаад



“Нэг угийн бичиг-нэг өрх” арга хэмжээний хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Байгаль орчны газар, Стандарт хэмжилзүйн газар, Аймгийн хөгжимт драмын театр, Арвайхээр сумын нийгмийн ажилтнууд, Багийн ахлагчид, “Суралцагч сурагч клуб”, Нийгмийн даатгалын газар, Музей, ЕБ-ын 1 дүгээр сургуулийн 9а ангийн эцэг эхчүүд, сурагчид зэрэг байгууллагын ажилтнуудад угийн бичгийн сургалтыг хийж нийт 237 хүнийг хамруулсан байна.

”Угийн бичгийн зураглал, бичиглэл хийх арга” ”Угийн бичиг хөтлөхийн ач тус” хичээлүүдийг орсон. Угийн бичиг хөтөлсөн иргэний тоо 136, сургалтыг 11 удаа хийсэн. Угийн бичиг хөтлөн ураг удмын номыг эрхлэн гаргасан 46 номыг судалгааг аваад байна.

“Соёлын бүтээлч сар”

Төрийн шагналт, Ардын уран зохиолч, Хөдөлмөрийн баатар, яруу найрагч Дэндэвийн Пүрэвдоржийн амьдрал уран бүтээлийг олон нийтэд таниулах зорилгоор “Түүхэн хүмүүнээс суралцахуй” нэрийн дор 5 ажлыг төлөвлөн зохион байгуулсан. Соёлын бүтээлч сараар нийт 1958 үйлчлүүлэгч, үүнээс 0-18 насны 1246, 18-65 насны 698, хөгжлийн бэрхшээлтэй 14 хүн хамрагджээ. Боловсролын хөтөлбөрт 208, хэлэлцүүлэг хуралд 241, цахим орчинд түгээсэн контент, мэдээллийн тоо 592 хүнд хүрсэн байна. Үүнд:

-“Их зохиолчоо алдаршуулья” танилцуулга хэлэлцүүлэг

- “Эрээн уулын эгэлгүй найрагч” цахим контент хийх

-Номын тэмдэглэл, бүтээлийн уралдаан

-“Түүхэн хүн” цахим мэдээлэл

-Түүхэн хүмүүнээс суралцахуй” номын үзэсгэлэн зэрэг ажлыг долоо хоногоор төлөвлөн зохион байгуулж ажилласан.

Аймгийн цагдаагийн газрын 50 албан хаагч номын сангийн үйл ажиллагаатай танилцан уншигчийн карт нээлгэн "Номтой нөхөрлөө" өдөрлөг боллоо.

- "Ном уншихын гайхамшиг" сургалт мэдээлэл

- Танин мэдэхүйн "Алтан хонх" тэмцээнийг зохион Ахлах ахлагч Т. Баяраа, Дотоодын цэргийн 833 дугаар ангийн орлогч Д. Пүрэвдорж нар амжилттай оролцож номоор бэлэг барьж, цагдаагийн байгууллагын номын санд ном хандивлалаа.

Монголын уран зохиолын ноён оргилууд болох зохиолуудаар "Номын тэмдэглэл хөтлөх, бүтээл хийх" уралдааныг номын санч мэдээллийн ажилтнуудын дунд зохион байгууллаа.

I байр: Хархорин сумын номын санч мэдээллийн ажилтан Ц.Цэцгээ "Жангар" тууль

II байр: Аймгийн төв номын сангийн Хүүхдийн уншлагын танхимын номын санч мэдээллийн ажилтан Б.Цэрэнпүрэв "Жангар" тууль

III байр: Бат-Өлзий сумын номын санч мэдээллийн ажилтан Л. Содномбалжир "Монголын нууц товчоо" зохиолоор шалгарч Өргөмжлөл мөнгөн шагналаар шагнагдсан.

“Утга зохиолын өдрүүд”

Хаврын номын баяраар орон нутгийн 5 зохиолчдод хүндэтгэл үзүүлэн зохиогч уншигчийн уулзалтыг хийсэн. Ахмад зохиолч яруу найрагч Д.Эрдэнэбатын яруу найргийн наадмыг хамтран зохион байгуулж, хүндэтгэл үзүүлж 300,000 төгрөг, яруу найрагч На.Пүрэвийн номыг худалдан авч 200000 төгрөгийг тус тус зарцуулсан болно. 2 удаа зохиолч уншигчийн уулзалтыг хийж нийт 156 хүн оролцсон байна. Зохиолч уншигчдын уулзалтыг Арвайн хүрээ утга зохиолын нэгдэлтэй хамтран нийт 20 зохиолч урьснаас 11 зохиолч оролцож, өөрийн бүтээсэн номын талаар ярьж, уншигчидтай уулзалт зохион байгуулж, яруу найргийн дээжээсээ хүргэсэн. Уулзалтанд СГЗүтгэлтэн С.Мөнхдалай гуай ирж оролцсон байна. Мөн ирсэн зохиолч хэвлэн нийтлэгчиддээ хүндэтгэл үзүүлсэн байна.

Мөн “OPEN-MIC-шүлэг” ийн чөлөөт арга хэмжээг зохион утга уянга яруу найргийн өөрийн мэддэг шүлгүүдээ хэлсэн байна. Хамгийн сайхан шүлэг олонд сонордуулсан 5 үзэгчийг тодруулан урамшууллаа. Намрын номын баяраар 500,000 мянган төгрөг зарцуулж 116 уншигч оролцсон.

Зохиолч хэвлэн нийлэгчдэд хүндэтгэл үзүүлэх, яруу найргийн наадмыг ивээн тэтгэх зардалд 1,050,000 сая төрөгийг зарцуулж, 273 хүнийг хамруулан уулзалт хэлэлцүүлэг болсон.

ТАВ. ЛАВЛАГАА НОМ ЗҮЙН АЖИЛ

"Үндэсний тогтмол хэвлэлийн нэгдсэн цахим сан"-д хөдөлмөрийн төлөө сонины 2300 нүүрийг орууллаа. Энэхүү цахим санд 21 аймгийн номын санд хадгалагдаж байгаа 1929-1990 хүртэлх тогтмол хэвлэлийг цахим хэлбэрт шилжүүлж тогтмол хэвлэлийн нэгдсэн цахим санг бүрдүүлэхэд ихээхэн дэмжлэг болж байна.

"Үндэсний тогтмол хэвлэлийн өгүүллийн нэгдсэн сан"-д Улирал ба зохиолч сэтгүүлээс 122 мэдээлэл түүвэрлэн авч оруулсан байна.

Татгалзлыг тогтмол хөтлөн 284 номын санал ирж, шинэ ном авах ажлыг 35 хувийг бүрдүүлэн ажилласан. Уншигчдын татгалзлын дагуу номын санчидтай хамтран шинэ ном авах ажлыг зохион байгуулан ажилласан. Номонд ангилалт хийн стандартын дагуу техник ажиллагааг хийж электрон каталогит оруулан мэдээллийн сан үүсгэж фондонд хүлээлгэн өглөө. Уламжлалт цаасан каталогийн картыг үүсгэж, стандартын дагуу засвар хийж хэвлэхэд бэлтгэгдэж бна.

Уншлага үйлчилгээнд гарч бар код хуучирч, кодгүй болсон 93 ширхэг номыг дахин коджуулж үйлчилгээнд орууллаа.

"ЕБС-ийн сурагчдын хичээлээс гадуур судлах зохиолын номзүйн гарын авлагыг бэлтгэн монголын уран зохиолоос 439 зохиолыг 620 эх сурвалж, гадаадын уран зохиолоос 98 зохиолыг 68 эх сурвалжийг олж нэгтгээд байна. шатандаа байгаа бөгөөд цахимаар гаргахаар төлөвлөн ажиллаж байна.

"Өвөрхангай-яруу найраг" аймаг нутаг усаа магтан дуулсан яруу найрагчдын 60 шүлгийг эх сурвалжаас олж эмхэтгэлээ.

Өвөрхангай аймгийн нийтийн номын сангуудын нэгдсэн электрон каталогит 31187 нэр төрлийн 89988 номыг оруулсан байна. Электрон каталогийн хэрэглэгчийн тоо 3086 д хүрч номын захиалга өгч үйлчилгээ авсан нь номын сангийн хүртээмж нэмэгдэж байна.

Уншигчдаас амаар, бичгээр, facebook, email -хаягаар тодотгосон буюу сэдэвчилсэн 1518 лавлагааг өгч үйлчиллээ.

Хавар намрын номын баяр Дэлхийн номын өдөр, Шинэ номын мэдээ,Тэмдэглэлт өдрүүд, Нүүр номоосоо гэрэлтэе, Цахим мэдээлэл, "Миний монгол бичиг" Угийн бичиг, Түүхт хүн, Соёлын бүтээлч сар, Өвөрхангай яруу найрагт 302 мэдээлэл, танхимуудын хийсэн ажлын мэдээлэл 136 цахимд оруулан Өвөрхангай төв номын сан хуудсанд байршуулан 217069 хүнд хүргэсэн байна.

ЗУРГАА. МЭДЭЭЛЭЛ АРГА ЗҮЙН АЖИЛ

Номын сангаас зохион байгуулж буй ажил, соёл танин мэдэхүйн арга хэмжээнүүдийг зохион байгуулах,чиглүүлэх үүргийг арга зүйн оновчтой хэлбэрүүдийг сонгон зохион байгуулж ажиллалаа. Номын санчдын сургалтыг 3 удаа, цахимаар 2 удаа явуулсан.

Номын санчдыг ажлын байранд сургах, мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор жил бүр "Бүтээлч номын санч" "Номын тэмдэглэл хөтлөх, бүтээл"-ийн уралдааныг зохион байгуулсан.

Номын сангийн нийгэмд соён гэгээрүүлэх ач холбогдол, төгсөх ангийн сурагчдад мэргэжлээ сонгоход нь номын санч мэргэжлийн онцлогийг сурталчилах "Бид номын санч" арга хэмжээг зохион байгуулсан.


Богд, Нарийнтээл, Хайрхандулаан, Өлзийт,Тарагт сумын номын санч мэдээллийн ажилтнуудыг номын санд 3-5 хоногийн дадлага ажил хийлгэсэн.

Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, ном соёл нөлөөллийн ажлын удирдамж гаргах, зөөврийн номын сан ажиллуулах, мэдээ тайлан гаргах, номыг

программд оруулах, уншигчаа бүртгэх, ном олгох зэрэг зөвлөмжийг өгч ажилласан. Нийт 47 номын санч мэдээллийн ажилтанд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн.

Статистикийн мэдээллийн нэгдсэн сан, Цахим мэдээллийн сан “Koha” программын сургалтанд 8 хүн хамрагдсан. Соёл урлагийн газар болон бусад байгууллагаас зохион байгуулсан нийт 12 сургалт мэдээлэлд хамрагдсан. Сан хөмрөгийн тооллогыг нэг бүрчилсэн бүртгэлээр болон программаар тоолон дутагдсан номыг номын санчдад хугацаатай үүрэг өгч уншигчийн гар дээр удсан болон алга болгосон уншигчийн судалгааг гарган “Ном авах өдөр”-ийг зохион байгуулан зөвлөмж өгч 232 номыг нөхөн бүрдүүлж ажилласан байна.

“Уншигчаа сонсоё” санал асуулгыг цахимаар болон цаасаар авч ажил үйлчилгээг сайжруулж уншигчаа сонсоё хөдөлгөөн өрнүүлэн ажилласан байна.



ДОЛОО. БУСАД АЖИЛ

Төсөв санхүүгийн ажил

Номын сан нь 435,950,700 мянган төгрөгийн нийт төсөвтэй. Ажилчдын нийгмийн асуудлыг дэмжиж хоолны зардалд 14,784,000 төгрөг, ажилчдын үр дүнд 24,912,000 төгрөг, ажилсан жилийн урамшуулалт 7,638,000 төгрөг, түлээ нүүрс, дулааны хөнгөлөлтөд 2,648,300 төгрөгийг зарцуулж, ажилчдад шаардлагатай тохиолдолд цалинтай чөлөө өгч ажилласан.

Эрүүл ахуй хөдөлмөрийн аюулгүй байдал 657,000 төгрөг, “Цуврай гол” ББН хоршоогоор 350,000 төгрөгийг ариутгалд, урсгал засварт 7,107,550 төгрөг, томилолтын зардалд 2,700,000 төгрөгийг зарцуулсан байна.

1 дүгээр сард аудитын шалгалтаар илэрсэн зөрчилгүй шалгагдсан. 4 дүгээр сард төсөв санхүү, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын бүрдэл, өмч хөрөнгө бүртгэл хадгалалт хамгаалалтын үйл ажиллагаанд хяналт үнэлгээг аймгийн Соёл урлагийн газраас явуулсан. 9 сард санхүүгийн албаны шалгалт 4 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж улсын байцаагчийн зөвлөмжийн дагуу илэрсэн зөрчлийг засан сайжруулан ажилласан.

Байгууллагын үндсэн хөрөнгийн тооллогыг жилийн эцсээр, үндсэн сан хөмрөг /ном/-ийг хагас жилээр нэг бүрчлэн тоолж бүртгэн ажилласан. Өмчийн хэлтсээс шалгалт ирэн заавар зөвлөмж өгч ажилласан. Байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн гишүүд ашиглах боломжгүй болсон, эвдэрч хэмхэрсэн эд хогшлийг засч үйлчилгээнд ашиглаж байна. Хамт олноороо складанд байгаа өмч хөрөнгийг бүртгэлтэй тулган, цэвэрлэж янзаллаа. Өмч хөрөнгийг бүрэн бүтэн байдалд дотоод хяналтыг хагас жилээр хийн ажиллалаа. Үр дүнгийн санхүүжилтээр олгогдсон 7052,000 төгрөгийг Хүүхдийн уншлагын танхимын ширээ сандлыг авахад зориулан.

Яамнаас өгсөн компьютер принтерийг цахим санг хөгжүүлэхэд ашиглахаар үндсэн хөрөнгөнд бүртгэсэн. Шилэн дансны мэдээллийг журманд заасны дагуу сар бүр оруулж ажилласан. Аймгийн засаг даргад уламжлан 585,000 сая төгрөгийг музейн барилгын засварт 2025 оны төсөвт суулгуулсан. 3300,000 мянган төгрөгийг барилгын зураг төсөл хийж гүйцэтгэх зардлыг шийдүүлсэн байна.

Хүний нөөц

Хүний нөөцийн программд мэдээллийг үнэн зөв оруулан төрийн албан хаагчийн хавтсыг баяжуулалт хийсэн. Ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулсан. Мөн сар бүр хоолны үнийн хөнгөлөлт, цагийн бүртгэлд хяналт тавьж ажилласан. Сүлжээний инженер Л.Даваахүүгийн 5 жилийн нэмэгдэл тэтгэмж 7,638,000 төгрөгийг журмын дагуу бүрдүүлэлт хийн олгосон. Тэтгэвэрт гарч байгаа 2 ахмад ажилтанд 54,086,614 төгрөгийг тэтгэмж урамшууллын зардлаас гаргаж тэтгэмж олгосон. Санхүү, сан хөмрөгчийн ажлын байрыг зарлаж, 2 ажилтныг шинээр авч ажиллуулан ажлыг хүлээлцсэн.

Бичиг хэрэг

Захирлын тушаал арга хэмжээ, үйл ажиллагааны А тушаал 26, хүний нөөц, боловсон хүчний Б тушаал 14-ийг гарсан.

А5 хэмжээтэй 30 тоот, А4 хэмжээтэй албан тоот 2 тоот гарган бүртгэж холбогдох албан байгууллагуудад хүргүүлсэн.

47 албан бичгийг хүлээн авч бүртгэсэн. Үүнээс 33 хариутай албан бичиг байснаас холбогдох газар, албан хаагчдад цаг тухай бүр хүргүүлэн хариуг хугацаандан гарган явуулсан.

Монгол бичгээр үйлдэх албан бичгийн хэвлэмэл хуудасны MNS 6395:2022 стандартын дагуу бэлтгэн аймгийн Архивын хэлтсээр батлуулан захиалга өгч гаргуулан одоогийн байдлаар А5 хэмжээтэй албан бичиг 3, А4 хэмжээтэй 2 тушаал, албан бичгийг хос бичгээр хөтлөн гаргасан байна.

Баримт бичиг нягтлан шалгах комиссыг шинэчлэн байгуулж, Хөтлөх хэргийн жагсаалтыг шинэчлэн гаргасан.

Байгууллагын 2023 оны захирлын тушаал, ирсэн, явуулсан албан бичиг, бусад баримт бичгүүдийг стандартын дагуу дараалан бүртгэн, товъёг үйлдэн, үдэж хавтаслан архивласан.

Аймгийн соёл урлагийн газрын бичиг хэргийн хөтлөлтийн шалгалтын зөвлөмжийн дагуу архив бичиг хэргийг стандартын дагуу бүртгэн баримтжуулах талаар аймгийн архиваас 1 удаа биечлэн, 2 удаа зөвлөгөө авч хэрэгжүүлэн ажилласан байна.

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

УНШЛАГА ҮЙЛЧИЛГЭЭ

Хүснэгт 1. Уншлага үйлчилгээний үзүүлэлт.

Үзүүлэлт	Хүүхдийн уншлагын танхим	Нийтийн уншлагын танхим	Гэрээр ном олгох танхим	Мэдээллийн төв	Сан хөмрөг	Зөврөөр	Цахим	Нийт
Уншигч	2405	1185	352	300				4242
Ирэгсэд	9777	4256	4189	636	525	5653	1927 6	44312
Ном олголт	18331	4544	8007	945	1200	4990	1927 6	57293

Урилгат үйлчилгээ

Хүснэгт 2. Хүүхдийн уншлагын танхимын урилгат үйлчилгээний тоон мэдээ

Д/д	Сар, өдөр	Сургууль, анги	Ирсэн давтамж	Ирц	Ном олголт
1.	II/08 - V/01	2-р сургуулийн 5б анги	8 удаа	287	300
2.	II/23 - IV/12	2-р сургуулийн 5в анги	6 удаа	205	238
3.	II/27	2-р сургуулийн 3а анги	1 удаа	45	45
4.	II/28	5-р сургуулийн 4в анги	1 удаа	42	42
5.	II/22 - III/01	4-р сургуулийн 7а анги	3 удаа	75	160
6.	II/29	1-р сургуулийн 4в анги	1 удаа	30	30
7.	III/01- IV/04	4-р сургуулийн 4а анги	2 удаа	48	70
8.	III/05	1-р сургуулийн 1б анги	1 удаа	30	30
9.	III/06 - III/07	4-р сургуулийн 4в анги	2 удаа	60	80
10.	III/06 - X/31	3-р сургуулийн 6г анги	5 удаа	176	216
11.	III/12	4-р сургуулийн 7в анги	1 удаа	28	35
12.	III/14	1-р сургуулийн 7е анги	1 удаа	26	30
13.	III/19	4-р сургуулийн 1б анги	1 удаа	30	30
14.	III/20	1-р сургуулийн 3д анги	1 удаа	39	40
15.	III/22	1-р сургуулийн 5а анги	1 удаа	42	45
16.	III/25	4-р сургуулийн 3в анги	1 удаа	28	35
17.	III/25	4-р сургуулийн 3б анги	1 удаа	22	30
18.	III/26	4-р сургуулийн 1в анги	1 удаа	22	25
19.	III/26	4-р сургуулийн 2в анги	1 удаа	31	35
20.	IV/09	3-р сургуулийн 1б анги	1 удаа	36	36
21.	IV/10 - IV/26	5-р сургуулийн 4в анги	4 удаа	210	250
22.	IV/10 - IV/24	4-р сургуулийн 6б анги	3 удаа	60	105
23.	IV/10	4-р сургуулийн 4б анги	1 удаа	12	30
24.	IV/12	4-р сургуулийн 6а анги	1 удаа	17	17
25.	IV/18	3-р сургуулийн 2а анги	1 удаа	25	25
26.	V/07	3-р сургуулийн 1а анги	1 удаа	25	25
27.	V/08	3-р сургуулийн 3в анги	1 удаа	24	45
28.	V/14	3-р сургуулийн 1в анги	1 удаа	16	20
29.	V/21	3-р сургуулийн 1г анги	1 удаа	33	50
30.	V/28	1-р сургуулийн 1а анги	1 удаа	46	46
31.	IX/04-XII/14	5-р сургуулийн 5в анги	10 удаа	281	735
32.	X/29	1-р сургууль 3б анги	1 удаа	23	46
33.	X/30	2-р сургууль 1а анги	1 удаа	30	1
34.	X/30	4-р сургууль 5в анги	1 удаа	24	24

35.	X/30	1-р сургууль 3б анги	1 удаа	21	42
36.	X/30	2-р сургууль 3в анги	1 удаа	31	31
37.	X/31	2-р сургууль 2в анги	1 удаа	32	96
38.	X/31	3-р сургууль 6а анги	1 удаа	32	64
39.	XI/01	2-р сургууль 2б анги	1 удаа	33	66
40.	XI/01	3-р сургууль 6б анги	1 удаа	33	66
41.	XI/05	2-р сургууль 5б анги	1 удаа	38	78
42.	XI/06	2-р сургууль 2а анги	1 удаа	34	34
43.	XI/20	7-р сургууль 6а анги	1 удаа	23	23
44.	X/08-XII/03	4-р сургууль 5а анги	6 удаа	175	375
45.	XI/21-XII/02	3-р сургууль 3б анги	6 удаа	152	139
46.	X/24-XI/21	3-р сургууль 4в анги	5 удаа	162	523
47.	X/28-XII/02	1-р сургууль 3ё анги	2 удаа	80	270
48.	XI/01-XI/27	5-р сургууль 3в анги	3 удаа	123	220
49.	XI/01-XII/03	3-р сургууль 6в анги	4 удаа	84	136
50.	III/11	11-р цэцэрлэг Ахлах А бүлэг	1 удаа	34	34
51.	III/13	1-р цэцэрлэг Бэлтгэл Б бүлэг	1 удаа	41	41
52.	III/19	11-р цэцэрлэг Бэлтгэл Б бүлэг	1 удаа	28	30
53.	III/20	11-р цэцэрлэг Бэлтгэл А бүлэг	1 удаа	33	35
54.	III/25	9-р цэцэрлэг Бэлтгэл А бүлэг	1 удаа	30	40
55.	IV/05	4-р цэцэрлэг Ахлах Б бүлэг	1 удаа	14	28
56.	IV/08	2-р цэцэрлэг Бэлтгэл А бүлэг	1 удаа	38	70
57.	IV/10	4-р цэцэрлэг Бэлтгэл Б бүлэг	1 удаа	31	31
58.	IV/11	2-р цэцэрлэг Ахлах А бүлэг	1 удаа	33	40
59.	IV/12	26-р цэцэрлэг Дунд Б бүлэг	1 удаа	31	
60.	IV/23	8-р цэцэрлэг Бэлтгэл А бүлэг	1 удаа	37	40
61.	IV/25	8-р цэцэрлэг Ахлах А бүлэг	1 удаа	34	40
62.	IV/29	8-р цэцэрлэг Бэлтгэл Б бүлэг	1 удаа	21	35
63.	IV/30	26-р цэцэрлэг Дунд А бүлэг	1 удаа	24	24
64.	V/01	8-р цэцэрлэг Ахлах Б бүлэг	1 удаа	19	19
65.	V/01	9-р цэцэрлэг Бэлтгэл Б бүлэг	1 удаа	20	30
66.	X/08	23-р цэцэрлэг Ахлах Б бүлэг	1 удаа	30	30
67.	X/18	24-р цэцэрлэг Ахлах А, Б бүлэг	1 удаа	70	2
Нийт 67			120	3749	5703

Хүснэгт 3. Нийтийн уншлагын танхимын урилгат үйлчилгээний тоон мэдээ

Д/д	Сар, өдөр	Багшийн нэр Сургууль, анги	Ирсэн давтамж	Сурагчдын тоо	Уншсан номын тоо
1.	II/07	3-р сургуулийн 9б	1 удаа	37	40
2.	II/16	4-р сургуулийн 9а	1 удаа	15	18
3.	II/16 - V/7	2-р сургуулийн 8б	10 удаа	210	230
4.	II/20	3-р сургуулийн 11а	1 удаа	33	35
5.	II/20	4-р сургуулийн 9б	1 удаа	21	24
6.	II/23	4-р сургуулийн 9в	1 удаа	21	30
7.	II/26	4-р сургуулийн 9в	1 удаа	24	28
8.	II/27- III/13	2-р сургуулийн 11а	4 удаа	92	120
9.	III/01	3-р сургуулийн 12в	1 удаа	24	25
10.	III/01	4-р сургуулийн 8в	1 удаа	23	25
11.	III/04	4-р сургуулийн 8б	1 удаа	22	28
12.	III/05 - V/13	5-р сургуулийн 8д	6 удаа	92	150
13.	III/06	3-р сургуулийн 10а	1 удаа	24	27
14.	III/12 - V/21	2-р сургуулийн 8а	8 удаа	176	240
15.	III/14	4-р сургуулийн 11б	1 удаа	14	20
16.	III/22	3-р сургуулийн 9в	1 удаа	25	37
17.	III/02	4-р сургуулийн 11в	1 удаа	13	17
18.	III/22	3-р сургуулийн 10в	1 удаа	16	20
19.	IV/10	4-р сургуулийн 11а	1 удаа	16	17
20.	IV/12	4-р сургуулийн 10б	1 удаа	15	20
21.	IV/10	4-р сургуулийн 10а	1 удаа	18	21
22.	IV/10-IX/-24	1-р сургуулийн 9б	13 удаа	115	338
23.	X/09	1-р сургуулийн 8е	6 удаа	96	108

24.	X/28	1-р сургуулийн 11б	1 удаа	18	23
25.	X/28	1-р сургуулийн 10д	1 удаа	21	25
26.	X/29	1-р сургуулийн 9а	1 удаа	28	32
27.	X/30	3-р сургуулийн 8в	1 удаа	34	35
28.	X/31	1-р сургуулийн 8г	1 удаа	13	18
29.	X/31	1-р сургуулийн 9г	1 удаа	23	26
30.	XI/14	1-р сургуулийн 10в	1 удаа	31	38
Нийт 30 анги			71	1310	1815

Хүүхдийг номын сангаар үйлчлүүлэх үйлчилгээний соёлд сургах, ном уншлагад анги хамт олныг татан оролцуулах зорилгоор Хүүхдийн уншлагын танхимын зүгээс 6 сургуулийн 49 ангид 103 удаагийн урилгат үйлчилгээгээр 3181 хүүхдийг, 9 цэцэрлэгийн 19 бүлгийн 568 хүүхдүүдийг тус тус хамруулан 5703 ном олгож үйлчилсэн ба Нийтийн уншлагын танхимаас 30 ангид 71 удаагийн урилгат үйлчилгээгээр 1310 хүүхдэд 1815 ном олгож нийт 97 ангийг 191 удаа уг үйлчилгээнд хамруулан 4491 хүүхдэд 7518 ном олгож үйлчилжээ.



ЗӨӨВРИЙН НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Иргэдэд номын сангийн үйлчилгээг ойртуулах, ном хэвлэлийг сурталчлах зорилгоор зөөврийн номын сангийн үйлчилгээг **71** удаа **5435** ирцэд хүргэн **4949** ном олгож ажилласан байна.

Цэцэрлэгүүдэд / 10 удаа 1118 ирцэд 928 ном олголт/

1. II/23. 25-р цэцэрлэгийн 142 хүүхдүүдэд 111 номоор уншлага үйлчилгээ хүргэн ажилласан.
2. III/14. 1-р цэцэрлэгийн 147 хүүхдүүдэд 118 номоор уншлага үйлчилгээ хүргэн ажилласан.
3. III/28. 2-р цэцэрлэгийн 140 хүүхдүүдэд 118 номоор уншлага үйлчилгээ хүргэн ажилласан.
4. IV/25. 4-р цэцэрлэгийн 112 хүүхдүүдэд 91 номоор уншлага үйлчилгээ хүргэн ажилласан.
5. IV/30. 8-р цэцэрлэгийн 89 хүүхдүүдэд 98 номоор уншлага үйлчилгээ хүргэн ажилласан.
6. V/23. 11-р цэцэрлэгийн 71 хүүхдүүдэд 103 номоор уншлага үйлчилгээ хүргэн ажилласан.
7. X/25. 23-р цэцэрлэгийн 82 хүүхдүүдэд 82 номоор уншлага үйлчилгээ хүргэн ажилласан.

8. XI/05. 24-р цэцэрлэг 116 хүүхдүүдэд 77 номоор уншлага үйлчилгээ хүргэн ажилласан.
9. XI/06. 9-р цэцэрлэг 115 хүүхдүүдэд 80 номоор уншлага үйлчилгээ хүргэн ажилласан.
10. XI/08. 26-р цэцэрлэг 104 хүүхдүүдэд 50 номоор уншлага үйлчилгээ хүргэн ажилласан.

Сургуулиудад /9 удаа 1347 ирцэд 1122 ном олголт/



1. II/21. 5-р сургуулийн 128 сурагчдад 128 номоор уншлага үйлчилгээг хүргэн ажилласан.
2. II/28. Цогт-цэций сумын 2-р сургуулийн 360 сурагчдад 115 номоор уншлага үйлчилгээг хүргэн ажилласан.
3. II/29. Улсын тэргүүний 3-р сургуулийн 108 сурагчдад 140 номоор уншлага үйлчилгээг хүргэн ажилласан.
4. III/15. Оюуны мэлмий 4-р сургуулийн 192 сурагчдад 192 номоор уншлага үйлчилгээг хүргэн ажилласан.
5. III/22. 2-р сургуулийн 223 сурагчдад 190 номоор уншлага үйлчилгээг хүргэн ажилласан.
6. IV/11. 7-р сургуулийн 64 сурагчдад 90 номоор уншлага үйлчилгээг хүргэн ажилласан.
7. IV/18. 1-р сургуулийн 160 сурагчдад 136 номоор уншлага үйлчилгээг хүргэн ажилласан.
8. XI/20. 7-р сургуулийн 70 сурагчдад 81 номоор уншлага үйлчилгээг хүргэн ажилласан.
9. XI/22. 5-р сургуулийн 42 сурагчдад 50 номоор уншлага үйлчилгээг хүргэн ажилласан.

Байгууллагуудад /13 удаа 1382 ирцэд 1342 ном олголт/



1. III/14. Ахмадын чөлөөт холбооны хамт олонд зөөврийн номын сангийн үйлчилгээг 78 ирцэд 61 номоор үйлчилгээ үзүүллээ.
2. IV/02. Хүндэт хилчин хошууч генерал Чогын Сандрын нэрэмжит Цэргийн гавьяаны одонт Хилийн цэргийн 0131 дүгээр ангийн ажилтан албан хаагч нарт 37 ирцэд 100 номоор үзүүллээ.
3. IV/09. "Стандарт, хэмжилзүйн хэлтэс"-ийн хамт олонд 22 ирцэд 80 номоор үйлчилгээ үзүүллээ.
4. IV/15. "Төрийн банк"-ны хамт олонд 25 ирцэд 100 номоор уншлага үйлчилгээ үзүүллээ.
5. IV/27. Даланзадгад сум Хөдөлгөөнт баг арга хэмжээнд зөөврийн номын сангийн үйлчилгээг 216 ирцэд 110 номоор үйлчилгээ үзүүллээ.
6. VIII/08. Буянт зусланд амрагч хүүхдүүдэд үйлчилгээ үзүүлсэн. 64 ширхэг номоор 38 ирцэд
7. IX/05. "Ар үр" сувиллын газрын ажилтан албан хаагчид болон амрагчдад зөөврийн номын сан үйлчилгээг хүргэн ажиллалаа. Нийт 108 ширхэг номоор 80 хүнд үйлчилгээ үзүүлсэн.
8. IX/20. "Үндэсний бичиг соёл номын өдрүүд-2024" Номын баярын арга хэмжээнд "Гэрээр ном олгох танхим" нь шинэ номын үзэсгэлэн гаргаж уншигчдын карт нээн 135 ширхэг номоор 370 хүнд үйлчилсэн.
9. X/10. "Ар үр" сувиллын газрын ажилтан албан хаагчид болон амрагч нарт "Нүүдлийн номын сан" үйлчилгээг хүргэн ажиллалаа. Нийт 130ш номоор 56 хүнд үйлчилгээ үзүүлсэн.
10. XI/18. Даланзадгад сумын 4-р сургуулийн багш ажилчдад "Нүүдлийн номын сан" үйлчилгээг хүргэн шинээр уншигчийн карт нээж ном олгох үйлчилгээг үзүүллээ. 232 ширхэг номоор 234 хүнд үйлчилгээ үзүүлсэн.
11. XI/20. Даланзадгад сумын 7-р сургуулийн багш ажилчдад "Нүүдлийн номын сан" үйлчилгээг хүргэн шинээр уншигчийн карт нээж ном олгох үйлчилгээг үзүүллээ. 50 ширхэг номоор 81 хүнд үйлчилгээ үзүүлсэн.
12. XI/22. Даланзадгад сумын 5-р сургуулийн багш ажилчдад "Нүүдлийн номын сан" үйлчилгээг хүргэн шинээр уншигчийн карт нээж ном олгох үйлчилгээг үзүүллээ. 50 ширхэг номоор 15 хүнд үйлчилгээ үзүүлсэн.

13. XI/27. Нүүдлийн номын сан Зэвсэгт хүчний 167-р ангид 150 ширхэг номоор 130 хүнд үйлчилгээ үзүүлсэн.

Багийн төвд /4 удаа 396 ирцэд 500 ном олголт /

1. IX/16. “Үндэсний бичиг соёл номын өдрүүд-2024” арга хэмжээний хүрээнд “Зөөврийн номын сан-багт” үйлчилгээ 5-р багийн төвийн гадна талбайд зохион байгуулагдлаа. Үйлчилгээний хүрээнд: Уншигчийн карт нээх, гэрээр ном олгон 135 ширхэг номоор 176 хүнд үйлчилгээ үзүүлсэн.
2. IX/18. Баруун сайхны 1-р багийн төвийн гадна талбайд “Зөөврийн номын сан” үйлчилгээг 150 ширхэг номоор 100 хүнд үйлчилгээ үзүүлсэн.
3. XI/06. Даланзадгад сумын Их уулын 6-р багийн төвд “Зөөврийн номын сан” үйлчилгээг 115 ширхэг номоор 75 хүнд хүргэн үйлчилсэн.
4. XI/12. Даланзадгад сумын Далангийн 3-р багийн төвд “Зөөврийн номын сан” үйлчилгээг 100 ширхэг номоор 45 хүнд хүргэн үйлчилсэн.

Байгууллагуудтай хамтран зөөврөөр /33 удаа 765 ирцэд 879 ном олголт/

- ШШГГазар 18 удаа 529 ш ном, 348 ирц
- 0131-р анги 8 удаа 206 ш ном 165 ирц
- 4-р сургууль 6 удаа 84 ном 132 ирц
- XII/05.167-р анги 1 удаа 60 ш ном 120 ирц

Сумдад /2 удаа 427 ирцэд 178 ном олголт/

1. II/28. Цогтцэций сумын ард иргэд, хүүхэд багачуудад зөөврийн номын сангийн үйлчилгээг хүргэж, шинэ ном хэвлэлийг танилцуулах, танин мэдэхүйн тэмцээн, номын тэмдэглэлийн сургалт, иргэдэд зориулсан “Хүүхдийг номоор хөгжүүлэхүй” сургалт зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулж чөлөөт уншлагын орон зайг танилцуулж номын сангийн үйл ажиллагаатай танилцан зөвлөн тусалж ажилласан. /92 номоор 363 ирцэд/
2. XI/08. Соёлын сарын хүрээнд Булган сумын ард иргэд, хүүхэд багачуудад зөөврийн номын сангийн үйлчилгээг хүргэж, шинэ ном хэвлэлийг танилцуулах, номын сангийн үйл ажиллагаатай танилцан зөвлөн туслаж ажилласан. /86 номоор 64 ирцэд/
 1. XII/9. Номгон суманд Номгон сумын Соёлын төвийн номын санд 2024 оны 12 дугаар сарын 9-ний өдөр зөөврийн номын сангийн үйлчилгээг хүргэн ажиллав. Бага ангийн сурагчдад чанга уншлага, ахлах ангийн сурагчдад номын тэмдэглэл хөтлөх сургалт зохион байгуулав. Номын санч Батзоригийн ажилд зөвлөн туслаж номын сангийн программ гэмтсэн байсныг засаж баазыг сэргээн хэвийн ажиллагаатай болгов.



Нэгдсэн болон нэг бүрчилсэн бүртгэл өдөр тутмын бүртгэлийн хөтөлгөө, номын ангиллуудад хяналт тавьж, Монголын үндэсний номын сан болон хандив тусламжаар хүрсэн номуудын бүртгэлийг шалгаж заавар зөвлөмж өглөө. Нийт 75 хүүхдэд 105 ном олгож үйлчлэв.

СОЁЛ ТАНИН МЭДЭХҮЙН АЖИЛ

Иргэд, хүүхэд залуучуудыг суралцаж, хөгжих, авьяас чадварыг нээн илрүүлэх,



чөлөөт цагийг соёлтой өнгөрүүлэхэд чиглэсэн 69 соёл танин мэдэхүйн ажлуудыг зохион байгуулж 38533 хүнийг хамрууллаа.

I/02-I/26. “Үлгэрч хүүхэд” уралдаан.

Үлгэрээр дамжуулан хүүхдэд зөв хүмүүжил, төлөвшил бий болгох, ардын уламжлалт ёс заншлыг өвлүүлэн үлдээх, амралт чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлж номоор дамжуулж ярих ур чадварыг эзэмшүүлэх зорилгоор Даланзадгад сумын бага, дунд ангийн сурагчдын дунд “Үлгэрч хүүхэд” уралдааныг зохион байгуулж нийт 50 сурагчид хамрагдсан байна. Уралдаанд оролцсон хүүхдүүд уншиж номын санчид ярьж өгөх, тэмдэглэл хөтлөх бүтээлч уншлагын үр дүнгээрээ өрсөлдсөн ба хүүхдийн ярих, унших, тэмдэглэл хөтлөх чадваруудыг хөгжүүлэхийн зэрэгцээ үлгэрээс үлгэрлэн суралцах боломжийг олгосон нь уралдааны гол үр дүн байлаа.

I/17. Чанга уншлага.Тусч уншигч хөтөлбөрийн хүрээнд "Ирээдүйн эзэд" номын клубийн гишүүдийн төлөөлөл Б.Бат-Ялалт, Б.Буяндэлгэр нар бяцхан дүү нартаа монгол үндэсний өв соёл, түүх, ёс заншлын тухай өгүүлэх Бумбардай "Аргалд явсан нь" номыг уншиж хүүхдүүдтэй харилцан ярилцаж мөн клубийн гишүүд өөрсдийн номын клуб болон анх ямар ном уншаад номд дуртай болсон талаараа яриа өрнүүлсэн. Нийт 15 хүүхэд.

I/26. “Миний Монгол ёс” номын хэлэлцүүлэг

“Цагаан сарын баяр”-ыг угтан Монголын уламжлалт ёс заншлыг хүүхэд багачуудад танин мэдүүлэх, анхны мэдэгдэхүүн олгох, амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор Хөгжлийн мэдээллийн танхимтай хамтран зохион байгуулсан “Миний Монгол ёс” номын хэлэлцүүлгийг нийт 17 хүүхдэд зохион байгуулав. Хэлэлцүүлгээр хүүхдүүд өөрсдийн сонгон уншиж мэдсэн монгол ёс заншлыг бие биедээ танилцуулж өөрийн мэдлэгээ бататгахын зэрэгцээ бусдын олж мэдсэнээс шинэ зүйлд суралцсанаараа онцлог байлаа.

II/21. “Зохиолын дараагийн хуудас”

Зөөврийн номын сангийн үйлчилгээгээр Даланзадгад сумын 5-р сургууль дээр уншлага үйлчилгээг хүргэн ажиллаж сурагчдын дунд “Зохиолын дараагийн хуудас”

үйл ажиллагааг зохион байгуулж хэлэлцүүлэг өрнүүлэн нийт 10 сурагчид хамрагдсан байна.

II/26-III/22. “Утга зохиол, төр нийгмийн нэрт зүтгэлтэн Сономын Удвал” сэдэвт илтгэлийн уралдаан



Утга зохиол, төр нийгмийн нэрт зүтгэлтэн Сономын Удвалын зохиол бүтээл Монголын түүхэнд оруулсан түүхэн гавьяа, үйл хэргийг бүх нийтэд сурталчлан таниулж дурсан хүндэтгэх зорилгоор аймгийн хэмжээнд 9-12-р ангийн сурагчид, насанд хүрэгчид гэсэн 2 насны ангиллаар зохион байгуулсан илтгэлийн уралдаанд 18 оролцогч материалаа ирүүлснээс 2-р шатанд ангилал тус бүрд 5 оролцогчийг шалгаруулав. 2-р шатны

шалгаруулалтыг Багш хөгжлийн ордны хурлын заланд сонирхогчид хүүхэд залуучуудыг сонсох боломжтойгоор зохион байгуулж 120 хүүхэд залуучууд үзэгч сонсогчоор оролцов.



II/28. “Хүүхдийг номоор хөгжүүлэхүй” сургалт

Цогтцэций сумын иргэдэд “Хүүхдийг номоор хөгжүүлэхүй” сургалтыг зохион байгуулж ном уншлагаар дамжуулан хүүхдийг хөгжүүлэх, хүүхэдтэйгээ ойлголцож халуун дотно холбоо тогтоох боломжийг танилцууллаа. Оролцогчдын тоо 150.



II/29. Кофетой уншлага

Номтой өглөө хөтөлбөрийн хүрээнд кофетой уншлага зохион байгууллаа. Нийт оролцсон хүүхдийн тоо-8



III/01. "Хүүхдээ сонсох өдөр"-ийн арга хэмжээ

Сар бүрийн эхний өдөр зохион байгуулдаг "Хүүхдээ сонсох өдөр"-ийн арга хэмжээг "Уншдаг хүүхэд хөгждөг" аяны хүрээнд зохион байгуулав. АЗДТГазрын дарга Ц.Амартөгсийг урин уншигч хүүхдүүдийн төлөөлөл 20 хүүхдийг оролцуулан хүсэл мөрөөдөл, дуу хоолойг нь аймгийн удирдлагуудад хүргэж ажиллалаа.

III/05-V/21. "Үлгэрийн цаг"

"Говийн ирээдүй хүүхэд" дэд хөтөлбөрийн хүрээнд "Үлгэрийн цаг" хөтөлбөрийг хэрэгжүүлэн долоо хоног бүрийн Мягмар гаригт Даланзадгад сумын Ахмадын чөлөөт холбоотой хамтран үлгэрээр дамжуулан хүүхдийг хөгжүүлэх үлгэр унших цаг үйл ажиллагааг зохион байгуулан 3 сургуулийн 7 ангийн 208 хүүхэд хамрагдаж үлгэрээс болон ахмадуудаас суралцлаа.



III/01-III/21. Уран уншлагын уралдаан

Дэлхийн яруу найргийн өдрийн хүрээнд хүрээнд Уран уншлагын уралдаан 2 үе шаттайгаар зохион байгуулсан эхний шатанд нийт 13 оролцогч оролцож 03-р сарын 15 наас 20 хооронд уран уншлагын бичлэгийг номын сангийн пэйж дээр байр байрлуулж цахим хандалтаар 2-р шатны 10 оролцогчийг шалгаргуулж сүүлийн шатыг 5-р баг дээр зохион байгууллаа. Шилдэг 10 оролцогчдоор

- 1-р байр Цогт-Овоо сумын Эрүүл мэндийн төвийн сувилагч Ш.Бадамсүрэн /Д.Пүрэвдорж Буурал эмээ шүлэг/
- 2-р байр СУГ-ын хяналт шинжилгээ, үнэлгээ статистик мэдээ хариуцсан мэргэжилтэн Б.Энхболд /Ш.Гүрбазар Би монголоороо гоёдог/
- 3-р байр Цогт -Овоо сумын иргэн Х.Жаргалмаа /О.Дашбалбар Залуус дүү нартаа хүргэх шүлэг/
- Тусгай байр Даланзадгад 10-р багийн иргэн Б.Бүжин /Мөнгөн шөнөөр/ шүлгээр тус тус шалгарсан. Энэхүү 2 шатны уралдаан, арга хэмжээнд нийт 65 хүн оролцсон.



III/06. Кофетой уншлага

Бүтээлч уншлага-хүүхдийн боловсролын хөтөлбөрийн хүрээнд 3-р сургуулийн Ц.Сайнзаяа багштай 10а ангийн хамт олны дунд кофетой уншлага хийж номын хэлэлцүүлэг зохион байгууллаа. Нийт оролцсон хүүхдийн тоо-30.



III/18. Номын тэмдэглэл хөтлөх сургалт 1-р сургуулийн Ариунбайгаль багштай 7д анги Номын тэмдэглэл хөтлөх сургалт зохион байгуулсан оролцсон хүүхдийн тоо-12

III/20. Номын тэмдэглэл хөтлөх сургалт 1-р сургуулийн Т.Эрдэнэсайхан багштай 7е анги Номын тэмдэглэл хөтлөх сургалт зохион байгуулсан оролцсон хүүхдийн тоо-13

III/21. "УТГА УЯНГА" яруу найргийн хэлэлцүүлэг

Дэлхийн яруу найргийн өдрийн хүрээнд "УТГА УЯНГА" яруу найргийн хэлэлцүүлэг зохион байгууллаа. Уг Хэлэлцүүлэгт Урилгаар: МЗЭ -ийн Өмнөговь аймаг дахь салбарын зохиолч яруу найрагчид нар болон ЕБСургуулиудын шүлэг, яруу найраг сонирхогч сурагчид оролцлоо. Найрагчид өөрсдийн шүлгээс дээжлэн уншиж мөн сурагчид зохиосон шүлгээсээ уншиж шүлэг яруу найраг бичих зөвлөгөө, зөвлөмж авч зохиол бүтээлийн халуун дотно яриа өрнүүлсэн уулзалт боллоо. Нийт 17 хүн оролцсоноос сурагчдын дунд азын сугалаа явуулснаас 7-р сургуулийн 10а ангийн сурагч Б.Шижирболд номын багцын азтан боллоо.



III/22. "30 НОМ УНШЪЯ" асуулт хариултын тэмцээн

Зөөврийн номын сангийн үйлчилгээгээр Эрдмийн гэгээ 2-р сургууль дээр 8-10-р ангийн сурагчдын дунд "30 НОМ УНШЪЯ" асуулт хариултын тэмцээнийг зохион байгууллаа. Нийт 8 сурагч оролцсоноос хамгийн олон асуултад хариулж амжилттай оролцсон 11Б ангийн сурагч Ж.Батсүрэн, Т.Нямбаяр нар шалгарч номын багцаар шагнаж урамшууллаа.

III/22. "Хэн хамгийн олон шүлэг мэдэх вэ" тэмцээн

Зөөврийн номын сангийн үйлчилгээгээр Даланзадгад сумын 2-р сургууль дээр уншлага үйлчилгээг хүргэн ажиллаж сурагчдын дунд ангийн сурагчдын "Хэн хамгийн олон шүлэг мэдэх вэ" тэмцээнийг зохион байгуулж нийт 15 сурагчид хамрагдсан байна.



IV/02-IV/19. "Цондоолой Цүндээлэй хоёр" гар зургийн уралдаан.

Дэлхийн хүүхдийн номын өдөр болон Динза ба Цондоолойгийн найзуудын өдөрлөг арга хэмжээний хүрээнд 2-4-р ангийн сурагчдын дунд "Цондоолой Цүндээлэй хоёр"

гар зургийн уралдааныг зохион байгуулж нийт 58 сурагчдын бүтээл ирснээс 1-4 байрыг шалгаруулан Динза брэндийн гарын бэлгээр шагнаж урамшууллаа.

IV/02-IV/19. “Динза ба Цондоолой Цүндээлэй хоёр” номын тэмдэглэлийн уралдаан

Дэлхийн хүүхдийн номын өдөр болон Динза ба Цондоолойгийн найзуудын өдөрлөг арга хэмжээг угтан 5-7-р ангийн сурагчдын дунд “Динза ба Цондоолой Цүндээлэй хоёр” номын тэмдэглэлийн уралдааныг зохион байгуулж нийт 13 сурагчид номын тэмдэглэлээ ирүүлж оролцлоо.



IV/09. “Хүүхдийг номоор хөгжүүлэхүй” сургалт

"Стандарт, хэмжилзүйн хэлтэс"-ийн хамт олонд “Хүүхдийг номоор хөгжүүлэхүй” сургалтыг зохион байгуулж номоор дамжуулан хүүхдийн авьяас чадвар, оюун ухааныг хөгжүүлж, хүүхдээ ойлгох, холбоо тогтоох, харилцах боломжийг танилцууллаа. Оролцогчдын тоо 22.

IV/20. “Динза ба Цондоолой Цүндээлэйгийн найзууд” өдөрлөг

Нутгийн хишиг хөтөлбөрийн Говийн-Ирээдүй хүүхэд дэд хөтөлбөрийн хүрээнд Ирмүүн агентлагтай хамтран хүүхдийн уншлагын танхимд бага ангийн сурагчдыг номтой нөхөрлөхөд хамгийн их нөлөө үзүүлж буй Динза ба Цондоолой



Цүндээлэй хоёр комик цувралуудыг хүүхдүүдэд хүргэх, уншсан хүүхдүүдээ урамшуулах зорилгоор “Динза ба Цондоолой Цүндээлэйгийн найзууд” өдөрлөг арга хэмжээг Даланзадгад сумын ЕБС-ийн 200 гаруй хүүхдүүдийн дунд зохион байгууллаа.

IV/15. “Хүүхдийг номоор хөгжүүлэхүй” сургалтыг "Төрийн банк"-ны 25 ажилтан, ажиллагсадд зохион байгуулж хүүдийн уншлага, хүүхдийн хөгжлийг дэмжин ажиллахыг уриаллаа.

IV/23. Чанга уншлага

Тусч уншигч номын сангийн боловсролын хөтөлбөрийн хүрээнд "Ирээдүйн эзэд" номын клубийн гишүүдийн төлөөлөл Т.Хишигсүрэн, Ц.Ариунхүслэн нар цэцэрлэгийн бяцхан дүү нартаа Хормогчин театрын ГУРВАН ТООРОЙ үлгэрийг ярьж чанга уншлага зохион байгуулав. Оролцогч 30 хүүхэд



IV/24. "Өглөөний кофетой уулзалт хэлэлцүүлэг"

НОМТОЙ ӨГЛӨӨ-бүх нийтийн соёлын боловсрол хөтөлбөрийн хүрээнд номын сангийн дэргэдэх "Ирээдүйн эзэд" номын клубийн сурагчид болон ном унших сонирхолтой уншигч хүүхдүүддээ "Өглөөний кофетой уулзалт хэлэлцүүлэг" зохион байгууллаа. Оролцогч 13 хүүхэд

IV/25. "Номоо эмчилье" үйл ажиллагаа

Тусч уншигч номын сангийн боловсролын хөтөлбөрийн хүрээнд 3-р сургуулийн Ц.Сайнзаяа багштай 10а ангийн төлөөлөл сурагчид "НОМОО ЭМЧИЛЬЕ" үйл ажиллагаанд Нийтийн уншлагын танхим болон Гэрээр ном олгох танхимуудын урагдаж гэмтсэн номуудад сэлбэн засалт хийлээ. Нийт 4 хүүхэд



IV/22-V/2. "БИДНИЙ БАХАРХАЛ-МОНГОЛ БИЧИГ" хичээнгүй, цэвэр бичлэгийн уралдаан.

Үндэсний утга соёлын нандин өв болсон монгол бичгийг хойч үедээ өвлүүлэн уламжлуулах, сурталчлах, иргэд, төрийн албан хаагчид, хүүхэд багачуудын монгол бичгийг сурч эзэмших идэвхийг дэмжих зорилгоор "Бидний бахархал-Монгол бичиг" хичээнгүй, цэвэр бичгийн уралдааныг Өмнөговь аймгийн иргэд, хүүхэд, залуучуудын дунд 3 насны ангиллаар зохион байгуулсан. Д.Нямсүрэнгийн "Дөрвөн цаг" шүлгийг монгол бичгээр хөрвүүлэн сайхан бичиж оролцсон. Уралдаанд төв

ХИЧЭЭНГҮЙ, ЦЭВЭР БИЧЛЭГИЙН УРАЛДААН

ХАМРАХ ХҮРЭЭ: Өмнөговь аймгийн иргэд, хүүхэд, залуучууд
УРААДААНЫ АНГИАЛАА: Уралдаан 3 насны ангиллаар явагдана.
• ЕБС-ийн 7-9-р ангийн сурагчид
• ЕБС-ийн 10-12-р ангийн сурагчид
• Насанд хүрэгчид
УРААДААНД ОРОЛЦОХ:
Д.Нямсүрэнгийн "Дөрвөн цаг" шүлгийг монгол бичгээр хичээнгүй, цэвэр бичиж ирүүлэх.
ТАВИГАХ ШААРДАГА:
• А4 цахилга хөтгөр байрлуулан захаас 1 см зайг суя үлдээн хүрээ татаж зүүн талыг хүрээлж, дотоон 2.5 см өргөнтэй зай суя (Уг зийд сумсүрүүл анх, онов иэрийг монгол бичгээр бичих) үлдээж эх бичвэрээ бичнэ.
• Үндсэн эхний бичвэрдээ үзэг болон тосон бэл ашиглан бичнэ
ШААГАРУУЛААТ: Ирүүдсэн бичвэрүүдээс
• Хичээнгүй бичгийн ээлбэр, хармаа, жонд байдал,
• Бүтээмж байдал,
• Алдлагүй зөв зориулсан бичсэн байдал зэргийг харгалзан мөргөжлийн багш нараас бүрэлсэн баг шүүж ангилаа тус бүрд шалдга. 4 бичвэрийг байр хэмүүлэх
МАТЕРИАЛ ХҮАЭЭН АВАХ:
Бичвэрийг 2024 оны 5-р сарын 2-ны өдрийн 16:00 цаг хүртэл Төв номын сангийн байранд хүлээн авна.



хөдөөгийн 9 сургуулийн 170 сурагчдын болон иргэд, төрийн албан хаагчдын 30 гаруй хичээнгүй цэвэр бичгийн бүтээл ирүүлсэн.

Хичээнгүй, цэвэр бичгийн уралдааны шүүгчээр Ахмад багш Ч.Цоодол /Монгол хэлний багш/, Л.Цэцэгмаа /Хэлний бодлогын салбар зөвлөлийн/ нар ажиллаж, шилдэг бичвэрүүдийг шалгарууллаа.

Насанд хүрэгчдийн төрөлд

- 1-р байр Манлай сумын эрүүл мэндийн төвийн ажилтан Б.Түвшиншишиг
- 2-р байр 4-р сургуулийн багш Б.Отгонжаргал
- 3-р байр ШУТИС-ийн 1-р курсийн оюутан Ж.Энхсүвд
- Тусгай байр УЦУОШТ-ийн ажилтан Э.Оргодол

7-9-р ангийн төрөлд

- 1-р байр Манлай сумын ЕБС-ийн 9а ангийн сурагч Б.Хүслэн
- 2-р байр Манлай сумын ЕБС-ийн 8б ангийн сурагч М.Мөнгөнзул
- 3-р байр 1-р сургуулийн 9а ангийн сурагч А.Цэцэнбэлэг
- Тусгай байр 2-р сургуулийн 8а ангийн сурагч О.Мөнхжин

V/02. “МОНГОЛ БИЧГИЙН ЦАХИМ БИЧВЭР”-ийн уралдаан

Монгол бичгийн цахим хэрэглээг нэмэгдүүлэх, монгол бичгээр цахим бичвэр боловсруулах ур чадварыг дээшлүүлэх зорилгоор “Монгол бичгийн цахим бичвэр” уралдааныг Даланзадгад сумын төрийн албан хаагчид, иргэдийн дунд зохион байгуулсан. Уралдаанд 13 байгууллагын 18 оролцогч бүртгүүлэн оролцсоноос

- 1-р байр ХГБХХГ-ын мэргэжилтэн Г.Нандинцэцэг
- 2-р байр 4-р сургуулийн багш Б.Отгонжаргал
- 3-р байр ХГБХХГ-ын мэргэжилтэн Б.Батцэцэг
- 4-р байр Говийн байгаль, түүхийн музей Н.Оюун нар тус тус шалгарлаа



V/8. “Үндэсний бичиг үсгийн баяр”



2024 оны “Үндэсний бичиг үсгийн баяр”-ын үйл ажиллагааг аймгийн Засаг даргын Тамгын газар дэмжлэгтэйгээр “Говийн ирээдүй-хүүхэд” хөтөлбөрийн хүрээнд үндэсний өв болсон монгол бичгээ иргэн бүр чанартай эзэмших, хэрэглэж хэвших талаар нийтэд чиглэсэн олон талт арга хэмжээг зохион байгуулж, хүүхэд залуучуудад үндэсний бичгээ сурах хүсэл сонирхол төрүүлэх, сурах эрмэлзэлд нь дэмжлэг үзүүлэх зэргээр өргөн олонд хүртээлтэй ажил өрнүүлэн төв хөдөөгийн 1112 иргэд хүүхэд залуучуудыг хамрууллаа.

V/10. “Номын хэлэлцүүлэг”

Хүүхдийн зохиолч Э.Амарзаяагийн Сонгогдоогүй краш, Миний херо, Манай гэрийн нууц номуудыг сонгон сурагчид маань баг болон хуваагдаж номын хэлэлцүүлэгт сонирхолтой байдлаар амжилттай оролцлоо. 31 хүүхэд **V/17. “Өглөөний уулзалт”**

Үндэсний номын баярын хүрээнд Үлгэрийн цаг хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлсэн 8 ахмад болон зохион байгуулагч хийсэн Д.Мядагсүрэн, ахмадын холбооны дарга Энхчимэг нарыг урьж “Өглөөний уулзалт”-ыг зохион байгуулан хүүхэдтэй ажилласан сэтгэгдэл, хүүхдийг номоор хөгжүүлэхэд эмээ, өвөөгийн оролцоо, цаашдын хамтын





ажиллагааны талаар ярилцан, талархал илэрхийлэн дурсгалын зүйлээр урамшууллаа.

V/17. Үндэсний номын баяр-2024 “Оюуны чихэр” азтантай сугалаа

Үндэсний номын баяр-2024 “Оюуны чихэр” азтантай сугалааг нийт 156 хүүхэд, насанд хүрэгчид 239 хүн оролцож азтанаар тодорсон оролцогчдыг номын багцаар шагнаж урамшуулав.

V/17. НОМЫН БАЯР-2024 АХА танин мэдэхүйн тэмцээн

Номын баярт оролцогч хүүхдүүдийн дунд ном, зохиолын сэдэвт АХА танин мэдэхүйн тэмцээнийг зохион байгуулж 64 хүүхэд оролцсоноос

1-р байр Л.Амар-Амгалан (1-р сургууль 8а анги)

2-р байр Б.Тэмүүлэн (1-р сургууль 8а анги) нар шалгарч номын багцаар шагнууллаа.

V/17. Номын баяр

Өмнөговь аймаг нь бүх нийтийн уншлагыг дэмжих, номын сангийн өв санг арвижуулах, хүүхэд залуусын сурах эрмэлзэлд дэмжлэг үзүүлэх, ном эрдмийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор номын баярын арга хэмжээг зохион явууллаа. Энэ жилийн номын баяр арга хэмжээг “Уншдаг хүүхэд хөгждөг-Илүү их уншъя” уриатайгаар зохион байгуулагдлаа.

35 дахь удаагийн Номын баярын нээлтийн арга хэмжээ Даланзадгад сумын ЕБСургуулиуд, СӨБоловсролын байгууллагуудын “Уншдаг хүүхэд хөгждөг” хөтөлбөрийн хүрээнд хүүхдийг номоор дамжуулан хөгжүүлэхэд зориулан хийсэн бүтээлүүдээрээ үзэсгэлэн гаргаж нийтэд танилцууллаа. Өмнөговь аймгийн хувьд “УНШДАГ ХҮҮХЭД ХӨГЖДӨГ” аяныг 2 дахь жилдээ зохион байгуулж байна. Аяны хүрээнд идэвхтэй оролцсон шилдгүүдийг шалгаруулан ном авах эрхийн бичгээр шагнаж урамшууллаа.

Номын үзэсгэлэн

- ✓ “Хүүхдийг номоор хөгжүүлэхүй” сэдэвт номын үзэсгэлэн 116 номоор гаргаж 156 хүн үзэж танилцав.
- ✓ Гэрээр ном олгох танхимаас шинэ номын үзэсгэлэнг 100 номоор гаргаж 246 хүн үзэж танилцав.
- ✓ “Уншдаг хүүхэд хөгждөг” аянд шалгарсан сургууль, цэцэрлэгийн номын сангууд хүүхдийг номоор хөгжүүлж буй туршлага үзэсгэлэн гарган нийтэд танилцуулав.

Шилдэг уншигч байгууллага хамт олныг шагнаж урамшуулав.

Цэргийн гавьяаны одонт хилийн цэргийн 0131-р ангийн номын санч Д.Алтантуяа нь хамт олон болон цэргийн алба хаагчдад Гэрээр ном олгох танхимаас зөөврийн номын сангийн үйлчилгээг хүргэн ажилдаг. Хагас жилийн байдлаар 12 удаагийн давтамжтайгаар 960 номыг 578 ирцэд хүргэн ажиллаж бусад байгууллагуудаас шалгарч Шилдэг байгууллага хамт олон болж өргөмжлөл номын багцаар шагнаж урамшууллаа

Шилдэг уншигч сурагчдыг шагнаж урамшуулав.

Өдөр бүр номтой нөхөрлөн өөрийгөө хөгжүүлсэн Шилдэг сурагчдыг Тэргүүний уншигч Д.Нацагдорж тэмдэг болон номоор шагнаж урамшууллаа.

- ✓ Б.Даваасамба (7-р сургууль 11б анги)
- ✓ С.Ууганзаяа (3-р сургууль 10б анги)
- ✓ Л.Хурцэцэг(4-р сургууль 4а анги)
- ✓ Б.Одбаяр(4-р сургууль 6б анги)
- ✓ Б.Баясгалан (4-р сургууль 10а анги)
- ✓ О.Хүсэлцэцэг (3-р сургууль 10а анги)
- ✓ М.Энх-Үйлс (2-р сургууль 8б анги)
- ✓ Ж.Батхуяг (Гурван тэс сум 8б анги)
- ✓ О.Үүрийнтуяа(Гурван тэс сум 10а анги)
- ✓ Ч.Мандуухай (Булган сум 8а анги)

Ном бид 2 номын хэлэлцүүлэг

"НОМ БИД ХОЁР" номын хэлэлцүүлгийг 2 дахь жилдээ амжилттай зохион байгуулж байна.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ маань Номонд дурласан, ном амьдралыг нь өөрчилсөн, ном сэтгэлийг нь хөглөсөн тийм л хүмүүс уулзалтдаа ирлээ

Өөрийн унших дуртай номоо өөр өөрийнхөө өрнөл төсөөлөл, сэтгэл хөдлөл, эмоциор уншсан сэтгэгдлээсээ бусад уншигчдад танилцуулан, хэлэлцүүлэг өрнүүлэн дүгнэн ярилцах журмаар явагдсан.

Үлгэр унших цаг өглөөлөг уулзалт

"Говийн ирээдүй хүүхэд" аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд "Ахмадын чөлөөт холбоо"-той хамтран Монгол өв соёл, зан заншлаас суралцуулах, номоор дамжуулан танин мэдэхүй, хэл яриаг хөгжүүлэх зорилготой "ҮЛГЭР УНШИХ ЦАГ" үйл ажиллагааг Даланзадгад сумын ЕБС-ийн 1 дүгээр ангийн бяцхан сурагчдад зориулан Хүүхдийн уншлагын танхимаас амжилттай зохион байгуулж нийт 8 ангийн 199 хүүхдүүд хамрагдаж энэхүү үйл ажиллагаанд хамтран ажилласан ахмадуудаа хүндэтгэн урьж "ҮЛГЭР УНШИХ ЦАГ" өглөөлөг уулзалтыг зохион байгууллаа. Анги хамт олноороо хүрэлцэн ирж үлгэр сонссон хүүхдүүдийн төлөөлөл үлгэр домог уншиж өгсөн ахмадууддаа сэтгэлийн үгээ бичлэг болгон ирүүлснийг үзүүлж, дурсамж яриа өрнүүллээ.

Дундговь аймгийн номын сан туршлага судлах уулзалт

Номын баярын хүрээнд Нацагдоржийн нэрэмжит Дундговь аймгийн нийтийн номын сантай туршлага солилцон хамтран ажиллах уулзалт арга хэмжээг өрнүүллээ.

Сайн туршлага хуваалцах хэлэлцүүлэг

Уншдаг хүүхэд хөгждөг аяны "Сайн туршлага хуваалцах хэлэлцүүлэгт" дараах эрхмүүдийг урин оролцууллаа.

- ✓ Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Ц.Бадамцэрэн
- ✓ ИТХ-ын төлөөлөгч Б.Чинбат

- ✓ Цогтцэций сумын 30-р цэцэрлэгийн эрхлэгч А.Шинэсар
- ✓ Цогтцэций сумын 2-р сургуулийн номын санч Д.Оюун-Эрдэнэ
- ✓ 7-р сургуулийн 11б ангийн сурагч Б.Даваасамба
- ✓ Даланзадгад сумын 2-р сургуулийн 5б ангийн багш Ч.Амарбаясгалан
- ✓ 1-р сургуулийн 12в ангийн сурагч Э.Гэрэлдэлгэр нар өөрсдийн ном унших сайн туршлагаасаа хуваалцлаа.

Дүгнэлт: Оролцогчид чиглүүлэгчийн тавьсан асуултад 3 минутын хугацаанд хариулсан бөгөөд “Уншдаг хүүхэд хөгждөг” аяны хүрээнд өөр өөрийн салбар тус бүрийн хийж хэрэгжүүлж байгаа ажил, үр өгөөжийн тухай мэдээлэл хүргэв. Хэлэлцүүлгийн оролцогчдын мэдээллийг товч байдлаар хүргэвэл.

- Уншдаг хүүхэд хөгждөг аян урт хугацааны турш хэрэгжих боломжтой
- Уншдаг аймаг болгон өргөжүүлэх саналтай
- Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад “Уншдаг хүүхэд хөгждөг” аяныг зохион байгуулахад сонсдог номыг түлхүү ашигладаг
- Анги хамт олноороо өдөр бүр хуваарь гарган унших нь их үр дүнтэй
- “Уншдаг хүүхэд хөгждөг” аян өрнөснөөр сургуулийн номын сангаар үйлчлүүлдэг хүүхдүүдийн тоо 2 дахин нэмэгдсэн
- Аян хүрээнд сургуулийн номын сангийн үйл ажиллагаа өглөө 08:00-19:00 цагийн хуваарьт шилжсэн
- Гадаад дотоод руу аяллаар явахдаа хүүхдүүдээ ном авч ирж бэлэглэх соёлыг түгээн дэлгэрүүлэх шаардлагатай
- Англи хэл сурахад ном унших аргаар суралцах нь илүү дөхөм байдаг.
- Өрх гэр бүр номын сантай байхыг уриалах нь зүйтэй
- Одоогийн залуучууд, өсвөр насны сурагчид уран зохиолын ном уншин сонирхолтой байгаа

Уншдаг хүүхэд хөгждөг аян

“Уншдаг хүүхэд хөгждөг” ном уншлагын аянд аймгийн 31 цэцэрлэг, 22 сургууль, 1 коллеж 100% хамрагдсан бөгөөд түүгээр дамжуулан боловсролын байгууллагууд, сургуулийн номын сангаас сургуулийн өмнөх боловсролын үндсэн бүлгийн 6399 хүүхэд, ерөнхий боловсролын сургуулийн 16366 суралцагч болон тэдний эцэг эхчүүдэд чиглэсэн номын ач тусыг таниулах, номоос суралцах соёлыг түгээн дэлгэрүүлэх олон талт арга хэмжээг зохион явуулж, багш, суралцагч, хамт олон, эцэг эх, асран хамгаалагч, иргэдийг хамруулан ажилласан.

“Уншдаг хүүхэд хөгждөг” аяны тайлангийн арга хэмжээг Үндэсний номын баярын өдрөөр тэмдэглэн өнгөрүүлсэн бөгөөд шалгарсан байгууллагуудад тэргүүн байр 4.0 сая төгрөг, дэд байр 3.0 сая төгрөг, гутгаар байр 2.0 сая төгрөг, тусгай байр 2 – 1.0 сая төгрөгийн ном авах эрхийн бичгээр тус тус шагнаж, урамшуулав.

Шилдэг сургуулийг шагнав:

- 1-р байр Даланзадгад сум 4-р сургууль
- 2-р байр Цогтцэций сум 1-р сургууль
- 3-р байр Даланзадгад сум 3-р сургууль
- Тусгай байр Номгон сумын ерөнхий боловсролын сургууль
- Тусгай байр Даланзадгад сум 7-р сургууль

Шилдэг цэцэрлэгийг шагнав:

- 1-р байр Цогтцэций сум 30-р цэцэрлэг
- 2-р байр Цогт-Овоо сум 12-р цэцэрлэг
- 3-р байр Даланзадгад сум 26-р цэцэрлэг
- Тусгай байр Даланзадгад сум 2-р цэцэрлэг
- Тусгай байр Даланзадгад сум 11-р цэцэрлэг тус тус шилдгээр шалгарлаа.



VI/27-VI/6. "Англи хэлний сургалт"

Тусч уншигч хөтөлбөрийн хүрээнд Улсын тэргүүний лаборатори 1-р сургуулийн 12в ангийн сурагч Э.Гэрэлдэлгэр "Англи хэлний сургалт"-ыг сурагчдад зориулан зохион байгуулж 10 сурагч хамрагдлаа.

"МИНИЙ НОМЫН САН" гар зургийн уралдаан

Эх үрсийн баярыг тохиолдуулан "МИНИЙ НОМЫН САН" гар зургийн уралдааныг ЕБС-ийн 5-8 дугаар ангийн сурагчдын дунд зохион явууллаа. Уралдаанд нийт 13 бүтээл ирснээс шагналт байранд:

- 1-р байр 3-р Сургууль 7в ангийн сурагч Ц.Ариунхүслэн
- 2-р байр 1-р сургууль 6г ангийн сурагч С.Амирлан
- 3-р байр 3-р сургууль 7а ангийн сурагч Б.Анударь
- Тусгай байр 5-р сургууль 7г ангийн сурагч М.Уянгалянхуа нар шалгарлаа. Оролцсон хүүхдүүдийн зургийг Номын өргөө бяцхан гэрт Хүүхдийн баяраар сурталчлан 151 хүүхдэд хүргэв. Уралдааныг зохион байгуулснаар хүүхдийн авьяас чадварыг дэмжин номын сан, ном уншихын ач холбогдлыг хүүхдээр дамжуулан сурталчлав.

VI/01. Хүүхдээ сонсох өдөр арга хэмжээ

Арга хэмжээг байгууллагын ажиллагсдын хүүхдүүдийн дунд зохион байгуулж ээжүүдийнх нь ажлын онцлогийг танилцуулан, хүсэл мөрөөдлийг сонсон номтой бэлэг гардуулав. Оролцогч 15 хүүхэд.

VI/01. "Хөгжсөн хүүхэд-хамгаалагдсан ирээдүй" өдөрлөг

- "Ноён талхны үсний газар" асрыг ХААН банк болон 26-р цэцэрлэгийн хамт олонтой хамтран ажиллуулж олон олон сонирхолтой бэлгүүдээр хүүхдүүдээ баярлууллаа.

- “Оюуны чихэр” азтан шалгаруулж нийт 186 хүүхэд, багачууд оролцож, 30 азтан шалгарсан.



- Номын сангийн асрыг тохижуулан зохиолын баатрууд болон баярын мэндчилгээгээр чимэглэсэн зураг авхуулах орчныг бүрдүүлэн хүрэлцэн ирсэн хүүхдүүдийн хүүхдийн баярын мэндчилгээ дэвшүүлж дуу дуулах, шүлэг унших, спортын үзүүлбэрүүдийг бусад хүүхдүүдэд хүргэн дурсгалын зүйлээр урамшуулав.
- “Хүүхдийг номоор хөгжүүлэхүй” номын үзэсгэлэн гаргаж эцэг эхчүүдэд танилцуулав.
- Хүүхдийн номын худалдаа зохион байгуулж хүүхдээ номоор урамшуулж баярлуулахыг уриаллаа.

VI/07. Тунгалаг улирал номын нээлт

МЗЭ болон МУЗЭ-ийн гишүүн Г.Сэр-Одын нэрэмжит Д.Нямсүрэнгийн хишигт яруу найрагч, зураач Төмрийн Батхүрэлийн 4 дэх ном болох "ТУНГАЛАГ УЛИРАЛ" номын нээлтийг хамтран зохион байгуулав. /Оролцогчдын тоо 32/

VII/27. “Дээлтэй монгол наадам”

Ардын хувьсгалын 103 жилийн ой, Батмөнх даян хааны мэндэлсний 560 жилийн ой, Өмнөговь аймаг байгуулагдсаны 93 жилийн ой, Говийн бүсийн хурдан морины уралдаан “Говь Шанх-7” наадмыг тохиолдуулан Монгол үндэсний соёлын өв үндэсний хувцас, эдлэл хэрэглэлийг өмсөж эдлэх соёлыг түгээн дэлгэрүүлэх, өвлөн уламжлуулах, үндэсний бахархлыг дээдлэх, сурталчлан таниулах зорилгоор Өмнөговь аймгийн иргэд, хүүхэд залуучуудын Дээлтэй Монгол наадам 2024 арга хэмжээг 7 дугаар сарын 27-ны өдөр Ажнай талбайд зохион байгууллаа.

Дээлтэй Монгол наадмыг аймгийн Соёл, урлагийн газар, ГБХЗХГазар, ХЖТеатр, Говийн байгаль, түүхийн музей, Төв номын сангийн хамт олон хамтран зохион байгуулсан. Наадмыг нээж Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Ц.Бадамцэрэн үг хэлж оролцогчдод амжилт хүсэж, аймгийн Хөгжимт жүжгийн театрын залуу уран бүтээлчид урлагийн үзүүлбэрээр наадамчин олонд ая дууны мэнд хүргэсэн. Наадмын сурталчилгаа мэдээллийг цахим хэлбэрээр 2 төрлийн постер бэлтгэн хийж бүртгэлийг аймгийн Төв номын сан дээр

07 дугаар сарын 23-25-ны өдрүүдэд явуулж нийт **447** оролцогчдод Мандат, баг хамт олны төрөлд оролцогчдод жагсаалын пайз олгох ажлыг зохион байгууллаа.



VIII/07-VIII/20. Компьютерын сургалт

“Мэдээллийн боловсролын хөтөлбөр”-ийн хүрээнд сурагчдын зуны амралтад зориулсан цахим ур чадвар дээшлүүлэх, компьютерын анхан шатны мэдлэг олгоход чиглэсэн сургалтыг зохион байгууллаа. Энэхүү сургалт нь 2 долоо хоногийн турш Даваа-Баасан гарагийн хооронд үргэлжилж Microsoft office хэрэглээний программын Word болон Power Point-ын мэдлэг олгох хичээлүүд хөтөлбөрийн дагуу явагдлаа. Тус сургалтад **6** хүүхэд бүртгүүлж хамрагдлаа.

VIII/12-VIII/23. “Ирээдүйн эрдэмтэн” боловсролын хөтөлбөр

Сурагчдын зуны амралтад зориулан ирээдүйн мэргэжлээ сонгох, зорилгоо тодорхойлоход дэм болох зорилгоор Хүүхдийн уншлагын танхимын номын санч Г.Ренчиндаваа, Каталогч М.Баасанжав нар хамтран “Ирээдүйн эрдэмтэн” хөтөлбөрийн хүрээнд “Сансар огторгуй ба Одон орон судлал” сургалтыг Даланзадгад сумын ЕБСургуулиудын 4-7 дугаар ангийн сурагчдын дунд зохион байгуулж 11 хүүхэд бүртгүүлснээс 5 хүүхэд амжилттай суралцаж төгсгөн Батламж гардуулан дурсгалын зүйлээр урамшуулав. Энэхүү сургалтад “Тусч уншигч” хөтөлбөрийн хүрээнд одон орон сонирхогч, Өмнөговь аймгийн Одон орон



сонирхогчдын клубийн гишүүн Б.Буяннэмэх оролцож суралцагчдад сонирхолтой туршлага, танин мэдэхүйн олон асуултад хариулт өгөв.

IX/16-IX/20. Үндэсний бичиг соёл номын өдрүүд

“Үндэсний бичиг соёлоо эрхэмлэн дээдэлъе” уриа дор үндэсний бичиг соёлыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, бүх нийтээр ном уншихыг уриалан зохиол бүтээлийг сурталчлан номын сангуудын сан хөмрөгийг баяжуулах зорилгоор “Нутгийн хишиг” хөтөлбөрийн хүрээнд Аймгийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн А/1637 тоот захирамжийн дагуу 2024 оны намрын арга хэмжээг Өмнөговь аймгийн иргэд хүүхэд залуучуудын дунд 09 дүгээр сарын 16-22-ны өдрүүдэд өргөн хүрээнд зохион байгууллаа. Нийт **6620** иргэд, хүүхэд залуучуудыг энэ удаагийн номын баярт хамрууллаа.

АЗДТГазрын Нийгмийн бодлогын хэлтэс, Боловсрол, шинжлэх ухааны газар, Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар, Буянт хотхон УТУГазар,Төв



номын сангийн албан хаагчид хамтран зохион байгууллаа.

2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр Батмөнх Даян хааны талбай, Нутгийн удирдлагын ордонд номын баярын нээлтийн арга хэмжээг зохион байгуулж Өмнөговь аймгийн Засаг даргын орлогч Ц.Дэнээдорж нээн үг хэлж амжилт хүслээ.Нээлтийн үйл ажиллагаанд **200** гаруй иргэд оролцож номын баярт хамрагдлаа. Авьяаслаг сурагчдын урлагийн үзүүлбэрээр үргэлжилсэн нээлтийн арга хэмжээнд Хүүхдийн ордны дууны дугуйлангийн сурагчид “Миний ном” дуугаар, Хүүхдийн ордны дэргэдэх ардын болон чөлөөт бүжгийн дугуйлангийн “Гэрэлт-Ирээдүй-2” хамтлагийн сурагчид “Хөхөө Намжил” Монгол ардын бүжиг, Даланзадгад сумын ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын “Флаш моб” бүжгээр хурсан олны сонор, мэлмийг мялаалаа.

Нээлтийн өдөр Нутгийн удирдлагын ордонд дараах үйлчилгээ, үйл ажиллагаануудыг зохион байгуулж иргэдэд хүргэлээ.

- Номын сангийн шинэ номын үзэсгэлэн
- “Нутгийн түүх” сэдэвт номын үзэсгэлэн
- “Номоо солилцъё” шинэ, хуучин номын худалдаа, солилцоо
- “Нацагдорж тэмдэгт” тэргүүний уншигч хүүхдүүдэд шагнал гардуулах үйл ажиллагаа
- “Тэргүүний уншигч хүүхэд” уншигчдын уулзалт зөвлөгөөн
- Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжсэн төрөл бүрийн материалаар хийгдсэн

номын баринтаг, хавчуурга, ном уншихад зориулагдсан хэрэглэгдэхүүний үзэсгэлэн зэрэг арга хэмжээг зохион байгууллаа. Номын баярын үйл ажиллагаанд урилгаар Монголын зохиолчдын эвлэлийн шагналт “Болор цом”-ын эзэн яруу найрагч Ш.Лхамноржмаа, МЗЭ-ийн шагналт яруу найрагч, сэтгүүлч, цаасан хайчилбар урлаач Ц.Галбадрах, Г.Сэр-Одын шагналт яруу найрагч Т.Батхүрэл, яруу найрагч



МУСТА Б.Баярмөнх, англи хэлний "Глобал паспорт" сургалтын төвийн багш А.Баттуулнар оролцлоо.



Номын сангийн шинэ номын үзэсгэлэн

Номын сангийн сан хөмрөгт шинээр ирсэн номуудаа иргэддээ сурталчлах, танилцуулах зорилгоор Хүүхдийн уншлагын танхим, гэрээр ном олгох танхим, хөгжлийн мэдээлэл сургалтын төвийн англи хэл дээрх номууд үзэсгэлэн гаргаж танилцууллаа. Мөн Үндэсний бичиг соёлоо түгээн дэлгэрүүлэх, монгол бичгээр хэвлэгдсэн ном хэвлэлээр номын сангийн сан хөмрөгийг баяжуулах Аймгийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн А/1580 тоот захирамжийн дагуу 3 сая төгрөгөөр 63 нэр төрлийн 134 ширхэг монгол бичгээр бичигдсэн номуудаар сан хөмрөгөө баяжуулсан. Энэхүү номуудаар “Эх хэл мину” сэдэвт үзэсгэлэн гаргаж танилцууллаа. Нийт 291 ширхэг номоор гарган **607** хүнд хүргэн үйлчиллээ.



“Нутгийн түүх” номын үзэсгэлэн

Манай номын сангийн орон нутгийн тусгай сан хөмрөгт Өмнөговь аймгийн түүхэнд холбогдох чухал ном, лавлагааны материалууд болох аймаг, сумд байгууллагууд болон хувь хүн, ураг удмын түүх, Өмнөговь аймгийн зохиолчдын зохиол бүтээл, аймагт хэвлэгдсэн номууд, орон нутгийн анхны сонин Говийн мэдээ сонин хадгалагдаж байдаг ба уншигч, үйлчлүүлэгчид, түүхэн ном, зохиол бүтээл бичих хүмүүсийн хамгийн их ашигладаг уг лавлагааны сан хөмрөгийг жил бүр түүхэн ном, бүтээлээр баяжуулдаг уламжлалтай. 2024 онд Төв номын сангийн түүхт 80 жилийн ой тохиож буйтай холбогдуулан орон нутгийн сан хөмрөгийг сумд, байгууллагуудын түүхэн ном, бүтээлээр баяжуулах ажлыг зохион байгуулж

холбогдох байгууллагууд, сумд түүхэн ном, нэвтэрхий толь зэргийг номын сандаа хандивлаж тус хугацаанд цугласан номуудаар Нутгийн түүх сэдэвт номын үзэсгэлэнг дэлгэж нийтэд танилцууллаа.



“Номоо солилцъё” шинэ, хуучин номын худалдаа, солилцоо

Номын сангийн дэргэдэх “Ирээдүйн эзэд” номын клубийн гишүүд, “Өмнөговь аймгийн хүүхдийн зөвлөл” хамтран “Номоор оюунаа цэнэглэе” нөлөөллийн ажлыг ном солилцооны хүрээнд зохион байгууллаа. Иргэд, хүүхэд залуусын дунд өөрт байгаа уншихгүй номоо бусдад хандивлах, солилцох, худалдан борлуулах боломжийг дэмжин ажиллав. Мөн гишүүдийн хандиваар бий болсон 70 орчим номыг бүрдүүлэн манай сан хөмрөгт хандивласан. “Ирээдүйн эзэд” номын клуб нь 2022 оны 06 дугаар сарын 24-нд байгуулагдаж өдгөө 30 уншигч гишүүнтэйгээр ном соёл түгээн дэлгэрүүлэх, “Тусч уншигч” хөтөлбөрийн хүрээнд бидний үйл ажиллагааны нэгээхэн хэсэг болон ажиллаж байна. “Таван-Эрдэнэ” номын дэлгүүртэй хамтран шинэ номын худалдаа зохион байгуулсан.



IX/20. “Нацагдорж тэмдэгт” тэргүүний уншигч хүүхдүүдэд шагнал гардуулах үйл ажиллагаа

Номыг шимтэн уншиж мэдлэг оюунаа хөгжүүлж байдаг хүүхдүүдээ Монголын орчин үеийн уран зохиолыг үндэслэгч Д.Нацагдоржийн нэрэмжит “Тэргүүний уншигч” үнэмлэх тэмдгээр шагнаж урамшуулдаг уламжлалтай. Номтой нөхөрлөж мэдлэг оюунаа хөгжүүлсэн, амжилттай суралцаж үеийн нөхдөдөө ном унших үлгэр дуурайлал болсон төв, хөдөөгийн шилдэг уншигч сурагчдыг тус шагналаар шагнаж урамшууллаа. Эдгээр сурагчдыг номын баярын нээлтийн болон “Тэргүүний уншигч хүүхдүүд” зөвлөгөөн дээр үнэмлэхийг гардуулан тэмдгийг зүүж өглөө. Уншиж хөгжиж үлгэрлэн яваа эдгээр хүүхдүүдэд номын баярын үйл ажиллагаанд урилгаар оролцогч эрхэм зохиолч, яруу найрагчид



зөвлөгөө зөвлөмж өгч санал бодлоо хуваалцан гарын үсэгтэй номын бэлэг нардууллаа.

“Тэргүүний уншигч” уншигч хүүхдүүдийн зөвлөгөөн

Үндэсний бичиг соёл номын өдрүүд-2024 арга хэмжээ, Өмнөговь аймгийн Төв номын сангийн түүхт 80 жилийн ойг тохиолдуулан номыг шимтэн уншдаг уншигч хүүхдүүдийг дэмжих, тэдний уншиж хөгжсөн туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор зохион байгуулсан Өмнөговь аймгийн 15 сумын тэргүүний уншигч хүүхдүүд оролцож нийт **80** тэргүүний хүүхдүүдийг хамрууллаа. Зөвлөгөөнд урилгаар МЗЭ-ийн шагналт, “Болор цом”-ын эзэн, яруу найрагч Ш.Лхамноржмаа МЗЭ-ийн шагналт, яруу найрагч Ц.Галбадрах, Г.Сэр-одын нэрэмжит шагналт яруу найрагч Т.Батхүрэл, яруу найрагч Б.Баярмөнх, “Глобал паспорт” сургалтын төвийн багш А.Баттуул нар оролцлоо.

Зөвлөгөөний нэгдүгээр хэсэг:

Хүүхдийн ордны дэргэдэх авьяаслаг сурагчид сурсан мэдсэнээрээ үе тэнгийн нөхдөдөө мэндчилгээ хүргэж “Дэгдээхэй нас” дуугаар дууны дугуйлангийн сурагч Цэлмүүн, “Сүүн далай ээж” аязаар хийл хөгжмийн дугуйлангийн сурагчид Цогзолмаа, Мишээл “Монгол хүний зүрхний бичээс” шүлгээр бяцхан уран уншигч О.Бүжинлхам нар мялаалга өргөлөө.



“Глобал паспорт” сургалтын төвийн багш А.Баттуул зөвлөгөөнд оролцогчдод зориулан англи хэл сурах түүний ач тус, цаашид суралцах эрч хүч, урам зориг өгөхүйц “Гадаад хэлээр бичигдсэн ном уншихын ач тус” сэдэвт илтгэл, Аймгийн Төв номын сангийн дарга А.Одончимэг номын сангаас зохион байгуулагдаж буй хүүхдүүдэд зориулсан боловсролын хөтөлбөрүүдийн танилцуулга мэдээллийн дэлгэрэнгүйг хүргэлээ.

Номыг шимтэн уншдаг уншигч хүүхдүүдийг дэмжих, тэдний уншиж хөгжсөн туршлагыг түгээн дэлгэрүүлж яваа аймаг, сумын шилдэг тэргүүний уншигч хүүхдүүдийн төлөөлөл үе тэнгийн найз нөхдөдөө Цогтцэций сумын 2-р сургуулийн 12а ангийн сурагч С.Билгүүн өөрийн



номтой нөхөрлөж эхэлсэн бага насны түүх, тэмцээн мэтгэлцээнүүдэд манлайлан оролцдог туршлагаа, Улсын тэргүүний 3-р сургуулийн 11а ангийн сурагч

О.Хүсэлцэцэг номын сангийн “Тусч уншигч” хөтөлбөрт хамрагдаж ном уншихын ач тусыг сурталчлан сургуулийнхаа 300 гаруй хүүхдүүдэд зөвлөгөө мэдээлэл хүргэж ажилласан түүхээ хуваалцлаа. Номын сангийн хүүхдийн уншлагын танхимын шилдэг уншигч Э.Учрал, ном уншихаас гадна яруу найраг зохиох авьяасаа хөгжүүлж буй шилдэг уншигч сурагч Улсын тэргүүний 1-р сургуулийн 9б ангийн сурагч Наранбаяр нар зөвлөгөөнд оролцогчдоо өөрсдийн ном уншлагатай холбоотой илтгэл мэдээлэл хүргэж дурсгалын зураг авхуулснаар зөвлөгөөний нэгдүгээр хэсэг өндөрлөсөн.

Зөвлөгөөний хоёрдугаар хэсэг:

Зохиолч-Уншигчдын уулзалт МЗЭ-ийн шагналт, Болор цомын эзэн яруу найрагч Ш.Лхамноржмаа, МЗЭ-ийн шагналт, яруу найрагч Ц.Галбадрах, Г.Сэр-одын нэрэмжит шагналт яруу найрагч Т.Батхүрэл, яруу найрагч Б.Баярмөнх нар оролцож хүүхдүүдэд ном уншихын ач холбогдлын тухай хэлэлцүүлэг өрнүүлж, уншигч хүүхдүүдтэй чөлөөт ярилцлага хийн, шүлэг яруу найраг сонирхдог хүүхдүүд өөрийн зохиосон шүлгээ уншиж яруу найрагчдаас үнэтэй зөвлөмж зөвлөгөөг авлаа.



Зөвлөгөөний үеэр ажиллаж буй сум орон нутагтаа эзэмшсэн мэргэжил, хийсэн ажилдаа эзэн болж сумынхаа хүүхдүүдийг номоор соён гэгээрүүлж, хүүхэд багачуудыг ном уншлагад уриалан дуудаж номын сангийн үйлчилгээндээ хүүхдүүдийн оролцоог үргэлж дэмжиж байдаг Хүрмэн, Баяндалай, Сэврэй, Номгон сумын сургууль болон соёлын төвийн номын санчдаа урамшуулан “Номын богц” номын багцаар шагналаа.

Зөвлөгөөний төгсгөлд оролцогч хүүхдүүдийг “Даланзадгад хоттой танилцах аялал”-ын хөтөч тайлбарлагч Ц.Алтангэрэл чиглүүлэн Өмнөговь аймгийн хөгжил бүтээн байгуулалтыг харуулсан баримтат 15 минутын видео бичлэгийг ХЖТ-т үзүүлж, “Говийн байгаль, түүхийн музей”-тэй танилцуулан автобустай аяллыг хийлээ.

Уншигчдын уулзалт арга хэмжээнд оролцогч хүүхдүүдэд тэмдэглэлийн дэвтэр, бал өгч, үдийн хоол катеринг үйлчилгээнд хамруулсан.

IX/20. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжсэн төрөл бүрийн материалаар хийгдсэн номын баринтаг, хавчуурга, ном уншихад зориулагдсан хэрэглэгдэхүүний үзэсгэлэн

Төв хөдөөгийн ерөнхий боловсролын сургуулиудын сурагчдад Мэдээлэл технологийн хичээлээр дамжуулан соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжсэн номын хавчуурга, номын баринтаг урлахад зориулсан танилцуулга хичээл орж хугацаанд 14 ЕБСургуулийн **985** сурагчид, 13 номын санч хамрагдаж, 611 бүтээл урлаж сурч мэдсэнээ бататган номын баярын өдөр үзэсгэлэн дэлгэж үзэгчдэд сонирхууллаа. Үүнд: Номын хавчуурга, эсгийн ном, уншсан номын тэмдэглэл болон бусад бүтээлүүд багтсан байна. Номоор дамжуулан сурагчдаа соён гэгээрүүлж ном уншлагыг дэмжин хамтран ажилладаг шилдэг сургууль болох Улсын тэргүүний 1-р сургуульд 500,000 төгрөгийн номын багц, “Эрдмийн гэгээ” 2-р сургуульд 300,000 төгрөгийн номын багцаар тус тус шагнагдлаа.



IX/16. “Зөөврийн номын сан-багт” арга хэмжээ /5-р багийн төв/

Ном хэвлэлээ сурталчлах, иргэдэд номын сангийн үйлчилгээг ойртуулах, оролцоог нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгын хүрээнд Даланзадгадын 5 дугаар багийн төвийн иргэдэд зөөврийн номын сангийн үйлчилгээг “Номын сан” асар дор зохион байгууллаа. Тус арга хэмжээний хүрээнд **252** иргэд, хүүхэд залуучуудад дараах үйлчилгээг хүргэн ажиллалаа.

Үүнд:

- Номын сангаас зохион байгуулж буй үйл ажиллагааг иргэдэд сурталчлах, мэдээлэл өгөх
- Уншигчийн карт нээж гэрээр ном олгох үйлчилгээ үзүүлэх
- “Үлгэрийн цаг” арга хэмжээ
- “Бүтээлч иргэн” номын хавчуурга хийх сургалт
- Шинэ номын худалдаа
- Номын үзэсгэлэн /Гэрээр ном олгох, Хөгжлийн мэдээлэл сургалтын төв, Хүүхдийн уншлагын танхим/
- “Хуучин номоо солилцъё”
- “Оюуны чихэр”
- Номын тухай 4 мөрт шүлэг зохиох /Иргэдийн дунд/

- “Сэтгэлийн үгээ үлдээ” сэтгэгдлийн булан зэрэг ажлуудыг зохион байгууллаа.

Уншигчийн карт нээх, гэрээр ном олгох үйлчилгээ

Гэрээр номын олгох танхим нь аймгийнхаа насанд хүрэгчдэд ном олгож үйлчлэхээс гадна байгууллага, хамт олонд зөөврийн номын сангийн үйлчилгээг хүргэж ажилладаг. Арга хэмжээний хүрээнд иргэнд уншигчийн карт нээж, 11ш номыг гэрээр олгон үйлчиллээ.



Үлгэрийн цаг: Даланзадгад сумын “Ахмадын чөлөөт холбоо”-ны ахмадуудтай хамтран “Үлгэрийн цаг” үлгэрээр дамжуулан хүүхдийг хөгжүүлэх, үлгэр уншиж өгөх үйл ажиллагааг зохион байгуулж байна. Тус холбооны 6 ахмад настан хамтран сурагчдад үлгэр домог, монгол ардын аман наадгай болох оньсого таалцах, түргэн хэллэгийн тухай хоорондоо хэлэлцүүлэг өрнүүлэх зэргээр энэхүү арга хэмжээ зохион байгуулагдлаа. Даланзадгад сумын 4-р цэцэрлэгийн бэлтгэл бүлгийн 38 хүүхэд хамрагдлаа.

Номын үзэсгэлэн: Номын сангийн сан хөмрөгт шинээр ирсэн номуудаа иргэдэд танилцуулах, сурталчлах зорилгоор хүүхдийн уншлагын танхим, гэрээр ном олгох танхим, хүүхдийн уншлагын танхимууд нь хүүхэд багачуудын насны онцлогт тохирсон номууд болон насанд хүрэгч иргэдийн дунд хамгийн ихээр уншигддаг номуудаараа үзэсгэлэн гаргаж танилцууллаа. Нийт 212 ширхэг номыг 252 уншигчдад танилцууллаа.

“Бүтээлч иргэн” номын хавчуурга хийх сургалт: Хүүхдүүдийн бүтээлч байдал, танин мэдэхүй, сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх, өөрсдийн уншсан номдоо өөрийн гараар хавчуурга хийж сурах сургалт тус багийн төвийн хүүхдүүдэд зохион байгууллаа.

Оюуны чихэр: Бидний үйл ажиллагаанд оролцож үйлчлүүлж буй иргэддээ уламжлал болсон оюуны чихрийг монгол ардын зүйр үгтэйгээр хэвлэн бэлтгэж энэ удаа явууллаа. Оюуны чихрийг 88 хүнд хүртээж тэдний мартсан байсан зарим зүйр үгийг санууллаа хэмээн сайхан үгийг буурлуудаасаа сонслоо.

“Номын тухай 4 мөрт” шүлэг зохиох тэмцээн:

Тэмцээнийг арга хэмжээний үеэр иргэдийн дунд явуулж нийт 15 шүлэг зохиолоос насанд хүрэгчдээс 1, хүүхдээс 1 шилдэг шүлгийг шалгаруулан номын багцаар шагнаж урамшууллаа.

Насанд хүрэгч: В.Энхээ- /4-р цэцэрлэгийн бүлгийн багш/

Хүүхэд: Г.Энгүүндалай /4-р сургуулийн 7в ангийн сурагч/ нар тус тус өөрийн зохиосон шүлэг найргаараа номын эзэд боллоо.

“Сэтгэлийн үгээ үлдээ” сэтгэгдлийг хүлээн авах үйл ажиллагаа

Иргэдийн санал сэтгэгдлийг сонсох, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх зэргээр үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжид тулгуурласан сэтгэгдлийн буланг ажиллууллаа. Тухайн цаг үеийн сэтгэгдлээ цаасан дээр үлдээх булангаар нийт 15 үйлчлүүлэгч сэтгэгдлээ үлдээсэн.



IX/10-IX-17. “Сэтгэлд хоногшсон ном” уншсан номын сэтгэгдлийн уралдаан.

Уншигчдынхаа бүтээлч байдлыг идэвхжүүлж залуучуудын оролцоог нэмэгдүүлэх, ном хэвлэлээ сурталчлах зорилгоор Даланзадгад сумын насанд хүрэгчдийн дунд 2024 оны 09-р сарын 10-17-ны өдрийн хооронд зохион байгууллаа. Оролцогчдын сэтгэгдлүүдээс номын утга, агуулга, дүгнэлтээ тодорхой гаргасан, бүтээлчээр хандсан, цэвэр нямбай, эмх цэгцтэй бичсэн, цаг баримталсан байдал зэргийг харгалзан үзэж ирүүлсэн бүтээлээс шилдэг 3 сэтгэгдлийн эзнийг тодруулан 50,000 төгрөгт өөрийн дуртай номоо сонгон авах эрхийн бичгээр шагнаж урамшууллаа.

Оролцогч С.Сарантунгалаг- Зохиолч Х.Дуламсүрэнгийн "Цагаан цувтай бүсгүй" номоор

- Оролцогч М.Отгонтуяа- Зохиолч Мүраками Харүки-ийн "Норвегийн ой" номоор
- Оролцогч Г.Ууганзул- Зохиолч Кавагүчи Тошиказу-ийн "Кофе хөрөхөөс өмнө" номуудаар уралдаанд оролцож номын эрхийн бичгийн эзэд болж



өөрсдийн хүссэн номоо сонгон авлаа. Уралдаанд 11 оролцогч өөрийн уншсан номын тухай сэтгэгдлийг бичиж ирүүлсэн.

X/09. “Жаргалтай гэр бүл өдөрлөг”

Байгууллагын ажилчдын гэр бүл, үр хүүхдүүдийг танилцуулах, нэгэн үдшийг гэр бүлийн хүний ажлыг ойлгон таних зорилгоор уг өдөрлөгийг зохион байгууллаа. Өдөрлөгийн хүрээнд

- Гэр бүл бүр нэг өнгийн хувцсаар ижилсэх
- Танилцах
- Номын сангийн үйл ажиллагааны мэдээллийг танилцуулах
- “Угийн бичиг” сургалт мэдээлэл
- Хөгжөөнт тоглоомууд
- 4 бэрх буулгаж азтан болох
- Хүүхдүүдэд зориулсан Бийрхэн зургийн сургалттай хамтарсан сургалт
- Шинэ байранд орсон гэр бүлүүдэд байгууллагаас мөнгөн дэмжлэг үзүүлэх
- Дурсгалын зураг даруулах гэх мэд үйл ажиллагааг зохион байгуулж нийт 11 бүлийн 34 гишүүд оролцлоо.

Тухайн өдөр гэр бүл өөр өөрийн сонгосон өнгөөр хувцас болон хүнсний зүйлсийг сонгож бэлдэж ирсэн ба өөрийн гэр бүлийн танилцуулгуудыг хийж үйл ажиллагааг эхлүүлсэн. Номын сангийн дарга А.Одончимэг номын сангийн үйл ажиллагааны танилцуулга мэдээллийг ажилчдынхаа гэр бүлийн хүмүүст танилцуулсан.



Хүүхдийн уншлагын танхимын номын санч Г.Ренчиндаваа “Угийн бичиг” сургалт мэдээллийг товч байдлаар хүргэж номын сангийн сан хөмрөгт хадгалагдаж буй номуудаар үзэсгэлэн гаргаж танилцуулав.

Шинэ байр, гэрт орсон Н.Даваажаргал, Б.Оюунзаяа, М.Баасанжав нарын албан хаагчдадаа нийгмийн байдлыг дэмжих дэм болох зорилгоор 500,000 төгрөгийн “Эрхийн бичиг” гардуулав.

“Бийрхэн” зургийн сургалтын төвтэй хамтран хүүхдүүдийн сэтгэн бодох чадвар, чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх зорилгоор зургийн сургалтад хамрууллаа.

XI/01. Номын тэмдэглэл хөтлөх сургалт

2-р сургуулийн Ж.Нинжбадгир багштай 8б ангид Номын тэмдэглэл хөтлөх сургалт зохион байгуулсан оролцсон [хүүхдийн тоо-30](#)

XI/06. Номын тэмдэглэл хөтлөх сургалт

1-р сургуулийн М.Жаргалмаа багштай 10е ангид Номын тэмдэглэл хөтлөх сургалт зохион байгуулсан оролцсон [хүүхдийн тоо-14](#)

XI/07. Номын тэмдэглэл хөтлөх сургалт

1-р сургуулийн Б.Энхжаргал багштай 5б ангид Номын тэмдэглэл хөтлөх сургалт зохион байгуулсан оролцсон [хүүхдийн тоо-20](#)

XI/08. Номын тэмдэглэл хөтлөх сургалт

4-р сургуулийн 5-7-р ангийн сурагчдад Номын тэмдэглэл хөтлөх, номын хавчуурга хийх сургалт зохион байгуулсан оролцсон [хүүхдийн тоо-29](#)

XI/19. Номын тэмдэглэл хөтлөх сургалт

7-р сургуулийн Т.Гүнжинлхам багштай 7г ангид Номын тэмдэглэл хөтлөх, Номын хавчуурга хийх сургалт зохион байгуулсан оролцсон [хүүхдийн тоо-19](#)

XI/16. “Эгшиглэнт говь-2024” яруу найргийн наадам

"Соёлын бүтээлч сар"-ын хүрээнд Өмнөговь аймгийн “Эгшиглэнт говь” яруу найргийн уралдаан энэ жил 37 дахь жилдээ зохион байгууллаа. Энэхүү яруу найргийн наадам нь 1987 оноос эхлэн Өмнөговь аймгийн зохиолч яруу найрагчид өөрсдийн зохиосон бүтээл яруу найргаа говь нутгийнхаа түмэн олонд хүргэсээр ирсэн түүхтэй.

2024 оны “Эгшиглэнт говь” яруу найргийн наадам нь Төв номын сангийн түүхт 80 жилийн ойн хүрээнд зохион байгуулсан ба Өмнөговь аймгийн Засаг даргын тамгын газар, Нийгмийн бодлогын хэлтэс, Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар, Буянт хотхон УТҮГазар, Хөгжимт жүжгийн театр, МЗЭ-ийн Өмнөговь дахь салбар, Төв номын сангийн хамт олон хамтран зохион байгууллаа. Наадамд **200** гаруй хүн хамрууллаа.

Наадам 3 үе шаттайгаар зохион байгуулагдаж шинэ залуу найрагчдын шинэ бүтээлүүдийг олны сонорт хүргэсэн нь нэгэн онцлог байлаа. Наадмын нэгдүгээр шатны шалгаруулалтад аймаг сумдаас 30 орчим оролцогчид шүлэг найргийн



бүтээлээ ирүүлж тус найрагчид өөрийн сонгосон бүтээлүүдээ шүүгчдэд уншиж танилцуулснаар 3 дугаар шатанд оролцох эрхээ авав. Наадмын 3 дугаар шатанд шалгарсан оролцогчид Аймгийн хөгжимт жүжгийн театрын тайзнаа өөрийн зохиол бүтээлээрээ өрсөлдөж шилдгүүдээ тодруулснаар энэхүү наадам өндөрлөлөө.

Тэргүүн байр цомын эзнээр Т.Энх-Эрдэнэ

Дэд байр Б.Баянтунгалаг

Гутгаар байр Ц.Чулуун-Эрдэнэ

Тусгай байр О.Баярмаа

Тусгай байр Б.Бүжин нар тодорч тус тус өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнууллаа.

Манай номын сангийн зүгээс “Өмнөговь аймгийн, зохиолч яруу найрагчид” сэдвийн дор МЗЭвлэлийн шагнал хүртсэн эрхэм зохиолч, найрагчдаа алдаршуулан таниулах зорилгоор хүндэтгэлийн номын үзэсгэлэнг гаргаж нийтэд танилцуулан сурталчиллаа. Үзэсгэлэн үзэгчийн тоо **122**.

“Эгшиглэнт говь-2024” яруу найргийн Сонгодог үдшийн хөтлөгчөөр “Болор цом”-ын эзэн, яруу найрагч Н.Гантулга, шүүгчдийн бүрэлдэхүүнд Монгол Улсын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, утга зохиол судлаач, хэл бичгийн ШУ-ны доктор, профессор С.Байгалсайхан, МЗЭвлэлийн хорооны дэд дарга, яруу найрагч П.Нямлхагва, МУСГЗ, яруу найрагч Л.Эрдэнэбат нар урилгаар оролцов.

XII/04-XII/06.Номын сангийн 80 жилийн ой

1944 оноос эхэлсэн 80 жилийн түүхэн ойгоо аймгийн Төв номын сангийн хамт олон 12 дугаар сарын 04-06-ны өдрүүдэд өргөн дэлгэр зохион байгууллаа. Номын сангийн түүхэн ойд холбоотой хүндэт зочдодоо урилга хүлээлгэн өгөх, номын нээлт, сургалтын үйл ажиллагааны бэлтгэл, үзэсгэлэн, танилцуулга зар мэдээлэл түгээх зэрэг ажлуудыг зохион байгуулж нийт **3440** хүнийг цахим болон танхимаар хамрууллаа.

XII/04.“Бүх нийтийн соёлын боловсрол” сургалт

12 дугаар сарын 4-ний өдөр соёлын ажилтнуудад бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх ажлын чадамжийг нэмэгдүүлэх арга зүйг олгох зорилгоор сумдын соёлын төвийн дарга, төв номын сангийн болон сумд, сургуулиудын номын санчдын дунд зохиогдлоо. Ойн арга хэмжээний “Бүх нийтийн соёлын боловсрол” сургалтыг номын сангийн дарга нээн үг хэлж сургалтад нь амжилт хүссэнээр эхлүүлэв.

- “Орон нутгийн цахим сан үүсгэх боломж, шийдэл” Монгол Улсын боловсролын их сургуулийн номын сангийн захирал Ж.Баатарсүрэн
- “Номын сангийн шинэчлэл-2024”, “Соёлын ажилтнуудын хамтын ажиллагаа-Хамтын хөгжил” Монголын номын сангуудын консорциумын гүйцэтгэх захирал Ч.Мөнх-Эрдэнэ
- “Цахим хэрэглүүр ашиглан ажлын бүтээмжээ нэмэгдүүлэх нь”, “Номын сангийн бүтээлч орон зайн төв-Make space” Монгол Улсын Үндэсний номын сангийн арга зүйч В.Түвшинтогтох
- “Ном зүйн мэдээллийн систем хөгжүүлэх, хамтын ажиллагааны санаачилга”МҮНСангийн МАЗЭШХэлтсийн дарга Т.Хайдав нар дээрх сэдвүүдийн хүрээнд Бүх нийтийн соёлын боловсрол сургалтыг амжилттай зохион байгууллаа. Ийнхүү сургалтад хамрагдсан номын санчдадаа Батламж гардууллаа. Сургалтад төв хөдөөгийн **40** гаруй номын санч, соёлын төвийн дарга нарыг хамруулсан.



XII.05. Номын нээлт, хүндэтгэлийн баярын хурал

Номын сангийн салбар орон нутагт хөгжсөн түүхэн замналыг түүхт 80 жилийн ойгоор дамжуулан номд мөнхрүүлэхээр номын сангийн хамт олон “Намтар зузаан наян жил” түүхэн номыг бүтээлээ. Номыг дарга А.Одончимэг эмхэтгэв.

Мөн номын сангийн сан хөмрөгч Т.Нямсүрэн орон нутгийн ном бүтээлүүдээр “Өмнөговь-Орон нутгийн ном зүй” номыг эмхэтгэ хэвлүүлснээр 80 жилийн ойн босго дээр манай номын сангийн зүгээс 2 номын нээлтийн үйл ажиллагааг өргөн дэлгэр зохион байгуулж уригдсан олондоо танилцууллаа.

Нээлтэд үе үеийн ахмад номын санчид, ном хайртай уншигч олон, номын садан болсон ахмад буурал уншигч номын зохиолчид оролцлоо.

80 жилийн түүхийн хуудсыг хамт бичилцсэн эрхэм олныг урин баярын хурлаа хийж хүндэтгэл үзүүллээ. Аймгийн удирдлагууд, УИХурлын эрхэм гишүүдийн баярын мэндчилгээгээр эхлүүлсэн энэхүү хурлын үеэр мөр зэрэгцэн ажиллаж явсан ахмад буурлуудаасаа эхлүүлээд одоо цагт тэдний үйл хэргийг үргэлжлүүлэн ажиллаж буй залуу ажилчдаа шагнаж урамшууллаа.

Монгол Улсын “Соёлын Тэргүүний ажилтан” хүндэт тэмдгээр

- Ахмад номын санч М.Цэенпил
- Сан хөмрөгч Т.Нямсүрэн
- Нийтийн уншлагын танхимын номын санч Н.Даваажаргал

Өмнөговь аймгийн “Тэргүүний ажилтан” хүндэт тэмдгээр

- Ахмад номын санч Р.Бодьцэцэг
- Ахмад ажилтан Ц.Тогтох
- Сүлжээ-Мэдээллийн ажилтан Б.Оюунзаяа

Өмнөговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Хүндэт жуух” бичгээр

- Үйлчлэгч, нярав Ц.Бадамханд
- Харуул З.Батхуяг

Монголын соёлын ажилтны “Соёлын түшиг” холбооны дээд шагнал “Соёлын гавьяа” одонгоор

- Ахмад номын санч Ч.Түвшинжаргал
- Ахмад номын санч А.Оюунгэрэл

Монголын Залуучуудын Холбооны “Тэргүүний залуу” тэмдгээр

- Харуул жолооч Х.Мөнххуяг
- Каталогч М.Баасанжав

Монголын Залуучуудын Холбооны “Хөдөлмөрийн алдар” тэмдгээр

- Хүүхдийн уншлагын танхимын номын санч Г.Ренчиндаваа нар тус тус шагнагдлаа.

Өөрийн хүсэл, сонирхолдоо хөтлөгдөн калиграф /уран бичлэг/ урлагийг амьдралынхаа нэгээхэн хэсэг болгосон чөлөөт уран бүтээлч, номын сангийн болон соёл урлагийн салбарт өөрийн хувь нэмрээ оруулан амжилттай яваа залуу уран

бүтээлч Г.Ганзоригийг Монголын соёлын ажилтны “Соёлын түшиг” холбооны шагнал “Соёлын алдар” одонгоор шагнаж урамшуулав.

Мөн сум орон нутгийн иргэд, хүүхэд залуучуудад ном соёлыг түгээх үйлсэд хоёргүй сэтгэлээр хамтран зүтгэж яваа Манлай сумын соёлын төвийн дарга Д.Отгонбат, Номын сумын соёлын төвийн номын санч О.Батзориг, Баяндалай сумын соёлын төвийн номын санч С.Сарантуяа, Ноён сумын соёлын төвийн номын санч Ж.Бадамсүрэн нарыг шагнаж урамшуулан, өдөр бүр номтой нөхөрлөн, бүтээлч уншлагад идэвхтэй хамрагддаг 1-р сургуулийн Б.Ганчимэг багштай 9б ангийн хамт олон, 4-р сургуулийн Ш.Мөнх-Эрдэнэ багштай 5а ангийн хамт олныг Тэргүүний уншигч “Д.Нацагдорж тэмдэгт хамт олон”-оор өргөмжлөв. Нээлтийн үйл ажиллагаанд оролцогчдын тоо **150**.



XII/06. 3 үеийн номын санчдын уулзалт, өдөрлөг

Төв хөдөөгийн үе үеийн ахмад номын санчид дарга нарыг хүлээн авч уулзах, тэдний тухайн үеийн ажиллаж байсан түүхэн дурсамж дуртгалыг сонсож ярилцах боломжийг бий болгон үзэсгэлэн гаргаж танилцууллаа. Оролцогчдын тоо 50.

Орон нутгийн Мэлмий сайт, төв номын сан хамтран "Түүхээ зузаалсан 80 жил" баримтат нэвтрүүлэг бэлтгэж нийтэд толилуулав. Нэвтрүүлгийг 3 үеийн номын



санчдын уулзалтын үеэр өдөрлөгт оролцогчдод үзүүлэх, олон нийтийн сүлжээгээр нийтэд танилцуулав. /Үзэлт хандалтын тоо **3200**/

МЭДЭЭЛЭЛ СУРТАЛЧИЛГАА

2024 онд олон нийтийн сүлжээнд номын сангийн фэйсбүүк фэйж хаягаар нийт **449** удаа мэдээ мэдээллийг цахимаар сурталчилж нийтэд хүргэсэн. Мэдээллийг цахимаар сурталчлахдаа богино болон урт хугацаатай бичлэгүүдийг хийж байршуулсан ба нийт **19276** хүнд хүргэн ажиллалаа.


Сан хөмрөгийн хуучин ном хэвлэлийг сурталчлах, тэмдэглэлт өдрүүд тодорхой сэдвийг хамарсан сэдэвчилсэн номын үзэсгэлэнг нийт 54 удаа 2384 ширхэг номоор гарган 5499 хүнд, шинэ ном хэвлэлийг уншигчид олон нийтэд танилцуулах номын үзэсгэлэнг нийт 23 удаа 1141 ширхэг номоор гарган 1893 хүнд танилцуулж ажиллалаа.

Мэлмий видео сайтад номын сангийн үйлчилгээ үйл ажиллагааны мэдээ болон Дэлхийн яруу найргийн өдөр, Номын баяр хавар, намар, Үндэсний бичиг үсгийн баяр Монгол бичгийн цахим хэрэглээ, Цондоолой цүндээлэйгийн найзууд, Дээлтэй Монгол наадам, Эгшиглэнт говь-2024 яруу найргийн наадам, Номын сангийн 80 жилийн ойн "Түүхээ зузаалсан 80 жил" баримтат нэвтрүүлэг зэрэг уралдаан, арга хэмжээний мэдээг нийт 9 мэдээ, ОНХА-д арга хэмжээний 3 мэдээ МОНЦАМЭ-д 2 мэдээ нийт мэдээлэл сурталчилгааг телевиз болон мэдээний сайтаар дамжуулан нийтэд хүргэлээ.

Easycall үйлчилгээг нэвтрүүлээ

Easy Call шийдэл нь виртуал буюу үүлэн технологи дээр суурилсан бөгөөд өөрийн байгууллагын бүтэц үйл ажиллагаанд тохируулан үйлчилгээний мэдээллийг иргэдэд хялбараар хүргэх үйлчилгээ юм. Энэхүү үйлчилгээг номын сандаа нэвтрүүлснээр номын сангийн зарим үйлчилгээг утсаар шууд авах боломж бүрдэж байгаа юм. 2024 оны 11 дүгээр сараас эхэлсэн уг үйлчилгээг 216 иргэн утсаар авсан байна. Уг үйлчилгээнд холбогдсоноор

- Үйлчилгээний лавлагаа авах
- Мэдээлэл лавлагаа авах
- Номын хугацаа сунгах буюу Гэрээр ном олгох танхимтай холбогдох
- Санал хүсэлт үлдээх гэх мэт үйлчилгээнүүдийг шууд авах боломжуудыг бий болгосон.



Шинэ номын үзэсгэлэн 22 удаа, 1105 ширхэг номоор, 1905 ирцэд

Хүүхдийн уншлагын танхимаас /4 удаа 172 ширхэг номоор 217 хүнд/

1. II/16. Уншлагын танхимд шинээр ирсэн 42 номоор үзэсгэлэн гаргаж цахимаар 48 хүн танилцсан байна.

2. IV/15. Уншлагын танхимд шинээр ирсэн 24 номоор үзэсгэлэн гаргаж уншлага үйлчилгээг 24 хүнд хүргэсэн.
3. VI/05. Зуны уншлагын үеэр шинээр ирсэн 66 номоор үзэсгэлэн гаргаж цахимаар 60 хүн үзэж сонирхсон байна.
4. X/10. Шинээр ирсэн Монгол бичгийн 40 ширхэг номоор үзэсгэлэн гаргаж танхимаар 85 хүүхэд багачуудад танилцуулсан.

Гэрээр ном олгох танхимаас /3 удаа 196 ширхэг номоор 344 хүнд/

1. I/20. Шинээр ирсэн 79ш номоор үзэсгэлэн гаргаж 312 хүнд танилцуулсан.
2. IV/12. Шинээр ирсэн 50ш номоор үзэсгэлэн гаргаж 32 хүнд танилцуулсан.
3. VIII/06. Шинэ 67 номоор үзэсгэлэн гаргаж хүн үзсэн.

Сан хөмрөгөөс /4 удаа 114 ширхэг номоор 130 хүнд/

1. I/17. 29 ширхэг номоор /Үзсэн хүн-36/
2. II/29. 28 ширхэг номоор /Үзсэн хүн-43/
3. V/21. 26 ширхэг номоор /Үзсэн хүн-21/
4. IX/23. 31 ширхэг номоор /Үзсэн хүн-30/

Нийтийн уншлагын танхимаас /6 удаа 121 ширхэг номоор 551 хүнд/

1. II/18. Шинэ номын үзэсгэлэн 20 ном 95 хүн
2. III/28. Шинэ номын үзэсгэлэн 2 номоор 131 хүн
3. IV/22. Шинэ номын үзэсгэлэн 16 номоор 104 хүн
4. VII/31. Шинэ номын үзэсгэлэн 26 номоор 70 хүн
5. IX/02. Шинэ номын үзэсгэлэн 46 номоор 67 хүн
6. XII/10. Шинэ номын үзэсгэлэн 11 номоор 84 хүн

Зөөврийн номын сангаар /5 удаа 502 ширхэг номоор 663 хүнд/

1. II/28. Цогтцэций суманд /112 номоор 363 хүнд/
2. IV/02. Хилийн цэргийн 0131 дүгээр ангийн ажилтан албан хаагчдад /100 номоор 37 хүнд/
3. IV/09. "Стандарт, хэмжилзүйн хэлтэс"-ийн хамт олонд /80 номоор 22 хүнд/
4. IV/15. "Төрийн банк"-ны хамт олонд /100 номоор 25 хүнд/
5. IV/27. Даланзадгад сум Хөдөлгөөнт баг арга хэмжээнд /110 номоор 216 хүнд/



Сэдэвчилсэн номын үзэсгэлэн /54 удаа, 2374 номоор, 5399 хүнд/

1. I/02-I/25. "Улгэрч хүүхэд" орон орны үлгэрүүд 200 номоор үзэсгэлэн гаргаж нийт цахимаар 82 хүн үзэж танилцсан байна.
2. I/26. "Хос бичигтэн-Өмнөговь" аяны нээлтээр монгол бичгээр бичигдсэн номын үзэсгэлэнг ХЖТ-т дэлгэж танилцуулсан/75 ширхэг номоор 132 ирцэд/
3. I/29. Монгол бичгийн сурах бичиг, гарын авлага номын үзэсгэлэнг Нийтийн уншлагын танхимд гаргаж танилцуулсан. /36 ширхэг номоор 110 ирцэд/
4. I/29. "Монгол бичиг мину" монгол бичигтэй 36 номоор үзэсгэлэн гаргаж цахимаар 73 хүн үзэж танилцсан байна.

5. I/31. Түмэн тэмээний баярт үзэсгэлэн /19 ширхэг номоор 142 ирцэд/
6. Цагаан сарын номын үзэсгэлэн /34 ширхэг номоор 83 ирцэд/
7. II/05. “Монгол ардын оньсого” үзэсгэлэнг 24 номоор гаргаж цахимаар 55 хүн үзэж танилцсан байна.
8. II/14. Хайр сэдэвт номын үзэсгэлэн 42 ном 84 хүнд хүрсэн
9. II/19. ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад зориулсан Бие даан суралцах номоор үзэсгэлэн гаргасан 42 ном 79 хүн
10. III/06. Сономын Удвалын 103 жилийн ой амьдрал уран бүтээлийн алдаршуулах сурталчлах өдөрлөг арга хэмжээнд зохиолчийн зохиол бүтээлийн түүвэр болон зохиол бүтээлийг багтаасан 20 ширхэг номын үзэсгэлэнг гаргаж танилцуулсан. /20 ширхэг номоор 156 ирцэд/
11. III/07. Март 8 сэдэвт номын үзэсгэлэн 39 ном 155 хүнд хүрсэн
12. III/13. Монголын яруу найраг номын үзэсгэлэн 28 ном 164 хүнд хүрсэн
13. III/13. Бүх цаг үеийн яруу найргийн номоор үзэсгэлэн гаргасан 36 ном 208 хүн үзсэн
14. III/21. Даланзадгад сумын 5-р багт Дэлхий яруу найргийн өдрийн арга хэмжээгээр Өмнөговь аймгийн яруу найрагчдын номоор үзэсгэлэн гаргасан. Нийт 17 ном 23 хүн
15. III/25. Дэлхийн хүүхдийн номын өдөрт зориулан “Дэлхийн сонгодог зохиол” үзэсгэлэнг 136 номоор, Ханс Андерсений тухай цуврал баримтыг цахимаар хүргэн нийт 280 хүн үзэж танилцсан байна.
16. III/27. Хүүхдийн комик номын үзэсгэлэн 83 ном 55 хүнд хүрсэн
17. III/30. Монголын зохиолчдын эвлэлийн шагналт, хүүхдийн зохиолч, яруу найрагч С.Гантогтохын “Даланзадгадын мөндөөлэй-2024” сургуулийн өмнөх боловсролын хүүхдүүдийн урлагийн наадамд “Мөндөөлэй” номын үзэсгэлэн 22 ширхэг номоор гарган танилцуулж 65 үзсэн.
18. IV/15. Дэлхийн номын өдрийн хүрээнд “Дэлхийн сонгодог зохиол” номын үзэсгэлэн гаргасан /55 ном, 86 хүн/
19. IV/16. Дэлхийн номын өдрийг тохиолдуулан хүүхдүүдийн сонирхол татахуйц, танин мэдэхүй, зурагт номуудаараа “Танья, мэдье, сурья” үзэсгэлэнг 50 ширхэг номоор гаргаж танилцууллаа. Үзэсгэлэнг цахимаар 368 үзэгч, үүнээс танхимаар 40 хүүхэд үзэж сонирхлоо.
20. V/02. Монгол бичгийн номуудаар үзэсгэлэн гаргасан 29 ном 34 хүн
21. V/06. “Хөдөлмөрийн аюулгүй байдал Эрүүл ахуйн” 23 ширхэг номоор үзэсгэлэн гаргаж 88 хүн үзэж танилцсан.
22. V/8. Бичиг үсгийн баярт зориулан Монгол бичгээр бичигдсэн номын үзэсгэлэн. /71 ширхэг номоор 113 ирцэд/
23. V/14. Хүмүүн бичиг сониноор үзэсгэлэн гаргасан /102 Сонин 75 хүн/
24. V/15. Гэр бүлийн өдрийг тохиолдуулан “Жаргалтай гэр бүл” сэдэвт номын үзэсгэлэн 50 ном 67 ирц
25. V/17. Номын баярт зориулсан “Хүүхдийг номоор хөгжүүлэхүй” номын үзэсгэлэнг ХЖТеатрт 110 номоор гаргаж 156 хүн үзэж танилцсан байна.
26. V/21. Өрхийн үйлдвэрлэл сэтгүүлээр үзэсгэлэн гаргасан /109 сэтгүүл 64 хүн/
27. V/24. Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтан “Динзатай хамт” сэдэвчилсэн комик цуврал 80 номоор үзэсгэлэн гаргаж цахимаар 120 хүн үзсэн.
28. VI/01. Хүүхдийн баяр арга хэмжээн дээр 100 номоор үзэсгэлэн гаргаж 150 хүүхэд багачууд уншиж танилцсан.
29. VI/21. Шинжлэх ухааны номоор (20 ном 85 хүн)
30. VII/02. Номын сангийн 80 жилийн ойн хүрээнд “Миний номын сан” сэдэвт далбагар 48 номоор үзэсгэлэн гаргаж танхимаар 50 уншигч уншиж танилцсан байна.
31. VII/9. Баяр наадамд зориулсан номын үзэсгэлэн. /37 ширхэг номоор 73 ирцэд/
32. VII/19. “Дээлтэй монгол наадам”-д зориулсан номын үзэсгэлэн. /12 ширхэг номоор 41 ирцэд/
33. VII/23. Батмөнх даян сэцэн хааны мэндэлсний 560 жилийн ойд зориулсан номын үзэсгэлэн. /14 ширхэг номоор 39 ирцэд/
34. VIII/16. Эмэгтэйчүүдийн заавал унших номоор (30 ном 144 хүн)
35. VIII/12-VIII/23. “Ирээдүйн эрдэмтэн” хөтөлбөрийн хүрээнд “Сансар огторгуй ба одон орон судлал” сургалтын хүрээнд “Ирээдүйн эрдэмтэн” сэдэвт номын үзэсгэлэнг нийт 14 номоор гаргаж танхимаар 39 хүүхэд уншсан.

36. VIII/28. “Өөрийгөө өөрчилъе” сэдэвт хувь хүний хөгжлийн 40ш номоор үзэсгэлэн гаргаж 93 хүнд хүрсэн.
37. IX/02. Эх хэл мину (66 ном 86 хүн)
38. IX/05. “Нутаг мину” Өмнөговь аймагтай холбоотой хүүхдийн заавал унших 14 номоор үзэсгэлэн гаргаж цахимаар 44 хүн үзэж сонирхсон байна.
39. IX/20. Үндэсний бичиг соёл номын өдрүүд-2024 арга хэмжээнд 40 ширхэг хүүхдийн номоор үзэсгэлэн гаргаж 81 хүүхэд, залуус үзэж танилцсан.
40. IX/20. “Нутгийн түүх” номын үзэсгэлэн. /25 ширхэг номоор 80 ирцэд/
41. IX/26. Монгол улсын төрийн шагналт эрдэмтэн зохиолч Шанжмятавын Гаадамба мэндэлсний 100 жилийн ойд зориулан манай номын сангийн сан хөмрөгт байгаа уран бүтээлийн номоор үзэсгэлэн (13 ном 24 хүн)
42. X/07. Олон улсын охидын өдөрт зориулсан үзэсгэлэнг 60 ширхэг номоор гаргаж 159 хүн цахимаар үзэж сонирхсон.
43. X/18-X/30. “Хүний эрх” сэдэвт номын үзэсгэлэн. /21 ширхэг номоор 53 ирцэд/
44. XI/01. Нэрт зохиолч Б. Лхагвасүрэн мэндэлсний 80 жилийн ойд зориулсан номын үзэсгэлэнг 20 ширхэг номоор гаргаж 150 хүн үзэж сонирхсон.
45. XI/01- XI/30. “Нутгийн түүх” номын үзэсгэлэн. /51 ширхэг номоор 120 ирцэд/
46. XI/04. “Нутгийн түүх” номын үзэсгэлэн. /16 ширхэг номоор 53 ирцэд/
47. XI/04. “Соёлын бүтээлч сар-2024” нээлтийн арга хэмжээ Дээдсийн ухааныг дээжлэн өвлөхүй” уриа дор хөгжимт жүжгийн театр дээр “БАТМӨНХ ДАЯН ХААН”-ны намтар түүхтэй холбоотой хэвлэгдэн гарсан номоор үзэсгэлэн гаргасан (20 ном 77 хүн)
48. XI/06. “Нутгийн түүх” номын үзэсгэлэн. /19 ширхэг номоор 21 ирцэд/
49. XI/06. “БАТМӨНХ ДАЯН ХААН”-ны намтар түүхтэй холбоотой хэвлэгдэн номоор нийтийн уншлагын танхимд үзэсгэлэн гаргасан (20 ном 387)
50. XI/08. “Нутгийн түүх” номын үзэсгэлэн. /21 ширхэг номоор 34 ирцэд/
51. XI/08-XI/15. Д.Нацагдоржийн уран бүтээл болох нийт 22 номоор үзэсгэлэн гаргаж танхимаар 66 хүүхдүүд уншиж танилцан байна.
52. XI/12. “Нутгийн түүх” номын үзэсгэлэн. /21 ширхэг номоор 30 ирцэд/
53. XI/15. Өмнөговь аймгийн зохиолч, яруу найрагчдын номын үзэсгэлэн. /36 ширхэг номоор 122 ирцэд/
54. XI/20. 7-р сургууль дээр Монгол улсын үндсэн хуулийн 100 жилийн ойг тохиолдуулан 1949-2017 оны хооронд бичигдсэн үндсэн хуультай холбоотой номоор үзэсгэлэн гарган багш, ажилчид болон сурагчдад танилцууллаа. (16 ном 81)



САН ХӨМРӨГИЙН БАЯЖИЛТ, ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТ

2024 онд **761** нэр төрлийн **1170** ширхэг монгол ном, сонин, сэтгүүлээр сан хөмрөгөө баяжуулсан байна. /Нийт **22,761,500** төгрөгийн/ Үүнд:

Төсвийн хөрөнгөөр: 273 нэр төрлийн 443 ширхэг ном 8,784,000

Бэлэг хандиваар: 474 нэр төрлийн 647 ширхэг ном 13,109,500

Сонин сэтгүүл: 53 нэгж 616,000 төгрөг

Сонин хандив: 27 нэгж 252,000 төгрөг

Цахим болгосон ном: 14 нэр төрөл 14 ширхэг ном

Ашиглалтын явцад урагдаж гэмтсэн **680** ширхэг номыг сэлбэн засаж ашиглалтыг уртасгах арга хэмжээ авч ажиллалаа.

Байгууллагын их цэвэрлэгээний өдрөөр өрөө танхим болон ном хэвлэлийг ариутган ажиллахын зэрэгцээ гэрээр болон танхимаар уншлага үйлчилгээнд гарсан номыг ариутгах ажлыг зохион байгуулж ажиллав.

Орон нутгийн 12 ширхэг номыг цахим хэлбэрт шилжүүлж цахимаар унших боломжийг бүрдүүлэв. *Дараах номууд:*

- Говийн эрэлхэг эмэгтэй 1962 он
- Өрнөж яваа Өмнөговь аймаг 1961он
- Өмнөговь аймгийн Манлай сумын туршлагаас 1963он
- Өмнөговь аймаг 50 жилд 1981он
- Тэмээчдийн алдар 1975 он
- Говийн хүүхнүүд 1964 он
- Цогт-Овоо сум 1961 он
- Таанын үнэр 1963 он
- Манай тэргүүний эмэгтэйчүүд 1961 он
- Тэмээний ашиг шим 1969 он
- Аймгийн тэмээчид, хоньчид, ямаачдыг 1976 оны төл бойжуулалтаар байр эзлүүлсэн цуваа 1977 он
- Гурван сайхан 1959 он


КАТАЛОГ, НОМЗҮЙ, ЛАВЛАГАА

2024 оны жилийнэцсийн байдлаар цахим каталогийн хандалтын тоо **5068** байна. Иргэд, уншигчдад цахим болон бусад хэлбэрээр нийт 810 лавлагааг хүргэснээс

- Цахим 336
- Сэдэвчилсэн лавлагаа 164
- Ном зүйн лавлагаа 11
- Тодотгосон лавлагаа 631
- Статистик тоо баримт 4
- Татгалзалд 57 ном бүртгэгдсэн байна.

Мэргэжлийн ажиллагсдын бэлтгэсэн 3 ном зүйг үйлчлүүлэгчдэд танхим болон вэб хувилбараар ашиглах боломжийг бүрдүүллээ.

- Нийтийн уншлагын танхимын номын санч Н.Даваажаргал “**Өмнөговийн яруу найрагчдын уран бүтээл**” сэдэвт ном зүй.
- Фондчин Т.Нямсүрэн Өмнөговь аймгийн Төв номын сангийн 80 жилийн ойд зориулан орон нутгийн тусгай сан хөмрөгт хадгалагдаж байгаа орон нутгийн холбогдолтой 437 номыг ном зүйн бичилтийн стандартыг баримтлан товч агуулга, нүүр зургийн хамт он дараалалд оруулан “**Өмнөговь орон нутгийн ном зүй**” номыг эмхэтгэн гаргалаа.
- Хүүхдийн уншлагын танхимын номын санч Г.Ренчиндаваа “**Хүүхдийн сэтгэл зүй**” санамж өгөх ном зүй.
- Сүлжээ-Мэдээллийн ажилтан Б.Оюунзаяа “**Өөрийгөө өөрчлөхүй**” санамж өгөх ном зүй.



Шинэ номын мэдээ 4 удаа бэлтэн гаргаж уншигч үйлчлүүлэгчдэд танилцуулав.

1. I/27. Шинэ ирсэн 26 ширхэг ном цахимаар танилцуулж 79 хүн үзсэн.
2. III/30. Монголын зохиолчдын эвлэлийн шагналт, хүүхдийн зохиолч, яруу найрагч С.Гантогтохын "Даланзадгадын мөндөөлэй-2024" сургуулийн өмнөх боловсролын хүүхдүүдийн урлагийн наадамд 22 ширхэг "Мөндөөлэй" цувралын үзэсгэлэн гаргаж 65 хүн үзсэн.
3. IV/17. Шинэ ирсэн номуудаар мэдээ хийж уншигчдад хүргэсэн. 45 хүн
4. X/04. Монгол бичгээр бичигдсэн номуудаа шинэ номын мэдээ хийсэн. 70 хүн

Үндэсний тогтмол хэвлэлийн цахим санг баяжуулав

Үндэсний тогтмол хэвлэлийн цахим сан Зотерод "Монгол говь" болон "Говийн мэдээ" сонины 2 нэгж 189 нийтлэл мэдээллүүдийг оруулж Монголын Үндэсний номын санд илгээв. **Үүнд:** Номын санч Н.Даваажаргал 1978 оны 164 "Говийн мэдээ" сониныг, Каталогч М.Баасанжав 1976 оны 25 нийтлэлийг оруулж ажиллалаа.

СУРГАЛТ, АРГА ЗҮЙ

Номын санчдыг мэргэжил арга зүйгээр хангах ажлын хүрээнд:

Аймаг орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг сумдын соёлын төвийн болон сургуулиудын номын санчдыг мэргэжил арга зүйгээр хангах ажлыг дараах байдлаар хэрэгжүүлж ажиллаа. Үүнд:

1. II/22-23. Ажлын байрны 2 өдрийн дадлагажих сургалтад Хилийн цэргийн 0166 дугаар ангийн номын санч Д.Болортуяад номын сангийн анхан шатны бүртгэл, ном ангилал, ном тавиурт хэрхэн байрлуулах талаар арга зүйн зөвлөгөөг өгч ажилласан.
2. II/28. Цогтцэций сумын номын сангийн үйл ажиллагаатай танилцан номын санч Б. Шинэбаярт зөвлөн тусалж, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.
3. IV/09. Цогтцэций сумын соёлын төвийн номын санд шинээр авсан компьютерт номын сангийн программ баазыг суулгаж, баазын аюулгүй ажиллагааг хангах талаар арга зүйн зөвлөгөө өгч ажиллав.
4. IV/16. Сэврэй сумын номын санч Ц.Дэлгэрмаад нэгбүрчилсэн бүртгэл, ном хэвлэлийн тооллого, лавлагааны талаар арга зүйн зөвлөгөөг өгч ажилласан. /Цахимаар/
5. 4-р сургуулийн номын санч Т.Баярсайханд номын сангийн орчныг сайжруулах төсөл боловсруулахад үйлчилгээ, уншлагын орчин, ном хэвлэлийн хадгалалт хамгаалалтын талаарх арга зүйн зөвлөгөө, тусламж үзүүлэв.
6. Байгууллагынхаа 80 жилийн ойн ажлын хүрээнд номын сан болон номын санчийн ажил мэргэжлийг сурталчлах, номын сангийн хөгжлийн түүхийг олон нийтэд танилцуулах зорилгоор аймгийн сумдын соёлын төв, сургуулийн

- номын санд ажиллаж байгаа болон ажиллаж байсан үе үеийн номын санчдын дунд “Номын сан ба дурсамж” эсээ бичлэгийн уралдааныг зарлаад байна.
7. МҮНсан, Хүний эрхийн үндэсний комисс, Дата клуб зэрэг байгууллагуудаас сумдын соёлын төвүүдэд хүргүүлсэн номуудыг бүртгэл, тооцоо баримт үйлдэн хуваарилах ажлыг зохион байгуулав.
 8. Аймгийн сумд, сургуулийн номын санчдын дунд 2024 онд зохион байгуулах арга зүйн сургалтын саналыг цахимаар авч нэгтгэн 9-р сард зохион байгуулах сургалтад тусгах бэлтгэл ажлыг хангав.
 9. Номын санчдын мэдлэг олгох цахим болон түр сургалтууд, мэргэжлийн сургалтын байгууллагуудын зар мэдээ, танилцуулгыг цахимаар хүргэн мэдээллээр хангаж ажиллав.
 10. XI/08. Булган сумын номын сангийн үйл ажиллагаатай танилцан номын санч И.Бат-Оюунд зөвлөн тусалж, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.



Засгийн газрын зорилтот сургалт: Нийт 6 удаагийн сургалтад давхардсан тоогоор 13 ажилтан хамрагдав.

Засгийн газраас болон салбарын хэмжээнд зохион байгуулагдсан зөвлөгөөн, сургалтуудад ажилтан ажиллагсад хамрагдан төр засгийн бодлого шийдвэрийг орон нутагт хэрэгжүүлэн, байгууллагын бодлогын баримт бичиг, үйл ажиллагаанд тусган ажиллаж байна. Үүнд:

1. IV/15. “Нийгмийн даатгалын багц хууль”, “Хүүхэд хамгааллын хууль”-ийн тухай сургалт /Нягтлан бодогч Т.Нарантуяа, Фондчин Т.Нямсүрэн, Сүлжээ-Мэдээллийн ажилтан Б.Оюунзаяа, Үйлчлэгч/нярав Ц.Бадамханд/
2. V/06. Соёлын сэргэлт-2024 Соёлын салбарын удирдах ажилтны зөвлөгөөн /Дарга А. Одончимэг/
3. V/07-V/08. Юнескогийн дэлхийн дурсамж хөтөлбөрийн Ази, Номхон далайн бүсийн хорооны 10-р ерөнхий чуулган /Дарга А.Одончимэг/
4. V/28.Номын сангийн нэгдсэн систем /ДаргаА.Одончимэг, Фондчин Т.Нямсүрэн/
5. V/03-V/07. Монгол улсын Соёлын биет бус өвийг хамгаалах чадварыг бэхжүүлэх үндэсний сургагч багш бэлтгэх сургалт 2-р шат /Дарга А.Одончимэг/
6. VI/13-VI/15. “Номын сангийн нэгдсэн систем” сургалтад номын сангийн мэргэжлийн ажиллагсад хамрагдан КОХА 22.11 суурьтай <https://e-lib.cis.mn/> нэгдсэн системийг номын сангийн үйлчилгээ үйл ажиллагаандаа нэвтрүүлэх бэлтгэлийг хангалаа. /Мэргэжлийн ажиллагсад/

Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 Арга зүйн сургалт: Нийт 17 удаа 116 ажилтан ажиллагсад

1. III/07. Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн төслийн танилцуулга, хэлэлцүүлэг
2. III/14. "Дижитал шилжилт: Виртуал орчинд ажиллах"
3. III/22. "Байгууллага, хувь хүний санхүүгийн төлөвлөлт, удирдлага"
4. III/28. "Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаа"
5. IV/13. "Төрийн албаны үнэт зүйл (эрхэм), үе хоорондын ялгаатай байдал"
6. IV/16. "Монгол төрийн зүтгэлтний хэв шинж (XX зууны эхэн үе)"
7. IV/18. "Төрийн албан хаагч нарт зориулсан эх хэл, бичгийн мэдлэг, чадвар, дадлын номын танилцуулга"
8. IV/26. "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын танилцуулга
9. V/02. "Хүний эрх хамгаалагчийг хамгаалах механизмын үйл ажиллагаа"
10. V/17. "Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгаа"
11. V/30. "Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль тогтоомжийг төрийн албан хаагч зөрчихөөс урьдчилан сэргийлэх нь"
12. VI/06. "Төрийн жинхэнэ албан хаагчийг томилох үйл ажиллагаанд тавих хяналт"
13. XI/26. "КОЙКА-гийн тэтгэлэгт хөтөлбөрийн талаарх мэдээлэл, зөвлөмж"
14. XI/07. "Төрийн албан хаагчийн ёс зүй ба эрүүл мэнд"
15. XI/21. "Төрийн албан хаагчийн ёс зүй" (Дижитал ёс зүй)
16. XI/28. "Төрийн албан хаагчийн ёс зүй" (Ёс зүй ба бодлого, үйл ажиллагаа)
17. XII/05. "Төрийн албан хаагчийн цалин хөлс /орон нутгийн нэмэгдэл/"

ХҮНИЙ НӨӨЦ

Шинэ байр ашиглалтад орох бэлтгэл ажлын хүрээнд номын сангийн бүтэц, орон тоог шинэчлэх төслийг боловсруулан шаардлагатай хүний нөөцийн судалгааг цалин хөлсний судалгааны хамт боловсруулан Соёл, урлагийн газарт хүргүүлэв.

Мэргэжил дээшлүүлэх сургалтууд:

Номын сангийн ажилтан ажиллагсдыг мэргэжил боловсролоо дээшлүүлэн бакалавр, магистрын боловсролын зэрэг эзэмших сургалтад хамрагдсан байдал:

1. Дарга А.Одончимэг ШУТИС-ийн "Бизнесийн удирдлагын магистр"-ын боловсролыг дүүргэв.
2. Мандах Их сургуулийн Нягтлан бодох бүртгэлийн эчнээ ангид Нягтлан Т.Нарантуяа суралцаж байна.
3. СУИС-ийн Соёлын сургуулийн "Номын сан судлал" мэргэжлээр бакалаврын эчнээ анги ХУТ-ын номын санч Г.Ренчиндаваа, Каталогч М.Баасанжав нар суралцаж байна.

Мэргэжлийн бусад байгууллагын сургалт: *Нийт 25 удаа давхардсан тоогоор 85 ажилтан албан хаагчид*

Орон нутгийн хэмжээнд зохион байгуулагдсан сургалт, арга хэмжээнд байгууллагын төлөөллийг оролцуулан мэдлэг, ойлголтыг дээшлүүлэхийн зэрэгцээ хамрагдсан албан хаагч дотоод мэдээллийн цагаар бусад ажилтнуудад мэдээлэл, мэдлэг олгож ажиллаж байна. Сургалтууд:

1. I/25.Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газраас байгууллагуудын эцэг эхийн зөвлөлийн "Анхдугаар уулзалт" /Сүлжээ-мэдээллийн ажилтан Б.Оюунзаяа/
2. II/05-IV/15. Төрийн албан хаагчдын үндэсний бичгийн сургалтад 8 хүн хамрагдан монгол бичгийн мэдлэг, ур чадвараа дээшлүүлэв.
3. II/20. "Хамгаалагдсан ирээдүй" хүүхдийн хөгжил хамгааллын жилийн нээлт /Дарга А.Одончимэг, Сүлжээ-Мэдээллийн ажилтан Б.Оюунзаяа, Фондчин Т.Нямсүрэн, Номын санч М.Сувданцэцэг, Харуул Х.Мөнххуяг/
4. II/29-III/01. "Бичиг хэргийн ажилчдын Монгол бичгийн сургалт" /Сүлжээ-мэдээллийн ажилтан Б.Оюунзаяа/
5. III/14. Дотоод хяналтын сургалт цахимаар /ФондчинТ.Нямсүрэн/
6. III/18. "Цахимд хэвшье" төрийн албан хаагчдын уулзалт /Дарга А.Одончимэг, Сүлжээ-Мэдээллийн ажилтан Б.Оюунзаяа, Фондчин Т.Нямсүрэн, Үйлчлэгч/нярав Ц.Бадамханд, Харуул З.Батхуяг, Нягтлан бодогч Т.Нарантуяа, Каталогч М.Баасанжав, Харуул Х.Мөнххуяг/
7. IV/17.Архив бичиг хэргийн ажилчдын сургалт /Сүлжээ-Мэдээллийн ажилтан Б.Оюунзаяа/
8. IV/24-29. МНБИ Санхүүгийн тайлагнал сургалт /Нягтлан бодогч Т.Нарантуяа/
9. IV/25-IV/27.МҮЭ-ийн Холбоо, ХБНГУлсын Фридрих Эбертийн Сантай хамтарсан "Хөдөлмөрлөх эрх" сэдэвт бүсийн сургалт /Каталогч М.Баасанжав/
- 10.IV/26. Төрийн албан хаагчдын нэгдсэн сургалт, лекц /Нягтлан бодогч Т.Нарантуяа, Фондчин Т.Нямсүрэн, Сүлжээ-Мэдээллийн ажилтан Б.Оюунзаяа/
- 11.V/16. Төсвийн удирдах ажилтны зөвлөгөөнд дарга А.Одончимэг, Нягтлан бодогч Т.Нарантуяа нар тус тус хамрагдав.
- 12.VI/06. "Санхүүгийн боловсрол ба банкны бүтээгдэхүүн үйлчилгээ" /Нягтлан бодогч Т.Нарантуяа/
- 13.IX/11.Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэжлийн түвшинг үнэлэх аргачлал. ХШҮХ-ийн мэргэжилтэн Б.Янжмаа зохион байгуулав. /Номын сангийн ажиллагсад/
- 14.IX/12."Манлайлал, менежмент, хувь хүний хөгжлийн" сургалт Аxiom сургалтын төв. /Сүлжээ-Мэдээллийн ажилтан Б.Оюунзаяа, Үйлчлэгч/нярав Ц.Бадамханд, Каталогч М.Баасанжав, Номын сан А.Алтанзул, Харуул З.Батхуяг, Х.Мөнххуяг/
- 15.IX/27. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан албан хаагчдыг чадавхжуулах сургалт. /Фондчин Т.Нямсүрэн, Сүлжээ-Мэдээллийн ажилтан Б.Оюунзаяа/
- 16.IX/27. BD System Asia LLC вирусын программын сургалт /Нягтлан бодогч Т.Нарантуяа, Каталогч М.Баасанжав, Номын санч Г.Ренчиндаваа, А.Алтанзул, Н.Даваажаргал/
- 17.X/08. "Цахимд зөв байя" бүх нийтийн цахим ур чадварын гуравдугаар сургалт /Сүлжээ-Мэдээллийн ажилтан Б.Оюунзаяа, Каталогч М.Баасанжав/
- 18.X/14. Монгол улсын Үндэсний номын сан дээр "Номын сангийн нэгдсэн цахим систем"-ийн давтан сургалтад хамрагдлаа. /Дарга А.Одончимэг, Сүлжээ-Мэдээллийн ажилтан Б.Оюунзаяа, Фондчин Т.Нямсүрэн, Каталогч М.Баасанжав, Номын санч Г.Ренчиндаваа, А.Алтанзул/
- 19.X/25. Орон нутаг дахь төрийн албан хаагчдын нэгдсэн сургалт /Дарга А.Одончимэг, Фондчин Т.Нямсүрэн/
- 20.XI/08. "Эрүүл монгол хүн" үндэсний хөдөлгөөн /Үйлчлэгч/нярав Ц.Бадамханд/
- 21.XI/11. Easy call нэвтрүүлсэнтэй холбоотой сургалт /Сүлжээ-Мэдээллийн ажилтан Б.Оюунзаяа, Фондчин Т.Нямсүрэн, Каталогч М.Баасанжав, Номын санч Г.Ренчиндаваа, А.Алтанзул, Н.Даваажаргал, Нягтлан бодогч Т.Нарантуяа/

22. XI/20. Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын эд хариуцагчдыг чадавхжуулах сургалт. /Фондчин Т.Нямсүрэн/
23. XI/22. Номын санч, мэдээллийн ажилтнуудын “MONGOLIAN LIBRARY UPDATE” ЗӨВЛӨГӨӨН XI УДААГИЙН ЗӨВЛӨГӨӨН “Хамтдаа хөгжье” уриатай Монголын номын санчдын “Mongolian library update” зөвлөгөөн XXI дэх удаагаа зохион байгуулагдсан. /Номын санч Н.Даваажаргал/
24. XI/28. Хүний эрхийн төлөө хамтдаа өдөрлөг төвийн бүсийн арга хэмээ зохион байгуулах сургалтад М.Баасанжав хамрагдав.
25. XII/4-5. Өмнөговь аймгийн номын санчид, соёлын төвийн дага нарт зориулсан “Бүх нийтийн соёлын боловсрол” сургалт /Дарга А.Одончимэг, Сүлжээ-Мэдээллийн ажилтан Б.Оюунзаяа, Фондчин Т.Нямсүрэн, Каталогч М.Баасанжав, Номын санч Г.Ренчиндаваа, А.Алтанзул, Н.Даваажаргал/

Ажилчдын мэдлэг, ур чадвар, харилцаа хандлага, хууль эрх зүйг дээшлүүлэх дотоодын сургалтууд *:Нийт 13 удаа хамрагдав*

1. I/25. “Сэтгэлтэй ажилтан” НТСТ-ийн дарга Б.Батболд
2. II/22. “Хүүхдийг номоор хөгжүүлэхүй” Дарга А.Одончимэг
3. II/29. “Аливааг хурдан сурах арга” Мэдээллийн ажилтан Б.Оюунзаяа
4. III/07. “Төлөвлөлт” НТСТ-ийн ёс зүй, төлөвлөлтийн багш М.Ууганбаяр
5. III/28. “Дохионы цагаан толгой” НТСТ-ийн багш О.Нарантуяа
6. IV/18. “Номын сангийн хууль эрх зүй” Дарга А.Одончимэг
7. IV/25. “Эмх цэгц” НТСТ-ийн багш О.Нарантуяа
8. IV/26. Өмнөговь аймгийн ҮЭХолбоотой хамтран “Хөдөлмөрийн холбогдолтой хууль дүрэм, журам” соёлын, урлагийн салбарт хөдөлмөрлөх эрхийн холбогдолтой эрх зүйн баримт бичгүүдийн танилцуулга, асуудлуудыг талаарх тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцүүлэг сургалтыг зохион байгуулав.
9. V/02. “Ажлын орчин дахь харилцаа” НТСТ-ийн багш О.Өлзийхишиг
10. VI/06. “Санхүүгийн боловсрол ба банкны бүтээгдэхүүн үйлчилгээ” Төрийн банк Ш.Охин /Номын сангийн ажиллагсад/
11. VI/13. “Хамгийн чухал юу вэ?” НТСТ-ийн багш О.Нарантуяа
12. X/29. Хүний эрх хамгаалагч гэж хэн бэ? Дарга А.Одончимэг
13. XI/13. “Байгууллагыг соёлоор удирдах нь” М.Алтаншагай /Эмэгтэй захирлуудын холбоо/

Туршлага судлах үйл ажиллагаа:

1. V/20. Дундговь аймгийн Төв номын сангийн хамт олонтой хамтран харилцан туршлага солилцох уулзалт өдөрлөгийг зохион байгууллаа.
2. V/27. МҮНСангийн шинэ байрны танхим, үйлчилгээний зохион байгуулалттай танилцан туршлага судлав. /Дарга А.Одончимэг, фондчин Т.Нямсүрэн/
3. VII/04- VII/06. Дундговь, Говьсүмбэр, Дорноговь аймгийн номын сангуудын үйл ажиллагаатай танилцаж, туршлага судалсан. /Дарга А.Одончимэг, Фондчин Т.Нямсүрэн, Номын санч Г.Ренчиндаваа, М.Сувданцэцэг/
4. X/14. Монгол Улсын Үндэсний номын сангийн салбар байрны үйл ажиллагаатай танилцаж, туршлага судалсан. /Дарга А.Одончимэг, Сүлжээ-Мэдээллийн ажилтан Б.Оюунзаяа, Фондчин Т.Нямсүрэн, Каталогч М.Баасанжав, Номын санч Г.Ренчиндаваа, А.Алтанзул/
5. X/16. Бээжин хотын номын сантай танилцаж, туршлага судалсан. /Дарга А.Одончимэг, Сүлжээ-Мэдээллийн ажилтан Б.Оюунзаяа, Фондчин Т.Нямсүрэн, Каталогч М.Баасанжав, Номын санч Г.Ренчиндаваа, А.Алтанзул/

АЖИЛЧДЫН НИЙГМИЙН АСУУДЛУУДЫГ ШИЙДВЭРЛЭХ ХҮРЭЭНД

- I/01-XII/31. Ажилчдын өдрийн хоолны мөнгийг сар бүр олгов.
- VI/01. Хүүхдийн баярын хүрээнд ажилчдын 15 хүүхдэд номтой бэлэг гардуулан аав, ээжийнх нь ажил мэргэжлийн тухай ярилцаж, хүүхдээ сонсох арга хэмжээг зохион байгууллаа.
- X/09. Гэр бүлийн гишүүдийн хоорондын эерэг хандлага харилцааг дэмжих, номын санчийн ажил мэргэжлийг гэр бүлийн гишүүдэд танилцуулах, ажилчдын хүүхдүүдийн чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх зорилгоор "Жаргалтай гэр бүл" гэр бүлийн өдөрлөг арга хэмжээг 2024 оны 10 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулж шинээр байранд орсон ажилчдыг 500,000 төгрөгийн мөнгөн дэмжлэг үзүүлэн хүүхдүүдийг зураг зурах үйл ажиллагаанд хамруулав.
- "Эрүүл шүд" арга хэмжээг зохион байгуулах тухай Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.21 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, Засгийн газрын 2023 оны "Шүд арга хэмжээг хэрэгжүүлэх тухай" 322 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Эрүүл шүд" хөтөлбөрийг хэрэгжүүлэн байгууллагатаа Шүд угаах булан байгуулж,



ажилчид шүдээ угаах дадалд хэвшсэн.

- Ахмадын баярыг тохиолдуулан ахмадуудаа хүлээн авч "Хамтдаа дурсъя" номын хэлэлцүүлэг хийж хүндэтгэл үзүүлсэн.
- Ажиллагсдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг улирал бүр дүгнэнажилласан ба 1-4 дүгээр улирлын үр дүнгээр урамшуулал олгов.
- XI/04-XI/08. Төрийн албан хаагчдыг нийгмийн баталгаа, ажил орлоготой эрүүл байлгах тал дээр анхаарах, эрт илрүүлэгт тогтмол хамрагдаж байна. 2024 онд нийт албан хаагчид хуваарьт үзлэгт бүрэн хамрагдлаа.

- I/01-XII/31. Ажилчдын төрсөн өдөрт зориулан сар бүр хуримтлал үүсгэж, өөрийн болон өрхийн санхүүд нь хувь нэмэр болох зорилгоор уламжлал болгон тэмдэглэж ирсэн.
- I/01-XII/31. Байгууллагын Дотоод журмыг үндэслэн ажилчдын хүүхдүүдийн төрсөн өдрөөр 1 хоногийн цалинтай чөлөөг эцэг эхэд нь олгож эхлээд 2 дахь жилдээ хэрэгжүүлэн ажиллаж байна.

НОМЫН САНГИЙН БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨРҮҮД

1. I/17. "Тусч уншигч" хөтөлбөрийн хүрээнд "Ирээдүйн эзэд" номын клубийн гишүүдийн төлөөлөл Б.Бат-Ялалт, Б.Буяндэлгэр нар бяцхан дүү нартаа монгол үндэсний өв соёл, түүх, ёс заншлын тухай өгүүлэх Бумбардай "Аргалд явсан нь" номыг уншиж хүүхдүүдтэй харилцан ярилцаж мөн клубийн гишүүд өөрсдийн номын клуб болон анх ямар ном уншаад номд дуртай болсон талаараа яриа өрнүүлсэн. Нийт 15 хүүхэд.
2. III/06. Бүтээлч уншлага-хүүхдийн боловсролын хөтөлбөрийн хүрээнд 3-р сургуулийн Ц.Сайнзаяа багштай 10а ангийн хамт олны дунд кофетой уншлага хийж номын хэлэлцүүлэг зохион байгууллаа. Нийт оролцсон хүүхдийн тоо30.
3. IV/23. Тусч уншигч номын сангийн боловсролын хөтөлбөрийн хүрээнд "Ирээдүйн эзэд" номын клубийн гишүүдийн төлөөлөл Т.Хишигсүрэн, Ц.Ариунхүслэн нар цэцэрлэгийн бяцхан дүү нартаа Хормогчин театрын "Гурван тоорой"үлгэрийг ярьж өглөө. Нийт 30 хүүхэд.
4. V/27-VI/27."Тусч уншигч" хөтөлбөрийн хүрээнд Улсын тэргүүний лаборатори 1-р сургуулийн 12в ангийн сурагч Э.Гэрэлдэлгэр Хөгжлийн мэдээлэл сургалтын төв хамтран "Сайн дурын ажил" хийх зорилгоор Англи хэлний сургалтыг 1 сарын хугацаатай зохион байгуулж 10 сурагч хамрагдсан.
5. IV/25."Тусч уншигч" номын сангийн боловсролын хөтөлбөрийн хүрээнд 3-р сургуулийн Ц.Сайнзаяа багштай 10а ангийн төлөөлөл сурагчид "Номоо эмчилье" үйл ажиллагаанд Нийтийн уншлагын танхим болон Гэрээр номолгох танхимуудын урагдаж гэмтсэн номуудад 4 тусч уншигч сэлбэн засалт хийв.




ШИНЭЛЭГ АЖИЛ

1. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх, байгууллагыг олон нийтэд илүү таниулах, брэнд дүр төрхийг бүрдүүлэх зорилгоор орон нутгаас төрөн гарсан дизайнер болон уран бүтээлчидтэй хамтран байгууллагын брэндбүүкийг бүтээлгэн сурталчилгаа, болон байгууллагын өнгө үзэмж, тохижилт дизайнд ашиглаж байна.



2. Хүүхдийг номоор хөгжүүлэх чиглэлээр эцэг эхчүүдийг соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулахад ашиглах “Хүүхдээ номоор хөгжүүлэхүй” гарын авлагыг бэлтгэн сургалт мэдээллийн ажлын хэрэглэгдэхүүн болгон ашиглаж байна.




ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР/ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

1. Номын сангийн идэвхтэй уншигчид, номд шимтэн дурлагч хүмүүсийг номын сангийн үйл ажиллагаанд татан оролцуулж хамтран ажиллах, тэдний өөрийн сайн дураар бусдад туслах, мэдлэг, мэдээлэл түгээх хүсэл эрмэлзлэлийг дэмжин “Тусч уншигч” хөтөлбөрийг хэрэгжүүлж орон нутгийн дэмжлэгээр тусч уншигчдаа урамшуулан 7 удаагийн сургалт, мэдээлэл сурталчилгааны арга хэмжээг зохион байгуулж 430 иргэд, хүүхэд залуучуудыг хамруулжээ.

2. “Динза ба Цондоолой Цүндээлэйгийн найзууд” төслийг хэрэгжүүлж үндэсний агуулгатай комик номоор дамжуулан хүүхдийн монгол ахуй, зан заншил, ахмадыг хүндлэх, аливаад ухаалгаар хандаж даван туулах ухаарлыг олгох уншсан цувралын утга агуулгыг зурах зургийн, номын тэмдэглэлийн уралдаануудыг зохион байгуулж үр дүнг үнэлэн урамшуулсан өдөрлөгийг зохион байгууллаа. Нийт уралдаан арга хэмжээг орон нутгийн 5,0 сая төгрөгийн төсвөөр зохион байгуулж Ирмүүн агентлагийн тэтгэлэг 3,0 сая төгрөгийн дэмжлэгээр номын сангийн автоматжуулалтын эрхийн программ хангамжийн эрхийг сунгалтыг шийдвэрлэж ажиллав.

3. Орон нутгийн жилийн хөгжлийн төлөвлөгөө, дэд хөтөлбөрүүдийн хүрээнд ажил арга хэмжээг төлөвлөн нийт 50,401,500 төгрөгийн орон нутгийн төсвийн дэмжлэгээр соёл танин мэдэхүйн ажил, арга хэмжээг байгууллага бие даан буюу соёл урлагийн байгууллагууд, болон боловсролын байгууллагуудтай хамтран зохион байгуулж ажилласан байна. Мөн шинэ барилга ашиглалтад оруулахтай холбогдон 2024 онд нийт 2,4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийгдээд байна.

Хөрөнгө оруулалт /сая.төг/
шинэ байртай холбоотой




БУСАД АЖИЛ

1. I/26.Хос бичигтэн-Өмнөговь аяны нээлтийн үйл ажиллагаанд хамт олноороо оролцож байгууллагуудаар аялах Гэрэгэг хүлээн авч 7 хоногийн турш монгол бичгээр бичих, унших, танхимын хаягийг өөрчлөх гэх мэт үйл ажиллагааг зохион байгуулж дэвтрийг дараагийн байгууллагад хүлээлгэн өгсөн.
2. III/06. С.Удвал ахайтны 103 жилийн ой амьдрал, уран бүтээлийг алдаршуулан сурталчлах өдөрлөг арга хэмжээг хамтран зохион байгуулсан. /Дарга А.Одончимэг, Сүлжээ-Мэдээллийн ажилтан Б.Оюунзаяа, Фондчин Т.Нямсүрэн, Номын санч Н.Даваажаргал, Г.Ренчиндаваа/
3. III/21. Сар бүрийн 21 өдөр Даланзадгад сумын Засаг даргын А/51 дүгээр захирамжийн дагуу Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор олон нийтийн эргүүлийг хуваарийн дагуу ажилтан албан хаагчид хийж гүйцэтгэсэн.
4. IV/01. “Эрүүл шүд” хөтөлбөрт хамт олноороо хамрагдсан.
5. XI/04 Өмнөговь аймгийн БОЭТөвтэй хамтран “Эрт илрүүлэг” үзлэг оношилгоонд хамт олноо хамруулсан.
6. VII/05,VII/19.Даланзадгад сумын Засаг Даргын 317 тоот албан бичгийн хэрэгжилтийг ханган байгууллагынхаа ойр орчмын хог хаягдал, шарилжийг түүж нийтийн цэвэрлэгээг хамт олноороо хийж гүйцэтгэсэн.
7. VII/20. Өмнөговь аймгийн баяр наадмын нээлтийн үйл ажиллагааг хамт олноороо хамтран зохион байгуулсан.
8. VIII/20-VII/22. Гэрээр ном олгох танхимын номын санч М.Сувданцэцэгийн ажил хүлээлцэх тооллогын комиссын гишүүд хамтран ажиллаж ном, эд хөрөнгө, бичиг хэргийн файлууд гэх мэт шаардлагатай зүйлсийг А.Алтанзулд ажлыг хүлээлгэж өгсөн.
9. X/01.“Хамтдаа дурсъя” Олон улсын Ахмадын баярын өдрийг тохиолдуулан номын сангийн ахмад ажиллагсдадаа хүндэтгэл үзүүлэн хүлээн авах, тэдний ажиллаж байсан түүх дурсамж дурьдатгалыг хуваалцах арга хэмжээг зохион байгууллаа. Залуу үеийн ажиллагсад одоогийн ажил байдлын үйл ажиллагааны тухай мэдээллийг хүргэж танилцуулсан.
- 10.X/04. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн “Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр”-ийн хүрээнд манай хамт олон хуваарьт газраа 30 ширхэг тод тарьж суулгалаа.
- 11.XI/01. Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Соёлын бүтээлч сар” аяны нээлтэд манай байгууллага оролцсон.
- 12.XI/07. “Цэцгээр гоёсон гэр” Хамт олны уур амьсгалыг дулаан эерэг уур амьсгалыг бий болгох гэр бүлийн гишүүдийн бүтээлч байдлыг дэмжих, урамшуулах зорилготой гэрийн аль нэг хэсэгт өөрийн тарьсан цэцгүүдийг ашиглан орчин бүрдүүлэх чэллэнж зарлаж ажилчид идэвхтэй хамрагдлаа.
- 13."Дэлхийн хүүхдийн өдөр"-2024 "Ирээдүйгээ сонсьё" уриа дор тэмдэглэн өнгөрөөж буй энэ өдөр манай номын сангийн зүгээс уншлагын танхимуудаар үйлчлүүлж буй хүүхдүүдэд тухайн өдрийн мэдээ мэдээллийг хүргэж тэднийг хүндэтгэн үйлчилгээний танхимын номын санчид цэнхэр өнгөөр хувцсаар ижилсэн баярын үгтэй мэндчилгээний хуудас, анхны үйлчлүүлэгчдэдээ номын бэлэг, дурсгалын зүйлээр урамшууллаа.



ДҮГНЭЛТ



Нийт уншигчдын тоо өмнөх оныхоос 40.4%-аар өссөн энэ нь Зөөврийн номын сангийн үйлчилгээг багийн төв болон байгууллагуудад хүргэх үйл ажиллагааг зохион байгуулж насанд хүрэгсдийн ном уншлагыг идэвхжүүлсний, мөн хүүхдийн уншлагын танхимын уншигчдын тоо өмнөх оныхоос 53.5%-аар өссөн буюу хүүхдийн уншлагыг дэмжин ажиллаж эцэг эх асран хамгаалагчид нөлөөллийн ажил зохион байгуулж, Уншдаг хүүхэд хөгждөг аяны хүрээнд анги хамт олныг хамтын уншлагад хамруулан ажилласны үр дүн харагдаж байна.

Номын сангийн 80 жилийн ойн хүрээнд түүхэнд тэмдэглэгдэн үлдэх ажил, арга хэмжээг зохион байгууллаа. Үүнд:

- Өмнөговь аймагт номын сангийн салбар үүсэж хөгжсөний 80 жилийн түүхийг багтаасан “80 жилийн түүхтэй намтар зузаан номын сан” номыг эмхэтгэн гаргаж номын сан болон номын санчдын ажил үйлс, түүхэн үйл хэргийг олон нийтэд сурталчиллаа.
- 80 жилийн түүхэн нэвтрүүлгийг бэлтгэн гаргаж “Мэлмий” видео сайт, “Соён гэгээрүүлэгч” телевизээр орон даяар нэвтрүүлэн олон нийтэд хүргэсэн.


- Орон нутгийн ном зүйн бүтээлийг “Өмнөговь-орон нутгийн ном зүй” нэртэйгээр хэвлүүлж гаргасан нь Өмнөговь аймгийн Төв номын сангийн түүхэнд анхдагч нь болж байна.
- Сумд болон сургуулиудын ном уншлагаар манлайлагч шилдэг уншигч сурагчдыг хамруулсан “Тэргүүний уншигч” хүүхдийн зөвлөгөөн зохион байгуулсан.
- Аймгийн болон сумдын 3 үеийн номын санчдын ажил үйлсийг сурталчилж, түүх, туршлагаас харилцан ярилцаж солилцох боломж бүрдүүлсэн ажлуудыг зохион байгуулсан.

Номын санчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, ажил үйлсэд шинэ туршлага хуримтлуулах боломж олгосон арга хэмжээнүүд зохион байгуулсан Үүнд:

- Говийн бүсийн аймгуудын номын сангийн үйлчилгээ үйл ажиллагаатай танилцсан.
- МҮНСангийн шинэ байрны тохижилт, зохион байгуулалт үйл ажиллагаатай танилцсан сургалтад хамрагдсан.
- Бээжин хотын Эрдмийн ой номын сангийн үйл ажиллагаатай танилцан номын сангийн орчин үеийн чиг хандлага, дэвшилтэт технологийн хэрэглээний талаар мэдлэг, ойлголтоо нэмэгдүүллээ.

Сан хөмрөгийг өмнөх онуудтай харьцуулахад илүү баяжуулж ажилласан ба ингэхдээ орон нутгийн онцлог чухал лавлагааны номуудаар баяжууллаа.

САН ХӨМРӨГИЙН БАЯЖИЛТ /төрөл ангиар/



2024 он орон нутгийн зүгээс номын сангийн шинэчлэл, хөгжилд зориулсан томоохон хөрөнгө оруулалт хийсэн, иргэдийн уншлагыг дэмжин ажилласан онцгой жил байлаа.

Номын сангийн барилгын үндсэн гүйцэтгэлийг хүлээн авах комисс хуралдан хугацаатай үүрэг даалгавар өгсөн, дотоод интерьерийн ажил 85%-ийн гүйцэтгэлтэй удахгүй ашиглалтад орох энэхүү цаг хугацаанд номын сан шаардлагатай хүний нөөцийг бүрдүүлэх бодлого барин харьяа яам, орон нутагт асуудлыг тавьж шийдвэрлүүлж буй хэдий ч номын сангийн мэргэжлийн боловсон хүчин орон нутагт ховор байгаа нь сорилтыг бий болгож байна.

СҮХБААТАР АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ЗАХИРГАА УДИРДЛАГЫН АЖИЛ:

Соёлын салбарт “Үр дүнд суурилсан санхүүжилтийн аргачлал” журам батлагдан 2022 оноос мөрдөн ажиллаж байна. Уг журмын хэрэгжилтийн үр дүнгээр улсын хэмжээнд өмнөх жилийн байраа ахиулж 5 дугаар байрт дүгнэгдэж 25,000,000 төгрөгийн нэмэлт санхүүжилт авсан.



Аймгийн Соёл Урлагийн газрын даргатай 2024 онд хамтрах ажиллах гэрээ байгуулж, аймгийн Засаг даргатай “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г батлуулан, хэрэгжилтийг ханган ажилласан.



Ажилтан, албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, даваа гариг бүрийн аймгийн удирдах ажилтны шуурхай хуралдаанд тогтмол сууж, мэдээллийг албан хаагчдад хүргэн, “Долоо хоног бүрийн шуурхай” хурлыг Мягмар гараг бүрийн 09:00 цагаас тогтмол хийж хэвшсэн.

Байгууллагын үйл ажиллагааг хангах, хөтөлбөр, арга хэмжээг хэвийн явуулах, уншигч ирэгсдийн ая тухтай орчинг бүрдүүлэх зорилгоор ажилтан, албан хаагчдаас хэрэгцээт шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн судалгааг авч, хамт олны хурлаар хэлэлцэн шийдвэрлэж, 7.082.700 төгрөгний эд хогшил, техник хэрэгсэл худалдан авсан.

Байгууллагын захирал өөрийн мэдлэг боловсролоо дээшлүүлэн “Шихихутаг” их сургуульд эрх зүйч мэргэжлээр суралцаж байгаа бөгөөд удирдах ажилтны шуурхай хурал дээр явагдаж байгаа Үндэсний бичгийн хичээл даалгаврыг тогтмол хийн цахим сүлжээнд байршуулж ирсэн. Байгууллагын албан хаагчдын ажлын цаг бүртгэлийг ERP системээр хийж эхэлсэн бөгөөд чөлөө хүссэн тохиолдолд зөвхөн



01	02	03	04	05	06	07	08
Ба	Бя	Ня	Да	Мя	Лх	Пу	Бс
Х			БД	Х	Х		
Э			Э	БД	Т	И	
И			И	И	И	И	
И			И	Х	И		
И			Э	И	И	И	
И			И	И	И	И	
Э			И	Э	И	И	
И				Ч	Ч	Ч	

төрийн албаны ERP системээр шийдвэрлэдэг болсон.

Мягмар гараг бүрийн 09:00 цагаас Монгол бичгийн уншлагын цагийг тогтмолжуулан арга зүйч Т.Чандмань монгол бичгийн хичээл орж хэвшсэн.



НОМЫН САНГИЙН САН ХӨМРӨГИЙН БҮРДҮҮЛЭЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТ

Номын сангийн сан хөмрөгийн бүрдүүлэлт, бүтэц зохион байгуулалт, боловсруулалт, байрлуулалт, эргэлтийн байдал:

Төсвөөр: 187700 төгрөгний 58 ш ном, хандиваар 1596000 төгрөгний 173 ш нийт 231 ш 3473000 төгрөгний ном авч, данс бүртгэлд бүртгэн, техник ажиллагаа хийж, электрон каталогит оруулан баркоджуулж, танхимдуудад хүлээлгэн өгсөн.



Номын сангийн сан хөмрөгт үнэлэлт, дүгнэлт хийж судалгаа хийсэн эсэх


Уншлага үйлчилгээг “Үүлэн технологи”-д суурилсан шинэлэг үйлчилгээгээр 2019 оноос нэвтрүүлэн ажиллаж, аймгийн нийтийн номын сан цахим каталогт 18869 нэр төрлийн 44610 ном, 12 сумдын соёлын төвийн номын сангууд 29086 ном нийт 27555 нэр төрлийн 73696 ном мэдээллийн баазад байршсан.

Номын сангийн тооллого, хадгалалт хамгаалалтын талаар хийж хэрэгжүүлсэн ажлын талаар: Нийтийн уншлагын танхимд ээлжит тооллогыг хийж, номыг электрон каталог, гар дансанд тулгалт хийн, тооллогын явцад номын ангилал солих, шинээр баркоджуулах, ангиллын зөрчлийг тухай бүр засах, актлах номыг ялгаж авах, тавиурт ББК ангиллаар байрлуулах, номын ариутгал, цэвэрлэгээг хийх зэргээр ажилласан.

Гэрээр ном олгох танхимын тооллогоор уншигчдын гар дээр байсан Гэрээр ном олгох танхимын уншигчийн гар дээрх 300 гаруй номыг тооллогонд оруулан уншлага үйлчилгээнд гаргаж, англи хэл дээрх 150 гаруй номыг электрон каталогит оруулсан.



Урагдаж гэмтсэн ном-ыг тухай бүр нь үдэж, нааж, засаж, сэлбэн уншлага үйлчилгээнд гаргаж байна. Үүнд: Super детектив 1,2, Сидни шелдон, Хүйтэн уулын



бичиг, Эмзэг газрыг нь олж цохь, Тэнгэрийн хаяа, Газар шороо, Ор хөнжлийн орос орон, Түрүүлж л үхэхгүй юмсан, Шоронгийн хаалтта түүхээс-3, Дотоод ариуслын мөн чанар, Гүн ухаан, Мухулай, Өсвөр насныхны дээдэлж мөрдөх 7 зуршил, Хувь заяаны цадиг, Хөл хориотой бүсэд, Аав жанжин, Төөрөлдсөн хүүхэд, Монгол уран зохиолын дээж бичиг, Хятад гудамжинд гарсан хэрэг, Танин мэдэхүйн нэвтэрхий толь (амьтад), Мадонна, Үлгэрийн далай, Библийн 100 үлгэр, Сонгодог зохиолууд, Математикийн гайхамшигт ертөнц, Танин мэдэхүйн нэвтэрхий толь (Үлэг гүрвэл) Бөгтрөгтэй морьхон, Хүүхэд залуучуудын нэвтэрхий толь, Сүхбаатар аймаг түүхэн товчоон, Дэлхийн шилдэг 100 үлгэр, Монгол жангар, Улаан сүүний урсгал... гэх зэрэг 115ш ном слэбэн зассан.

Хуучин сонинг үдэж янзлах, бор хавтасжуулан архивлаж, Үүнд : Өдрийн сонин-5ш, Зууны мэдээ-5ш, Хүмүүн бичиг 2007, 2009, 2005, 1999, 2012, 1997, 2009, 1993, 2000, 1998, 1994, 2008, Утга зохиол-1996, Ардын эрх-2006, 1997, 1998, 2007, 2005, Гайхмаараа-1995, 1997, Хууль зүйн мэдээ-2006, Говийн бизнес мэдээ-2000, Ням гариг-1994, Байгаль-1994, Инфо-2005, Үнэн-2008, 2007, 1995, Зууны мэдээ-3ш, Ардын эрх-2ш, Өдрийн сонин-4ш, Цох-1ш, Яагаад -2ш, Үнэн сонин-10ш нийт **70ш** сонин үдэж цэгцэлсэн ба хүүхдийн танхимын өдөр тутмын үйлчилгээнд гарсан **7417** ш номыг ариутгасан.



НОМЫН САНГИЙН УНШЛАГА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Уншигчдад номын сангаас үзүүлж буй үйлчилгээ болон номын сангийн үйлчилгээний инноваци, нэн шаардлагатай үйлчилгээ:

Номын сангийн үйлчилгээг өргөжүүлэх, номын сангийн танхимаар үйлчлүүлэх уншигч, иргэд, ном олголтыг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг сайжруулах зорилгоор ЕБС-иуд, албан байгууллагууд, иргэдийн дунд “Оюунлаг” иргэн, анги хамт олон, байгууллагыг шалгаруулах уралдааныг 03 дугаар сарын 11-ний өдрөөс 12 дугаар сарын 05 хүртэл зарласан.

Байнгын уншигч-2930/2863

Ирэгсэд-13000/11433

Ном олголт-19800/15809

Номын сангуудад шаардлагатай төсөл-хөтөлбөр

СҮХБААТАР АЙМГИЙН ОНЫ ШИЛДЭГ УНШИГЧ ШАЛГАРУУЛАХ “СУДАР ЭГШИГЛЭН” ТӨСӨЛ

“Судар эгшиглэн-2024” төсөл 4 жилдээ хэрэгжиж, Улаанбаатар хот, Увс, Өвөрхангай, Хэнтий, Дорнод, Дорноговь, Сүхбаатар аймгаас давхардсан тоогоор 10000 гаруй уншигчийн 50000 номын тэмдэглэлийг цахим орчинд байршуулан сурталж, шилдэг уншигчдаа тодруулсан.

СОЁЛ ОЛОН НИЙТИЙН АЖИЛ :



Шинэ номын болон тэмдэглэлт өдрүүдэд зориулж сэдэвчилсэн номын үзэсгэлэнг:

- Д.Сүхбаатарын мэндэлсний 132 жилийн ойд зориулж, 15 ном
- Хүүхдийн уншлагын танхимд “Шинэ ном”, “Танин мэдэхүйн цувралууд”-85 ном
- Хүүхдийн зохиолчдын бүтээл-29 ном
- Нутгийн зохиолчдын бүтээл-60 ном
- Яруу Увидас- Хүүхдийн зохиолчдын бүтээлээр 35 ном
- Яруу Увидас- Нутгийн зохиолчдын бүтээлээр 150 ном
- “Хүүхдийн шилдэг цуврал номнууд”-80 ном
- “Үндэсний бичиг соёл, Номын өдрүүд-2024” арга хэмжээ-200 ном
- “Үлгэрийн ертөнцөөр аялцгаая” 150 ном
- “Шинэ ном”-35 ном
- “Зуны зугаатай уншлага” 80 ном
- “Үлгэрийн ертөнцөөр аялцгаая” 150 ном
- Сурагчдын заавал унших номнууд”
- 1970-1990 оны хүүхдийн шилдэг номнууд- 100
- “Эх хэлний өдөрт” 80
- “Дэлхийн шилдэг ном” -100 ном
- “Жаахан шарга-2024” монгол бичгийн уралдаанд Нутгийн зохиолчдын 122 ном
- Дэлхийн номын өдөрт “Яруу увдас” арга хэмжээний хүрээнд Түмэнцогт сумын Соёлын төвд-60
- МЗЭ-ийн Сүхбаатар салбарын 70 жилийн ойд -160
- Аймгийн цагдаагийн газарт-30 номоор нийт 1667 номоор, шинээр ирсэн Монгол хатад, Монгол хаад цуврал ботиудыг монгол бичгээр номзүйн бичилтийг зурагжуулан сурталчилсан.

Номын цахим танилцуулга-ыг “Сарны үлгэр”, “Үлэмж биетний үлгэр”, “Элээ




яагаад янцгаадаг болсон бэ?" үлгэрээр 6 удаа, "Цасны баяр", "Эмээ бид хоёрын тухай бяцхан ном", "Би өнөөдөр ниснэ", Хүүхдийн шилмэл зохиолын эрдэнэсийн сан 108 цуврал, Зохиолч Б.Наминчимэд "Галт шувуу" роман, Б.Ойдов "Луу амталан нулимс" роман, "Өнхөрч яваа чулуу" роман, Б. Сарантуяа "Ял тулгасан замбуулан, Амжилт-800 гэх зэрэг номоор хийж, байгууллагын цахим хуудсаар сурталчилсан.



Enhtuya Wolooj is with Сүхбаатар Аймаг Номын Сан
Jan 5
ГЭРЭЭР НОМ ОЛГОХ ТАНХИМД ШИНЭ НОМ ИРЛЭЭ.
№-01
ӨНХӨРЧ ЯВАА ЧУЛУУ
Өнгөрсөн зууны жаран найман онд Чех улсад коммунизмын эсрэг томоохон бослого дэгдэж, үүнийг Зөвлөл... See more



Enhtuya Wolooj is with Сүхбаатар Аймаг Номын Сан
Jan 5
ГЭРЭЭР НОМ ОЛГОХ ТАНХИМД ШИНЭ НОМ ИРЛЭЭ.
№ 02
"Шинэ ном" Л. Сарантуяа
"Ял тулгасан замбуулин" роман
"Үнэний мөр хэзээ ч балрахгүй"
"Гориг шиг дугуйлж намайг х..." See more



Enhtuya Wolooj is with Сүхбаатар Аймаг Номын Сан
Jan 5
ГЭРЭЭР НОМ ОЛГОХ ТАНХИМД ШИНЭ НОМ ИРЛЭЭ.
№-01
ӨНХӨРЧ ЯВАА ЧУЛУУ
Өнгөрсөн зууны жаран найман онд Чех улсад коммунизмын эсрэг томоохон бослого дэгдэж, үүнийг Зөвлөл... See more






“English book time” цахим номын танилцуулгын англи шинэ номын танилцуулгыг сар бүр видео хэлбэрээр 6 цувралаар бэлтгэн, байгууллагын цахим хуудсаар хүргэлээ.



“АЛТАН ХОНХ” УРАЛДААНТ ТЭМЦЭЭН: Д. Сүхбаатарын мэндэлсний 132 жилийн ойд зориулж Барилгын цэргийн 338-р салбарт уншсан номын тэмдэглэл бичих уралдаан зарлаж, “Алтан хонх” уралдаант тэмцээн зохион байгуулахад нийт 80 цэргийн албан хаагч хамрагдсан.

“ЦАГААН САР” ГАР ЗУРГИЙН УРАЛДААН: Монголын уламжлалт сар шинийн баярыг угтаж, “Цагаан сар” гар зургийн уралдааныг зохион байгуулахад 100 гаруй хүүхэд багачууд оролцсон.




ДЭЛХИЙН ЯРУУ НАЙРГИЙН ӨДӨР-Дэлхийн яруу найргийн өдөр-т зориулж, МЗЭ-ийн Сүхбаатар аймаг дахь салбартай хамтран “Яруу увидас”-арга хэмжээг зохион байгууллаа. Уг арга хэмжээний үеэр

- МЗЭ-ийн гишүүн Уртнасангийн Будын “Уран бүтээлийн танилцуулга, уулзалт” / Яруу найрагчийн хувийн цуглуулгын үзэсгэлэн, уран бүтээлийн номзүйн лавлагаа, шинэ номын үзэсгэлэнг гарган сурталчилж, найрагчийн зохиолын дууны сангаас ХЖТ-ын дуучид ая дуугаа өргөсөн /

- Нутгийн зохиолчдын номын үзэсгэлэн
- “Үзэсгэлэн гоо бүсгүйчүүд”, “Халхын сайхан эрчүүд” цахим шүлгийн уралдааны шагналт байрын оролцогчдын шүлгийн уншлага

- Шүлэг яруу найраг сонирхдог хүүхдүүдийн уран бүтээлээс сонсож, “Үзэсгэлэн гоо бүсгүйчүүд”, “Халхын сайхан эрчүүд” цахим шүлгийн уралдааны шүлгийн уралдаанд оролцогчдын шүлгээр “ЯРУУ УВДИС” товхимол гаргаж, нийт 12 сумдын нийтдээ 24 яруу найрагч идэвхтэн бичигч, сонирхогчдын 30 гаруй уран

бүтээл орсон бөгөөд нийтдээ 40 гаруйг хэвлэн гаргаж, шинэ шүлгийн сонирхогч нарын шинэхэн шүлгүүдийг нийтэд сурталчлан түгээж, уг арга хэмжээн дээр гардуулсан. Тус арга хэмжээнд яруу найрагч, идэвхтэн бичигч, дэмжигч, орон нутгийн иргэд, ЕБС-ийн сурагчид зэрэг 120 гаруй хүн хамрагдлаа.



ДЭЛХИЙН НОМЫН ӨДӨР: "БИД -УНШИГЧ" номын клубын сурагчид БӨДБ-ын бага ангийн сурагчдад "Ном уншихын ач холбогдол" -ын талаар сургалт мэдээллийг хүргэж, "Номын тэмдэглэл хөтлөх аргачлал"-ийг зааж зөвлөн өөрсдийн тэмдэглэсэн номын тэмдэглэлүүдээр танилцуулга хийж харилцан ярилцлагыг хийсэн.



МСҮТ-ийн номын санчтай хамтран “Хуучны мартагдсан ном”-ын болон нутгийн зохиолчдын номнуудыг суртачлах зорилгоор дэлгэмэл үзэсгэлэнг зохион байгуулсан. Аймгийн Соёл урлагийн газар, МЗЭ-ийн Сүхбаатар аймаг дахь салбартай хамтарч, Түмэнцогт суманд ажиллаж, соёлын төвийн номын санд зөвлөн туслах ажиллагаа явуулж, нутгийн зохиолчдын болон шинэ номын үзэсгэлэнгээ дэлгэж, сумын номын сантай танилцаж, ЯРУУ УВДИС өдөрлөгөө амжилттай зохион байгуулсан.



“ҮНДЭСНИЙ БИЧИГ СОЁЛ, НОМЫН ӨДРҮҮД-2024” ХАВРЫН НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭ:

Нийтээр тэмдэглэх баяр болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль, “Алсын хараа”-2025” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлигийг хэрэгжүүлж, номын баярыг 05 дугаар сард “Илүү их уншъя” уриатайгаар тэмдэглэн өнгөрүүллээ. Монгол Улсын Их хурлын даргын ивээл дор жил бүр зохион байгуулдаг номын баярыг “Илүү их уншъя” уриан дор зохион байгуулж, энэ хүрээнд тусгай хөтөлбөрийн дагуу 20 нэр төрлийн арга хэмжээг зохион байгууллаа.

“Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2024” арга хэмжээний ерөнхий зохион байгуулагчаар Аймгийн нийтийн номын сан, хамтран зохион байгуулагчаар соёл, урлагийн байгууллагууд ажиллаж, иргэд, уншигчид, номын санчид, ном хэвлэлийн төлөөлөгчид, зохиолч, яруу найрагчид, шүлэг яруу найраг сонирхдог хүүхэд залуус нийт 2000 гаруй хүн хамрагдсан байна.

“Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2024” нэгдсэн арга хэмжээнд:

1. Нийтийн номын сангийн нийгэмд гүйцэтгэх үүрэг, соёл гэгээрүүлэх ач холбогдол, төгсөх ангийн сурагчдад мэргэжлээ сонгоход нь номын санч мэргэжлийн онцлогийг сурталчлах

2. Ном уншихын ач тусын талаар хүүхэд, залуучуудад сурталчлах

Олон төрлийн номын үзэсгэлэн зохион байгуулах

- Номын сангийн мэргэжлийн холбогдолтой номын үзэсгэлэн

- Нутгийн зохиолч, яруу найрагчдын

- Ховор ном, ганц хувь номын үзэсгэлэн

- Монгол бичгийн номын үзэсгэлэн гаргаж сурталчлах

3. Аймгийн нийтийн номын сангаас эрхлэн гаргасан орон нутгийн ном зүйн бүртгэл болон ном, товхимлын худалдаа, үзэсгэлэн гаргаж сурталчлах

4. Орон нутгийн соёлын өв, түүхийг сурталчлах зорилгоор баримтат өвийн үзэсгэлэн гаргах

5. Хүүхэд, залуучуудыг номтой нөхөрлүүлэх, уншлагын дэмжих ажлын хүрээнд:

6. “Book flashmob” зохион байгуулах

7. “Сүхбаатарын үлгэрч хүүхдүүд” уралдааныг дүгнэж, шагналыг нээлтийн арга хэмжээн дээр гардуулах ажлыг зохион байгуулах

8. Яруу найргийн “Open mic -2” арга хэмжээг зохион байгуулах

9. Монгол бичгийн бичвэрийн үзэсгэлэнг гаргаж сурталчлах

10. Үндэсний мэдлэг чадварыг дээшлүүлэх “Монгол бичгийн аварга уншигч-3” уралдаан зохион байгуулах
11. “Цэвэр сайхан бичигтэн” уралдаан зохион байгуулах
12. “Үлгэрлээс үлгэрлэе” аяны хүрээнд “Хормогчин хүүхэлдэй”-гээр сургуулийн өмнөх насныханд Монголын болон дэлхийн сонгодог үлгэрүүдээр чанга уншлага зохион байгуулах
13. “Номын сайн нөхөр” уралдаан зарлах
14. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн хүрээнд төрөл бүрийн материалаар хийсэн ном, баринтаг, номын хавчуургын үзэсгэлэн гаргах
15. “Үлгэрийг зүрхээрээ амилуулья” харааны бэрхшээлтэй хүүхэд, иргэдийн дунд брайл болон цахим номын уншлагын хөдөлгөөн зохион байгуулах
16. “Монголын нууц товчоо” сэдэвт мэдлэг сорих “Агшин” тэмцээн зохион байгуулах
17. Нийтийн уншлагын танхимаас Боловсрол өргөө дотуур байртай хамтарч ажиллах /тусгай төлөвлөгөөний дагуу /
18. Яруу найрагч Б.Төгсжаргалтай “Зохиолч, уншигчдын уулзалт” зохион байгуулах
19. МЗЭ-ийн Сүхбаатар аймаг дахь салбартай хамтран “Яруу үдэш” арга хэмжээний хүрээнд ахмад номын санч Б. Сумъяаг алдаршуулах хүндэтгэлийн арга хэмжээ зэрэг ажлыг зохион байгууллаа.

Уралдаан тэмцээн:

Үндэсний бичиг үсгийн баярыг тохиолдуулан Монгол үндэсний бичиг соёл, эх хэлээ эрхэмлэн дээдлэх, судлах, монгол бичгээ сурч эзэмших, хойч үедээ өвлүүлэх, хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх сурталчлах зорилгоор **"МОНГОЛ БИЧГИЙН АВАРГА УНШИГЧ"** тэмцээнийг 3 дахь жилдээ амжилттай зохион байгуулж,

ЕБС-ийн 7-9 ангилалд: 115

ЕБС-ийн 10-12 анги, МБС-ын ангилалд: 35

Насанд хүрэгсдийн ангилалд: 14 нийт 164 хүн оролцсон.

Үндэсний бичиг үсгийн баярыг тохиолдуулан эх хэл, бичиг, үндэсний соёлоос суралцах, хойч үедээ танин мэдүүлэх, түгээн дэлгэрүүлэх, өвлөн уламжлуулах зорилгоор **"ЦЭВЭР САЙХАН БИЧИГТЭН"** уралдааныг ЕБС-ын 7-р ангийн сурагчдын дунд зохион байгуулахад 14 ангийн 190 гаруй бичвэр ирсэн.

"Үндэсний бичиг, соёл-Номын өдрүүд-2024" арга хэмжээг угтан номын сангаас олгох боловсролын хөтөлбөрийн хүрээнд Дарьганга ардын аман зохиол, зан заншил, өв соёлыг хойч үедээ өвлүүлэх, нутгийн хүүхдийн зохиолчдын бүтээлийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор **"СҮХБААТАРЫН ҮЛГЭРЧ ХҮҮХДҮҮД"** уралдааныг цэцэрлэгийн насны хүүхдүүдийн дунд зохион байгуулахад 10 цэцэрлэгийн 11 хүүхэд хамрагдсан.

Хүүхэд залуусыг номтой нөхөрлүүлэх, номонд дурлуулах сэдэл тэмүүллийг урамшуулах, гоо зүйн мэдлэг боловсрол олгох, хөгжүүлэх, зорилгоор зохион байгуулсан **"АГШИН"** цэнгээнт танин мэдэхүйн уралдааныг Баруун-Урт сумын ЕБ-ийн 4 дүгээр сургуулийн 8в ангийнхны дунд зохион байгуулсан.

2.5. Уулзалт хэлэлцүүлэг:

"Зохиолч-уншигчийн уулзалт" болж зочноор Яруу найрагч Батсүхийн Төгсжаргал, "Баян шарга" Төрийн бус байгууллагын тэргүүн Лосолын Бортой "Зохиолч-Уншигч"-дын уулзалтыг зохион байгуулахад нийтдээ 100 гаруй хүн хамрагдсан бөгөөд 1,5 мянган хүн хандалт хийжээ. Мөн яруу найрагчийн уран бүтээлээр аудио сурталчилгаа бэлтгэн сурталчлахад 1000 гаруй хүн хандалт хийжээ.

МЗЭ-ийн Сүхбаатар аймаг дахь салбартай хамтран 5 үе дамжсан ахмад номын санч Баатарын Сумъяаг алдаршуулах "Хүндэтгэлийн арга хэмжээ"-г зохион байгуулж, номын санчийн гэр бүл хамаатан садан хамтран тэмдэглэн өнгөрөөж,

аймгийн Соёл урлагийн газар, Ахмад багш нарын холбоо, Сүхбаатар аймаг дахь Урчуудын эвлэлийн салбар, аймгийн Ахмадын хороо, Баруун -Урт сумын ахмадын хороо, Албан бус боловсролын төв зэрэг байгууллага, холбоод, хамтран ажиллаж байсан дарга нарын төлөөлөл оролцлоо.

Санхүүгийн үйл ажиллагаа:

“Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2024” арга хэмжээнд нийт 2.600.000 гаруй төгрөг зарцуулсан.

Номын баярын нээлтийн үйл ажиллагаа:



Номын үзэсгэлэн:



Уралдаан тэмцээн: “Сүхбаатарын үлгэрч хүүхдүүд”



“АГШИН” цэнгээнт танин мэдэхүйн уралдаан



Шагнал гардуулалт:






Эх үрсийн баярын өдөрт "Хөгжилтэй зургаан өртөө" соёлын арга хэмжээнд оролцож танин мэдэхүй хөгжүүлэх, зохион бүтээх тоглоом, дартс, азтан шалгаруулж дэлхийн шилдэг хүүхдийн уран зохиолын номын үзэсгэлэн гаргаж, хүүхдийн номын худалдаа гаргана ажилласан.



Эх хэлний өдрийг тохиолдуулан эх хэлээ сурталчлах, түүгээр бахархах, олон нийтэд түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн эх хэл соёл, түүх, зан заншил, өв уламжлалын тухай мэдээ мэдээллийг байгууллагын цахим хуудсанд оруулан түгээсэн. БТА, ахмад багш С. Мандахтуяатай зочин подкаст хийж сурталчлахад 810 хүн хандалт өгсөн.



“ҮНДЭСНИЙ БИЧИГ СОЁЛ, НОМЫН ӨДРҮҮД-2024” НАМРЫН НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2012 оны 158 дугаар зарлигийг хэрэгжүүлж, Номын баярыг Монгол Улсын Их хурлын даргын ивээл дор жил бүр "Илүү их уншъя" уриан дор зохион байгуулдаг байсан бол энэ намрын арга хэмжээг Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор "Үндэсний бичиг соёлоо эрхэмлэн дээдэлье" уриан дор зохион байгуулж, тусгай хөтөлбөрийн дагуу 20 нэр төрлийн ажил үйлчилгээг зохион байгууллаа.

“Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2024” намрын нэгдсэн арга хэмжээнд:

2024 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр нээлтийн арга хэмжээг зохион байгуулж, нутгийн зохиолч, яруу найрагчдын уран бүтээлийг байгууллагын цахим хуудсаар тогтмол сурталчилж, Баруун-Урт сумын цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд “Чанга” уншлага хийж, ЕБС-ын 1-7 ангийн сурагчдын дунд "Олуулаа уншицгаая" аяныг үргэлжлүүлэн өрнүүллээ.

Үзүүлэн таниулах ажлын хүрээнд: Эх хэлний өдөрт эх хэлний болон монгол бичгийн ном, бичвэрээр үзэсгэлэн гарган, подкаст хийж, байгууллагын цахим хуудсаар сурталчилсан. Нутгийн зохиолчдын болон хүүхдийн шилдэг номоор сэдэвчилсэн номын үзэсгэлэн гаргаж, “Судар эгшиглэн” номын тэмдэглэлийн үзэсгэлэнг давхар гаргаж сурталчилсан.

Уралдаан тэмцээн: "Угийн бичиг удмын хэлхээ" аяныг өрнүүлж, МЗЭ-ийн Сүхбаатар аймаг дахь “Яруу увдис-9” арга хэмжээ, Харааны бэрхшээлтэй иргэдийн дунд “Үлгэрийг зүрхээрээ амилуулья” брайл болон цахим номын уншлагын хөдөлгөөн явуулж, Соёл-спорт өдөрлөгт хамрагдаж, Зэвсэгт хүчний 338 дугаар анги дээр ном уншиж, номын тэмдэглэл бичих хөтөлбөрийн 2 дахь удаагийн аян зохион байгуулж, багийн ахмадуудад арга хэмжээ зохион байгууллаа.

Номын баярын арга хэмжээнд оролцогчид:

Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2024” арга хэмжээний ерөнхий зохион байгуулагчаар Аймгийн Нийтийн номын сан, иргэд, уншигчид, соёлын байгууллагууд, яруу найрагчид, шүлэг яруу найраг сонирхдог хүүхэд залуус нийт хамрагдсан.

Арга хэмжээний үеэр хүндэтгэл үзүүлэх, шагнал гардуулсан тухай мэдээлэл:

Арга хэмжээний үеэр хүндэтгэл үзүүлэх:

Соёл, урлагийн салбарын Ахмадын хөгжлийн зөвлөлийн дарга Г.Энхцэцэг, тэргүүлэгч М. Дэнсмаа нарын санаачилгаар “Ахмад ажилтнуудын дурсамж уулзалт”-ыг зохион байгуулж, телевизийн бичлэг хийлгэсэн.

Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газраас арга хэмжээнд оролцож буй 25 ахмадыг хүлээн авч хүндэтгэл үзүүллээ.

Аймгийн Нийтийн номын сангаас Соёлын ахмадууддаа хүндэтгэл үзүүлэн ТВ ярилцлага хийх ая тухтай орчинг бүрдүүлэн тэдний зохион байгуулж үйл ажиллагааг дэмжин 300.000 мянган төгрөгөөр ивээн тэтгэсэн.

Шагнал гардуулсан тухай

Баруун-Урт сумын “Хүндэт тэмдэг”-ээр номын санч, мэдээллийн ажилтан Г. Эрдэнэчимэг, Баруун-Урт сумын ЗД-ын “Баярын бичиг”-ээр бичиг хэрэг, архивын

ажилтан Оюунтуяа, нягтлан бодогч Батсүрэн, МЗХ-ийн “Тэргүүний залуу” медалиар шагнагдсан.

Арга хэмжээний үеэр СУАЖЗГ-аас салбарын байгууллагуудын дунд зарласан Уран бичлэгийн уралдааны шагнал гардууллаа.

Судар эгшиглэн төсөл, Насан туршийн боловсролын төвөөс зохион байгуулсан арга хэмжээнд амжилттай оролцсон тэргүүний оролцогчдоо шагнаж урамшуулсан.

Энэ удаагийн номын баярын онцлог тал гэвэл:

Энэ удаагийн номын баярыг Соёл, урлагийн ажилтны баяр, Нээлттэй хаалганы өдөртэй цуг хамтатган тэмдэглэснээрээ онцлог боллоо.

Хоёр. Зохион байгуулсан үйл ажиллагаа:

"Үндэсний бичиг соёл-номын баярын өдөр"-т зориулсан "Соёлын орон зай - Нээлттэй хаалганы өдөр"-ийг Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар, Нийтийн номын сан, Жаахан шарга театр, Угсаатны зүйн музейтэй хамтран 09 дүгээр 14-ний өдөр зохион байгуулсан.

Номын баярын нээлтийн үйл ажиллагаанд зориулан уншигч хүүхдүүд ая дууны түрлэг өргөж, Ерөнхий боловсролын 4-р сургуулийн Алтантуяа багштай 3-р ангийн уншигч сурагчид Орос ардын "Өнхрүүш" үлгэрээр дүрийн тоглолт тоглож, "Судар эгшиглэн" номын тэмдэглэлийн нээлт, яруу найргийн "Open mic" нээлттэй уншлага, Судар эгшиглэн номын тэмдэглэлийн нээлтийн арга хэмжээ зэргийг зохион байгуулж уншигч хүүхдүүд бүжгийн үзүүлбэрээр мэндчилгээ дэвшүүлж оролцсон.

Гадна талбайн асарт Аймгийн Нийтийн номын сангийн уншлагын танхимуудаас 120 гаруй номоор сэдэвчилсэн үзэсгэлэн гарган ажиллаж байгууллагын танилцуулга тараан сурталчилж, гаднах талбайн орчинг бүрдүүлэн ажиллахад давхардсан тоогоор 500 гаруй хүн хамрагдсан.

Баруун-Урт сумын 9 дүгээр багийн 180 ахмад, 2-р багийн 120 ахмад, багийн албадтай хамтран Ахмадын нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, дэмжих, идэвхижүүлэх тэдний үзэл бодлыг сонсох зорилгоор "ХАЙЛААСТЫН АХМАДУУД", УРТЫН ГОЛЫН АХМАДУУД" чуулга уулзалтыг багийн ажлын алба, ахмадын зөвлөл, нийтийн номын сантай хамтран зохион байгууллаа. Тус чуулганаар:

- Номын үзэсгэлэн, худалдаа
- Уншигчийн карт нээх, ном сурталчлах
- "Агшин" хөгжөөнт тэмцээн
- Ном солилцох үйл ажиллагааг зохион байгууллаа.

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжсэн төрөл бүрийн материалаар хийсэн ном, баринтаг, хавчуурга болон бусад зүйлсийн үзэсгэлэн:

Судар эгшиглэн номын тэмдэглэлийн нээлтийн арга хэмжээг зохион байгуулж, номын тэмдэглэлээр үзэсгэлэн гаргаж, ивээн тэтгэгчээр ажилласан УИХ-ын гишүүн Н.Ганибал ирж оролцсон.

2.3. Уралдаан тэмцээн:

Харааны бэрхшээлтэй иргэд, хүүхэд, залуучуудын ном унших идэвхийг өрнүүлж, номтой нөхөрлүүлэх, ном соёлын үйлчилгээгээр дамжуулан нийгмийн зэрэг хандлагыг бий болгохын зэрэгцээ цахим болон сонсдог номын уншлагын эргэлтийг сайжруулах замаар тэднийг ном унших хөдөлгөөнд уриалан, нийгэмд

хамтдаа хөгжих, сурч мэдэх эрхэнд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор ҮЛГЭРИЙГ ЗҮРХЭЭРЭЭ АМИЛУУЛЬЯ" брайл болон цахим номын уншлагыг зохион явуулахад Тэргүүн байр: Дагвадорж Батдулам /Баруун-Урт сум / Дэд байр: Ишгэн Хуягбаатар Баруун-Урт сум/

Гутгаар байр: Гомбосүрэн Бат-Эрдэнэ Асгат сум/ нар тус тус шалгарлаа.

Зэвсэгт хүчний 338 дугаар ангийн цэргийн албан хаагчдын дунд ном унших, номын тэмдэглэл хөтлөх хөтөлбөрийн 2 дахь аяныг зохион байгуулж, цэргийн албан хаагч нарт карт нээн, зөөврийн номоор үйлчлэн, номын сантай танилцуулах ажлыг зохион байгуулахад нийт 85 цэргийн байлдагч хамрагдсан.

Зэвсэгт хүчний 338-р цэргийн байлдагчдын дунд ханын сонин хийх /баг, салаагаар /уралдаант “Агшин” нэвтрүүлгийг бие бүрэлдэхүүнтэй хамтран зохион байгууллаа.

Ном унших, номын тэмдэглэл хөтлөх уралдаанд:

1-р байр: А/х У.Тэнүүн ахмлагчтай 2-р мотобуудлагын салаа

2-р байр: А/х Х.Төгөлдөр ахлагчтай 1-р мотобуудлагын салаа

3-р байр: А/х У. Насангэрэл ахлагчтай 3-р салаа шалгарлаа.

Уралдаанд агшин тэмцээнд:

2-р салааны байлдагч Г.Хишигням

1-р салааны байлдагч Н.Наранхишиг нар тус тус шалгарсан.

2.4. Уулзалт хэлэлцүүлэг:

Яруу найргийн үнэлэмжийг дээшлүүлэх, яруу найрагчид, идэвхтэн бичигч, иргэд сонирхогч нарын идэвхийг сэргээх, олон нийтэд сурталчлан таниулах, чанартай уран бүтээл туурвиулах зорилгоор Соёл урлаг аялал жуулчлал залуучуудын газар, Аймгийн Нийтийн номын сан, МЗЭ-ийн Сүхбаатар аймаг дахь салбар зөвлөл, Оюунлаг шатрын клуб, Сүхбаатар Аймгийн Ахмадын хороо хамтран Яруу увдис өдөрлөгийг 09 дүгээр сарын 19-ний өдөр хамтран зохион явуулж, тус арга хэмжээнд давхардсан тоогоор 100 гаруй ахмадууд идэвхтэй оролцлоо. Арга хэмжээний үеэр:

-МЗЭ-ийн салбар зөвлөлийн гишүүдийн Шинэ шүлгийн уншлага

-Уран сайханчдын ая дууны эгшиг Дарьганга ардын дууг хэн сайн дуулах вэ

-Нийтийн номын сангийн Нутгийн зохиолчдын уран бүтээлийн үзэсгэлэн

-Азын сугалаа

-Нийтийн бүжиг гэх зэрэг арга хэмжээнүүд явууллаа.

Хүүхэд залуусын сурах эрмэлзэлд дэмжлэг үзүүлэх, ном эрдмийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор НОМЫН ХИШИГ-ЭРДМИЙН ТҮШИГ хэлэлцүүлэг, үзэсгэлэнг зохион байгуулахад 45 хүн оролцож,

🏠 Номын хэлэлцүүлгийн зочноор :

Аймгийн номын сангийн номын санч В. Энхтуяа

МЗЭ-ийн СБ аймгийн салбарын тэргүүн, яруу найрагч Ц. Оюундэлгэр

Ая дууны мэндчилгээ дэвшүүлэн хичээл зохицуулагч С. Үржинханд нар оролцлоо.

НОМЫН КЛУБЫН НЭГДСЭН АНХДУГААР ЧУУЛГА УУЛЗАЛТ

Номын клубын нэгдсэн анхдугаар чуулганыг 09 дүгээр сарын 27-ны өдөр Баруун-Урт хотноо амжилттай зохион байгууллаа. Тус чуулга уулзалтанд нийтдээ 12 сумд төвийн 22 номын клубын 187 уншигч хүүхдүүд, соёлын төв, Ерөнхий боловсролын сургуулийн номын санчид нийтдээ 225 гаруй хүн давхардсан тоогоор хамрагдлаа.

“Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2024” арга хэмжээ-г тусгай төлөвлөгөө гарган амжилттай зохион байгуулж, 20 төрлийн арга хэмжээнд нийт 2000 гаруй хүн хамрагдсан.



6. Санхүүгийн үйл ажиллагаа:
“Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2024” арга хэмжээнд нийт 7.730.000төгрөг зарцуулсан.

**7. Хавсралт /Тайлангийн зургууд/
Номын баярын нээлтийн үйл ажиллагаа**



Сүхбаатар аймаг  Нийтийн номын сан

Монгол улсын ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн ивээл дор

НОМЫН БАЯР 36 дахь
“Үндэсний бичиг соёлоо эрхэмлэн дээдэлье”

Нээлт арга хэмжээнд хүрэлцэн
ирэхийг урьж байна.

- Яруу найргийн OPEN MIC,
- Судар эгшиглэн номын тэмдэглэлийн нээлт, сэдэвчилсэн номын үзэсгэлэн
- Үлгэрээс үлгэрлэе аяны хүрээнд уншигч хүүхдүүдийн “үлгэрийн баатрууд”-ын парад

**ҮНДЭСНИЙ БИЧИГ СОЁЛ
НОМЫН ӨДРҮҮД - 2024**

“ЖААХАН ШАРГА” хжт-ын талбайд
2024.09.14нд 11-13 цагийн хооронд болно.

Баруун-Урт - Нийтийн номын сан  9951-8922





Шагнал гардуулалт, Ном унших, номын тэмдэглэл хөтлөх уралдаан, Агшин тэмцээн



“Үлгэрийг зүрхээрээ амилуулъя” уралдааны шагналтнууд



НОМЫН ХИШИГ-ЭРДМИЙН ТҮШИГ хэлэлцүүлэг



“ХАЙЛААСТЫН АХМАДУУД”, УРТЫН ГОЛЫН АХМАДУУД” чуулга уулзалт, Чанга” уншлага



"Бидний номын тэмдэглэлүүд"



Дүрийн тоглолтын тайзны болон хувцас хэрэглэл бэлтгэсэн хэсгээс



"Яруу увдис" арга хэмжээ Ахмадын арга хэмжээ

Соёлын бүтээлч сарын хүрээнд Бичиг соёлын эртний дурсгал болох “Чингисийн чулууны бичиг”, “Дуутын хар чулууны бичээс”-ийг хүүхэд залуучуудад танин мэдүүлэх, сурталчлах, хэрэглээнд нэвтрүүлэх зорилгоор зохион байгуулсан уралдааныг насанд хүрэгсдийн болон ЕБС-ийн сурагчдын дунд зохион байгуулахад:

Насанд хүрэгсдийн ангилалд:

Тэргүүн байр: Х. Алтанчимэг / Онгон сумын МХБУЗ-ын багш/

Дэд байр: Б. Хасархүү Дорнод аймаг. Хэрлэн сум

ЕБС-ийн ангилалд:



Тэргүүн байр: Э. Сүндэрьяа /ЕБ-ын 2 сурууль. 9г анги

Дэд байр: М. Эрдэнэбаатар /ЕБ-ын 3 сурууль. 11г анги.

Гутгаар байр: Т. Баттуяа/ Баяндэлгэр сум. ЕБС. 10а анги/

Тусгай байр: Б. Ану/ ЕБ-ын 3 сурууль. 11г анги.

Тусгай байр: Мишээл /ЕБ-ын 3 сурууль. 11г анги тус тус шалгарсан.



"ХҮМҮҮН БИЧИГ-ХҮН БҮРИЙН БИЧИГ" Монгол улсын Монгол хэлний тухай хууль, Засгийн газрын 2020 оны 96-р тогтоолоор батлагдсан "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III"-ийг хэрэгжүүлэх хүрээнд эх хэл бичиг, түүх, соёлын дурсгалаа судлах, хөгжүүлэх, төрийн албан хаагч болон иргэдийн үндэсний бичгийн хэрэглээний чадварыг сайжруулах зорилгоор Аймгийн ЗДТГ, БГ, НТСТ, ННС хамтран "ХҮМҮҮН БИЧИГ-ХҮН БҮРИЙН БИЧИГ" уралдааныг 7 дахь жилдээ амжилттай зохион байгуулж шилдгүүдээ тодрууллаа.

Тус тэмцээнд 6 багийн 30 оролцогч 5 төрлөөр ур чадвараа сорилоо.

🏆 1-р байр Нийгмийн даатгалын газрын "ТАТАЛБАР" баг

🥈 2-р байр Баруун-Урт сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн "ТЭНГЭРИЙН ЗУРЛАГА" баг

🥉 3-р байр Баяндэлгэр сумын ерөнхий боловсролын сургуулийн "ТИТЭМ" багууд тус тус шалгарсан.



ТЭРГҮҮНИЙ УНШИГЧ Д. НАЦАГДОРЖ ТЭМДЭГТЭН

“Тэргүүний уншигч-Нацагдорж тэмдэгтэн” шалгаруулах сарын аян зарлаж, ЕБ-ын 2-р сургуулийн номын сантай хамтран Д. Нацагдоржийн намтар уран бүтээлийг сурталчилж, бүтээлийн үзэсгэлэн, шинэ болон шилдэг хүүхдэд зориулсан үлгэрийн номнуудаар “Үлгэрийн ертөнцөөр аялцгаая” номын үзэсгэлэн, болзолт тусгагдсан заавал унших номнууд болон “Монголын нууц товчоо” номын үзэсгэлэнг гаргасан.



“Тэргүүний уншигч-Нацагдорж тэмдэгтэнээр:

Ш. Төгсбилэг- ЕБ-ын 4-р сургууль. 5 в анги

Э. Энхмарал- ЕБ-ын 1-р сургууль. 5 б анги

О. Бүжинлхам- ЕБ-ын 4-р сургууль. 5 в анги

Ө. Тэмүүлэн - ЕБ-ын 4-р сургууль 5 в анги

Бат-Эрдэнэ - ЕБ-ын 4-р сургууль 6е анги нар тус тус шалгарсан.



СОЁЛЫН БҮТЭЭЛЧ САР
Өвлөн бүтээх
Өнөө ирээдүй



“ЗОЧИН” подкаст-нэвтрүүлгийн энэ удаагийн дугаарт Боловсрол шинжлэх ухааны газрын дарга асан Л.Байгальмаа уригдан оролцлоо

Соёлын бүтээлч сарын хүрээнд Аймгийн Нийтийн сангаас Сүхбаатар аймгийн Боловсрол шинжлэх ухааны газрын дарга асан Л. Байгальмааг “Зочин-подкаст” нэвтрүүлгийн энэ удаагийн дугаартаа урин оролцууллаа.

Тус уулзалтад МБС-ийн цахилгаан, тогооч, гоо сайхан, төмөр зам, барилгын засал чимэглэл зэрэг төрөл бүрийн мэргэжлийн ангийн суралчид оролцлоо. Тус дугаарыг сэтгүүлч А. Нарантунгалаг хөтлөн явуулж, Боловсролын салбарын тухай, мэргэжил сонголт, боловсрол, ирээдүйн зорилго, номтой хэрхэн нөхөрлөх гэх мэт олон сонирхолтой сэдвээр ахмад багштай халуун дотно яриа өрнүүлсэн сонирхолтой уулзалт боллоо.



ᠰᠣᠶ᠋ᠣᠯ ᠪᠦᠲᠡᠭᠡᠯᠴ ᠰᠠᠷ

МБС-ийн хүүхдүүдийн дунд БШУГ-ын дарга асан Л. Байгальмааг урьж оролцуулан уулзалт зохион байгуулахад 30 хүүхэд оролцсон бөгөөд тус сургуулийн номын санд яруу найрагч Ч. Эрдэнэбаатарын “Монгол ухааны эрхин хэлхээ” 2 ш ном, бичгийн хэрэгсэл хандивлаж, оролцогч хүүхдүүдийн дунд асуулт хариултын тэмцээн явуулж, гарын бэлэг гардуулав. Уг ярилцлагаар зочин подкаст бэлтгэн байгууллагын цахим хуудсаар сурталчлахад 856 хүн хандалт өгсөн байна.

Ном уншилтыг сайжруулах. Уншлагын төвүүдийг зохион байгуулах, үйл ажиллагааг нь зохицуулах ажил хийсэн эсэх:

Баруун-Урт сумын 1 дүгээр цэцэрлэгийн багш ажилчидтай хамтран “Надаас чамд” ном унших сарын аяныг зохион байгуулж, ЕБ-ын 3 дугаар сургуулийн багш нартай номын танилцуулга, уулзалтыг хийсэн.



“Судар эгшиглэн” төслийн хүрээнд Баруун-Урт сумын ЕБ-ын 4 дүгээр сургуулийн М.Алтантуяа багштай 4в ангийн хамт олноороо номын тэмдэглэл хөтөлж, Бид уншигч номын клубын гишүүд номын тэмдэглэл хөтлөх талаар зөвлөгөө мэдээлэл солилцож, Талын түрлэг бүлгэмийн тэргүүн, сэтгүүлч Э. Ирэхбаяр, “Судар эгшиглэн” төслийн шилдэг уншигчдын уулзалт ярилцлагыг зохион байгуулсан.



Нийтийн уншлагын танхимын дэргэдэх “Бид уншигч” номын клубын сурагчдын цугларалтыг сар бүр хийж уншсан номын тэмдэглэл, зураглалыг хийж, 68 номын хавчуургыг шинээр хийсэн. Клубын цугларалтаар номтой нөхөрлүүлж, ном уншихын ач тусыг таниулах зорилгоор “Бие дааж төлөвлөж ном унших” Уншсан номыг яриагаар илэрхийлэх нь” танин мэдэхүйн ярилцлагыг хийсэн.





**Алслагдсан хэрэглэгчдийн үйлчилгээг зохицуулсан байдал
Зөөврийн үйлчилгээ зохион байгуулсан эсэх**

№	Байгууллагын нэр	Номын тоо		
Фонд				
1.	ШШГГ Төрболд	73		
2.	Өндөр настан	7		
3.	Хувиараа хөдөлмөр эрхлэгч	5		
4.	Түмэнцогт сум	40		
		125		
Нийтийн уншагын танхим				
5.	МБС-/Нутгийн зохиолчдын ном/ 62	90		
6.	МБС-/Хуучны мартагдсан ном/ 65	90		
7.	МБС 60	90		
8.	Халзан сумын соёлын төв /Нутгийн зохиолчдын ном/30	80		
9.	Халзан сумын соёлын төв -40	80		
10.	Эрдэнэцагаан сумын соёлын төв-47	100		
11.	БӨНДБ-52	100		
		630		
Гэрээр ном олгох танхим				
№	Үйлчилгээ авсан	Номын тоо, ширхэг	Хамрагдсан хүний тоо	Тайлбар
1	Барилгын цэргийн 338-р анги	67	200	
2	Түмэнцогт сумын соёлын төв	65	150	
3	Брайль ном /Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, албан хаагчдад/	33	60	Аймгийн Тамгын газар
4	Баруун-Урт сумын 1-р цэцэрлэг	35	52	
5	Баруун-Урт сумын 3-р цэцэрлэг	30	45	
6	Д.Сүхбаатарын мэндэлсний 132 жилийн ойд /338-р цэргийн ангид /	15	250	
7	Ахмадын хороо /Нутгийн зохиолчдын ном /	60	120	
8	Шинэ ном	65	200	ГНО
9	Хөгжлийн бэрхшээлтэй 2 иргэн	20	2	Гэрт
10	Жаахан шаргын нутгаар	50	150	Дарьганга зочид буудал

11	Түмэнцогт сумын соёлын төв /Брайль ном/	30	20	
12	Баруун-Урт сумын 8 дугаар багийн нутаг Эрдэнэ-Ус, Говь, Тал булгийн уурхай, Аранжил, Рашаант	200	600	Алслагдсан багуудаар
13	Хайлаастын ахмадууд 9-р багийн ахмадын өдөрлөг	60	100	Амжилтын талст төв
14	2-р багийн ахмадын өдөрлөг	50	75	Амжилтын талст төв
15	Асгат сумын соёлын төв /Брайль, аудио ном/	35	60	Асгат сум
16	Цагдаагийн газар	40 гаруй ном	80	Номын фонд
	Нийт тоо /Давхардсан тоогоор/	855	2164	

Хүүхдийн уншлагын танхим		
10.	1-р цэцэрлэг	54
11.	2-р цэцэрлэг	81
12.	3-р цэцэрлэг	15
13.	4-р цэцэрлэг	74
14.	5-р цэцэрлэг	80
15.	6-р цэцэрлэг	15
16.	8-р цэцэрлэг	20
17.	11-р цэцэрлэг	26
18.	Түмэнцогт сум	67
19.	Халзан сум	71
20.	1-р БДС	50
21.	2-р БДС	49
		553
	Нийт	3472



Баруун-Урт сумын Засаг даргын газар, АНЭ, Нийгмийн даатгал, ГБХХГазар, Татварын газартай хамтран Баруун-Урт сумын 8 дугаар багийн Эрдэнэ-Ус, Аранжил, Говь, Тал булаг, Рашаант зэрэг газруудад зөөврийн номын сангийн үйлчилгээг хүргэлээ.



“ХАЙЛААСТЫН АХМАДУУД” чуулга уулзалтыг багийн ажлын алба, ахмадын зөвлөлтэй хамтран зохион байгууллаа. Тус чуулганаар:

- Номын үзэсгэлэн, худалдаа
- “Агшин” хөгжөөнт тэмцээн
- Ном солилцох үйл ажиллагаа
- Асуулт, хариулт, санал хүсэлт гэсэн хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдаж багийн 86 ахмад оролцсон.




Хүүхдэд номын сангийн үйлчилгээ үзүүлсэн байдал: Номын сангаас олгох боловсролын хөтөлбөрийн хүрээнд Хүүхдийн Уншлагын танхимын дэргэдэх "Бяцхан Номын Санчид" дугуйланг тогтмол ажиллуулан хүүхдүүд Орос ардын



үлгэр "Манжин" үлгэрээр дүрийн тоглолт бэлтгэн 2,3,4,5,7,9,11-р цэцэрлэгийн 800 гаруй хүүхэд багачуудад тоглож үзүүлээ Мөн "Өнхрүүшхэн үлгэрээр хувцас хэрэглэлтэй дүрийн тоглолт бэлтгэл сургууль болон цэцэрлэгийн нийтдээ 1400 гаруй хүүхдэд хүргэн ажиллалаа.

11-р цэцэрлэгийн Өнөржаргал багштай бэлтгэл бүлгийн хүүхэд багачууд номын сантай танилцах аялал хийж, "Заан оготно хоёр" үлгэрээр "Чанга" уншлага хийж, хүүхдийн танхимаа танилцуулан хамтран ажиллалаа.

Дэлхийн хүүхдийн номын өдрийн хүрээнд "Үлгэрийн ертөнцөөр аялцаа" миний театрыг тохижуулан ажиллалаа.



Амаржаргал эрхлэгчтэй 5-р цэцэрлэгийн урилгаар очиж хамтран ажиллаж, Бэлтгэл, ахлах, дунд ангийн 90 гаруй хүүхэд багачуудад "Өвөл зун ээлжилдэг болсон нь", "Тэмээ эврээ алдсан нь", "Заан оготно хоёр", Герман ардын үлгэр "Бүжигчин охин" үлгэрээр "чанга уншлага хийж, "Үлгэрийн ертөнцөөр аялцгаая" номын үзэсгэлэн гаргаж сонирхууллаа.

Номын сангаас олгох боловсролын хөтөлбөрийн хүрээнд Хүүхдийн уншлагын танхимын дэргэдэх "Бяцхан номын санчид" дугуйлангийн сурагчдын хамт Номын баярын өдийг угтсан "Өнхрүүш" үлгэрээр дүрийн тоглолт зохион байгуулж, дүрийн тоглолтын тайзны болон хувцас хэрэглэл бэлтгэсэн.

"Соёлын бүтээлч сар" аяны хүрээнд 11 сард хамрагдсан хүүхдүүдэд номын хавчуурга хийх бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх зорилгоор сургалт явуулахад 10 ангийн 121 хүүхэд хамрагдаж хүүхдүүдийн хийсэн бүтээлээрээ гацуур модоо чимэглэж танхимдаа байршуулсан.

ЕБС-ын 1-7 ангийн сурагчдын дунд "Олуулаа уншицгаая" аян өрнүүлэн ажиллахад нийтдээ 4-н сургуулийн 39 ангийн 1817 хүүхэд хамрагдан ажилласан.



“ЗУНЫ ЗУГААТАЙ УНШЛАГА” ХӨТӨЛБӨР

Хүүхдийн уншлагын танхимаас “Зуны зугаатай уншлага” хөтөлбөрийг 6 сарын 04-нөөс 07 сарын 01-ний хооронд амжилттай зохион байгуулж,

- “Эрвээхэй” сэдвийн хүрээнд хөтөлбөрт хамрагдсан хүүхэд багачуудад Эрвээхэй, Мөөг, Цэцэг сэдвийн тухай танин мэдэхүйн мэдээлэл өгч, хүүхдүүдээр ертөнцийн гурав, оньсого, шүлэг зохиолгон, бүтээлийг цаас, ватум, эсгий, өнгөт цаас гэх мэт төрөл бүрийн материалаар бүтээл хийн, харилцан мэдээлэл солилцон хүүхэд бүр шүлэг зохион оролцож, давхардсан тоогоор 130 гаруй хүүхдүүд хамрагдан хөтөлбөрт хамрагдсан хүүхдүүдийн бүтээлээр хүүхдийн танхимд үзэсгэлэн гаргахад нийтдээ 1400 гаруй хүүхэд үзэж хамрагдсан.






Хүүхдүүдийн хийсэн бүтээлүүдээс:

Олон улсын хүүхдийг хамгаалах өдөрт хүүхдийн хөгжилд зориулсан "Хөгжилтэй зургаан өртөө" соёлын арга хэмжээнд оролцож танин мэдэхүй хөгжүүлэх, зохион бүтээх тоглоом, Дартс-хөгжөөнт тоглоом -шидэлт бүрээр азтан шалгаруулж авьяас, оюун ухаан, мэдлэг сорих тэмцээнийг явуулж, дэлхийн шилдэг хүүхдийн уран зохиолын номын үзэсгэлэн гаргаж, хүүхдийн номын худалдаа зохион байгуулж ажилласан.



Дэлхийн хүүхдийн өдрийг тохиолдуулан байгууллагын зүгээс өөрсдийн үр хүүхдэдээ чин сэтгэлийн бэлгээ илгээв.



ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДЭД НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛСЭН БАЙДАЛ:

Харааны болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бүтээлч байдлыг дэмжих, орчин үеийн тоног төхөөрөмжийг ашиглан хэвлэлийн хүртээмжийг нэмэгдүүлэх, ном унших боломжийг нэмэгдүүлэхэд чиглэж ажиллаж ирлээ.

Луй Брайлийн мэндэлсэн өдрийг тохиолдуулсан Харааны болон хөгжлийн бэрхшээлтэй 50 иргэн, харааны бэрхшээлтэй 5 хүүхдийн эцэг эх, нийт 59 хүнд уншигчийн карт үнэ төлбөргүй нээж, брайль болон аудио ном, харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан Иво-10 төхөөрөмжийг, харааны бэрхшээлтэй иргэдэд сурталчилсан.



Брайль үсгийн цагаан толгой зохиогч Луй Брайлын өдрийг тохиолдуулан Сүхбаатар аймгийн Хараагүйчүүдийн Холбоотой хамтран Ерөнхий боловсролын IX-XI -р ангийн сурагчдын дунд "**Харааны бэрхшээл**" цахим контентын уралдааныг зохион байгуулахад

Тэргүүн байр- ЕБ-ын 3-р сургуулийн 10 б ангийн Б. Намуун- анги хамт олон

Дэд байр-ЕБ-ын 2-р сургуулийн 9в анги А. Нарансолонго- анги хамт олон

Гутгаар байр- ЕБ-ийн 4-р сургуулийн 10а анги Б. Хүслэн-анги хамт олноороо шалгарсан.



Эрх зүйн хөтчийн хүрээнд аймгийн “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэлэлцүүлэг” –т 20 гаруй төрийн албан хаагч, хөгжлийн бэрхшээлтэй 40 гаруй иргэдэд брайль болон аудио номыг сурталчилж, брайль болон аудио 30 гаруй номыг иргэддээ сурталчилж, мэдээлсэн.



Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд эцэг эхэд-хамтдаа амжилтыг бүтээцгээе- зургийн хичээлийн сургалт:

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоотой хамтран Харааны болон Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн авьяас, ур чадварыг олон нийтэд таниулах, нийгмийн харилцаанд тэгш оролцох эрхийг хангах, олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, тэдэнд урам зориг өгөх, эцэг эх, асран хамгаалагчид хүүхдүүдийн хамт нэгэн өдрийг үр бүтээлтэй хөгжилтэй өнгөрүүлэх зорилгоор Тусгай хэрэгцээт хүүхдүүдийн дунд **“Хамтдаа Амжилтаа Бүтээцгээе”** зургийн хичээл зохион байгуулж, Хичээлийг мэргэжлийн багш зааж, хүүхдүүдийн бүтээлийг Ханын сонинд байршуулан бүтээлээр үзэсгэлэн гаргаж тоогоор 10 хүүхэд, эцэг эхийн хамт хамрагдлаа. “Үлгэрийг зүрхээрээ амилуулья” харааны бэрхшээлтэй хүүхэд, иргэдийн дунд зохион байгуулж буй уралдаанд оролцогчдод Иво-10 дэйзи номонд зохиол, үлгэрийг суулгаж өгч байгаа, мөн хэрхэн ажиллуулах талаар зөвлөмж өглөө.



“Үлгэрийг зүрхээрээ амилуулья” харааны бэрхшээлтэй хүүхэд, иргэдийн дунд зохион байгуулж буй уралдаанд оролцогчдод Иво-10 дэйзи номонд зохиол, үлгэрийг суулгаж өгч байгаа, мөн хэрхэн ажиллуулах талаар зөвлөмж өгч ажиллалаа.



Номын сан болон номын сангийн үйлчилгээнд дүн шинжилгээ хийсэн эсэх
 Номын сангийн үйлчилгээг өргөжүүлэх, номын сангийн танхимаар үйлчлүүлэх уншигч, иргэд, ном олголтыг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг сайжруулах зорилгоор

ЕБС-иуд, албан байгууллагууд, иргэдийн дунд “Оюунлаг” иргэн, анги хамт олон, байгууллагыг шалгаруулах уралдааныг зарласан.

ЛАВЛАГАА, НОМЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Номын сангийн үйл ажиллагаанд лавлагаа номзүйн үйлчилгээг боловсронгуй болгох, нэвтрүүлэхэд чиглэгдсэн ажлын талаар

Байгууллагын пэйж хуудас fb хаягаар цаг үеийн мэдээлэл, байгууллагын үйл ажиллагаа, найргийн цаг булангаар нутгийн найрагч, нутгийн найрагч бүсгүй, уншигчийн сэтгэгдэл, номын тухай яриа, эерэг хандлага, шинэ номын булан, тэмдэглэлт өдрүүд гэх мэт төрөл бүрийн мэдээллээр лавлагаа мэдээлэл хүргэн ажиллаж, 8678 гаруй пост оруулж нийтдээ 14564 хүн хандалт өгчээ.

Монгол бичгийн албан хэрэглээг нэмэгдүүлэх ажлын хүрээнд байгууллагын нүүр хуудсаар тогтмол мэдээ мэдээлэл байгууллагын үйл ажиллагааны тухай мэдээллийг монгол бичгээр бичиж байршуулан ажиллаж байна. Үүнд: Бичгийн мэргэдийн онч мэргэн үгс, байгууллагын үйл ажиллагааг монгол бичгээр бэлтгэн зурагжуулан оруулаж хэвшсэн.

Анхдугаар Үндсэн хууль батлагдсан өдөр, Дэлхийн хүүхдийн номын өдөр, Дэлхийн номын өдөр, Дэлхийн яруу найргийн өдөр, Эх үрсийн эрхийг хамгаалах өдөр, Монгол бичгийн булан-Өдөр бүр унших эх тавья- уншаад завтай бол бичээрэй, Нутгийн яруу найрагч, Эх хэл бидний бахархал, 36 Номын баяр, Яруу увидас соёлын өдөрлөг, Уншигчдад номтой хэрхэн харьцах арга барилыг төлөвшүүлэх, МЗХ-ны ахмад гишүүн, Хүүхдийн зохиолч Н. Доржцэрэнгийн амьдрал, уран бүтээл аудио цуврал, МЗЭ-ийн шагналт яруу найрагч Уртнасангийн Будын уран бүтээлийн цэнгүүн, Сүхбаатар аймагт утга зохиолын салбар үүссэний 70 жилийн ой гэх мэт тэмдэглэлт өдрүүдэд лавлагаа номзүйн мэдээллийг тогтмол бэлтгэн цаас болон цахим аудио хэлбэрээр мэдээллийг бэлтгэн нийтэд түгээн сурталчилсан.

- Номын сангийн цахим каталогт байгаа 43 номын тухай номзүйн мэдээлэл номын хавтсаар зурагжуулан лавлагаа мэдээлэл, уншигчдад номтой харьцах арга барилыг төлөвшүүлэх” “Номын тойм”, Нутгийн яруу найрагч МЗЭ-ийн шагналт У. Будын уран бүтээлээс аудио хэлбэрээр мэдээлэл бэлтгэн байгууллагын нүүр хуудсаар сурталчлахад сурталчилж, цахим хэлбэрээр оруулсан аудио сурталчилгаанд 6274 гаруй хүний хандалт авсан.

ШИНЭ НОМЫН БУЛАН-БОТЬ-3

ISBN: 99798531617
 2023 онд гарсан
 112 хуудас

ШИНЭ НОМЫН БУЛАН:

ISBN: 99798531617
 2023 онд гарсан
 112 хуудас

Чинэний нэгдмэл үнэт зүйл
Чинэний бичиг соёлоо дээдэлье

Чинэний бичиг соёлоо дээдэлье
 Төр наймайн өрг зүтгэлтэн,
 эсэмтэн, яруу найрагч
 Очирбатын Дашбалбар

Чинэний нэгдмэл үнэт зүйл
Чинэний бичиг соёлоо дээдэлье

Орон зай, цаг хуурааны
 эрхшээл бус, харин
 түүнийг өөртөө багтаах
 ондр

Төр наймайн өрг зүтгэлтэн,
 эсэмтэн, яруу найрагч
 Очирбатын Дашбалбар

ШИНЭ НОМЫН БУЛАН-БОТЬ-1

ISBN: 99798531617
 2023 онд гарсан
 112 хуудас

Чинэний нэгдмэл үнэт зүйл
Чинэний бичиг соёлоо дээдэлье

Оюут мэргэд хичээгчэн бүү
 ай. Гай лав тарихгүй,
 Огоот муухаг нээгч бүү
 итгэ. Лай удах нь үнэн.

Төр наймайн өрг зүтгэлтэн,
 эсэмтэн, яруу найрагч
 Очирбатын Дашбалбар

Ганцаарчилсан хэрэглэгч болон үйлчлүүлэгч байгууллага, хамт олныг мэдээлэл-номзүйн үйлчилгээгээр хангасан байдал

ЗАЛУУЧУУД БА МАНЛАЙЛАЛ" клубээс зохион байгуулсан "Тархины сэргээш" уншсан номын хэлэлцүүлэг зохион байгууллаа.



Цэцэрлэгийн багш, ажилчдад номын тэмдэглэл хөтлөх, Ном уншаад мэдлэг мэдээлэл авч, бичих чадвараа хөгжүүлж, **НОМЫН** гол утга санааг хэрхэн бичих талаар зөвлөгөө өгч, зөврийн номоор үйлчилгээ үзүүлээ.



Баруун-Урт сумын 2-р сургуулийн 8а, 8б, 8в, 8г ангийн сурагчдын дунд “Хамтдаа номын тухай ярилцъя” хэлэлцүүлэг зохион байгуулж, нийт хүрэлцэн ирсэн 20 сурагчдад уншигчийн карт нээж, номоор үйлчилгээ үзүүллээ. Баруун-Урт сумын ерөнхий боловсролын 4-р сургуулийн Ө.Байгальсайхан багштай 8в ангийн сурагчид ангиараа ирж уншигчийн карт нээлгэж, номын сангийн үйл ажиллагаатай танилцлаа.



Цагдаагийн ажилтан, албан хаагчдын ном унших идэвхийг өрнүүлж, номтой нөхөрлүүлэх зорилгоор байгууллагаа сурталчилж мэдээлэл хийж, цагдаагийн албан хаагчдад уншигчийн карт нээж, зөврийн номоор үйлчилгээ үзүүлж, номын санд нь арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

СОЁЛЫН БҮТЭЭЛЧ САР
Өвөл бүтээх
Өнөө ирээдүй

Төрийн албан хаагчдад зөөврийн номын сангийн үйлчилгээ хүргэлээ

Аймгийн цагдаагийн газартай хамтран номын сангийн үйл ажиллагааг танилцуулж, ном уншихын ач холбогдлын талаар мэдээлэл бэлтгэн, 70 гаруй номоор үзэсгэлэн гарган сурталчилж, 60 гаруй цагдаагийн албан хаагчдад карт нээж үйлчлэн, цагдаагийн газрын номын сантай танилцан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.



СОЁЛ, СПОРТ, АЖЛАЛ, ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМ | ЗАСГИЙН ГАЗРЫН ХӨРГӨМЖИЙН АГЕНТЛАГ СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР

ᠰᠣᠶ᠋ᠣᠯ ᠪᠦᠲᠡᠭᠡᠯᠴ ᠰᠠᠷ

Хэрэглэгчийг мэдээллийн соёлтой болгоход чиглэгдсэн ажлууд

“Номын тэмдэглэл хэрхэн хөтлөх” талаар номын хэлэлцүүлэг 2 удаа 50 гаруй багш, сурагчдад, 1,3 дугаар цэцэрлэгийн багш 60 гаруй багш ажилчид, цэргийн ангийн 100 гаруй албан хаагчдад, 8,9 дүгээр ангийн 120 гаруй сурагчдад, нийтдээ 380 гаруй хүүхэд багачууд, багш ажилчдад мэдээлэл хийсэн.



Каталог, картын сан, санамж өгөх номзүйг номзүйн бичилтийн стандартын дагуу хийсэн ажил

НОМЫН САНГУУДЫН ОРОН НУТАГ СУДЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА



Орон нутаг судлах цогц төсөл боловсруулах, хэрэгжүүлэх талаар хийсэн ажил
Орон нутгийн картын сан, номзүйн бүртгэл эрхлэн гаргасан эсэх
Орон нутаг судлалын сан хөмрөгийг бүрдүүлж, хөгжүүлэх талаар хийсэн ажил

НОМЫН САНГИЙН МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Номын санд мэдээллийн технологийг нэвтрүүлэх, хөгжүүлэх, технологийн үйл ажиллагааг хэрэглэгчдэд хүргэхэд чиглэгдсэн ажлууд:



Монгол Улсын Соёлын яамны санаачлагаар улс орны хэмжээнд бүх нийтийн номын санг нэгдсэн программд шилжүүлэх үүднээс Коха программруу шилжихтэй холбогдуулан үндсэн датагаа Соёлын яамруу илгээн, 06 дугаар сарын 13-14-ний өдрүүдэд Үндэсний номын сангаас 2 сургагч багш уг программын сургалтыг зохион байгуулж, цахим системд ном оруулах, ном захиалга буцаалт, шинэ номын бүртгэл, коха программын тайлан нэгдсэн хайлтын систем гэх мэт хичээлүүдийг зааж, сургалтанд байгууллагын нийт албан хаагч ажилчид оролцов.соёлын төвийн номын санч нар онлайнаар давхар хамрагдсан. Zotero программд “Сүхбаатарын өнгө сонины 25 дугаарын 190 мэдээллийг оруулсан.





Байгууллагын ажлын зөөврийн i7 компьютерт хэрэглээний MS office-2019 программыг суулган ажлын хэрэгцээнд ашигладаг суурин компьютерыг форматлаж хэрэглээний програмуудыг суулган хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллаа.

АРГАЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Номын санчдад аргазүйн зөвлөгөөг амаар болон биечлэн хүргэсэн байдал

СУГ-ын даргын 2024 оны 02 сарын 17-ны өдрийн А/11 тушаалаар Сүхбаатар аймгийн “СОЁЛ УРЛАГИЙН БАЙГУУЛЛАГЫН ТҮҮХЭН ТОВЧООН” номын материал бэлтгэхтэй холбоотой хамтарсан удирдамж батлуулан, 12 сумдын материал хүлээн авч цэгцлэн эх бэлтгэлд бэлтгэж, зургуудыг янзалж фолдер үүсгэн мэдээллийн нөөцөд хадгалж байна.



Номын сангийн программ хангамжийн мэдээллийн санд ном оруулах ажлын хүрээнд соёлын төвийн номын сангуудтай хамтран ажиллаж, арга зүйн зөвлөгөөг өгч, мэдээллийн нөөцөд нийт 12 сумдын 38645 номноос 29082 ном цахим каталогт байршсан байна. Мэдээллийн нэгдсэн баазад ном оруулах ажлын хүрээнд Мөнххаан, Эрдэнэцагаан, Түмэнцогт, Дарьганга, Түвшинширээ, Уулбаян, Наран, Асгат, Баяндэлгэр, Сүхбаатар, Халзан арга зүйн зааварчилгаа авч танхим, цахимаар хамтран ажиллалаа.



МБС-ын номын санд очиж, Lib4U програмд ном оруулах, баркод, данс нэмэх, данс засах талаар тус программ дээр ном оруулах, нэгбүрчилсэн бүртгэлд ном данслах, тооллого хийх тэмдэглэлээ хийх, Мөнххаан сумын соёлын төвийн номын санч Б. Отгонтуяад данс бүртгэлийн талаар зөвлөгөө өгч ажилласан.



Номын санд томилолтоор явж туршлага судалсан, аргазүйн туслалцаа үзүүлсэн болон дүн шинжилгээ хийсэн байдал (тоо, сэдэв, үр дүн)

"ХИШИГ ӨДӨР" АРГА ХЭМЖЭЭ:

Соёл урлагийн газартай "Хишиг өдөр" арга хэмжээг зохион байгуулж, арга хэмжээний хүрээнд харилцан соёл гэгээрэл, статистик мэдээ хариуцсан мэргэжилтэн, номын санч, сэлбэн засагч, бичиг хэргийн ажилтны ажлын байранд ажиллан, туршлага судлаж соёлын боловсролын хөтөлбөрөөр гэр бүлд угийн бичгийн анхан шатны мэдлэг олгох сургалт хийж, номын клубын сурагчидтай уулзан, уншлагын танхимын үйлчлүүлэгчидтэй ажиллан, хуучин ном сэлбэн засаж, шинээр олон олон мэдлэг мэдээлэл цуглуулсан өдөр болсон.



Дэлхийн номын өдрөөр “Хормогчин театр” дүрийн тоглолтыг Түмэнцогт сумын хүүхдийн цэцэрлэгийн 42 хүүхдэд хүргэж, номын сангийн дугуйлангийн хүүхэд багачуудтай харилцан туршлага солилцлоо.



Монголын Үндэсний номын сангийн шинэ барилга, номын сангийн үйл ажиллагаатай танилцан Номын сангийн арга зүйч, ном зүйч, программист нараас Коха программ хангамжийн талаар сургалт авч харилцан санал бодлоо солилцлоо. Мөн номын сангийн үйлчилгээний танхимууд болон соёл олон түмний үйл ажиллагаа явуулдаг заал танхимуудыг үзэж сонирхлоо.



Мэргэжлийн аргачлал, зөвлөмж боловсруулсан эсэх

Мэргэжлийн ур чадварын тэмцээн зохион байгуулсан эсэх

Номын санчдад зориулсан сургалт семинар зохион байгуулсан байдал:

Соёлын яамнаас улсын хэмжээнд номын сангуудын нэгдсэн программ болох Коха-программд нэвтрүүлж байгаатай холбогдуулан Цахим номын сангийн системийн сургалтыг 06 дугаар сарын 12-14-ний өдрүүдэд зохион байгуулж, Монголын Үндэсний Номын сангийн ном бүрдүүлэгч И. Долзодмаа, Каталогич Э. Мянганзул нар ирж, сургалт явуулж, явуулж номын санч, мэдээллийн ажилтнуудаар дадлага ажил хийлгэв.



Төв, хөдөөгийн сум, сургуулийн номын санчдын нэгдсэн сургалтыг 12 сарын 13-ны өдөр онлайнаар зохион байгуулж, захирал Э. Амарбат цаг үеийн онцлох ажлуудын талаар, арга зүйч Т. Чандмань Номын сангуудын тайлан, Mongolian library

update зөвлөгөөний талаар мэдээлэл хүргэж, МҮНС-ын арга зүйч В Түвшинтогтох “КОХА” программын талаарх сургалтыг өгч ажиллалаа.

Мэргэжлийн сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн байдал

Номын санч мэргэжлийн сэтгүүлийн 2024 оны 01 дугаарт номын сангийн Коха прогграммын талаарх санал бодлоо бичиж илгээсэн.

ЕС. ХҮНИЙ НӨӨЦИЙН АСУУДАЛ

Номын сангийн хүний нөөцийн өнөөгийн байдал, хангалт (Номын сангийн орон тооны ажилтны тоо, номын санчийн тоо, мэргэжлийн боловсон хүчний тоо /бүрдэлт/-ийг судалгаанд үндэслэж гаргасан байдал):

2023 онд няравын орон тоо сул явж байсныг нөхөн бүрдүүлж 01 сарын 15-наас няравын орон тоон дээр хүн авч 3 сарын туршилтын хугацаатай ажилд авсан.

Сан хөмрөгч Ө. Хонгорзул СУИС-д магистрт суралцах болсон тул 2 сарын цалинтай чөлөө олгож, нэг удаагийн тэтгэмжээс 200,000 төгрөг олгосон.

Байгууллагын ажилчдын сар бүрийн ажлыг дүгнэн байгууллагын төсөв санхүүд тохируулан ур чадварын нэмэгдлийг олгож ирсэн.

2 өргөдөл ирж, архив албан хэргийн эрхлэгчээр ажиллаж байгаад хүүхэд харах чөлөөтэй байсан А.Оюунтуяа ажилдаа орох хүсэлтээ өгсний дагуу өргөдлийг шийдвэрлэж 02 сарын 13-ны өдрөөс эргүүлэн томилж оронд нь ажиллаж байсан ажилтныг чөлөөлсөн. Мөн Ө. Хонгорзулд чөлөөг олгосон.

Албаны архив, бичиг хэргийн эрхлэгчийн комьютер ашиглах боломжгүй болсон тул шинэ компьютер авч төсөвт тааруулан урьдчилгаа 1.200.000 төгрөгийг шийдвэрлээд байна.

Соёлын сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2024 оны А/166, А/63, А/73 дугаар тушаалын дагуу ур чадвартай, идэвх санаачилгатай ажилласан албан хаагчдад 8477500 төгрөгний ур чадварын нэмэгдлийг нөхөж олгосон.

ХАБЭА-н хүрээнд 260.000, байгууллагын ажилчдын хүүхдэд эх үрсийн баярын бэлэг 661500, монгол бичгийн уран бичлэгийн сургалтанд 2 албан хаагчдыг сургахад 300,000, 2 ажилтаны шинэ байр, шинэ хүүхдэд 300.00 нийт 1605200 төгрөг зарцуулсан байна.

Хүний нөөцийг чадавхижуулсан байдал (сургалт, семинар, урамшуулал)

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай үндсэн ойлголт, баримт бичгийн стандартын сургалтанд /арга зүйч, зааварлагч Б. Бямбасүрэн/ сургалтанд хамрагдлаа.




Төрийн албан хаагчдад зориулсан долоо хоног бүр зохион байгуулагддаг 7:4:10 сургалтанд албан хаагчид тогтмол сууж хэвшсэн.



Иргэний бие бялдарын хөгжил хөдөлгөөнийг идэвхжүүлэх зүүн бүсийн сургалтанд программист О. Мөнхбаатар хамрагдав.

Сүхбаатар аймгийн төрийн байгууллагуудын хүний нөөцийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах, мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх зорилготой Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан сургалтанд хүний нөөц хариуцсан ажилтан Р. Цолмонтуяа хамрагдсан.

“Mongolian library update” улсын XI зөвлөгөөнд арга зүйч Т. Чандмань, сан хөмрөгч Ө. Хонгорзул нар хамрагдаж, сум, сургуулийн номын санч нарт мэдээлэл өгсөн.



Өөрийгөө хөгжүүлсэн байдал -Номын тухай буу халья ТББ- аас зохион байгуулсан Номын тэмдэглэлийн уралдаанд номын санч В. Энхтуяа шилдэг 5 -т шалгарч, дурсамж, 10 номоор шагнуулсан.



Галын аюулгүй байдал хариуцсан комиссыг шинээр байгуулан, үүрэг чиглэл өгч, ОБГ-аас сургалтыг зохион байгуулж, мэдлэг олгов.

“Төрийн албаны шинэтгэл” сургалт
СУГ-аас зохион байгуулсан Соёлын албан хаагчдыг чадавхжуулах сургалт
“Алсын хараа-2050” 40 цагийн сургалт

"Мэдээллийн боловсрол ба цахим хэрэглээний ач холбогдол" номын санчдын нэгдсэн сургалт


Иргэний бие бялдарын хөгжил хөдөлгөөнийг идэвхжүүлэх зүүн бүсийн сургалтанд хамрагдав.

"Төрийн албан хаагчийн ёс зүйн сургалт"

"Цахимд хэвшье-Digital First" арга хэмжээ

ХШБХГ-аас Хүүхдийн эрхийн талаарх сургалт

Угийн бичгийн зураглал зөв хийх сургалтанд нийт албан хаагчид тус тус хамрагдсан.



Сүхбаатар аймгийн төрийн байгууллагуудын хүний нөөцийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах, мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх зорилготой Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан сургалтанд хамрагдсан.



Номын санд ажиллагсдад тулгарч буй бэрхшээл, цаашид авах арга хэмжээний талаар: Соёлын дэд сайд өөрчлөгдсөнтэй холбогдуулж, номын сангийн барилгын асуудлаар 2024 оны 04 сарын 01-ний өдрийн №18 тоот албан бичгээр хүсэлт гаргаж, Соёлын дэд сайд П. Баттөрд хүргүүлсэн.

Соёлын яамны 2024 оны 02 дугаар сарын 29-ний өдрийн 05-00-00-001/01 тоот “Орон нутагт төлөвлөгөөт хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу Соёлын яамны хяналт шинжилгээ, хариуусан мэргэжилтэн С. Урантөгс тус номын санд ирж, шалгалт хийж ажилласан.



ТӨСӨВ, САНХҮҮГИЙН АСУУДАЛ

2024 онд батлагдсан төсөв 326.000.000. Төсвийн тухай хуулийг мөрдөж, төсвийн тогтвортой байдлыг ханган, төсвийн иж бүрэн, үнэн зөв, ил тод байдал, санхүү, хариуцлагатай төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэн ажиллаж, одоогийн байдлаар 362.381.236.15 төгрөг зарцуулж, өр авлагагүй ажиллаж байна.


Бичиг хэрэг архивын ажлын талаар: Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой А– 34, Хүний нөөцтэй холбоотой тушаал -12 гаргаж, 39 албан бичиг явуулж, Өргөдөл, гомдлын тоо – 4 шийдвэрлэж, сар бүр үйл ажиллагааны тайлан илгээж, хугацаатай албан бичгийн хариуг тогтоосон хугацаанд илгээсэн.

Архивын улсын үзлэгт бэлтгэн тусгай төлөвлөгөө гарган, ББНШК томилон ажиллаж байна.

БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА: Сар шинийн баяр, ахмадын баярыг тохиолдуулан байгууллагын ахмадуудыг урьж хүндэтгэл үзүүлэн, нэг ахмадад 150.000 төгрөг, нийт албан хаагчдад 50.000 төгрөгийн бараа бараа худалдан авах эрх олгов.



ХАБЭА-н сарын хүрээнд ажилтан, албан хаагчдыг өрхийн эмнэлэгт болон Улсын 2 дугаар төв эмнэлэгт 11 дүгээр сарын 16-ны өдөр бүрэн хамруулж, дархлаажуулалтыг дэмжиж ажиллав. /260.000 төгрөг/



Сайн үйлсийн аян: Жил бүрийн 04 дүгээр сарыг “Дэлхийн сайн үйлсийн сар” болгон улс орон даяар нийгмийн сайн сайхны төлөө нийтэд тустай ажил өрнүүлж сайн дурын ажил хийж тэмдэглэн өнгөрүүлдэг уламжлалтай билээ. Уг өдрийг тохиолдуулан “Нэг байгууллага Нэг сайн үйлс” аяны хүрээнд манай байгууллага нь номын сангийн идэвхитэн уншигч, байнга үйлчлүүлж ном уншдаг хөгжлийн бэрхшээлтэй иргэн Дуламжавын Амартүвшингийн эд бараа материал болон мөнгөн тусламжийн хандив тусламж үзүүлсэн.

Байгууллагын цэвэр орчин бүрдүүлэх зорилгоор хүүхдэд зориулсан улавч 40



ширхэг оёж, сандал ширээ, цонх хөшиг угаан, бүх тавиурын болон номны тоос шороог цэвэрлэн, сандлын бүтээлгийг нь шинээр оёж, цонхны тоос шороог цэвэрлэж бүх хөшгийг угааж, индүүдэн, орчны гэрэлтүүлгийг шинэчлэн хийсэн.



БҮХ НИЙТИЙН ЦЭВЭРЛЭГЭЭ. Өөрийн хувиарт газрын цасыг тогтмол цэвэрлэлээ.

"Тэрбум" модны үндэсний хөдөлгөөнд 130 модыг өөрийн хуваарьт газар ХЖТ-ын зүүн талд суулгасан.



СЭЛЭНГЭ АЙМГИЙН НИЙТИЙН НОМЫН САНГИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

АГУУЛГА:

1. Ерөнхий мэдээлэл
2. Удирдлага зохион байгуулалт
3. Аргазүй ажил
4. Каталог, номзүйн үйл ажиллагаа
5. Фонд бүрдүүлэлт болон хадгалалт хамгаалалт
6. Уншлага Үйлчилгээ
7. Зөөврийн номын сангийн үйлчилгээ
8. Мэдээлэл Технологи
9. Зурган тайлан

Тайлбар: Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сангийн жилийн эцсийн үйл ажиллагааны тайланг дээрх 9 бүлэгт хуваан харуулсан байдал.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Эрхэм зорилго:

Номын сангийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, номын санг мэдээллийн төв болгон хөгжүүлэх нь бидний эрхэм зорилго юм.

Номын сангийн талаарх ерөнхий мэдээлэл:

Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сан нь 1948 онд 267 номтойгоор одоогийн Алтанбулаг суманд байгуулагдаж үндэс сууриа тавьжээ. 1961 оноос Сүхбаатар суманд Сэлэнгэ аймгийн Төв номын сан, 2009 оноос Сэлэнгэ аймгийн нийтийн номын сан болон өргөжиж 38000 гаруй номтойгоор Захиргаа аж ахуй, Арга зүй мэдээллийн танхим, Гэрээр ном олгох, тогтмол хэвлэлийн уншлагын танхим, Хүүхдийн уншлагийн танхим, Гадаад уншлагын танхим, Номын сангийн фонд, лавлагаа мэдээллийн тасаг гэсэн бүтэц зохион байгуулалттай нийт 18 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа явуулж байна. 2014 оноос Зөөврийн номын сангийн үйлчилгээг шинээр нэвтрүүлж алслагдсан баг болон албан байгууллагуудад хүрч үйлчилж байна. Нийтийн номын сан нь жилд дунджаар 2700 гаруй уншигчийг шинээр бүртгэн авч давхардсан тоогоор 16000 гаруй ард иргэдэд 21000 гаруй номоор үйлчилгээ үзүүлж байна. Мөн Сэлэнгэ аймгийн Сургуулийн өмнөх боловсрол болон Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, төрийн болон төрийн бус байгууллагуудын дунд Соёл олон нийтийн ажлыг тогтмол зохион явуулж байна. Үүнд: Тэмдэглэлт ойн баярууд болон Үндэсний бичиг үсгийн баяр, Эрдмийн баяр, Номын баяр, Үлгэрээр хүмүүжье-Чанга уншлага, “Зуны хөтөлбөр”, “Өвлийн хөтөлбөр”, арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулж байна.

Номын сангийн албан ёсны и-мейл хаяг: selengenomiinsan@gmail.com

Байгууллагын утасны дугаар: 7036-2169

Номын сангийн захирал: С.Шинэчимэг.

1. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сан нь 2024 онд Номын сангийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, номын санг нээлттэй мэдлэг мэдээллийн төв болгон хөгжүүлэх бодлого чиглэлийг баримтлан ажиллаа.

Жилийн болон улирлын ажлын төлөвлөгөөг “Алсын Хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлого, Соёлын яамны 2021-2024 стратеги төлөвлөгөөтэй уялдуулан, Засгийн Газрын 100 дугаар тогтоолын хүрээнд боловсруулж, Соёлын Яамны Шинэ Сэргэлтийн бодлого, Сэлэнгэ Аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Сэлэнгэ аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан ажил арга хэмжээнүүдийг тусган хэрэгжүүлж ажиллаа.

Уншигч хэрэглэгчдэдээ ном унших таатай орчин бүрдүүлэх, тэдэнд уншлага үйлчилгээг хүргэх, соён гэгээрүүлэх, соёлын боловсролын ажлыг үе шаттай хөгжүүлэх ажлыг зохион байгуулж, номын сангийн уламжлалт үйлчилгээг төгөлдөршүүлэх, шинэлэг үйлчилгээг нэвтрүүлэх ажлуудыг хэрэгжүүлж, шинээр үүсэн буй болж байгаа цаг үе, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хөгжүүлж байна.

Уншигч хэрэглэгчдийн ном унших таатай орчин бүрдүүлэх зорилгоор хүүхдийн уншлагын танхим бусад танхмыг тохижуулж, ажилчдын ажиллах орчин нөхцөл тоног төхөөрөмжийг шинэчлэн орчны стандартыг хангах зорилгоор 16,000,0 төгрөгийн хөрөнгө оруулалт хийлээ.

Ажилчдын Нийгмийн баталгаа хөтөлбөрийн хүрээнд цалинтай чөлөөг үр дүнтэй уян хатан нөхцөлтэйгөөр олгож, өвлийн бэлтгэл хангах дулаан өвөлжхөд зориулж төгрөгийн мөнгөн тусламжийг олгож ажилчдын цалин үр дүнгийн урамшууллыг зохих хууль дүрмийн хүрээнд олгож ажиллаж байна.

Номын сангийн төсвийг үр дүнтэй удирдаж 2024 оны жилд өр авлага үүсгэхгүй ажиллаж, сар бүрийн 15-нд шилэн дансандаа мэдээлэл оруулж, ил тод байдлын самбарыг тогтмол хөтөлж ажиллаа.

Архив бичиг хэргийн ажлыг Архивын тухай хууль, бусад хуулийн хүрээнд үр дүнтэй зохион байгуулж байна.

Сэлэнгэ аймгийн засаг даргын 2021-2024 оны хөтөлбөрийн хүрээнд Гэр бүл, хүүхдийн хүмүүжилрүү чиглэсэн нөлөөллийн ажлуудыг зохион байгуулах ажлын хүрээнд Дэлхийн Зөн байгууллагын сургагч багш бэлтгэх хөтөлбөрт хамрагдаж, Сүхбаатар сумын Хонгорморьт 1-р багийн зорилтот 20 өрх, Сүхбаатар сумын 4,5,8-р багийн иргэдэд “Хүүхдийг хүмүүжүүлэх эерэг арга” сургалтыг 6 өдөр амжилттай зохион байгуулж нийт 77 иргэд хамрагдсан байна. Дараах сэдвийн хүрээнд зохион байгуулсан.

- “Хүүхдийг хүмүүжүүлэх монгол арга ухаан”

- Хүүхдийн нас ба хөгжлийн онцлог, түүнийг таньж ойлгох нь
- Гэр бүлийн дүрэм хэрхэн бий болгон хэрэгжүүлэх
- Хүүхдийн хүчирхийлэл, түүнийг хэрхэн мэдээллэх
- Хүүхдийг хүмүүжүүлэх эерэг аргын хэрэглээ
- Хүүхэд хамгаалалын тухай эрхзүйн ойлголт

Хүүхэд, Гэр бүлийн хөгжил хамгааллийн газраас Сэлэнгэ аймгийн 17 сум 6 тосгодын нийгмийн ажилтан нарийг чадавхжуулах хөтөлбөрийн хүрээнд 12 модуль сургалтуудыг зохион байгуулсан. Тус арга хэмжээний 1 хэсэг болох “Угийн бичиг-Удмын сан” сургалтыг нийт 41 албан хаагчдын дунд зохион байгуулсан.

2. АРГАЗҮЙ АЖИЛ

Аймаг, Нийслэлийн Нийтийн номын сангийн үлгэрчилсэн дүрмийн 2.1.-т Нийтийн номын сан нь тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй номын санг харьяалалыг нь үл харгалзан мэргэжил арга зүйн удирдлага, мэдээллээр хангах нээлттэй төв байна.

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Алсын Хараа-2050”, Шинэ сэргэлтийн бодлого, хот, хөдөөгийн сэргэлт арга хэмжээний хүрээнд орон нутгийн номын санг хөгжүүлэх, номын санчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, тасралтгүй сурч, хөгжих шаардлагыг хангах, номын сангийн хүний нөөцийн хэрэгцээг сайжруулах зорилгоор “Нээлттэй номын сан-Номын санчдын анхдугаар чуулган”-ыг Сэлэнгэ аймгийн нийт сумдын соёлын төв болон Ерөнхий боловсролын сургуулиудын номын санчдыг хамруулан 6 сэдвийн хүрээнд сургалт, хэлэлцүүлэгийг зохион байгуулан ажилласан. Чуулганд нийт 57 номын санчид оролцож, урилгаар УБ хотын Хүүхдийн Төв номын сангийн хадгаламжийн хэлтэсийн эрхлэгч Л.Батболор оролцлоо. Дараах сургалтуудыг зохион байгуулан ажиллаа.

- “Хот хөдөөгийн сэргэлт ба орон нутгийн номын сангийн хөгжил” сэдвээр /*Нийтийн номын сангийн захирал С.Шинэчимэг /*
- “Сэлэнгэ аймгийн номын сангуудын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал” сэдвээр /*Нийтийн номын сангийн аргазүйч Т.Нарандалай /*
- Номын сангуудын өнөөгийн чиг хандлага сэдвээр /*УБ хотын хүүхдийн номын сангийн сан хөмрөг хадгаламжийн хэлтэсийн эрхлэгч Л.Батболор /*
- Номын сан ба зохиолчдын хамтын ажиллагаа /*МЗЭ-ийн Сэлэнгэ салбарын дарга Б.Батхүү, яруу найрагч Т.Доржсүрэн /*
- Номын сандаа шинээр санаачлан хийж хэрэгжүүлж байгаа ажил үйлчилгээ, арга барил, уншигчидтайгаа хийсэн бүтээлүүдийн санаагаа хуваалцахаар Сант сумын соёлын төвийн номын сан болон Мандал сумын 4-р сургуулийн номын санчид “Сайн туршлага”-аа хуваалцлаа.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007.11.08-ны өдрийн 415-р тушаалын нэгдүгээр хавсралт “Аймаг, Нийслэлийн Нийтийн номын сангийн үлгэрчилсэн дүрэм”-ийн 2.1-ын заалтын дагуу, аймгийн хэмжээний бүх номын сангуудын номын санчдад мэргэжил аргазүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлэн, тэдний мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд анхааран ажиллаа.

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 1,2,3,4,5,6 Спорт сургуулийн номын сангийн үйл ажиллагаатай танилцаж, аргазүйн зөвлөмж өгч нийт 500 гаруй номыг ангилж байрлууллаа.

“Загвар номын сан” хөтөлбөрийн хүрээнд 3 арга хэмжээ зохион байгуулж Сайхан, Мандал, Сүхбаатар сумын 6-р сургуулийн 38 номын санчдыг хамруулан номын санг стандартын дагуу зөв зохион байгуулж, нийт 10 мянга гаруй ном хэвлэлд техник ажиллагаа хийж, дадлагад суурилсан ажлыг зохион байгуулаад байна.

Жавхлант, Дулаанхан, Шаамар сумын Соёлын төвийн болон ЕБС-ийн номын сангийн үйл ажиллагаатай танилцаж, 8 номын санчдад аргазүйн зөвлөгөө өгч, Орхон, Хараа, Төвийн бүсийн соёлын төвийн болон ерөнхий боловсролын сургуулийн номын санч нар нь өөрсдийн номын сангуудын фондыг, номын сангийн дүрэм, стандартын дагуу ном хэвлэлийг ангилах шаардлагатай байна. Номын сангийн үсэг дарааллын болон төрөл ангийн каталогийг зөв зохион байгуулж, заавал бүртгэх бүртгэлүүдийг хөтлөж номын сангийн үндсэн үйл ажиллагааг орхигдуулахгүй ажиллах заавар зөвлөгөө өгөв.

Номын санчдад зориулсан мэргэжлийн онол аргазүйн “Номын санч” сэтгүүлийг 2022 оноос анх эрхлэн гаргаж, “Номын сан Номзүйн ангилал”, “Номын сангийн анхан шатны бүртгэлүүдийг хөтлөх”, “Номын сангийн орчин нөхцөлийн стандарт” “Номын санчийн ёс зүйн нэр томъёо” зэрэг 4 гарын авлага, 1 сэтгүүл боловсруулан нийт номын санчдад хүргэн мэдлэг боловсролоо дээшлүүлэхэд дэмжлэг үзүүллээ.

Сумдын болон сургуулиудын номын санч нарт танхимаар буюу цахимаар нийт 6 удаагийн 26 номын санчдад байнга мэргэжил аргазүйн зөвлөгөө өгч байна.

Аймгийн хэмжээний соёлын төвийн болон ерөнхий боловсролын сургуулийн нийт 65 номын санчдын судалгааг шинэчлэн бүртгэлээ.

Номын санчдын ёс зүй, хувь хүний зохион байгуулалт, үйлчилгээний соёлыг сайжруулах талд дээр анхааран зохих 5 сургалтуудыг тус тус зохиов.

“Номын сангийн орчин нөхцөл үйл ажиллагаа”-ны судалгааг-59 номын сан, соёлын төвийн болон Ерөнхий боловсролын сургуулийн номын сангуудын үнэлгээний хуудсыг-21 номын сангуудаас тус тус авч боловсруулж нэгтгэн дүгнэн үнэлгээ дүгнэлт, заавар зөвлөмж өгч ажиллаа.

Үлгэр жишээч номын сан 90-100 оноо	Сайн үйл ажиллагаатай номын сан 80 с дээш оноо	Хангалттай ажиллагаатай номын сан 70с дээш оноо	Хөгжих шаардлагатай номын сан 60с дээш оноо	Нэн яаралтай анхаарах номын сан 60с доош оноо
Номгон соёлын төвийн н.с. 93 оноо	Хушаат соёлын төвийн н.с 83 оноо		<ul style="list-style-type: none"> ➤ Сайхан ➤ Цагааннуур ➤ Орхон 	<ul style="list-style-type: none"> ➤ Баруунбүрэн ➤ Сант ➤ Рашаант
	СБ сумын ЕБ –ийн 3-р сургууль	СБ сумын ЕБ –ийн 6-р сургууль	<ul style="list-style-type: none"> ➤ Сант ЕБС ➤ Сайхан ЕБ 1-р сургууль ➤ Хушаат ЕБС ➤ Политехник коллеж ➤ СБ сумын ЕБ –ийн 6-р сургууль 	<ul style="list-style-type: none"> ➤ Номгон ЕБС ➤ Орхон ЕБС ➤ Баруунбүрэн ЕБС ➤ Рашаант ЕБС ➤ Сайхан ЕБ 2р сургууль ➤ Спорт сургууль
Нийт	2	1	8	9

3. КАТАЛОГИ, НОМЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Номзүйн ажлын хүрээнд төсвийн хөрөнгөөр 230 ширхэг, Хандив тусламжаар 126 ширхэг номуудыг хүлээн авч, дансанд бүртгэн, техник ажиллагаа хийн, уншлагын танхимуудад хуваарилан өглөө.

Номын сангийн уншигч хэрэглэгчиддээ шинэ номын мэдээ бэлтгэн, танхимаар болон цахим хаягаар сурталчлан 326 хүн үзэж сонирхсон байна.

Номын сангийн үндсэн бүртгэл болох Нэгдсэн бүртгэлийг бүртгэж дүгнэн нягтлан бодогчтой данс бүртгэлээ тулган нийт номын тоо болон үнийг эцсийн байдлаар дүгнэн гаргалаа.

Зохиолчдын намтар номзүйн бүртгэлийн баяжуулалтыг нэмэгдүүлж шинээр 21 зохиолчдын намтар уран бүтээлийн мэдээллийг бэлтгэсэн. Мөн МҮНС-ийн аргазүйчээс номзүйн бүртгэл гаргах зөвлөмж, зааварчилаа авсан. Зохиолчдын намтар уран бүтээлийг үндсэн фонд болон цахим эх сурвалж, ном хэвлэлээс хайж олон өдөр бүр баяжуулсаар байна.

Сэлэнгэ аймгийн Зохиолчдын намтар уран бүтээлийг Уугуул болон Суугуул зохиолчид болгон 2 хэсэгт хуваан мэдээллийг баяжуулжан ажилласаар байна. Нийт 74 зохиолчдын намтар уран бүтээлийг бүртгэсэн байна. Зохиолч яруу найрагч Т.Доржсүрэнтэй намтар номзүйн бүтээлд хамтран ажиллаж байна.

Сэлэнгэ аймгийн холбогдолтой номуудаар 34 ширхэг каталогийн карт бичиж, орон нутгийн картын сангаа баяжуулан ажиллаж байна.

Үндэсний тогтмол хэвлэлийн ZOTERO программд Сэлэнгийн мэдээ сонины 5 дугаарын 43 төрлийн мэдээ, мэдээллийг оруулж МҮНСанруу илгээсэн.

Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 3-р сургуулийн номын санд 46 ширхэг номонд каталогийн карт бичиж, төрөл ангийн болон үсэг дарааллын каталоги зохион байгуулах талаар заавар, зөвлөгөө өгч ажилласан.

4. ФОНД БҮРДҮҮЛЭЛТ БОЛОН ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТ

Үндсэн фондын ажлын хүрээнд жилд уншигч хэрэглэгчиддээ 715 гаруй номоор үйлчилж, 10 удаагийн номын үзэсгэлэн дэлгэж, 800 ширхэг ном хэвлэл, зохиол бүтээлийг танилцуулан 1600 гаруй иргэдэд үйлчиллээ.

Соёлын өвийг хадгалж хамгаалах, түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, иргэд аж ахуй нэгжтэй хамтран ажиллах, зөвлөмж, зөвлөгөө өгч, хамтын ажиллагааг идэвхжүүлэх ажлын хүрээнд соёлын төв болон сургуулийн номын номын санчдыг хамруулсан сургалт, фондыг зөв зохион байгуулах байршил, байрлуулалтанд анхаарч нийт 24 номын санч 3000 гаруй ном зохиолтой ажиллаж техник ажиллагаа хийлээ.

Соёлын баримтат өвийн судалгаа тандалтыг хийж, Сүхбаатар сумын 4 сүм, хийд, 1 хилийн цэргийн 0243-р ангид нийт 5 байгууллагад 10 хуучин судрын судалгаа тандалтыг хийж бүртгэлжүүлээд байна.

Сэлэнгийн зохиолчдын 180 ширхэг номоор номзүйн бичилт хийн “Номын санчдын анхдугаар чуулган”-д үзэсгэлэн гаргаж 300 гаруй хүн үзэж танилцсан.

Сэлэнгэ аймгийн түүхэн дургалт газаруудаа ард иргэддээ сурталчлан таниулах зорилгоор байгалын дурсгалт 8 газрын 680 ширхэг танилцуулгын эх бэлтгэн, тараах материал бэлтгэн иргэд уншигчдад үйлчиллээ.

Үндсэн фонд нь номын баяжилт байнга хийж байна. Иймээс тавиурын багтаамжыг нэмэгдүүлэх, номын өсөлтөнд анхаарч нөөц тавиурын талбай, байрлалыг зөв зохион байгуулах, мөн лавлагаа номзүйн буланг Сэлэнгэ аймгийн зохиолчдын зохиол, уран бүтээлээр баяжуулан ажиллаа.

д/д	Ном олголт	Тоо, ширхэг
1	Гэрээр ном олгох тасаг	640
2	Зөөврийн номын сан	46
3	Сум, сургуулийн номын сан	29
4	Нийт	715

Фондоос Зөөврийн номын сан, гэрээр ном олгох тасагт уншигчдын хэрэгцээт ном, тогтмол хэвлэлийг олгож үйлчилж , ном хэвлэлийн буцаалтанд хяналт тавин ажиллаж байна.

Ном хэвлэлийг хуурайшилтаас хамгаалах зорилгоор агаар чийгшүүлэгчийг байнга ажиллуулж байна. Фондын номын хадгалалт хамгаалалт, аюулгүй байдлыг хангах үүднээс шинээр ирсэн 38 номонд ялтсан дохиолол байрлуулж , сэлбэн засалт 36 , шинээр ирсэн, 450 ширхэг номыг ариутгалд орууллаа

5. УНШЛАГА ҮЙЛЧИЛГЭЭ

Сэлэнгэ аймгийн иргэдийг ном хэвлэлээр хангаж, уншлага үйлчилгээний чанарыг сайжруулах, ном олголтын хүртээмжийг нэмэгдүүлэх, соёл олон нийтийн ажлыг тогтмол зохион байгуулах зорилго тавин ажиллаж байна.



Уншлагын танхимаар үйлчлүүлж байгаа сургуулийн өмнөх болон 1-12 ангийн сурагчид, иргэд олон нийтийн уншлагын чанарыг сайжруулах, шинэ уншигч, ирэгсэд, ном олголтыг нэмэгдүүлэх, Соёл олон нийтийн ажлуудыг өргөн хүрээнд хамруулан зохион байгуулахад оршино.

Уншлага үйлчилгээ

Боловсрол соёл шинжлэх ухааны сайдын 2005 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 441 дүгээр тушаалын хавсралтын стандартын дагуу номын сангийн ажлын өдөр тутмын бүртгэл, ээлж хүлээлцэх бүртгэл, уншлаганд гарсан номын бүртгэл, өгөгдсөн номзүйн бүртгэл, татгалзлын бүртгэл, ном сэлбэн засалтын бүртгэл, цахим хаяг хөтлөлт гэсэн нийт 7 төрлийн бүртгэлүүдийг стандартын дагуу бүртгэж:

Уншлага үйлчилгээ нь жилд 1765 шинэ уншигч, 29090 ирэгсдэд, 39669 ширхэг ном хэвлэлээр үйлчилсэн.

Өгөгдсөн номзүйн лавлагааг 265 уншигчдад өгч бүртгэснээс 198 лавлагаа биелсэн.

Номын татгалзлын дэвтэрт 60 номын санал бүртгэгдсэнээс 49 татгалзал биелсэн байна.

Номын сангийн үлгэрчилсэн дүрмийн 3.2.6-д заасны дагуу ном хэвлэлийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах ажлын хүрээнд сэлбэн засалтын номын бүртгэлд 935 ном бүртгэгдэн урагдаж, нуруу шил нь гэмтэж салсан, хавтас нүүр, ярлык зэргээр номыг нааж, үдэж уншлага үйлчилгээнд гаргасан. Ном ариутгалын төхөөрөмжинд 1000 гаруй номыг ариутгав.

Цахим уншлагыг дэмжих, зохиол бүтээлийг сурталчлан таниулах 79 цахим мэдээ мэдээлэл бэлтгэн хүргэж 130598 иргэд олон нийтэд хүрсэн.

1. Монголын нууц товчоо зохиолын Чингис хааны бага насны үе 1-р бүлгийг-699, Чингисийн идэр насны үе 2-р бүлгийг-242, Мэргэдийг хөнөөсөн ба Тэмүжинд Чингис хаан цол өргөмжилсөн нь 3-р бүлгийг-213, Жамуха ба тайчуудтай тэмцсэн нь 4-р бүлгийг-786, Татаарыг сөнөөсөн ба ван хантай эвдэрсэн нь 5-р бүлгийг-456, Хэрэйд улс мөхсөн нь 6-р бүлэг-400, Ван хан сөнөсөн нь 7-р бүлэг-350, Хүчлүгийн дутаасан ба Жамухын дарагдсан нь 8-р бүлэг-389, Шадар хишигтэн цэргийг байгуулсан нь 9-р бүлэг-582, Уйгур ба ойн иргэдийг эзэлсэн нь 10-р бүлэг-520, Хятад, Тангуд, Сартуул, Багдад ба Оросыг эзэлсэн нь 11-р бүлэг-395, Чингис хаан нас барсан ба Өгэдэй хаан болсон нь 12-р бүлгийг 412 хүнд хүрж нийт 7444 иргэд олон нийтэд монголын нууц товчоог сурталчлан таниулсан.
2. Монгол Жангар тууль цуврал бичлэгийн 12 удаагийн мэдээллийг бэлтгэн 101781 иргэд олон нийтэд сурталчлан таниулсан.
3. Хүүхэд өсвөр үеийнхэнд түүх, соёл, хүмүүжил, хайрлах, хүндэтгэх, эерэг бүтээлч хандлага төлөвшүүлэх “Чингисийн чулууны бичиг”-ийг 538, “Кодын цагаан толгой”-ийг 303, “Гэсэр хүүхдэд зориулав” номыг 525, тооны чөтгөр номыг 647, Рейна Телгемайерийн Эгч дүүс, инээмсэглэл номыг 888, амьтдын тухай номын мэдээлэл бэлтгэн 1070, Р.Ж. Паласиогийн Огги бид хоёр номын мэдээллийг 452, Уиллиам Шекспир 275, орон орны баярууд 741, морин хуур хөгжмийн талаарх мэдээлэл 936, С.Дашдооров зохиолчийн намтар, уран бүтээл 297, үлгэрээр дамжуулан суралцъя 511 хүнд хүргэж нийт 7183 иргэд олон нийтэд сурталчлан таниулсан.

4. Дэлхийн хүүхдийн хүүрнэл зохиол бүтээлийн Лилит Норман Саваагүй нохой саранд мацах мэдээллийг 242, Жек Лондон Халцгай өгүүллэгийн мэдээллийг 391, Паула Фокс Тоглолт хийж мөнгө олдог нугас өгүүллэгийн мэдээллийг 356, А.Пушкин Хүүхдийн бяцхан ном мэдээллийг 871, Сельма Лагер солигдсон хүүхэд мэдээллийг 1288, Жеймс Олдриж гайхамшигт монгол морь 1377, япон зохиол 364, африк зохиол 468, хятад зохиол 398, армен зохиол 452 хүнд хүргэж тус тус мэдээллүүдийг бэлтгэн нийт 6207 иргэд олон нийтэд сурталчлан таниулсан.
5. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын мэдлэг ойлголтыг дээшлүүлэх мэдээллийг таниулах ажлын хүрээнд Цогтын хадны дурсгал буюу Дуутын хадны бичгийн дурсгалын мэдээллийг 969, Амарбаясгалант хийдийн цогцолбор дурсгалын мэдээллийг 1089, “Монгол ардын анхны байр” дурсгалын мэдээллийг 617, таван хан уулын тухай мэдээллийг 680, хадны сүг зураг мэдээллийг 889, барилга архитектурын дурсгал мэдээллийг 410, улсын хамгаалалтад байх түүх соёлын үл хөдлөх дурсгал 227, нийт 4881 иргэд олон нийтэд түүх соёлын үл хөдлөх дурсгалыг сурталчлан таниулсан.
6. “Монгол шунхан Данжуур” бурхан багшийн их хөлгөн судрыг цахимаар мэдээлэл бэлтгэн хүргэсэн. Нийт 386 хүнд хүрсэн. Танхим-25
7. “Есөн эрдэнийн Ганжуур” бурхан багшийн их хөлгөн судрыг цахим, танхимаар мэдээлэл бэлтгэн хүргэсэн. Нийт 200 хүнд хүрсэн.
8. Чулуун зэвсгийн үед холбогдох “Хадны зураг”-ийн мэдээлэл бэлтгэн цахимаар хүргэсэн. Цахим 338 хүнд хүрсэн.
9. Морин хуур хөгжмийн гарал үүсэл талаар цуврал мэдээлэн бэлтгэн цахимаар сурталчилсан. Цахим 233 хүнд хүрсэн.
10. “Халхын Цогт хунтайжийн хадны бичээс” өвийн мэдээлэн бэлтгэн цахимаар хүргэсэн. Нийт 200 Танхим 50
11. Монгол улсын Төрийн шагналт, эрдэмтэн зохиолч “Билгүүн номч” Б.Ренчингийн “Нууцыг задруулсан захиа” бүтээлийг мэдээлэл бэлтгэн уншигчдад хүргэв. Нийт 123 хүнд хүрсэн. Танхим-38
12. “Зэр зэвсэг минь баяртай” зохиолыг агуулгаар уншигч хүүхэд багачуудад мэдээлэл хүргэсэн. Нийт 65 Танхим 42
13. Банзрагч “Зам” роман агуулгын товч танилцуулга Танхим-365 хүнд хүрсэн.
14. Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Төрийн шагналт, Соёлын Гавьяат Зүтгэлтэн, МУА-ын Уран зохиолч яруу найрагч Б.Лхагвасүрэн намтар уран бүтээлийн танилцуулга бэлтгэн цахимаар хүргэсэн. Цахим 300 гаруй

15. Д.Пүрэвдорж зохиолчийн Тусгаар тогтнол, Хөх даалинбан тэрлэг, Сэгс цагаан богд шүлэг найраглал болон намтар уран бүтээлийг цахимаар хүргэсэн. Цахим 150, Танхим-25
16. Эрнест Хэмингуэй зохиолчийн “Бороонд норсон муур өгүүллэгийг сурталчилан таниулсан. Нийт 189 хүрсэн. Танхим-17
17. Том Сойерийн адал явдал Марк Твений зохиолыг цахим, танхимаар сурталчилан таниулсан. Нийт 195 хүрсэн. Танхим-27
18. Виктор Гюго зохиолчийн “Парисын дарь эхийн сүм” зохиолыг цахимаар сурталчилан таниулсан. Нийт 185 хүрсэн. Танхим-17
19. Виктор Гюго “Шоовдор хүмүүс” зохиолыг цахимаар сурталчилан таниулсан. Нийт 498 хүрсэн. Танхим 36
20. Михаэль Энде “Момо” зохиолыг цахим танхимаар сурталчилан таниулсан. Нийт- 227 Танхим- 28
21. “Зүйр цэцэн үг гэж юу? Мэдээлэлийг видео хэлбэрээр бэлтгэн хүргэсэн. Нийт 365 хүнд хүрсэн. Танхим-23
22. “Онъсого-Оюуны дасгал” мэдээлэлийг цахим болон танхимаар бэлтгэн хүргэсэн. Нийт 150 хүнд хүрсэн. Танхим-32
23. “Хэлц үгийн тайлбар ба ойролцоо хэлц” мэдээлэл бэлтгэн дунд, ахлах ангийн сурагчдад танилцуулав. Танхим 45 цахим-380
24. “Зул алдар хаан” туульсаа дээдлэн дэлгэрүүлэх сурталчлан таниулах талаар болон сумдын болон сургуулиудын номын санч нарт танхимаар буюу цахимаар нийт 42 удаагийн 196 номын санчдад байнга мэргэжил аргазүйн зөвлөгөө өгсөн.

Соёл танин мэдэхүйн ажил

Соёлын боловсролыг тэгш хүртээмжтэйгээр хүргэх зорилгоор 140 ажил арга хэмжээ зохион байгуулж 17235 хүүхэд багачууд, залуус, иргэд олон нийт хамрагдсан. Соёл танин мэдэхүйн ажлын удирдамж, бэлтгэл ажлын төлөвлөгөө, хөтөлбөр, оролцогчдын бүртгэлийн хуудас, хамтран зохион байгуулах байгууллага иргэдтэй холбогдох гэхчилэн бусад шаардлагатай бичиг баримтыг цаг тухайд нь гаргаж үйл ажиллагаандаа тусган ажиллаа.

1. Өвлийн хөтөлбөр-2024

“Уншъя, хөгжье, урагшилъя” сурагчдын өвлийн амралтыг үр бүтээлтэй өнгөрүүлэх зорилготой хөтөлбөрийг 01 сарын 08-аас 01 сарын 26 хүртэл 5 төрлийн сургалт, дугуйлангийн ажлыг зохион байгуулж Ерөнхий боловсролын сургуулийн 3-6 ангийн нийт 26 сурагч хамрагдсан.

- I. Ном бүтээлчээр уншиж номын тэмдэглэл хөтлөх дугуйлан

Номын тэмдэглэл бүтээлчээр хөтлөх дугуйланг Ерөнхий боловсролыг сургуулийн 1-5 ангийн 8 сурагчид хамрагдаж номын тэмдэглэл хөтлөх арга аргачлалаас суралцаж, зөв бичих, зурах, ном унших, бүтээлч чадваруудаа хөгжүүлэн амралтын хугацаагаа үр бүтээлтэй өнгөрүүллээ.

II. Номын сэтгэгдэл ярилцах дугуйлан

Номын сэтгэгдэл ярилцах дугуйланд Ерөнхий боловсролыг сургуулийн 1-5 ангийн 4 сурагчид хамрагдаж уншсан номоо үе тэнгийн найзуудтайгаа хуваалцаж, өөрийгөө илэрхийлэх, төсөөлөн бодох, ярих чадваруудаа хөгжүүлэн амралтаа үр бүтээлтэй өнгөрүүллээ.

III. Англи хэлний анхан шатны сургалт

Англи хэлний анхан шатны сургалтыг МУБИС-ийн Зр дамжааны оюутан Б. Анударь дадлагажигч багш удирдан зохион байгуулж Ерөнхий боловсролыг сургуулийн 5 ангийн 1 сурагч хамрагдаж англи хэлний анхан шатны хичээлийг судлан, англиар унших, бичих, ярих, дуулах чадваруудаа хөгжүүлэн амралтаа үр бүтээлтэй өнгөрүүллээ.

IV. Бяцхан санхүүч сургалт

Ерөнхий боловсролыг сургуулийн 5-6 ангийн 5 сурагчид хамрагдаж орос хэлний анхан шатны хичээлийг судлан, оросоор унших, бичих, ярих, дуулах чадваруудаа хөгжүүлэн амралтаа үр бүтээлтэй өнгөрүүллээ.

V. Урлан бүтээх дугуйлан

Шүрээр төрөл бүрийн гоёлууд урлах болон хос зүү, дэгээ зүүн нэхмэлийн анхан шатны хичээлийг Ерөнхий боловсролыг сургуулийн 1-5 ангийн 8 сурагчид хамрагдаж шүрээр толгойн гоёл, унжлагат ээмэг, бугуйвч, бөгж, зүүлт урласан.

2. “Дэлгэцтэй биш дэлгэсэн номтой нөхөрлөө” аян зохион байгуулах

Хүүхэд залуусын өвлийн амралтын хугацааг үр дүнтэй өнгөрүүлэх зорилгоор Сэлэнгэ аймгийн хэмжээнд Дэлгэцтэй биш Дэлгэсэн номтой нөхөрлөө аяныг зохион байгуулж, Сүхбаатар, Орхон, Хушаат, Сайхан сум Номгон тосгон, Бугант тосгон, Дархан-Уул аймгийн Ерөнхий боловсролын 2-11 ангийн 62 сурагчид зүйр үг хэн сайн мэдэх вэ, шилдэг номын тэмдэглэл, монгол шүлэг найраглал унших 3 төрлөөр оролцож хамгийн олон лайк цуглуулсан оролцогчид болон шилдэг 6 сурагчийг шалгаруулсан.

✓ Шилдэг Номын тэмдэглэл

Номгон ЕБС-ийн 7а ангийн сурагч Б.Нандин-Эрдэнэ, 11а ангийн сурагч Г.Лхагванаран

✓ Шүлэг найраглал

Номгон ЕБС-ийн 8а ангийн сурагч Э.Нарансолонго, Сүхбаатар сумын 1-р сургуулийн 2б ангийн сурагч Б.Энххүслэн

✓ Зүйр үг хэн сайн мэдэх вэ?

Хушаат сумын ЕБС-ийн 2а ангийн сурагч Ч.Ананд

Хушаат сумын ЕБС-ийн 2а ангийн сурагч М.Аялгуу

3. Хүүхэд өсвөр үеийнхэнд түүх, соёл, хүмүүжил, хайрлах хүндэтгэх, эерэг бүтээлч хандлага төлөвшүүлэх зохиол бүтээл, түүх соёлын дурсгалт бүтээлийг сурталчлан таниулах

А. Алсын хараа 1.1.1 заалтын түүх соёл, хүмүүжил хайрлах хүндэтгэх эерэг бүтээлч хандлага төлөвшүүлэх зорилгоор “Чингисийн чулууны бичиг” мэдээлэл гарын авлага бэлтгэн Ерөнхий боловсролын 35 хүүхдэд 7 хоногийн турш сурталчлан таниулсан.

Б. Ерөнхий боловсролын 1-7 ангийн 29 сурагчдад Гэсэр туулийн номыг чанга уншлагаар сурталчлан танилцуулж, Гэсэр туулийн дүрийн баатруудыг судлах даалгаврыг хийж, тууль хайлж буй бичлэг сонсож нүд чихээ баясгаж, туулийн талаарх мэдлэг ойлголтоо нэмэгдүүлсэн арга хэмжээг зохион байгуулсан.

В.Сүхбаатар сумын Спортын Ерөнхий боловсролын 4,5 ангийн 42 сурагчдад “Жангар” туулийн 4-р хэсгийг сонсож монгол баатарлаг туулийг сурталчлан, Жангар туулийн дүрийн баатруудын талаар санал бодлоо илэрхийлэх, зурах дүрслэх үйл ажиллагааг зохион байгуулж, туулийн талаарх мэдлэг ойлголтоо нэмэгдүүлсэн арга хэмжээг зохион байгуулсан. Нийт 106 сурагч хамрагдсан.

4. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын мэдлэг ойлголтыг дээшлүүлэх мэдээллийг таниулах

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын мэдлэг ойлголтыг дээшлүүлэх ажлын хүрээнд танхимын 2, цахим 1 арга хэмжээг зохион байгуулж нийт 1717 хүүхэд залуучууд, иргэдэд сурталчилсан. Үүнд: Цогтын хадны дурсгал буюу Дуутын хадны бичгийн дурсгал, түүх соёлын үл хөдлөх дурсгал мэдээлэл бэлтгэн ЕБС-ийн 5 дугаар ангийн 52 сурагчдад танилцуулж, ” сэлэнгэ нутгийн 8 түүх соёл, аялал жуулчлалын тухай 450 ширхэг гарын авлага бэлтгэн тарааж, 502 иргэд олон нийтэд сурталчлан таниулж, иргэдийн үл хөдлөх түүх, соёлын мэдлэг ойлголтыг дээшлүүлсэн. Цогтын хадны дурсгалтай холбоотой 1 цахим мэдээлэл, сэлэнгэ аймгийн үл хөдлөх дурсгалын талаарх 3 цахим мэдээллийг тус тус бэлтгэж олон нийтэд хүргэж нийт 1215 хүнд хүрсэн.

5. Монголын нууц товчоог сурталчлан таниулах

Монголын нууц товчоог сурталчлан таниулах номын үзэсгэлэн, номын тойм яриа, чанга уншлага, зургаар илэрхийлэх, ярилцлагын төрлүүдээр 12 бүлэгтэй танилцах 12 удаагийн арга хэмжээнд ЕБС-ийн 4-7 ангийн 25 ангийн нийт 458 сурагчид хамрагдсан.

6. Монгол Жангар тууль сурталчлан таниулах арга хэмжээ

Ерөнхий боловсролын 1-7 ангийн 78 сурагчдад Монгол Жангар туулийн мэдээлэл сургалтыг танилцуулж, Жангар туулийн дүрийн баатруудыг судлах даалгаврыг

хийж, тууль хайлж буй бичлэг сонсож нүд чихээ баясгаж, туулийн талаарх мэдлэг ойлголтоо нэмэгдүүлсэн арга хэмжээг 2 удаа зохион байгуулсан. Уншигчдын дунд Монгол Жангар туулийн тухай тойм яриаг зохион байгуулж нийт 52 сурагчид хамрагдсан.

7. Үлгэрээр хүмүүжье-Чанга уншлага

Үлгэрээр хүмүүжье чанга уншлагыг 2024 онд 12 удаа зохион байгуулж, Сүхбаатар сумын 1,2,3,4,5,бүжинхэн цэцэрлэгийн ахлах, бэлтгэл бүлгийн 306 суралцагчдад Монгол ардын үлгэрүүд, маршакын үлгэр, андерсений үлгэр, ах дүү гриммийн үлгэр гэх мэт дэлхийн сонгодог, монголын үндэсний үлгэрийг чанга уншлагаар уншиж өгч, зурагт ном хэвлэл, буддаг зураг будах, танин мэдэхүйн карттай танилцах, номын сангийн үйл ажиллагааг сурталчлан ажилласан.

8. Уншигч анги хамт олон- Урилгат уншлага

10 удаагийн арга хэмжээнд нийт ЕБ-ын 1,2,4,5, Спорт сургуулийн 1-7 ангийн нийт 13 ангийн 376 сурагч хамрагдсан.

- I. Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын 4 сургуулийн Ө.Нямаанямбуу багштай 5в ангийн 38 сурагч, Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын 4 сургуулийн С.Цэндээ багштай 4б ангийн 33 сурагчид номын сантай танилцлаа. 4б ангийн сурагчид маань "Ангиараа уншъя- Авьяасаа хөгжүүлье" уншлагын аянд нэгдэж, удирдамжид тусгагдсан бага ангийн сурагчдын уншиж судлах монголын болон дэлхийн шилдэг зохиол бүтээлтэй танилцаж, С.Я.Маршакийн "Бяцхан цамхаг" үлгэрээр чанга уншлага зохион байгууллаа.
- II. Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын Спорт сургуулийн 2а ангийн хөөрхөн, ухаалаг 35 сурагчид хүүхдийн номын өргөөтэй танилцлаа. Өнгөрсөн намар тус ангид номын уншлага, танилцуулга мэдээлэл хүргэсэн бөгөөд энэ удаа багш эцэг эхийн хамт хүүхдийн уншлагын танхимтай танилцахаар хүрэлцэн ирхэд 2а ангийн сурагчид маань "Ангиараа уншъя- Авьяасаа хөгжүүлье" уншлагын аянд нэгдэж, хүүхдийн уншлагын танхимд 7 хоногийн Даваа гараг бүр номын уншлага зохион байгуулж, удирдамжид тусгагдсан бага ангийн сурагчдын уншиж судлах монголын болон дэлхийн шилдэг зохиол бүтээлтэй танилцаж, Данийн алдарт хүүхдийн зохиолч Х.Х.Андерсений "Нугасны муухай дэгдээхэй" үлгэрээр чанга уншлага зохион байгууллаа.
- III. Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын 4 сургуулийн Хишигсүрэн багштай 4а ангийн 30 сурагчид номын сантай танилцаж "Ангиараа уншъя- Авьяасаа хөгжүүлье" уншлагын аянд нэгдэн, удирдамжид тусгагдсан бага ангийн сурагчдын уншиж судлах монголын болон дэлхийн шилдэг зохиол бүтээлтэй танилцаж, Х.Х.Андерсений "Эрэлхэг тугалган цэрэг" үлгэрээр чанга уншлага

зохион байгууллаа. Тус анги нь монгол хэлний хичээлтэйгээ уялдуулан номын тэмдэглэлийг бүтээлчээр өөр өөрөөр хийдгээрээ онцлог байв.

- IV. Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын Спорт сургуулийн 1а ангийн 10 сурагчид номын сантай танилцаж, унших чадвараа сайжруулахын тулд уншлагын танхимд өдөр бүр номын уншлага явуулан мөн "Ангиараа уншъя-Авьяасаа хөгжүүлье" уншлагын аянд нэгдэж, удирдамжид тусгагдсан бага ангийн сурагчдын уншиж судлах үлгэрийг уншлаа.
- V. Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын Спорт сургуулийн С. Оюунцэцэг багштай 3а ангийн 21 сурагч, 5а ангийн 20 сурагчид номын сантай танилцлаа. Өнгөрсөн намар тус ангиудад номын уншлага, танилцуулга мэдээлэл хүргэсэн бөгөөд энэ удаа багшийн хамт хүүхдийн уншлагын танхимтай танилцахаар хүрэлцэн иржээ. Сурагчид "Ангиараа уншъя- Авьяасаа хөгжүүлье" уншлагын аянд нэгдэж, Удирдамжид тусгагдсан бага ангийн сурагчдын уншиж судлах монголын болон дэлхийн шилдэг зохиол бүтээлтэй танилцаж, хүүхдийн зохиолч С.Маршакийн "Бяцхан цамхаг" үлгэрээр чанга уншлага зохион байгууллаа.
- VI. Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын 4 сургуулийн Шижир-Эрдэнэ багштай 4в ангийн 30 сурагчид номын сантай танилцлаа. "Ангиараа уншъя-Авьяасаа хөгжүүлье" уншлагын аянд нэгдэж, удирдамжид тусгагдсан бага ангийн сурагчдын уншиж судлах 9 зохиол болох монголын болон дэлхийн шилдэг зохиол бүтээлтэй танилцаж, номын тэмдэглэл хөтөлж, Х.Х.Андерсений "Хааны шинэ хувцас" үлгэрээр чанга уншлага зохион байгууллаа.
- VII. Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын Спорт сургуулийн 2а ангийн 35 сурагчид 7 хоногийн Даваа гараг бүр монгол ардын болон сонгодог үлгэрийн уншлагыг зохион байгуулж, удирдамжид тусгагдсан бага ангийн сурагчдын уншиж судлах монголын болон дэлхийн шилдэг зохиол бүтээлтэй танилцаж, Монгол ардын үлгэр "Болдоггүй бор өвгөн" үлгэрээр чанга уншлага зохион байгууллаа.
- VIII. Ерөнхий боловсролын 1-р сургуулийн Баярмаа багштай 4д ангийн 31 сурагчдад уншигчийн карт үнэ төлбөргүй нээн өгч, номын сангийн үйл ажиллагааг сурталчлан "Номын тэмдэглэл хэрхэн хөтлөх вэ" сургалт мэдээлэл, Залгууран мангас номыг чанга уншлагаар уншиж, номын тэмдэглэл, зураг зурж, олон төрлийн ном бие даан уншиж, тоглоом тоглож цагийг үр бүтээлтэй өнгөрүүлсэн үйл ажиллагааг зохион байгуулсан

- IX. Ерөнхий боловсролын 2-р сургуулийн н.Эрдэнэчимэг багштай 3б ангийн 32 сурагчдад номын сангийн үйл ажиллагааг сурталчлан монгол ардын үлгэрийн чанга уншлага, 3д зурагт ном үзэх, "АХА" танин мэдэхүйн тэмцээн зохион, хөгжөөнт тоглоомууд хоорондоо тоглож өнгөрүүлээ.
- X. Ерөнхий боловсролын 5-р сургуулийн 3а, 4а ангийн 61 сурагчдад Толстойн богино өгүүллэгээс чанга уншлага хийж, хүүхдэд зориулсан монголын нууц товчоо болон төрөл бүрийн ном унших аргууд, тэмдэглэл хөтлөхөд анхаарах зарим зүйлийн талаар мэдээлэл өгч ажиллаа.

9. "Тандаа барих миний бэлэг" зохион бичлэгийн уралдаан

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг угтан "Ухаарлын жимээр" ТББ-тай хамтран Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд зохион байгуулсан "Тандаа барих миний бэлэг" зохион бичлэгийн уралдаанд Сүхбаатар сум болон Номгон тосгоны ЕБС-ийн 86 сурагчдын бүтээл ирж, шагналт байранд орсон сурагчдыг шагнаж урамшуулсан.

3-5 ангийн ангилалд:

1. Тэргүүн байр: ЕБ-ын 2 сургуулийн 5б ангийн сурагч У. Насанжаргал
2. Дэд байр: ЕБ-ын 2 сургуулийн 5а ангийн сурагч И.Нандин-Эрдэнэ
3. Гутгаар байр: ЕБ-ын 4 сургуулийн 5в ангийн сурагч М.Марал
4. Тусгай байр: ЕБ-ын 2 сургуулийн 5а ангийн сурагч З.Энхжин
5. Тусгай байр: ЕБ-ын 6 сургуулийн 4а ангийн сурагч У.Бямбасүрэн

6-9 ангийн ангилалд:

1. Тэргүүн байр: Номгон ЕБС-ийн сургуулийн 7а ангийн сурагч Б.Нандин-Эрдэнэ
2. Дэд байр: ЕБ-ын 4 сургуулийн 9б ангийн сурагч Х.Авид
3. Гутгаар байр: ЕБ-ын 4 сургуулийн 9а ангийн сурагч Н.Арвинзул
4. Тусгай байр: ЕБ-ын 6 сургуулийн 6б ангийн сурагч О.Номин-Эрдэнэ
5. Тусгай байр: ЕБ-ын 4 сургуулийн 9б ангийн сурагч Н.Болор-Эрдэнэ

10-12 ангийн ангилалд:

1. Тэргүүн байр: ЕБ-ын 6 сургуулийн 11а ангийн сурагч А.Халиунаа
2. Дэд байр: ЕБ-ын 3 сургуулийн 10а ангийн сурагч Ц.Саранзул

10."Ангиараа уншъя- Авьяасаа хөгжүүлье" уншлагын аян, жүжигчилсэн дүрийн тоглолтын уралдаан зохион байгуулах

Дэлхийн номын өдрийг угтан зохион байгуулсан "Ангиараа уншъя-Авьяасаа хөгжүүлье" уншлагын аян, жүжигчилсэн дүрийн тоглолтын уралдааны Нэгдүгээр шатанд Зүүнбүрэн, Хушаат, Сүхбаатар сумын 10 ангийн бичлэгүүд ирж, шилдэг уншигч анги хамт олноо шалгаруулсан. Үүнд:

Бага ангийн төрөлд:

Тэргүүн байр: Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын 4-р сургуулийн Д.Хишигсүрэн багштай 4а ангийн хамт олон

Дэд байр: Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын 4-р сургуулийн Ө.Нямаанямбуу багштай 5в ангийн хамт олон

Гутгаар байр: Зүүнбүрэн сумын ЕБС-ийн Сувданчимэг багштай 4а ангийн хамт олон
Ахлах ангийн төрөлд:

Тэргүүн байр: Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын 2-р сургуулийн Мягмарсүрэн багштай 11а ангийн хамт олон

Тусгай байр: Хушаат сумын Ерөнхий боловсролын сургуулийн 11а ангийн хамт олон. Нийт 155 сурагчид хамрагдсан.

11. "Ангиараа уншъя- Авьяасаа хөгжүүлэе" уншлагын аян, жүжигчилсэн дүрийн тоглолтын уралдааны 2 дугаар шатны шалгаруулалт

Уралдааны 2 дугаар шатанд Сүхбаатар, Хушаат, Зүүнбүрэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 4-12 ангийн сурагчид анги хамт олноороо оролцож цахимаар дүрийн тоглолтын бичлэгээ илгээсэн. Нийт 145 сурагчид хамрагдсан.

Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын 1-р сургуулийн 6г ангийн хамт олон Ч.Лодойдамба-Манай сургуулийнхан тууж, ЕБ-ын 2-р сургуулийн н.Мягмарсүрэн багштай 11а ангийн хамт олон Шекспирийн Гамлет жүжиг, ЕБ-ын 4-р сургуулийн Ө.Нямаанямбуу багштай 5в ангийн хамт олон Х.Х.Андерсений Нугасны муухай дэгдээхий үлгэр, ЕБ-ын 4-р сургуулийн Д.Хишигсүрэн багштай 4а ангийн хамт олон Эрэлхэг тугалган цэрэг, Хушаат сумын Ерөнхий боловсролын сургуулийн Л.Отгонбаяр багштай 11а ангийн хамт олон Шекспирийн Гамлет жүжгээр тус тус өрсөлдөж Бага ангийн төрөлд: Тэргүүн байр: Сүхбаатар сумын ЕБ-ын 4-р сургуулийн Д.Хишигсүрэн багштай 4а ангийн хамт олон, Ахлах ангийн төрөлд: Тэргүүн байр: Сүхбаатар сумын ЕБ-ын 2-р сургуулийн 11а ангийн хамт олон тус тус шалгарсан.

12. Монгол гэр үзэсгэлэн

Соёлын яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газраас санаачилан "МОНГОЛ ГЭР" үзэсгэлэнг 2024 оны 05 дугаар сарын 04-12-ны өдрүүдэд Чингисийн талбайд зохион байгуулсан. Үндэсний өв соёлоо дээдлэн уламжилж, үр хойчдоо өвлүүлэх эрхэм үүргийг хүлээсэн хүүхэд багачууд, оюутан залуус, иргэд олон нийтэд 3 боловсролын хөтөлбөр хэрэгжүүлсэн. Нийт 4004 иргэд хамрагдсан. Үүнд:

1. Шагайн наадгайн хөтөлбөрийн хүрээнд бөгцөг няслах, шагай таалцах, морь уралдах, шагай сэлгэх, шагайн мэргэ гэсэн төрлүүдийг 2014 иргэд олон нийтэд сурталчлан таниулсан.

2. “Сэлэнгэ сайхан нутгаар аялцгаая” сэлэнгэ аймгийн танилцуулга, мэдээлэл, puzzle эвлүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж Сэлэнгэ аймгийн түүх соёлын онцлог бүхий газруудаар сэдэвчилсэн 8 төрлийн 266 ширхэг тараах материал тараав. Нийт 740 иргэд олон нийт хамрагдсан.

3. Оюуны оньс боловсролын хөтөлбөрөөр монгол гэрийн холбогдолтой оньсого тааж, монгол гэр барих үйл ажиллагааг зохион байгуулж нийт 1250 иргэд олон нийт хамрагдсан

13. Тоглонгоо уншъя-Гэр бүлийн өдөрлөг

Энэхүү өдөрлөгийг 2024 оны 3, 5, 6 саруудад 3 удаа зохион байгуулж, Сүхбаатар сумын 2, 4 багийн 5 гэр бүлийн 20 хүн, Шаамар сумын 5 гэр бүлийн 20, Зуны хөтөлбөрийн эцэг эх хүүхдийн төлөөлөл 5 гэр бүлийн 20, нийт 60 хүүхэд, эцэг эхчүүд хамрагдсан. Өдөрлөгийн хүрээнд Бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлэх, уншлагын хүрээ хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор гэр бүлээрээ хамтран монгол ардын болон дэлхийн сонгодог зохиол бүтээлийн уншлага явуулж, уншсан номын товч танилцуулга арга хэмжээг зохион байгууллаа. Гэр бүлийн бүх гишүүдийн оролцоотойгоор сонгогдсон номоо уншиж, зурж буддаг нь гэр бүлийн халуун дулаан уур амьсгал бүрдүүлж эерэг хандлагыг түгээн дэлгэрүүлэх юм.

14. Үндэсний номын баяр арга хэмжээ зохион байгуулах

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор улс орон даяар зохион байгуулагдсан "Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2024" арга хэмжээ Сэлэнгэ аймгийн нийт сум, Ерөнхий боловсролын сургуулиудын номын санчид, сурагчдыг хамруулан хавар, намар 2 удаа зохион байгуулж нийт 1869 сурагчид, иргэд олон нийтэд номын соёлыг сурталчлан ажилласан.

❖ Хаврын Номын баярын арга хэмжээнд 720 гаруй иргэд олон нийт оролцож, 6 ажил арга хэмжээ зохион байгуулсан.

1. Ангиараа уншъя-Авьяасаа хөгжүүлье аяны шилдэг дүрийн тоглолт
2. Сэлэнгэ аймгийн номын санчдын Анхдугаар чуулган, хэлэлцүүлэг
3. “Шилдэг Соёлын төвийн номын сан”
4. “Шилдэг сургуулийн номын сан”
5. “Шилдэг гэрийн номын сантай айл өрх
6. Хүүхэд өсвөр үеийнхнийг номтой нөхөрлүүлэх, ном унших сонирхолыг нь дэмжих зорилгоор “Тэргүүний уншигч-Нацагдорж тэмдэгтэн” шалгарууллаа.

- ❖ Намрын Номын баярыг “Үндэсний бичиг соёлоо эрхэмлэн дээдэлье” уриатайгаар зохион байгуулж 1149 иргэд олон нийт хамрагдсан.

Тус үйл ажиллагааны хүрээнд 6 ажил арга хэмжээг зохион байгууллаа. Үүнд:

1. МЗЭ-ийн Сэлэнгэ аймгийн салбар зөвлөлтэй хамтран “Шилдэг зохиолч”, “Шилдэг бүтээл” шалгаруулах уралдааныг зохион байгуулж 5 зохиолчийн 6 бүтээл ирсэнээс

- “Шилдэг зохиолч”-оор МЗЭ-ийн шагналт зохиолч, яруу найрагч Р.Шийлэгжаргал

- “Шилдэг бүтээл”-ээр Сэр-Одын шагналт, яруу найрагч Г.Хасбаатар "Яруу феномен", "Ойн монолог" бүтээлүүд шалгарч Цом, Мөнгөн шагналаар шагнаж урамшуулав.

2. Сэлэнгэ аймгийн сумдын соёлын төв, ЕБС-ийн номын санчдад "Соёлын боловсролын хөтөлбөр хэрхэн хэрэгжүүлэх вэ" цахим сургалтад 45 номын санчид хамрагдлаа.

3. Соёлын боловсролын хөтөлбөрийг Сүхбаатар сумын ЕБ-ын 1,3,4,5,6 сургуулийн сурагчид болон Сүхбаатар сумын Политехник коллежийн 1-р дамжааны оюутнуудад “Гэр” боловсролын хөтөлбөр, “Сэлэнгэ сайхан нутгаар аялцгаая” хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж 359 багш, сурагчид хамрагдсан.

4. Сэлэнгэ аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд МЗЭ-ын шагналт, зохиолч яруу найрагч Б.Батхүү зохиолчийн “Төрөлх монгол хэл минь” шүлгийг уран яруу унших цахим аяныг өрнүүлж 7 сумын 8 ангийн 260 гаруй сурагчид уншиж бичлэгээ явуулсныг хүлээн авч цахим хаягаар иргэд олон нийтэд сурталчиллаа.

5. МЗЭ-ын шагналт, зохиолч яруу найрагч Т.Доржсүрэнгийн хувийн архивт хадгалагдаж байгаа 180 гаруй номоор “Ном түүх өгүүлнэ” үзэсгэлэнг дэглэж 480 гаруй иргэдэд сурталчлан таниулав.

6. Номын сангийн үйлчилгээг иргэдэд задгай номын сан хэлбэрээр зохион байгуулан үйлчилсэн.

15. "Номтой дурсамж бүтээгч-аз жаргалтай гэр бүл" цахим аян

Гэр бүлийн уншлагыг дэмжих, нийгэмд эерэг зөв хандлага түгээн дэлгэрүүлэх зорилгоор "НОМТОЙ ДУРСАМЖ БҮТЭЭГЧ-АЗ ЖАРГАЛТАЙ ГЭР БҮЛ" цахим аяныг зохион байгуулсан. Аянд сүхбаатар, Хушаат, Зүүнбүрэн, Номгон, Бугант тосгоны гэр бүлүүд хамрагдсан. Нийт 10 гэр бүл оролцсон.

16. Эх үрсийн баярын Номын хотхон” арга хэмжээ

Арга хэмжээнд 5 төрлийн үйл ажиллагаанд нийт 552 иргэд хамрагдсан.

1. Open mic арга хэмжээнд 47 хүүхэд залуус хамрагдсан.

2. Бидний ирээдүй зургийн уралдаанд СӨБ, ЕБС-ийн 1-11 ангийн 42 сурагч оролцсон. Сургуулийн өмнөх боловсролын төрөлд тэргүүн байранд Мөнхжин ЕБС-ийн бага ангийн төрөлд тэргүүн байранд СБ сумын 2р сургуулийн 5в ангийн сурагч Л. Отгонбилэг, дэд байранд СБ сумын 6-р сургуулийн 5б ангийн сурагч Б.Ариуннандин, гутгаар байранд 2-р ангийн сурагч С.Пүрэвсайхан, тусгай байранд 2р сургуулийн 4-р ангийн сурагч А.Цэнгэлжаргал

ЕБС-ийн ахлах ангийн төрөлд тэргүүн байранд Н.Мишээл нар тус шалгарсан.

3.Танин мэдэхүйн “АХА” тэмцээнд 33 сурагч оролцож тэргүүн байранд Өгөдэй, дэд байранд Батгэрэл, гутгаар байранд Ангараг нар тус тус шалгарсан.

4. Хөгжөөнт спортын тэмцээн өдөрлөгт 30 хүүхэд багачууд хамрагдсан.

5. Номын үзэсгэлэнг нийт 400 гаруй иргэд олон нийтэд танилцуулсан.

17. Оюунлаг бүтээлч ирээдүйн төлөө уриатай “Зуны хөтөлбөр” хэрэгжүүлэх

Хөтөлбөрийн хүрээнд 2024 оны 06 сарын 10-аас 08 сарын 20-ныг дуустал 7 төрлийн сургалт, дугуйланг 2 удаагийн давтамжтайгаар хичээллүүлсэн. Нийт 90 сурагч хамрагдсан.

1.Номын тэмдэглэл хөтлөх дугуйлан

2. Номын сэтгэгдэл ярилцах дугуйлан

3. Шүрээр урлан бүтээх сургалт

4. Нэхмэлээр урлан бүтээх сургалт

5. Бяцхан санхүүч сургалт

6. Англи хэлний анхан шатны сургалт

7 Орос хэлний анхан шатны сургалт

18. “Оюунлаг” номын клубын номын мэтгэлцээн зохион байгуулах

Клубын гишүүн 20 сурагчийн дунд өсвөр үеийн хүүхэд залуучуудын сонирхон уншдаг номоор номын мэтгэлцээн зохион байгуулж, номын шүүмж, санал сэтгэгдлээ хуваалцаж, номын мэтгэлцээний соёлд суралцсан.

19. Гэр бүлийн амьдрах ухааны хөтөлбөр хэрэгжүүлэх

Гэр бүлийн гишүүдийг хөгжүүлэх 2 төрлийн сургалт зохион байгуулсан. Төрийн албан хаагчдад монгол ахуй соёлыг түгээн дэлгэрүүлэх монгол гэр барих зан үйлийн сургалт, Хүүхэд багачуудад санхүүгийн мэдлэг олгох “Бяцхан санхүүч” сургалтыг 20 сурагчдад хичээллүүлсэн. Нийт 55 албан хаагч, хүүхэд багачууд хамрагдсан.

20. СӨБ, ЕБС-ийн бага ангийн сурагчдын дунд “Номын сантай танилцах аялал” арга хэмжээ зохион байгуулах

Хүүхэд багачуудын ном унших идэвхийг нэмэгдүүлэх, хөхүүлэн дэмжих, номтой нөхөрлүүлэх ажлын хүрээнд:

1. Номын сангийн үндсэн фонд, уншлагын танхимуудтай танилцаж, карт нээх
2. Маршакийн “Бяцхан цамхаг” шүлэглэсэн үлгэр, Х.Х.Андерсений Эрэлхэг тугалган цэрэг, Ах дүү Гриммийн Үнсгэлжин үлгэр, Эмээ бид хоёрын үлгэрүүдээр” Чанга уншлага” зохион байгуулах
3. Сургамжит үлгэрийн видео бичлэг үзэх, ярилцах
4. Нас сэтгэхүйн онцлогт тохирсон номтой танилцаж
5. Танин мэдэхүйн зураг зурж, будах, зурган ном эвлүүлэх
6. Номын сангийн хүүхэд хөгжүүлэх тоглоомоор тоглох зэрэг ажлуудыг Сүхбаатар сум, Зүүнбүрэн сумын СӨБ-ийн 1,5 дугаар цэцэрлэгийн ахлах, бэлтгэл бүлгийн 65, ЕБ-ын 1,2,3,4, Спорт сургуулийн 1-7 ангийн 12 ангийн 507 сурагч, нийт 572 хүүхэд багачууд хамрагдсан.

21. Гэр бүлийн боловсрол олгох 4 сургалтад 80 иргэд хамрагдав

Дэлхийн зөн олон улсын байгууллагатай хамтран Сүхбаатар сумын зорилтот бүлгийн 60 өрхийн төлөөлөлд хүүхэд хүмүүжил, хүчирхийллийн эсрэг мэдээлэл өгч чөлөөт ярилцлага хийн өөрөө өөртөө дүгнэлт тавьсан сургалтыг зохион байгууллаа.

22. “Нүүдэлчин-Монгол” дэлхийн фестиваль

Соёлын өвийг дэлхий дахинд сурталчлах олон улсын арга хэмжээнд Соёлын биет бус өвийг сурталчлан таниулж, түгээн дэлгэрүүлэн үр хойч үедээ өвлүүлэн үлдээх зорилгоор “Сэлэнгэ сайхан нутгаар аялцгаая”, “Гэр” боловсролын хөтөлбөрүүдээр оролцлоо. Нийт 1200 гаруй хүн хамрагдав.

Гэр боловсролын хөтөлбөрт:

- ❖ Угсардаг монгол гэрийг эвлүүлэн барих
- ❖ Монгол гэрийн бүрдэл хэсгийн тухай оньсого тааж, танин мэдэх

Сэлэнгэ сайхан нутгаар аялцгаая боловсролын хөтөлбөрт:

- ❖ Уран зургийн булан
- ❖ Сэлэнгэ аймгийн онцлогийг, сэтгэн бодох чадвартай уялдуулсан үгийн сүлжээтэй ажиллах

23. Бид Эх Орны Хүүхдүүд

Хилийн цэргийн 0101 дүгээр ангитай хамтран Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 1,3,5,6 дугаар сургуулийн 10-12 дугаар ангийн нийт 33 сурагчид түүний 25 эрэгтэй 7 эмэгтэй сурагч хамрагдлаа. Сурагчдад Эх оронч, эр зоригийн хүмүүжил олгох, эх орноо хайрлан хамгаалах сэтгэлтэй болгох зорилгоор “Бид эх орны хүүхдүүд” өдөрлөгийг амжилттай зохион байгууллаа. Өдөрлөгөөр:

Монгол улсын баатар Жадамбын Нэхийтийн нэрэмжит Хилийн цэргийн 0101 дүгээр ангийн товч түүх, танилцуулгыг сонсож, Алдарын тасалгаа үзэж сонирхсон.

Харуул хамгаалалтын тусгай салбар, Хугацаат цэргийн албан хаагчдын байр объекттой танилцаж, Хил хамгаалалтад ашиглаж байгаа зэвсэг, техник хэрэгсэл

болон бусад хамгаалалтын хэрэгсэлтэй танилцан, Хилээр шалган нэврүүлэх төнөг төхөөрөмж, пасворыг хэрхэн шалгадаг талаар танилцлаа. Хугацаат цэргийн алба хаагчдын өдрийн хоолны норм, хангалтын хэрэгслүүдтэй танилцсан.

Өдрийн нэгдэлтэн дээр цэргүүд хөгжимтэй бие хамгаалах урлагийн дасгал, үзүүлэн тоглолт бэлтгэн хүргэсэн. Үүний дараа Дэд хурандаа Идэрбал Хувь хүний хөгжлийн талаар сонирхолтэй мэдээлэл хүргэж, харилцан ярилцаж, мөн гамшгийн аюулын тухай зарлан мэдээлэх дохиогоор дадлага сургуулилтад хамрагдаж, нэг өдрийг өөрсдийгөө хөгжүүлж өнгөрүүллээ.

24. Хүүхэд өсвөр үе залуусыг хорт зуршил, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ

Өсвөр үеийн залуусыг хорт зуршлаас ангид байлгах зорилгоор хорт зуршлаас урьдчилан сэргийлэх 14 хоногийн аян зарлаж, номын сангийн 258 уншигч хүүхэд багачуудад хорт зуршил, гэм хор, гэмт хэргийн тухай танилцуулсан зөвлөмж тараах материал бэлтгэн тарааж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаарх зөвлөмжийг сурталчлан таниулж ажилласан. Цахим хаягт түүнтэй холбоотой мэдээлэл, шторк, контентийг түгээж, 582 хүнд хүрсэн. Нийт 840 хүүхэд, залуус, олон нийтэд мэдээлэл түгээн хүргэсэн.

25. Дэлхийн хүүхдийн өдөр

“Дэлхийн хүүхдийн өдөр”-т зориулан дуу хоолойгоо нэгтгэн хүүхдийн өдөрт зориулсан цахим геел бичлэг, мэндчилгээ нийгмийн сүлжээ дээрээ түгээж, хамт олноороо 1 өдрийг цэнхэр хувцсаар ижилсэх, хүүхэд гэр бүлд ээлтэй бодлогын талаар дотоод яриа, уулзалт зохион байгууллаа. Контент бичлэг цахим хаягаар 491 хүнд хүрсэн.

26. Тэргүүний уншигч-Д.Нацагдорж тэмдэгтэн сурагч шалгаруулах

Нацагдорж тэмдэгтэн сурагч шалгаруулах аянд 4 сумын 5 сургуулийн 7 ангийн 47 сурагчдын бүтээл ирж нийт 17 сурагчийг үнэмлэх, тэмдэгээр шагнаж урамшуулсан.

27. Охиндоо захидал бичээрэй захидлын уралдаан

Захидлын уралдаанд Сүхбаатар сумын ЕБС-ийн 1-9 ангийн 45 сурагчийн бүтээл, политехник коллежийн 15 оюутны бүтээлүүд ирж, нийт 60 оролцогч хамрагдаж, бага, дунд насны ангилалд 6 сурагчийг өргөмжлөл, дурсгалын зүйлээр шагнаж урамшуулсан

28. Ном хэвлэл сурталчлах арга хэмжээ

Ном хэвлэлийг сурталчлах арга хэмжээний хүрээнд нийт 16 удаа зохион байгуулж 507 хүн хамрагдав.

1. Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын 9а ангийн 36 сурагчдад Нийтийн номын сангийн Гэрээр ном олгох, нийтийн уншлагын танхим, хүүхдийн уншлагын танхим, үндсэн номын фонд, гадаад хэлний танхимууд болон номын сангийн үйл ажиллагааг танилцуулав. Сурагчид өөрсдийн таалагдсан номоо сонгож танилцан ангийн сурагчдадаа таалагдсан хэсэгээ хуваалцлаа.
2. Сүхбаатар сумын ЕБ-ийн 2-р сургуулийн 8в ангийн 28 сурагчдад “Номын ач тус” сэдвийн хүрээнд номыг хэрхэн үр дүнтэй унших, номын тэмдэглэл хөтлөх аргачлалын талаар зөвлөгөө мэдээлэл өгч, каталоги, уншлагын танхимуудын үйл ажиллагааг танилцуулан номтой холбоотой номын тойм яриа хийв.
3. Сэлэнгэ аймгийн Политехникийн Коллежийн 1 дамжааны 18 оюутан залуус номын сангийн каталоги, үйл ажиллагаа ном хэвлэлтэй танилцав.
4. Сүхбаатар сумын ЕБ-ийн 2-р сургуулийн 8в ангийн 22 сурагчдын дунд тоглоомын аргаар оньсого таалгаж угсардаг монгол гэр бариулан монгол ардын аман зохиол болон гэрийн тухай мэдлэгийг нь нэмэгдүүллээ.
5. Сэлэнгэ аймаг дахь Цагдаагийн газрын хамт олод “Номтой нөхөрлөө” нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж соёлын боловсролын хөтөлбөр болон “Түүхээ судалъя-Танин мэдье” номын үзэсглэн, шинэ уншигчийн карт нээх үйлчилгээ үзүүлэн уншлагын танхимуудын үйл ажиллагааг сурталчлан таниулав.
6. Хилийн цэргийн 0101-р ангийн ангийн 35 ажилтан албан хаагч нарт “Номын тойм” уншлага зохион байгуулж, уншигчийн карт нээх үйлчилгээ, соёлын боловсролын хөтөлбөр номын сангийн электрон каталогтай ажиллах заавар зөвлөгөө өгч ажиллав.
7. Баянхан 4-р багийн 40 гаруй иргэдэд шинэ номын мэдээ, шинэ уншигчийн карт нээх үйлчилгээ, номтой болзоо зохион явуулж, нийтийн номын сангийн үйл ажиллагааг сурталчлан танилцууллаа.
8. Сүхбаатар сумын ЕБ-ийн 5-р сургуулийн 9а ангийн 13 суралцагч нарт номын сангийн төрийн ангийн болон үсэг дарааллын каталоги, лавлагаа номын зүйн булан, үндсэн фонд, 3 уншлагын танхимуудыг танилцуулан номын тойм яриа хийж гүйцэтгэв.
9. Сэлэнгэ аймагт амарч буй хүүхэд залууст Нийтийн номын сангийн үйл ажиллагаа болон “Монгол гэр барих уламжлалт арга ухаан”-ыг Сайхны хөтөл болон Хонгорморьт амралтын баазын 25 амрагч, аялагч нарын дунд зохион явууллаа.

10. Зуны хөтөлбөрт хамрагдсан 35 сурагчдын эцэг эхийн дунд номын сангийн үйл ажиллагаа, ном унших соёл, оновчтой уншлага хэрхэн хийж хэрэгжүүлэх тухай мэдээлэл өгч ажиллав.
11. ЕБ-ийн 6 сургуулийн 8а ангийн 20 сурагчдад номын сантай танилцах өдөрлөг зохион явуулж нас сэтгэхүйн онцлогт тохирсон номын үзэсглэн зохион байгуулж, номын тойм яриа зохион явууллаа.
12. Хилийн цэргийн 0243-р ангийн 45 цэргийн ангийн ажилтан алба хаагчдад “Гэр боловсролын хөтөлбөр”, “Сэлэнгэ сайхан нутгаар аялцгаая” боловсролын хөтөлбөр зохион байгууллаа.
13. Чингисийн чулууны бичиг, Цогтын хадны бичээсийн түүх утга санааг таниулах ажлыг сургуулийн өмнөх боловсролын 1-р цэцэрлэгийн багш, Онцгой байдлын газар, Хилийн цэргийн 0101-р анги, Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Хилийн цэргийн 0243-р ангийн алба хаагчдад хэвлэмэл байдлаар тараан танилцуулсан.
14. Эх түүхээ үнэн зөв таниж мэдэхийн тулд сургуулийн өмнөх боловсролын 1-р цэцэрлэгийн аргазүйч болон багш нарт Монголын нууц товчоо бүтээлийг 3 ширхэгийг 2 сарын хугацаатай 10,11-р сард гарган үйлчиллээ.
15. Хилийн цэргийн 0101-р ангийн номын санчтай хамтран 15 ахлагч 10-р сард мөн Хилийн цэргийн 0243-р ангийн номын санчтай хамтран 30 цэргийн алба хаагчдыг 11-р сард номын сангийн үйл ажилгаатай танилцуулж илүү их уншъя уриаг дэвшүүлэн соён гэгээрүүлэх танин мэдэхүйн ажил зохион байгууллаа.
16. 2025 оноос бүх нийтээр үндэсний бичиг үсгээр албан бичиг баримтыг хөтлөхтэй холбоотой монгол бичгээ зөв сайхан бичиж сурахыг ЗНСантай харилцагч иргэн албан байгууллагуудад уриалан ажиллаж байна.

29. Уншигчийн бага хурал

Дондойн Тогтохбаярын “Сэтгэлийн дуулал” хэмээх номын “Амьдралын урсгал” найраглалаар Сүхбаатар сумын ахлах, дунд ангийн сурагчдын дунд зохион явуулж зохиолчийн намтар уран бүтээлийн товч танилцуулга, ханын сонин, тойм яриа зохион явууллаа. Нийт 50 сурагчид хамрагдав.

30. Соёлын байгууллагатай танилцах аялал

Соёлын байгууллагатай танилцах аялалыг 70 төрийн алба хаагчдийн дунд зохион явуулж байгууллагын үйл ажиллагаа болон боловсролын хөтөлбөрт арга хэмжээнүүд зохион явуулан танин мэдэхүйн асуулт, сэтгэн бодох хөгжөөнт тоглоом зохион явууллаа.

31. Зуны зугаатай уншлага

Жил бүр зохион явуулдаг энэхүү үйл ажиллагаа нь цэвэр цэнгэг агаарт номын сангийн үйл ажиллагааг зохион явуулан чимээтэй уншлага, аудио номын тойм сонсох, чөлөөт ярилцлага зохион байгуулдагаараа онцлогтой. Уншлагад 20 уншигч хамрагдав.

32. Утга зохиолын дугуйлан

МЗЭ-ийн шагналт зохиолч Т. Доржсүрэн, Б. Батхүү нарын удирдлага дор Сэлэнгэ аймгийн ЕБС-ийн сурагчдыг хамруулсан богино өгүүллэгийн утга зохиолын дугуйланг долоо хоногийн хагас сайн өдөр хичээллүүлж байна. Дугуйланд нийт 20 сурагчид хамрагдаж байна.

Дугуйланд хамрагдсанаар найруулан бичих авьяасаа хөгжүүлж, шинэ үеийн богино өгүүллэг зохиогч уран бүтээлчдийг багаас нь бэлтгэн гаргах зорилготой билээ.

33. “Зохист аялгуу-2024” хүүхдийн богино өгүүллэгийн наадам

Арга хэмжээнд Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 1,2,4,5-р сургуулийн сурагчид, Мандал, Цагааннуур, Ерөө, Түшиг сумууд болон Номгон, Бугант, Рашаант тосгоны ЕБС-ийн 6-12 ангийн 52 сурагчид өөрсдийн зохион бичсэн богино өгүүллэгээр оролцсон. Шүүгчид шалгуурын дагуу дүгнэн шалгаруулж:

Тэргүүн байр: Номгон ЕБС-ийн 11а ангийн сурагч М. Биндэръяа

Дэд байр: Ерөө Бугант ЕБС-ийн 8а ангийн сурагч А.Амарзаяа

Гутгаар байр: Ерөө сумын ЕБС-ийн 9б ангийн сурагч Б.Янжинлхам

Тусгай байр: Сүхбаатар сумын 2-р сургуулийн сурагч Д.Ананд

Тусгай байр: Номгон ЕБС-ийн 12а ангийн сурагч О.Баярцэцэг нар тус тус шалгарч, цом, мөнгөн шагнал, өргөмжлөл, дурсгалын зүйлээр шагнаж урамшуулсан. Бэлтгэсэн багш, номын санчдыг дурсгалын зүйлээр урамшуулсан.

34. “Соёлын бүтээлч сар” аян

Аяныг түүхэн суут хүмүүсийн суу билгийг алдаршуулах, тэдний эрхэмлэн дээдэлж ирсэн үнэт зүйлс, ур чадвар, ухааныг хойч үе, хүүхэд, залууст сургах, эх оронч өв тэгш монгол хүнийг төлөвшүүлэх зорилготой тус аяны хүрээнд Сэлэнгэ аймгийн нийтийн номын сан нь Б. Ринчен, Д.Нацагдорж, Д.Пүрэвдорж, Б.Лхагвасүрэн зохиолч, уран бүтээлчийг танхимаар 33, цахимаар 7 буюу нийт 40 арга хэмжээгээр алдаршуулан 3749 хүнд сурталчлан таниуллаа. Үүнийг төрөл тус бүрээр нь үзвэл дараах байдалтай байна.

- Үзэсгэлэн, олон талт арга хэмжээний хүрээнд

1. Билгүүн номч Бямбын Ринчен зохиолчийн амьдрал, уран бүтээлийг сурталчлан таниулах 7 арга хэмжээг танхим, цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулж нийт 546 хүүхэд, залуус, иргэд хамрагдсан. Үүнд: Цахим хаягт зохиолчийн тухай

мэдээлэл бэлтгэн 140 иргэд олон нийтэд түүхэн хүнийг алдаршуулан танилцуулж сурталчилсан. Мөн цахимаар ерөнхий боловсролын сургуулийн сурагчид болон оюутан залуусын дунд “Бямбын Ринчен зохиолчийн амьдрал, уран бүтээлийг харуулах geels бичлэгийн уралдаан зарлагдаад байна. Танхимаар номын сангийн ирэгсдэд 5 удаагийн арга хэмжээг номын үзэсгэлэн, чанга уншлага, номын тойм яриа, асуулт хариултын тэмцээн гэсэн 4 төрлөөр зохиолчийн амьдрал, уран бүтээлийн тухай ярилцаж, нийт 386 ирэгсдэд сурталчлан таниулсан.

2. Дашдоржийн Нацагдорж зохиолчийн амьдрал, уран бүтээлийг сурталчлан таниулах 3 арга хэмжээг танхим, цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулж нийт 769 хүүхэд, залуус, иргэд хамрагдсан. Үүнд: цахим хаягт зохиолчийн тухай мэдээлэл бэлтгэн 385 иргэд олон нийтэд түүхэн хүнийг алдаршуулан танилцуулж сурталчилсан. Танхимаар Нацагдорж зохиолчийн номын үзэсгэлэнг гаргаж нийт 92 хүнд хүрсэн. Мөн сурагчдын дунд зарласан “Д.Нацагдорж тэмдэгтэн” сурагч шалгаруулах номын соёлыг түгээн дэлгэрүүлэх нөлөөллийн аяны болзлыг цахим хаягаар хүргэж, нийт 292 хүнд хүрсэн.

3. Дэндэвийн Пүрэвдорж зохиолчийн амьдрал, уран бүтээлийг сурталчлан таниулах 1 арга хэмжээг танхим, цахим хосолсон хэлбэрээр зохион байгуулж нийт 451 хүүхэд, залуус, иргэд хамрагдсан. Үүнд: цахим хаягт зохиолчийн тухай мэдээлэл бэлтгэн 213 иргэд олон нийтэд түүхэн хүнийг алдаршуулан танилцуулж сурталчилсан. Танхимаар Д.Пүрэвдорж зохиолчийн номын үзэсгэлэнг гаргаж нийт 81 хүнд хүрсэн.

4. “Үзэсгэлэнт Сэлэнгэ миний дуранд” фото зургийн уралдааныг зохион байгуулж байгаа бөгөөд одоогийн байдлаар 20 оролцогчийн бүтээл ирсэн. Ирсэн бүтээлүүдийг үзэсгэлэн гаргаж иргэд олон нийтэд толилуулах болно.

5. Анимэ сонирхогч хүүхэд залуусын дунд 2 удаагийн “Анимэ өдөрлөг”-ийг зохион байгуулж өдөрлөгийн хүрээнд 2 төрлийн уралдаан явуулан дэлхийн нийтийн соёлыг хүндэтгэн үзэж, өөрийн соёлын ялгааг танин мэдэх ач холбогдлыг сурталчлан таниулсан. Нийт 102 хүүхэд, залуус хамрагдлаа.

- Нийтийн уншлагыг дэмжих, идэвхжүүлэх хөтөлбөрийн хүрээнд 2 арга хэмжээг зохион байгуулж нийт 165 сурагч, иргэд олон нийт хамрагдсан. Үүнд:

1. “Номын сантай нэг өдөр-Номтой нөхөрлөө” нөлөөллийн арга хэмжээг Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газрын 50 албан хаагчдын дунд зохион байгуулсан. “Номын санч мэргэжил сурталчлах” өдөрлөгийг Ерөнхий боловсролын 2-р сургуулийн 9 а,б,в,г ангийн сурагчдад 4 удаагийн давтамжтайгаар “Мэргэжил сонголт” сургалт, номын санч мэргэжлийн онцлогийг харуулсан өртөөчилсэн аялал гэсэн 2 төрлөөр зохион байгуулж, нийт 115 сурагчид хамрагдсан.

2. “Бие даалтын цаг” 7 удаагийн арга хэмжээг ЕБС-ийн 1-12 ангийн сурагчдын дунд хэрэгжүүлж нийт 206 сурагчид хамрагдсан. Арга хэмжээнд Шаамар сумын ЕБС-ийн 5б ангийн 26 сурагч, Сүхбаатар сумын ЕБ-ын 1 дүгээр сургуулийн 4а, 4б, 4в, 4г ангийн 122 сурагч, ЕБ-ын 4 дүгээр сургуулийн 6а ангийн 20 сурагч, 11б ангийн 36 сурагчид тус хамрагдсан.

3. Бүх нийтийн боловсролыг дэмжин “Номын сантай танилцах” өдөрлөг арга хэмжээг ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, сургуулийн өмнөх боловсролын суралцагч нарт зохион байгуулж нийт 98 хүүхэд багачуудад ном, соёлыг сурталчлан таниулсан. Цахим 1 мэдээлэл бэлтгэн 164 иргэдэд хүрсэн байна.

4. “Дэлхийн хүүхдийн өдөр”-т зориулан дуу хоолойгоо нэгтгэн хүүхдийн өдөрт зориулсан цахим геел бичлэг, мэндчилгээ нийгмийн сүлжээ дээрээ түгээж, хамт олноороо 1 өдрийг цэнхэр хувцсаар ижилсэх, хүүхэд гэр бүлд ээлтэй бодлогын талаар дотоод яриа, уулзалт зохион байгууллаа.

5. “Нацагдорж зохиолчийн уран бүтээлийн цаг” арга хэмжээг зохион байгуулж нийт 386 ирэгсдэд сурталчлан таниулсан.

- Эх хэл, утга зохиолын чиглэлээр

1. Монголын зохиолчдын эвлэлийн Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөлтэй хамтран Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын яруу найраг сонирхдог, бичих туурвих хүсэл тэмүүлэлтэй, хүүхэд багачуудынхаа авьяас чадварыг нээн илрүүлэх, дэмжих зорилгоор “Утга зохиолын дугуйлан”-г хичээллүүлж нийт 15 сурагчид хамрагдаж байна.

2. Сэлэнгэ аймгийн 17 сум, 6 тосгоны ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд Д.Нацагдорж тэмдэгтэн сурагч шалгаруулах аян зарлаж, болзлын дагуу Сүхбаатар сум, Зүүнбүрэн сум, Бугант тосгон, Сайхан сумдуудын идэвхтэн 17 уншигчдыг шалгаруулж тэмдэг гардууллаа.

-Боловсролын хөтөлбөр

1. “Сэлэнгэ сайхан нутгаар аялцгаая” боловсролын хөтөлбөрийг 2 удаагийн давтамжтайгаар сурагчид, албан хаагчдын дунд зохион байгуулж, 85 хүнийг хамрууллаа. Бүх нийтийн соёлын боловсролыг төлөвшүүлэх чиглэлээр “Гэр боловсролын хөтөлбөрийг 2 удаагийн давтамжтайгаар сурагчид, оюутан залуус, албан хаагчдын дунд зохион байгуулж, 85 хүнийг оролцууллаа.

2. “Санхүүгээ зөв төлөвлөж ирээдүйгээ бүтээе”, “Мэргэжил сонголт” боловсролын сургалт, хөтөлбөрийн 5 арга хэмжээг Сүхбаатар сумын 1,2,3,4,5,6-р сургуулиудын 9 дүгээр ангийн сурагчид, политехник коллежийн 1-р дамжааны оюутнуудын дунд зохион байгуулж, нийт 16 ангийн 405 сурагчид хамрагдсан.

3. “Сэлэнгэ сайхан нутгаар аялцгаая” боловсролын хөтөлбөрийг 2 удаагийн давтамжтайгаар цэргийн албан хаагчдын дунд зохион байгуулж, 59 хүнийг хамрууллаа. Бүх нийтийн соёлын боловсролыг төлөвшүүлэх чиглэлээр “Гэр боловсролын хөтөлбөрийг 2 удаагийн давтамжтайгаар албан хаагчдын дунд зохион байгуулж, 76 хүнийг оролцууллаа. Нийт 135 албан хаагч хамрагдав.

Номын үзэсгэлэн

2024 оны байдлаар 20 удаагийн сэдэвчилсэн болон шинэ номын үзэсгэлэнг дэлгэж нийт 8768 хүүхэд багачууд, иргэдэд хүрсэн байна.

1. Байгалийн шинжлэх ухааны 27 номоор “Байгаль” номын үзэсгэлэн гаргаж, 134 хүн үзэж танилцсан.
2. Хүүхдийн уран зохиолын 24 номоор “Үлгэрийн ертөнц” номын үзэсгэлэн гаргаж 152 хүн үзэж танилцсан.
3. Монгол баатарлаг туулийг сурталчлах ажлын хүрээнд “Монгол тууль” номын үзэсгэлэнг дэлгэж нийт 789 иргэд, хүүхэд багачууд үзэж танилцсан.
4. Багачууд” номын үзэсгэлэнг дэлгэж 330 хүүхэд багачууд, иргэд үзэж танилцсан.
5. Заавал унших номын үзэсгэлэнг дэлгэж 330 хүүхэд багачууд, иргэд үзэж танилцсан.
6. Шинжлэх ухааны номын үзэсгэлэнг дэлгэж 501 хүүхэд багачууд, иргэд үзэж танилцсан.
7. Яруу найргийн номын үзэсгэлэнг дэлгэж 510 хүүхэд багачууд, иргэд үзэж танилцсан.
8. Түүх номын үзэсгэлэнг дэлгэж 542 хүүхэд багачууд, иргэд үзэж танилцсан.
9. Үндэсний бичиг үсгийн баярыг тохиолдуулан монгол бичгээр бичигдсэн Бичиг үсэг өв соёл номын үзэсгэлэнг дэлгэж 684 хүүхэд багачууд, иргэд үзэж танилцсан.
10. Англи номын үзэсгэлэнг дэлгэж 532 хүүхэд багачууд, иргэд үзэж танилцсан.
11. Хүүхдийн уран зохиолын номын үзэсгэлэнг дэлгэж 739 хүүхэд багачууд, иргэд үзэж танилцсан.
12. Сонгодог зохиолууд номын үзэсгэлэнг дэлгэж 345 хүүхэд багачууд, иргэд үзэж танилцсан.
13. Түүхийн жимээр аялахуй номын үзэсгэлэнг дэлгэж 402 хүүхэд багачууд, иргэд үзэж танилцсан.
14. Шинэ номын үзэсгэлэнг дэлгэж 574 хүүхэд багачууд, иргэд үзэж танилцсан.
15. Таньд хэрэгтэй номын үзэсгэлэнг дэлгэж 521 хүүхэд багачууд, иргэд үзэж танилцсан.

16. Амьтдын тухай номуудаар “Амьтдын тухай 39 номын жагсаалт” номын үзэсгэлэн гаргаж 281 хүн үзэж танилцсан.
17. “Өөрийгөө хөгжүүлэх нь” сэдвийн хүрээнд 30 ширхэг номоор үзэсгэлэн гаргаж 195 иргэж үзэж танилцсан байна.
18. “Түүхийн жимээр” сэдвийн хүрээнд 55 ширхэг номоор үзэсгэлэн гаргаж 250 иргэж үзэж танилцсан байна.
19. “Хувь хүний хөгжил” сэдвийн хүрээнд 38 ширхэг номоор үзэсгэлэн гаргаж 195 иргэж үзэж танилцсан байна.
20. “Монгол ардын аман зохиол” сэдвийн хүрээнд 29 ширхэг номоор үзэсгэлэн гаргаж 580 иргэж үзэж танилцсан байна.

Сургалт семинар

- ✓ Онцгой байдлын ерөнхий газраас “Галын аюулгүй байдал” сургалтанд хамрагдаж, галын хорыг хэрхэн ашиглах, түлэгдэлтийн зэрэг тогтоох анхан шатны тусламж хэрхэн үзүүлэх 2 сургалтад хамрагдсан.
- ✓ Хүүхдийн нас ба хөгжлийн онцлог, хүмүүжлийн эерэг аргад суралцах нь, хүүхэд хүмүүжүүлэх монгол арга ухаан, хүүхдийн эрх, хүүхдийн хүчирхийлэл гэсэн 2 өдрийн 5 сургалтад хамрагдсан.
- ✓ Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг цахим сургалт болох “Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр сургалтад хамрагдсан.
- ✓ Төрийн албан хаагчдаас авах монгол бичгийн судалгаа сургалтад сууж, монгол бичгийн судалгаанд хамрагдсан.
- ✓ Байгууллагын дотоод хяналт шалгалтын комиссын жилийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, орчны шинжилгээг хийж, дүгнэлт гаргасан.
- ✓ Бие даан монгол бичгийн сургалтыг байгууллагын нийт албан хаагчдад хуваарийн дагуу хичээл бэлтгэн орж, монгол бичгийн мэдлэг чадвараа хөгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж байна.
- ✓ Соёлын салбарын цахим шилжилтийн хүрээнд “ Соёлын салбарын нэгдсэн мэдээллийн систем ” номын сангийн мэдээллийн санг бүрдүүлэх 2 өдрийн чадавхжуулах сургалтанд суулаа .
- ✓ Үндэсний номын сан, Монголын номын сангуудын консерциумаас зохион байгуулсан “ Mongolia library update-2024 “ арга хэмжээний хүрээнд зохион байгуулагдсан сургалт ,хэлэлцүүлэгт хамрагдан мэргэжил арга зүйн зөвлөгөө авлаа.Мөн төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан цахимаар 4 танхимаар 5 нийт 11 удаагийн сургалтанд хамрагдлаа.

- ✓ Төвийн болон хойд бүсийн аймгуудын “Хамтар, суралц, хөгж” уриан дор Номын санч-мэдээллийн ажилтны сургалт зөвлөгөөний үйл ажиллагаанд оролцож туршлага судаллаа.

6. ЗӨӨВРИЙН НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Зөөврийн номын сан нь 2024 оны эцсийн байдлаар тусгай чиг үүргийн Онцгой байдлын газар, Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Хилийн цэргийн 243-р анги, Хилийн цэргийн 0101-р анги болох 4 байгууллага Баянханы 4-р баг, Алтанбулаг сумын соёлын төвийн номын сан, Ерөнхий боловсролын 5-р сургууль, Политехник Коллеж, сургуулийн өмнөх боловсролын 1-р цэцэрлэгтэй 2024 онд хамтран ажиллах гэрээ байгууллаа.

Гэрээр ном олгох Нийтийн уншлагын танхимаас 82 удаа 2033 ном, фондоос 2 удаа 46, Хүүхдийн уншлагын танхимаас болон Гадаад хэлний уншлагын танхимаас 40 ном 2 удаа авч зөөврийн номын үйлчилгээг тусгай чиг үүргийн байгууллагад 52 удаа, 358 шинэ уншигч 2057 ирэгсэд нийт 2405 уншигч /насанд хүрэгч/ 3493 ном олголт хийн үйлчиллээ.

Ерөнхий боловсролын 5-р сургууль, сургуулийн өмнөх боловсролын 1-р цэцэрлэг, Хөдөө аж ахуйн Политехник Коллежийн багш сурагчдад 15 удаа 45 шинэ уншигч 182 ирэгсэд нийт 227 уншигч /насанд хүрэгч/ 293 ном олголт, 96 шинэ уншигч 167 ирэгсэд нийт 263 уншигч /хүүхэд/ 388 ном олголт хийн үйлчиллээ.

Алтанбулаг сум, Баянханы 4-р багт 7 удаа 28 шинэ уншигч 108 ирэгсэд нийт 136 уншигч /насанд хүрэгч/ 183 ном олголт, 4 шинэ уншигч 4 ирэгсэд нийт 8 /уншигч /хүүхэд/ 8 ном олголт хийн үйлчиллээ.

Тусгай чиг үүргийн 4 байгууллага, сургуулийн өмнөх боловсролын 1-р цэцэрлэг, ерөнхий боловсролын 5-р сургууль, Хөдөө аж ахуйн Политехник Коллеж, Алтанбулаг сумын соёлын төвийн номын сан, Баянханы, 4-р багт нийт 84 удаа 3039 уншигч иргэдэд 4365 ном олголт хийн үйлчиллээ.

№	Үзүүлэлтүүд	Эхний хагас жил	Сүүлийн хагас жил	Нийт
1	ГНОТ-аас авсан ном	981 /42удаа/	1052 /40уд/	2033/82у д/
2	Фондоос авсан ном	46 2уд/	-	46 /2уд/
3	ХУТ-аас авсан ном	-	40 /2уд/	40 /2уд/
№	Алслагдсан сум баг дүүрэг			
1	Шинэ уншигч /насанд хүрэгчид/	15	13	28
2	Ирэгсэд /насанд хүрэнчид/	49	59	108
3	Нийт уншигч	64	72	136
4	Ном олголт	73	110	183

5	Шинэ уншигч /хүүхэд/	4	-	4
6	Ирэгсэд /хүүхэд	4	-	4
7	Нийт уншигч	8	-	8
8	Ном олголт	8	-	8
№	ААН, ЕБС, СӨБ Политехник Коллеж			
1	Шинэ уншигч /насанд хүрэгчид/	31	14	45
2	Ирэгсэд /насанд хүрэгчид/	87	95	182
3	Нийт уншигч	118	109	227
4	Ном олголт	138	155	293
5	Шинэ уншигч /хүүхэд/	36	60	96
6	Ирэгсэд /хүүхэд	51	116	167
7	Нийт уншигч	87	176	263
8	Ном олголт	100	288	388
№	Тусгай чиг үүргийн байгууллага			
1	Шинэ уншигч /насанд хүрэгчид/	253	95	348
2	Ирэгсэд /насанд хүрэгчид/	1034	1023	2057
3	Нийт уншигч	1287	1118	2405
4	Ном олголт	1660	1833	3493
5	Шинэ уншигч /хүүхэд/	-	-	-
6	Ирэгсэд /хүүхэд/	-	-	-
7	Нийт уншигч	-	-	-
8	Ном олголт	-	-	-
№	Нэгтгэсэн тоон үзүүлэлт			
1	Шинэ уншигч /насанд хүрэгчид/	299	122	421
2	Ирэгсэд /насанд хүрэгчид/	1170	1177	2347
3	Нийт уншигч	1469	1299	2768
4	Ном олголт	1871	2098	3969
5	Шинэ уншигч /хүүхэд/	40	60	100
6	Ирэгсэд /хүүхэд	55	116	171
7	Нийт уншигч	95	176	271
8	Ном олголт	108	288	396
9	Нэгтгэсэн уншигчдын тоо	1564	1475	3039
10	Нэгтгэсэн ном олголтын тоо	1979	2386	4365
№	Алслагдсан сум дүүрэг, аж ахуйн нэгжид үйлчилсэн тоо			
1		4	3	7

№ 2	ААН, ЕБС, Политехник Коллеж үйлчилсэн тоо	8	7	15	
№ 3	Тусгай чиг үүргийн байгууллагад үйлчилсэн тоо	32	20	52	
№ 4	Нийт үйлчилсэн сум дүүрэг, албан байгууллагийн тоо	44	40	84	
№ 5	СОНА	Зохион байгуулсан тоо	1	3	4
		Оролцсон хүний тоо	54	116	170

7. МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИ

Цахим номын сан хөмрөгийг баяжуулах уншлага, үйлчилгээг нэмэгдүүлэх зорилгоор цахим номын нөөцийг 20 хувь нэмэгдүүлж гадаад Монгол нийлсэн 480ш цахим ном, 107ш аудио номоор фонд баяжилт хийж ажиллаа.

- “Өвлийн хөтөлбөр”, “Ангиараа уншъя”, “Дэлгэцтэй биш дэлгэсэн номтой нөхөрлөө”, “Тандаа барих миний бэлэг”, “Номын баяр 2024”, “Сурагчдаа сонсоё”, “Монгол гэр үзэсгэлэн” “Боловсролын хөтөлбөр”, “Соёлын бүтээлч сар” зэрэг арга хэмжээнүүдийн 39 төрлийн постер, 18 төрлийн 117 ширхэг талархал, өргөмжлөл бусад төрлийн 260ш тараах материал, 50ш гарын авлага хэвлэн бэлтгэж холбогдох арга хэмжээ тус бүрт ашигласан байна.
- 2024 онд Аргазүйч, Фондчийн хамтаар хараа бүсийн 8 сум, 6 сургуулиудад “3 чухал платформ”, “Үүлэн технологи” “КОХА программын танилцуулга” сэдэвт 3 төрлийн сургалтыг зохион байгуулж нийт 40 номын санч хамрагдав. Мөн Зүүнбүрэн сум, Сайхан сум, Рашаант тосгон, Дулаанхаан, Шаамар, Жавхлан сумдын соёлын төвийн номын сан болон ерөнхий боловсролын сургуулиудын номын сангуудад программын нөөц бэлтгэх, компьютеруудад сервис үйлчилгээ хийх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэв.
- “Номын санч-Онол аргазүйн” сэтгүүлийн 2024 оны дугаарыг нийт 100 ширхэгийг хэвлэн бэлтгэв.
- “Соёлын бүтээлч сар” аяны хүрээнд 7 төрлийн 8 ширхэг постер, 9 удаагийн цахим мэдээлэл, 8 төрлийн 64ш талархал, өргөмжлөл, эрхийн бичиг зэргийг хэвлэн бэлтгэж арга хэмжээ бүрт ашигласан байна.
- Хүүхэд хамгааллын чиглэлээр 2 удаагийн цахим мэдээлэл хүргэсэн ба байгууллагын Гэр бүлийн зөвлөлтэй хамтран ажилчдын дунд “Хүүхдийн цахим хэрэглээ” сэдэвт сургалт явуулж 16 хүнийг хамруулав. Тухайн сургалтын хүрээнд “Google family link”-н ажиллах зарчим болон ашиглах заавар өгөв.

- Номын сангийн уншигчдад шинэлэг үйлчилгээ үзүүлэх зорилгоор “Хөгжимт уншлага” сэдэвт тандалт судалгааг 30 уншигчаас авч холбогдох дүгнэлт төлөвлөгөөг гарган ажиллаж байна.
- Номын сангийн шинэ уншигч болох танилцуулга мэдээллийн эхийг шинэчлэн сайжруулав.
- Иргэд уншигчдад интернэт орчинд ажиллах, цахим ном унших, компьютерын мэдлэг чадвараа дээшлүүлэхэд нь дэмжлэг болох зорилгоор нийтийн уншлагын танхимд 2 ширхэг нээлттэй компьютерыг байршуулж, шаарлагатай программ хангамж, бусад тохиргоонуудыг хийж гүйцэтгэв.
- Мэдээлэл аргазүйн танхимын зурган самбарын зургуудыг шичэчлэв.
- Номын сангийн цахимжуулалтын хүрээнд шаардагдах тоног төхөөрөмжийн төсвийг зах зээлийн суурь судалгаанд үндэслэн гаргав.
- Номын сангийн компьютер тоног төхөөрөмжийн өдөр тутмын бүртгэл протоколын бүртгэлийг 4-р сараас ашиглаж бүртгэж эхлэв.

ЗУРГАН ТАЙЛАН





Ангиараа уншъя аян



Бүс нутгийн загвар номын сан



Гэр үзэсгэлэн-Боловсролын хөтөлбөр



Хүмүүжлийн эерэг арга сургалт



“Гэр бүлээрээ уншъя” уншлага



Өвлийн хөтөлбөр-2024



Уншигч анги хамт олон-Урилгат уншлага



Ном хэвлэлийг сурталчлах арга хэмжээ



Үлгэрээр хүмүүжье-Чанга уншлага





ҮНДЭСНИЙ БИЧИГ СОЁЛ НОМЫН ӨДРҮҮД 2024

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ АЖЛУУД:

- Соёлын боловсролын хөтөлбөр боловсруулах сургалт /Цахимаар/
- Соёлын боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэх
- Арга хэмжээний нээлт /Шагнал гардуулах үйл ажиллагаа/
- Задгай номын сан
- Номын худалдаа
- Ном, сурах бичиг солилцоо
- Номын үзэсгэлэн /Номын сангийн фонд/
- Номын хандив
- "Ном түүх өгүүлэн" үзэсгэлэн
- /МЗЭ-н шагналт зохиолч, яруу найрагч Т.Доржсүрэн-н хувийн архиваас/

2024.09.20 11:00-16:00 цагт Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сангийн байранд



Үндэсний бичиг үсгийн баяр


Соёлын байгууллагатай танилцах аялал



Зохист аялгуу-2024 хүүхдийн богино өгүүллэгийн наадам



Соёлын бүтээлч сар-2024 аян



МАНДАЛ СУМЫН НИЙТИЙН НОМЫН САН
2024 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

**НЭГ: ТӨРИЙН БОДЛОГО, ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАЖ,
НОМЫН САНГ ХӨГЖҮҮЛЭХ БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД:**

1.1 Монгол улсын төрийн бодлого, чиглэлийн хүрээнд номын сангийн үйл ажиллагааны бодлого, төлөвлөлтийг сайжруулах, хэрэгжилтийг хангах: Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”, “Монгол улсыг 2020-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Төрөөс соёлын талаар баримтлах бодлого”, Монгол улсын Засгийн газар болон Аймаг, сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрүүд, Аймаг, сумын 2024 оны хөгжлийн төлөвлөгөө зэрэг төрийн бодлого, чиглэлийн хэрэгжилтийг хангах зорилгоор тухайн бодлого, хөтөлбөрүүдэд номын сан, соёлын талаар тусгасан заалтуудын дагуу хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг байгууллагын 2024 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байна.

“Соёлын салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, цахим шилжилтийг дэмжих чиглэлээр” төв, орон нутгийн болон ажлын байрны сургалт, мэдээлэлд 31 удаа давхардсан тоогоор 94 албан хаагчийг оролцуулж, 2 номын санчийг мэргэжлийн анхан шатны сургалтад хамруулж, сертификат эзэмшүүлж, 1 номын санчийг мэргэжлийн бакалаврын сургалтад суралцуулж, албан хаагчдын “Амрах өрөө”-нд нийт 439,000 төгрөгөөр мини хөргөгч, ус буцалгагч зэргийг авч, ашиглаж, 2023 оны үр дүнгийн нэмэлт санхүүжилтээс хамт олны нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд 1676,300 төгрөгийг зарцуулсан.

Үр дүнтэй цахим шилжилтийг хэрэгжүүлэх зорилго бүхий “CREATIVEHUB” цахим системийн сургалтад хамрагдаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө авсан.

Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын хэрэгжилтийн хүрээнд иргэдийг цус ойртолтоос сэргийлэх зорилгоор “Угийн бичгээ хөтөлж—Ураг удмаа мэдэцгээ” сэдэвт сургалт, мэдээлэлд нийт 136 хүнийг хамруулж, хүүхэд залуус, иргэдэд үндэсний өв соёл, бичиг үсгээ сурталчлах, түгээн дэлгэрүүлэх арга хэмжээнүүдийг зохион байгуулж, анхдугаар Үндсэн хууль батлагдсаны 100 жилийн ойн хүрээнд Мандал сумын Сум дундын Шүүхийн хамт олон 34 ш хууль, эрх зүйн номыг Нийтийн номын санд хандивлаж, номын сангаас цахим хуудсаараа Үндсэн хуулийн талаарх мэдээллийг иргэдэд хүргэсэн.

“Орон нутаг дахь хүний эрхийн төлөв байдлын журам”-ын хэрэгжилтийг хангаж, байгууллагаас боловсруулж буй боловсон хүчинтэй холбоотой тушаал шийдвэрт хүний эрхийг дээдлэх, аливаа хэлбэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байх талаар тогтмол тусгадаг бөгөөд байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын 6.1.2 дахь заалт болон хөдөлмөрийн гэрээний зохих хэсгүүдэд хүний эрхийг дээдлэх талаар тодорхой заалтуудыг тусгаж өгсөн байдаг. Албан хаагчдын ажиллах нөхцөлийг аливаа хэлбэрийн дарамт шахалт, ялгаварлан гадуурхалтаас ангид байхаар зохион байгуулж, хамт олны эв нэгдлийг бэхжүүлэн, удирдлагын манлайллыг хангаж, хамт олонтойгоо эвсэг, харилцаа хандлагаараа үлгэр жишээ 1 албан хаагчийг жил бүр нийт албан хаагчдын саналаар тодруулан “Инээмсэглэл-талархал”-ын шагналыг олгож, үлгэр дуурайлал болгох зэрэг ажлуудыг зохион байгуулж ирсний үр дүнд манай байгууллагын албан хаагчдаас аливаа нэгэн хэлбэрээр бусад ажилтны болон хэн нэгний эрхийг зөрчсөн гомдол санал гараагүй.

Соёлын үнэт өв болох ном хэвлэлийн хадгалалт, хамгаалалтын аюулгүй байдлыг хангах, төрийн өмчийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор мэргэжлийн байгууллагуудаас зөвлөгөө авч өөрсдийн нөөц боломжид

тулгуурлан шаардлагад нийцсэн “Галын дохиолол”, “Ус алдалт мэдрэгч”, “Агааржуулагч” төхөөрөмж болон баталгаат “Чийг, дулаан, тоосжилт хэмжигч” багажийг тус бүр авч суурилууллаа.

Соёлын сайдын 2023 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А/390 тоот тушаалын хавсралт “Соёлын байгууллагуудын үр дүнд суурилсан санхүүжилтийн аргачлал”-ын дагуу 2023 оны ажлын үзүүлэлтээр Соёлын яамнаас дүгнэгдсэн өөрийн байгууллагын үнэлгээндээ дүгнэлт хийж, дараах зорилтуудыг тавьж ажилласан. Үүнд:

Зорилт 1. Номын сангийн үйлчлүүлэгчдийн тоог нэмэгдүүлж, үйлчилгээний хүртээмжийг сумын суурин хүн амын 150 хувьд хүргэх

Зорилт 2. Байгууллагын өөрийн орлогыг нэмэгдүүлэх

Зорилт 3. Ур чадварын байдлыг дээшлүүлж, номын санч нарыг мэргэшүүлэх сургалтад хамруулах

Зохион байгуулсан ажил:

1 дүгээр зорилтын хүрээнд өмнөх оны мөн үеийнхээс номын сангийн шинэ уншигчийг 120,2 хувь, ирэгсдийг 163 хувь, ном олголтыг 189 хувиар нэмэгдүүлж, зохион байгуулсан соёл, олон нийтийн ажил, цахим үйлчилгээний тоон мэдээг нарийвчлан гаргасан.

2 дугаар зорилтын хүрээнд 2024 оны 09 дүгээр сараас эхлэн номын сандаа “Мини-Буфет” ажиллуулж, уншигчдадаа хүнсний шинэ бүтээгдэхүүн, цай, ундаагаар үйлчилж, “Бичиг хэрэг, компьютер, канон”-ы үйлчилгээг ажиллуулж, бичгийн хэрэгсэл борлуулж, дээрх үйлчилгээнүүд болон уншигчийн картын үнээс олсон өөрийн орлого болох 520,000 төгрөгийн орлогыг төрийн сангийн дансанд тушаасан.

3 дугаар зорилтын хүрээнд номын санч нараа мэргэшүүлэх сургалтад хамруулж, мэргэжлийн номын санчийн тоог 75 хувьд хүргэсэн.

2023 оны аудитын шалгалтад “Эрсдэлгүй” үнэлгээ, Сумаас дүгнэсэн 2023 оны гүйцэтгэлийн тайлангийн үнэлгээгээр 90% А, аймгийн Соёл, урлаг, аялал жуучлалын газраас дүгнэсэн 2024 оны 3-р улирлын ажлын үр дүнгээр 98,4% хувиар үнэлэгдэж, аймгийн Төрийн өмчийн хорооны шалгалтад 90%, аймгийн ЗДТГ-ын хууль зүйн хэлтсээс зохион байгуулсан хяналт шалгалтад хамрагдаж, манай байгууллагын албан хэрэг хөтлөлт, тушаал шийдвэрийн боловсруулалт сайн үнэлэгдсэн амжилттай ажиллаж байна.

1.2 Соёл, урлагийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн “Бүх нийтийн соёлын боловсрол” арга хэмжээ, “Цахим соёл”, “Цахим үндэстэн”, “Цахим засаглал” үндэсний хөтөлбөрүүд болон аймаг, сумын дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах:

Үзүүлэлт		2020	2021	2022	2023	2024	НИЙТ	
1	Цахим үйлчилгээ	Оруулсан мэдээлэл	316	1766	392	230	191	2895
		Хандалт	91915	99932	6409	12666	21348	232270

“Цахим соёл”, арга хэмжээний хүрээнд GLAM системийн мэдээлэлд хамрагдаж, мэргэжил аргагүйн зөвлөгөө авч, байгууллагын Сэлэнгэ Мандал Номын сан Facebook хуудсанд 191 удаа цахим мэдээлэл оруулж, давхардсан тоогоор 21348 хүнд хүргэсэн хандалттай ажиллаж байна.

“Бүх нийтийн соёлын боловсрол” арга хэмжээний хүрээнд “Соёлын боловсролын хөтөлбөр” баталгаажуулан хэрэгжүүлж, “Хүүхдийн эрхийг дээдэлъе” уриан дор номын сангийн үйл ажиллагаанд хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх тухай, соёл, олон нийтийн ажилд оролцож буй хүүхдүүдийн эцэг, эх асран хамгаалагчдаар зөвшөөрлийн хуудас бөглүүлэх тухай, номын сангийн үйл ажиллагаанд хүүхэд хамгааллын журам хэрэгжүүлэх тухай, “Дэлхийн хүүхдийн өдөр”-ийг тэмдэглэн тухай арга хэмжээнүүдийг байгууллагын Захирлын тушаалаар баталгаажуулан хэрэгжүүлж байна. “Үндэсний бичиг соёл-Номын өдөр”-ийн хүрээнд

“Монгол бахархал-100 жилд” арга хэмжээ, ахмадуудын “Өдрийн үйлчилгээ”-ний хүрээнд “Алтан намар” сэдэвт шинэ номын үзэсгэлэн, танилцуулга, “Эх хэлний өдөр”-ийн хүрээнд “Хос бичигтэн” аяныг тус бүр зохион байгуулж, нийт 1562 хүнийг хамруулж, иргэдийг номтой нөхөрлөхөд уриалсан цахим подкастуудыг хийж, цахим хуудсаар цувралаар хүргэсэн.

1.3 Соёлын яамнаас хэрэгжүүлж буй “Соёлын сэргэлт” аян, “Соёлын бүтээлч сар”-ын ажилд оролцож, “Хөшиг нээгдэх бүрд-Хүргэх нэг үг уриалгыг” хэрэгжүүлэх:

“Соёлын бүтээлч сар” арга хэмжээний хүрээнд нийт 5 арга хэмжээг зохион байгуулж, 621 хүнийг хамруулж, “Соёлын сэргэлт-2024” аяны хүрээнд, “Монгол гэр” үзэсгэлэнд зориулан тус Нийтийн номын сангаас 50,000 төгрөгийн хандив өгсөн.

Сэлэнгэ аймгийн Соёл, урлагийн газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 53 дугаар албан бичгийн биелэлтийг хангаж, “Хөшиг нээгдэх бүрд-Хүргэх нэг үг” уриалгыг хэрэгжүүлэн, хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн үүргийг сануулсан уриалга үг, постерыг тусгайлан бэлтгэж, ном уншлага, соёл, олон нийтийн ажил эхлэх бүрийн эхэнд уншигч, иргэдэд танилцуулж хэвшин, хэрэгжилтийг хангаж байна.

1.4 Аймгийн “Аялал жуулчлал, ногоон хөгжлийг дэмжих жил” зарласан жилийн хэрэгжилтийг хангах: Аймгийн “Иргэдийн оролцоотой цахим хөгжлийн жил” зарласан жилийн хэрэгжилтийг хангах зорилгоор 5 заалт бүхий төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж байна.

Аймгийн “Иргэдийн оролцоотой цахим хөгжлийн жил” зарласан жилийн хэрэгжилтийг хангах зорилгоор 5 заалт бүхий төлөвлөгөөг боловсруулан

хэрэгжүүлж сумын түүхт 100 жилийн ойг тохиолдуулан гаргасан “Түүх бүтээсэн нэгэн зуун” 200 нүүр сэтгүүлийг эрхлэн гаргаж, хэвлүүлж, нийгмийн хариуцлагын хүрээнд сумын нутаг дэвсгэрт буй түүх, соёлын дурсгалт газруудын нэгдсэн жагсаалтыг гаргаж, хөшөө дурсгалууд өмнө нь огт бүртгэгдэж, тоологдоогүй байсан тул 23 байрлалд орших 27 хөшөө дурсгалыг тоолж бүртгэн танилцуулга бэлтгэж, цахимаар иргэдэд мэдээлэл хүргэж, түүх, соёлын дурсгалын жагсаалтыг сумын ИТХ, ЗДТГ-т хүлээлгэн өгч, сумаас цаашид хэрэгжүүлэх ажлын жагсаалтад оруулж, сумын 100 жилийн түүхт ойн хүрээнд хөшөө дурсгалын тухай мэдээллийг “Сэлэнгэ Мандал номын сан” цахим хаяганд цувралаар нийтэлж, сумын 100 жилийн ойн хүрээнд байгууллагын орчны өнгө үзэмжийг сайжруулж, гэрлэн хаяг чимэглэлийг шинээр хийж 100 жилийн ойгоо угтаж, “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд байгууллагын хашаанд 2 нэр төрлийн 10ш модыг нэмж суулгаж, Хараа голын эрэгт нийт 100 ш бургас модыг 250,000 төгрөгөөр худалдан авч тарьсан.



Хөшөө дурсгалууд өмнө нь огт бүртгэгдэж, тоологдоогүй байсан тул 23 байрлалд орших 27 хөшөө дурсгалыг тоолж бүртгэн танилцуулга бэлтгэж, цахимаар иргэдэд мэдээлэл хүргэж, түүх, соёлын дурсгалын жагсаалтыг сумын ИТХ, ЗДТГ-т хүлээлгэн өгч, сумаас цаашид хэрэгжүүлэх ажлын жагсаалтад оруулж, сумын 100 жилийн түүхт ойн хүрээнд хөшөө дурсгалын тухай мэдээллийг “Сэлэнгэ Мандал номын сан” цахим хаяганд цувралаар нийтэлж, сумын 100 жилийн ойн хүрээнд байгууллагын орчны өнгө үзэмжийг сайжруулж, гэрлэн хаяг чимэглэлийг шинээр хийж 100 жилийн ойгоо угтаж, “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд байгууллагын хашаанд 2 нэр төрлийн 10ш модыг нэмж суулгаж, Хараа голын эрэгт нийт 100 ш бургас модыг 250,000 төгрөгөөр худалдан авч тарьсан.

1.5. Номын сангийн олон нийтийн хамтын ажиллагааг бэхжүүлж, иргэд, байгууллагуудтай хамтран ажиллах:

Соёлын үйл ажиллагааг дэмждэг иргэд, байгууллагуудтай хамтран ажиллаж, “Хараагийн уянга” нэгдлийн гишүүн, яруу найрагч С.Мөнхцэцэгтэй хамтран номын сангаас зохион байгуулж буй СОНА-ын шалгаруулалтыг хийж, сумын түүхт 100 жилийн ойг тохиолдуулан хамтын ажиллагаатай байгууллагын 2 ажилтныг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны тэргүүний ажилтан цолоор тодорхойлон шагнуулж, Мандал сумын “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо”-той хамтран 30 гаруй гишүүдийн дунд “Шинэ номын танилцуулга”, танин мэдэхүйн “Аха” тэмцээн зохион байгуулж, идэвхтэй оролцогчдыг шагнаж урамшуулан, тус холбоонд 10ш

шинэ ном хандивлаж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөгч, идэвхтэн С.Батсайханы үйл ажиллагааг дэмжиж “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх зүйн орчин, дэмжлэг” 2 цагийн сургалт, мэдээллийг ажлын байрандаа авч, 8 албан хаагчаа хамруулсан.

**ХОЁР: МЭРГЭЖЛИЙН БОЛОВСОН ХҮЧНИЙГ БЭЛТГЭХ,
ЧАДАВХЖУУЛАХ, ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫН
ХҮРЭЭНД:**

2.1 “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”, “Хүний хөгжлийн бодлого”-ын хүрээнд хүний

Үзүүлэлт		2020	2021	2022	2023	2024
Сургалт, мэдээлэл	Хэдэн удаа	14	34	19	28	31
	Хамрагдсан хүний тоо	69	150	65	87	94

нөөцийн бодлого, төлөвлөлтийг тодорхойлж, албан хаагчдыг сургалтад хамруулж, “100 жилээ 100 мэдлэгээр угтацгаая” аяныг байгууллагын хэмжээнд өрнүүлэх: “Байгууллагын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр 2022-2024” богино хугацааны хөтөлбөрийг боловсруулан хэрэгжилтийг хангаж, төв, орон нутгийн болон ажлын байрны сургалтад 31 удаа 94 хүнийг хамруулж, мэдлэг, ур чадварыг нэмэгдүүллээ.

2024 оны сургалт, мэдээллийн тоон мэдээ:

№	Сургалтын нэр	Хэзээ	Хүний тоо	Хаанаас зохион байгуулсан
1	Статистик тайлан хэрхэн гаргах вэ?	2024.01.24	2	Соёлын яам
2	Сумын удирдах ажилтны зөвлөгөөн	2024.02.02	1	Сумын ЗДТГ
3	7:4:10 Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн төслийн танилцуулга, хэлэлцүүлэг	2024.03.07	3	Төрийн албаны зөвлөл
4	Оюуны өмч, зохиогчийн эрх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх	2024.03.07	2	Соёлын яам
5	“Төрийн албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн төслийн хэлэлцүүлэг	2024.03.12	2	Сумын ЗДТГазар
6	Соёл, урлагийн байгууллагуудад дотоод хяналт шалгалтыг төлөвшүүлэх	2024.03.14	3	Соёлын яам
7	Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем ERP-ийн тухай	2024.03.19	2	И.Монгол академи
8	Байгууллагын хувь хүний санхүүгийн төлөвлөлт, удирдлага	2024.03.21	4	Төрийн албаны зөвлөл
9	Соёл урлагийн байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөн	2024.03.25	1	Аймгийн Соёл Урлагийн газар
10	7:4:10 "Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаа"	2024.03.28	3	Төрийн албаны зөвлөл
11	“Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл ахуйн сарын аян-2024” сургалт	2024.04.02	8	Зүүнхараа вагон депо

12	Хүний эрх хамгаалагчийг хамгаалах механизмын үйл ажиллагаа	2024.05.02	3	Төрийн албаны зөвлөл
13	Соёлын сэргэлт-2024 аяны хүрээнд соёлын салбарын удирдах ажилтны зөвлөгөөн	2024.05.06-07	1	Соёлын яам
14	“Төрийн албаны зөвлөлийн 2023 оны тайлангийн танилцуулга, Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилт”-ийн талаарх сургалт	2024.05.10	2	Төрийн албаны зөвлөлийн Сэлэнгэ аймгийн салбар зөвлөл
15	Номын санчдын анхдугаар чуулган	2024.05.17	2	Аймгийн Нийтийн номын сан
16	Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгаа	2024.05.17	3	Төрийн албаны зөвлөл
17	“Архив албан хэрэг хөтлөлт”-ийн сургалт	2024.05.20	1	Мандал сум ЗДТГ
18	“Албан хаагчдад системийн модулийг танилцуулах, сан бүрдүүлэх” сургалт	2024.05.22	3	Соёлын яам
19	Төрийн албан хаагчийн ёс зүй	2024.09.02	6	Номын санч С.Цэндсүрэн
20	Төрийн албаны шинэчлэл 30 жилд	2024.09.02	6	Монгол Улсын засгийн газар
21	"Монгол Улс дахь Австралийн тэтгэлэгт хөтөлбөрийн талаарх мэдээлэл, зөвлөмж"	2024.09.19	3	Төрийн албаны зөвлөл
22	“Номын баярын тухай” мэдээлэл	2024.09.19	3	Аймгийн Нийтийн номын сан
23	“Хос бичигтэн болж зөв найруулж сурцгаая” сургалт	2024.09.28	6	Политехник коллеж багш Х.Бямбасүрэн
24	"КОЙКА-гийн тэтгэлэгт хөтөлбөрийн талаарх мэдээлэл, зөвлөмж"	2024.09.26	4	Төрийн албаны зөвлөл
25	Google Forms-р судалгаа авах тухай	2024.09.27	3	Номын санч Б.Байгалмаа
26	“7:4:10” Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн хэрэгжилт	2024-10-10	3	Төрийн албаны зөвлөл
27	“Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн хэрэгжилт”	2024-10-17	5	НДЕГ-ын захиргаа удирдлагын газрын дарга С.Ундармаа
28	“Төрийн албан хаагчийн сэтгэл ханамж, түүнд нөлөөлж буй хүчин зүйл” судалгааны зорилго, явцын танилцуулга	2024-10-31		О.Баасантогтох ШУА-ийн ажилтан
29	“Төрийн албан хаагчийн ёс зүй ба эрүүл мэнд”	2024-11-07	3	Ёс зүйн хоон дарга М.Цэрэнбат
30	“Статистик мэдээ нэгтгэх”	2024-11-08	5	СУАЖЗГазар

31	"Mongolian library update-2024" номын санч- мэдээллийн ажилтнуудын улсын XI зөвлөгөөн	2024-11-22	1	Соёл, Спорт, Аялал жуулчлалын яам, Монголын номын сангуудын консорциум, Дотоод хэргийн их сургууль
	31 удаа		94 хүн	

ГУРАВ: НОМЫН ФОНДЫГ БАЯЖУУЛЖ, НОМ ХЭВЛЭЛИЙН ХАДГАЛАЛТ ХАМГААЛАЛТ, КАТАЛОГЖУУЛАЛТЫН АЖЛЫГ САЙЖРУУЛАХ СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД:

3.1 Номын фондын баяжилтыг нэмэгдүүлэх, “100 жилд-100 бэлэг” номын хандивын аян өрнүүлэх: Тус онд 3,763,500 төгрөгийн үнэ бүхий 157 ш номыг худалдан авч, 2,960,915 төгрөгийн үнэ бүхий, 3288 ш номыг хандиваар нийт 6,724,415 төгрөгийн 3445 ш ном шинээр ирлээ. Хандиваар ирсэн номоос ашиглалтын шаардлага хангах номыг ялган авч дансанд бүртгэснээр фондын нийт номын тоо өмнөх оныхоос 22,9 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Сумын түүхт 100 жилийн ойн хүрээнд зохион байгуулсан “100 жилд-100 бэлэг” номын хандивын аянд орон нутгийн 6 байгууллага, 6 иргэн нэгдсэн.

№	Төрөл	Ямар журмаар авсан	Хаанаас	Нэр төрөл	Тоо ширхэг	Үнэ
1	Ном	Худалдан авсан	“Интерном” ХХК	37	40	910,000
2	Ном	Худалдан авсан	“Аз хур” ХХК	103	103	2,245,600
3	Ном	Худалдан авсан	Соёлын яам	1	5	400,000
4	Ном	Худалдан авсан	Л.Мөнхбаатар	4	5	107,900
5	Ном	Худалдан авсан	Ж.Баасандаш	2	4	100,000
		Нийт		147	157	3,763,500
1	Ном	Хандив	Д.Дөлгөөнжаргал	3	3	15,000
2	Ном	Хандив	С.Сэлэнгэ	32	32	405,915
3	Ном	Хандив	З.Баясгалан	10	10	10,000
4	Ном	Хандив	Б.Отгонтуул	1	3	30,000
5	Ном	Хандив	Ц.Золзаяа	2	6	51,000
6	ном	Хандив	О.Мөнхсүлд	4	4	10,000
7	Ном	Хандив	Сум дундын Цагдаагийн хэлтэс	60	60	120,000
8	Ном	Хандив	Хүүхдийн ордон	2753	3131	2,195,000
10	Ном	Хандив	Мандал сумын ИТХ	1	3	6,000

11	Ном	Хандив	Сэлэнгэ аймгийн Нийтийн номын сан	4	5	5,000
12	Ном	Хандив	Мандал сумын ЗДТГ	1	1	8,000
13	Ном	Хандив	Сум дундын Шүүхийн тамгын газар	30	30	105,000
			Нийт	2901	3288	2,960,915
			НИЙТ	3048	3445	6,724,415

Фондын нийт номын дүн сүүлийн 5 жилээр:

Он	2020	2021	2022	2023	2024	Үзүүлэлт
Номын тоо	28270	28524	29137	29315	30159	2.9%

3.2.Ном хэвлэлийн хадгалалт хамгаалалтыг сайжруулж, ариутгал, цэвэрлэгээ, сэлбэн засалт хийх: Эрүүл ахуйн шаардлагыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор ном хэвлэлийг уншлагад гаргах, авахдаа ариутгалын уусмалаар тухай бүр тогтмол ариутгаж, фондод 15 удаа ариутгал, халдваргүйтгэл хийсэн нь тайлант оны төлөвлөгөө 100 хувиар, ашиглалтын явцад элэгдэж, гэмтсэн нийт 679 ш номд сэлбэн засалт хийсэн нь тухайн оны төлөвлөгөө 100 хувиар биелэгдэж буй дүнтэй байна. Шинээр бүрдүүлсэн 3445 ш номд техник ажиллагаа хийлээ.

Ном сэлбэн засалт, техник ажиллагааны тоон мэдээ:

	Номын сэлбэн засалт	Техник ажиллагаа
Нийт	679	3445

3.3.Ном, хэвлэлийн анхан шатны данс бүртгэлүүд, номын тооллого тооцоо, цаасан каталогийн зохион байгуулалтыг сайжруулах:

Тухайн онд номын тооллогын ажил хийгдээгүй.

Үндсэн фондод орсон, гарсан хүмүүсийн бүртгэлийг тухай бүр хөтөлж ном алдагдахаас сэргийлж байна.

Шинээр авсан 3445 ш номыг Monbiblio программын цахим бүртгэлд бүрэн бүртгэлээ.

ДӨРӨВ: ИРГЭДЭД НҮҮДЛИЙН НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ХҮРГЭХ СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД:

4.1.Нүүдлийн номын сангийн үйлчилгээний уншигч, ном олголтыг нэмэгдүүлж, “Байгалийн номын сан” ажиллуулах:

Нүүдлийн номын сангийн үйлчилгээний хүрээнд сумаас алслагдсан 21-р тоочиг, Өлөнтийн-Ам, “Хоёр салаа”-д намаржиж буй малчин айл өрхүүдэд “Байгалийн номын сан”-аар үйлчилж, ЕБ-ын 1,2,4,5 дугаар сургууль, 1 дүгээр цэцэрлэг, тусгай хэрэгцээт иргэд болох 1 дүгээр багийн иргэн Б.Мөнхбатад 31 ш, 7-р багийн иргэн Б.Андрейбаяр, 9 дүгээр багийн иргэн Магсаржав гуайд 12 ш номыг зөөврийн үйлчилгээгээр хүргэж, нийт 11 чиглэлд 385 хүнд 516 ш ном олгож үйлчиллээ.



**ТАВ: ИРГЭДИЙГ НОМТОЙ НӨХӨРЛҮҮЛЭХ СОЁЛ, ОЛОН НИЙТИЙН АЖИЛ,
НОМЫН СУРТАЛЧИЛГАА, ЛАВЛАГАА НОМ ЗҮЙН АЖЛУУДЫГ ЗОХИОН
БАЙГУУЛАХ СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД:**

5.1.Соёл олон нийтийн ажлыг зохион байгуулах: Иргэдэд номын сангийн үйлчилгээг сурталчлах, номтой нөхөрлүүлэх, мэдлэгийг нь нэмэгдүүлэх зорилгоор ном уншлагын аян, уралдаан, цахим контент, номын сурталчилгаа зэрэг соёл олон нийтийн ажлуудыг 168 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 10374 хүн, 128 байгууллага, анги хамт олныг хамруулаад байгаа нь төлөвлөгөөний биелэлт 100 хувь хэрэгжсэн дүнтэй байна.

СОНА-ын сүүлийн 5 жилийн харьцуулалт:

№	СОЁЛ, ОЛОН НИЙТИЙН АЖЛЫН ТООН МЭДЭЭ							
	Ном уншлагын аян, уралдаан, бусад		Тойм яриа чанга уншлага		Номын үзэсгэлэн		Тухайн онд нийт	
Он	Хэдэн удаа	Хүний тоо	Хэдэн удаа	Хүний тоо	Хэдэн удаа	Хүний тоо	Хэдэн удаа	Хүний тоо
2020	15	1640	30	579	17	949	62	3168
2021	17	578	19	415	15	378	51	1371
2022	18	1736	37	782	21	752	76	3270
2023	12	2813	10	804	7	184	29	3801
2024	56	6402	77	1871	35	2101	168	10374
Нийт	118	13169	173	4451	95	4364		
Нийт 386 удаагийн СОНА, ном сурталчлах арга хэмжээнд 21984 хүнийг хамруулжээ.								

д/ д	Зохион байгуулсан СОНА		Хугацаа	Оролцог чийн тоо	Байгуулл агын тоо	Төсөв
1	“Үндэсний Номын баяр”-ын хүрээнд “100 жил-100 уншигч” баярын арга хэмжээ	“Гэрийн номын сан” шалгаруулах	2024.05.07 -2024.05- 22		7	1,896,5
2		“Миний мөрөөдлийн Мандал сум” постерын уралдаан		13		
3		“Хормогчин театр” бүтээх уралдаан		21	4	
4	“Үндэсний бичиг соёл-номын өдөр”-ийн хүрээнд “Монгол бахархал-100 жилд” сэдэвт үзэсгэлэн, өдөрлөг	“Оны шилдэг уншигч” болон “Тэргүүний уншигч-“Д.Нацагдорж тэмдэгтэн” шагнал гардуулах		1460	11	3,380,0
5		“Тэргүүний уншигч анги хамт олон”-д шагнал гардуулах				
6	“Угийн бичгээ хөтөлж-ураг удмаа мэдэцгээ” сэдэвт сургалт, угийн бичгийн уралдаан			120	2	72,800
7	“Эх хэлний өдөр”-ийн хүрээнд “Хос бичигтэн болж-Зөв найруулж бичиж сурцгаая” сэдэвт сарын аян	“Эх хэл-Бидний дархлаа” тэргүүний уншигч шалгаруулах	2024.09.24	14	13	715,480
8		“Бичгийн соёл-Бидний гоёл” цээж бичгийн аварга шалгаруулах	2024.09.24	15	13	
9		“Үндэсний бичиг соёлоо дээдлэн дэлгэрүүлэгч хамт олон” шалгаруулах	2024.09.24		1	
10	“Хараагийн аялгуу-10” хүүхдийн яруу найргийн наадам		2024.03.20	51		150,000
11	“100 жил-100 ном” сэдэвт номын тэмдэглэл хөтлөх 1 сарын аян		2024.03.01 - 2024.04.01	147		741,000
12	“Англи хэлээр уншицгаая” ном уншлагын сарын аян		2024.02.25 - 2024.03.25	240	5	310,000
13	“Миний ширээний ном-Минжийн хангай роман” подкаст		2024.03.01	1	-	-
14	“Мандал сум-100 жилд” сэдэвт асуулт, хариултын цахим уралдаан			36		50,0
15	“Ном бид хоёр-100 жилд хамтдаа” сэдэвт гэрэл зургийн цахим үзэсгэлэн			27		
16	“Заавал унших бүтээлүүдээс хэр сайн мэдэх вэ” сэдэвт цахим контентийн уралдаан			20		1000,00 0

17	“No-Дэлгэц, Yes-Ном” цахим постерын уралдаан		12		
18	“Урилгат уншлага” аян	2024.02.25 - 2024.03.25	246	7	-
19	“Гэрэлт номын-Өргөө” урилгат уншлага аяныг анги, хамт олны дунд зохион байгуулах	2024.09.28	124	4	
20	“Ном уншихын ач холбогдол” сургалт лекц зохион байгуулах	жилийн турш	851	8	
21	Мандал сумын түүхт 100 жилийн зориулан гаргасан “Түүх бүтээсэн нэгэн зуун” зурагт сэтгүүлийн цахим сурталчилгаа	2024.03.10 - 2024.07.10	21		
22	“Эх зохиолоор аялахуй” уралдаан	2024.11.25	247	5	
23	Явуулын номын сангийн үйлчилгээ	2024.08.30	20		
24	“Номтой аялал” номын үзэсгэлэн	2024.03.05 - 2024.05.01	401	2	
25	"Сэлэнгэ аймгийн Мандал сумын газар усны нэршил" номын цахим танилцуулга	2024.07.24	38		
26	"Сэтгэлийн чанадад" нэртэй 3 дахь шүлгийн номын цахим танилцуулга	2024.07.14	66		
27	“Хүүхдийн баяр- 2024”	2024.06.01	354		
28	"Номын сан"-д 21 ширхэг судрын баринтаг хандивлах арга хэмжээ	2024.05.02	21	1	
29	Подкастын зочноор 50 гаруй жил номын сангаар үйлчлүүлсэн тэргүүний уншигч, өндөр настан Д.Батдэлгэр	2024.05.01	1		
30	Сэлэнгэ аймгийн Мандал сумын 2 дугаар багийн иргэн, ахмад багш, чөлөөт уран бүтээлч Д.Нина	2024.04.26	1		
31	Сэлэнгэ аймгийн Мандал сумын түүхт 100 жилийн ой залуу зураач Б.Энхчулуун	2024.04.25	1		
32	“Өнөөдөр дөрөвдүгээр сарын 23-ны өдөр- Дэлхийн номын өдөр”	2024.04.23	74		
33	“Олон Улсын Хүүхдийн Номын өдөр”	2024.04.02	51	5	
34	ЕБ-ын 2 дугаар сургуулийн номын сангаас зохион байгуулж буй "Номтой нөхөрлөө" сарын аян	2024.03.20	30	1	
35	1-р сургуулийн сурагчид номын сантай танилцав	2024.03.18	71	1	

36	Сэлэнгэ аймгийн Мандал сумын түүхт 100 жилийн ойн хүрээнд “Түүх бүтээсэн нэгэн зуун” сэдэвт сумын алдартнуудын мэдээллийг цуврал		2024.01.20 - 2024.05.30	23		
37	"Монгол зан заншил, соёлын өв" цахим цуврал танилцуулга "Ерөөл"-ийн тухай		2024.02.21	86		
38	“Монгол зан заншил, соёлын өв” цахим танилцуулга		2024.01.15	78		
39	“Түүх бүтээсэн нэгэн зуун” түүхт 100 жилийн ойд зориулан гаргасан зурагт сэтгүүлийн цахим танилцуулга		2024.09.01	103		
40	“Ном уншлагын цаг”		2024.10.20 - 2024.11.15	290	15	
41	"100 жилд-100 ном " хандивын аян		2024.09.30	6	6	
42	“Алтан намар” номын үзэсгэлэн		2024.09.11	124	2	
43	"Энгийн дадал" номын тухай подкаст		2024.09.23	2		
44	"Босоо бичигтэн" цахим подкаст		2024.10.03	1		
45	"Номтой нөхөрлөө"	Номын хандивын аян		60	1	
46	нөлөөллийн арга	"Миний унших дуртай ном" номын сурталчилгаа	2024.11.14	55		50,000
47	хэмжээ	“Угийн бичиг” хөтлөх уралдаан		81		
48	"Соёлын бүтээлч сар" цахим подкаст		2024.11.08	1		
49	"Хүүхэд хамгаалалд бидний оролцоо"	"Миний хайртай ном" номын үзэсгэлэн	2024.11.14	456	3	
50		“Хүүхдийг номтой нөхөрлүүлэх тухай” лекц			3	
51	өдөрлөг	"Миний уншсан ном" гар зургийн үзэсгэлэн			1	
52	“100 номд-100 бэлэг” номын хандивын аян		жилийн турш	6	6	
53	"Номын жим"	Хормогчин театрын үзвэр		29	1	
54	нөлөөллийн арга	"Баавгай шийтгэсэн нь" үлгэр сонсох				
55	хэмжээ	Зурагт номтой танилцах				
56	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан "АХА" асуулт, хариултын тэмцээн		2024.12.25	206		
	56 СОНА			6402	128	8,365,780

5.1.1 “ҮНДЭСНИЙ НОМЫН БАЯР”-ЫН ХҮРЭЭНД “100 ЖИЛ-100 УНШИГЧ” БАЯРЫН АРГА ХЭМЖЭЭ:

Үндэсний 36 дахь удаагийн “Номын баяр”-ын хүрээнд доорх арга хэмжээнүүдийг зохион байгуулж, 200 хүнийг хамруулж, номтой нөхөрлөдөг, идэвхтэй уншигчдыг шагнаж урамшууллаа.

-“Хормогчин театр” бүтээх уралдаан:

Хүүхэд багачуудыг “Хормогчин театр”-аар дамжуулан ном унших сэдэл төрүүлж, номын сайн нөхөр болгох зорилготой “Хормогчин театр” бүтээх уралдаанд нийт 21 бүтээл оролцлоо. Уралдаанд ирүүлсэн бүтээлээс шилдгүүдээ шалгаруулахад:

I байр- Хэрх 5 дугаар цэцэрлэг "Эвтэй дөрвөн амьтан"-Өргөмжлөл, 200,000 төгрөг
II байр- “Цэцэгхэн” 1 дүгээр цэцэрлэг "Улаан малгайт"- Өргөмжлөл, 150,000 төгрөг
III байр- “Мишээл” 4 дүгээр цэцэрлэг " Эрхий мэргэн харваач"- өргөмжлөл,100,000 төгрөгөөр тус тус шагнагдлаа.

Бага насны хүүхдүүдийг "Хормогчин театр"-аар дамжуулан номонд дуртай болгох, ном унших сэдэл төрүүлэх, ойлгосноо илэрхийлэх, сэтгэн бодох, ярих чадваруудыг эзэмшүүлэн сургалтын үйл ажиллагаа явуулах ач холбогдолтой.

Уралдааныг 450,000 төгрөгийн шагналын сантай зохион байгууллаа.



-“Миний мөрөөдлийн - Мандал сум” постерын уралдаан:

Сумын түүхт 100 жилийн ойг угтан хүүхэд залуус, иргэдэд цахим технологийн тусламжтайгаар “Миний мөрөөдлийн Мандал сум”-ын өнгө төрхийг тодорхойлох зорилготой постерын уралдааныг зохион байгууллаа.


Уралдаанд 13 материал ирснээс:

1-р байр: 3-р сургууль 10-а Э.Халиунаа

2-р байр: 3-р сургуулийн 8-г ангийн сурагч Г.Номин-Эрдэнэ

3-р байр: 1-р сургууль 8-в анги Э.Мөнгөнцацал нар тус тус шалгарлаа.

Сумын 100 жилийн ойн хүрээнд тохижуулах ажилд санаа авах олон олон шийдлүүд ирснээрээ энэхүү уралдаан чухал ач холбогдолтой боллоо. Уралдааныг 230,000 төгрөгийн шагналын сантай зохион байгууллаа.



Шилдэг гэрийн номын сан” шалгаруулах

Ном соёлын өвийг дээдлэгч гэр бүл, иргэнийг урамшуулж, сайн туршлагыг хуваалцах зорилготой шилдэг гэрийн номын санг шалгарууллаа.

Энэхүү шалгаруулалтад 7 өрх материалаа ирүүлснээс С.Найдансүрэнгийн гэр бүл шалгарч өргөмжлөл 200,000 төгрөгөөр шагнагдлаа.

Гэрийн номын сан нь гэр бүлийн сурч боловсрох орон зай байхаас гадна амралтаа зөв өнгөрөөх тав тухтай орчин болж, сайн үлгэр дуурайлалыг сумын иргэдэд түгээн дэлгэрүүлж байгаа нь энэхүү уралдааныг үр дүнтэй болголоо.



5.1.2 “ҮНДЭСНИЙ БИЧИГ СОЁЛ-НОМЫН ӨДӨР”-ИЙН ХҮРЭЭНД “МОНГОЛ БАХАРХАЛ-100 ЖИЛД” СЭДЭВТ ҮЗЭСГЭЛЭН, ӨДӨРЛӨГ:

Үндэсний бичиг соёл-Номын өдрийн хүрээнд “Монгол бахархал-100 жилд” сэдвийн дор нийт 9 арга хэмжээ зохион байгуулж, 1460 хүнийг хамрууллаа.

1.“Гэрэлт номын-Өргөө” урилгат уншлага аяныг анги, хамт олны дунд зохион байгуулах: Номын баярын арга хэмжээний хүрээнд анги хамт олноороо номын сангийн уншигч болгох зорилготой “Урилгат уншлага” аянд сумын хэмжээний ЕБ-ын 4 сургуулийн 9 бүлгийн нийт 161 хүүхэд хамрагдлаа. Сурагчид номын сангийн үйл ажиллагаатай танилцаж, номыг бүтээлчээр унших дадалд суралцаж анги хамт олноороо номын сайн нөхөр болцгоолоо.

2.“Ном уншихын ач холбогдол” сургалт лекц зохион байгуулах: “Ном уншихын ач холбогдол” сургалтад ЕБС-ийн 6 анги бүлгийн 210 хүүхдийг хамруулж, номын ач тус, номтой нөхөрлөхийн үр дүн, номыг хэрхэн зөв унших, номын тэмдэглэл хөтлөх талаарх мэдлэгийг нь нэмэгдүүллээ.

3.“Хормогчин театр”-ын үзвэр зохион байгуулах: Үлгэрийг ойлгомжтой хэлбэрээр хүргэх зорилготой “Хормогчин театр”-ын үзүүлбэрийг бага ангийн сурагчдад 12 удаа нийт 174 хүнд сонирхууллаа. Номын санчид өөрсдийн ур чадвараа дээшлүүлж хормогчин театраа урлаж, үзүүлбэрээ өөрсдөө ярьж өгсөн нь хүүхдийн ном унших сонирхлыг төрүүлсэн ач холбогдолтой ажил боллоо.

4. “Алтан намар” номын үзэсгэлэн дэлгэх: Ахмад настанд хүндэтгэл үзүүлэх зорилгоор ахмадуудад үзүүлэх “Өдрийн үйлчилгээ”-ний хүрээнд зохион байгуулсан арга хэмжээнд “Алтан намар” сэдэвт 50 гаруй шинэ номоор үзэсгэлэн гаргаж, 89 хүнийг хамруулж, 218 ном уншууллаа. Ахмадууд шинэ номтой танилцаж, зөөврийн үйлчилгээгээр хамтран ажиллах санал гаргасан ач холбогдолтой ажил боллоо.

5. “Бид уншигч боллоо” фото зургийн булангаар зочлох: “Зураг түүх өгүүлнэ” сэдэвт номын сангийн уншигч болсон үеэ фото зурганд мөнхлөх зорилготой энэхүү буланд 90 гаруй хүүхэд хамрагдаж “Бид уншигч боллоо” фото зургийн цомгийн бүтээлээ. Хүүхдийн чөлөөт уран сэтгэмжийг хөгжүүлэх ач холбогдолтой ажил боллоо.

6. Мандал сумын түүхт 100 жилийн зориулан гаргасан “Түүх бүтээсэн нэгэн зуун” зурагт сэтгүүлийн цахим сурталчилгаа: Мандал сумын түүхт 100 жилийн зориулан гаргасан “Түүх бүтээсэн нэгэн зуун” зурагт сэтгүүлийн цахим танилцуулгыг “Сэлэнгэ Мандал Номын сан” цахим хуудсаар сурталчиллаа. 3 бүлэг сэтгүүлийн эхний “Түүхэн товчоон” бүлгийг видео хэлбэрээр сурталчилж байна. Нийт цахим хандалт: 583

7. Уншигчидтай хийх подкаст: Сайн дадал зуршлыг алхам алхмаар хэвшүүлэх төлөвлөгөөг танилцуулах зорилготой Жеймс Клейрын “Энгийн дадал” номын тухай подкастад 3-р сургуулийн сурагч А.Энх-Амар, А.Энх-Амгалан нар оролцож уншигчдад хэний ч үл анзаарам энгийн дадлуудын ачаар дотоод нөөц боломжоо ил гаргаж чадах талаар сонирхолтой яриа өрнүүллээ.

Энэ удаагийн 36 дахь номын баярыг 2024.09.12-09.30-ны өдрүүдэд зохион байгууллаа. Номын баярын хаалтын өдөр тэргүүний анги хамт олон, уншигчдад шагнал гардуулав. Үүнд:

-Тэргүүний уншигч анги хамт олноор - EcoSchool Mandal III сургуулийн Н.Нямхүү багштай 4-в ангийн анги хамт олон шалгарч 300.000 төгрөгийн үнэ бүхий багц номоор,

-Тэргүүний уншигчаар- Ахмад уншигч Ч.Батсүх шалгарч 100.000 төгрөгийн үнэ бүхий багц номоор тус тус урамшууллаа. (50 гаруй жил номтой нөхөрлөж байна.)

-Тэргүүний уншигч Д.Нацагдорж тэмдэгтэн сурагчаар- EcoSchool Mandal III сургуулийн 11-в ангийн сурагч О.Мишээл шалгарлаа.

5.1.3 “УГИЙН БИЧГЭЭ ХӨТӨЛЖ-УРАГ УДМАА МЭДЭЦГЭЭ” СЭДЭВТ СУРГАЛТ, УГИЙН БИЧГИЙН УРАЛДААН:

Монгол улсын Засгийн газрын 2007 оны 257 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган, монгол хүний удмын санг хамгаалах, ураг төрлөө таньж мэдэх, “Угийн бичиг хөтлөх”-ийн ач холбогдлыг сурталчлан, иргэдэд мэдлэг олгож, угийн бичиг хөтөлдөг өрхийн тоог нэмэгдүүлж, урамшуулах зорилгоор дараах ажлуудыг зохион байгууллаа.

1. Ширхэнцэгийн 9-р багийн өдөрлөгт зориулж тус номын сангаас “Угийн бичгээ хөтөлж-Ураг удмаа мэдэцгээ” сэдэвт фото зургийн болон номын үзэсгэлэн гаргаж, оролцсон иргэдээс “Угийн бичиг хөтлөлт”-ийн талаарх судалгаа авч, угийн бичгийн цахим хэрэглээний тухай брошюр 30 гаруй ширхэгийг мөн угийн бичгийн



тэмдэг, тэмдэглэгээ бүхий заавартай дэвтэр тараалаа. Өдөрлөгт оролцсон 81 иргэн хамрагдлаа.

2."Соёлын бүтээлч сар"-ын хүрээнд Сум дундын цагдаагийн албан хаагчдад угийн бичиг хөтлөлтийн талаар шинэлэг мэдээлэл өгч угийн бичиг хөтлөлтөд тулгамдаж буй асуудлуудаар хамтран ярилцлаа. Мэдээлэлд 55 албан хаагч оролцлоо.

Дээрх арга хэмжээнүүдэд нийт 136 хүн хамрагдаж, цахим орчинд 1200 хандалт авч, иргэдийн угийн бичиг хөтлөлтийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлсэн үр дүнтэй ажил боллоо.

5.1.4 “ЭХ ХЭЛНИЙ ӨДӨР”-ИЙН ХҮРЭЭНД “ХОС БИЧИГТЭН БОЛЖ-ЗӨВ НАЙРУУЛЖ БИЧИЖ СУРЦГААЯ” СЭДЭВТ 1 САРЫН АЯН:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Эх хэлний өдөр зарлах тухай” 25 дугаар зарлиг, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”, Аймаг, сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх талаар санаачилга гарган ажиллах зорилгоор энэхүү аяныг 2024.09.01-09.30-ны өдрүүдэд сумын байгууллага, аж ахуйн нэгж, албан хаагчдын дунд зохион байгууллаа. Аянд нийт 14 байгууллагын 1316 албан хаагч, цахим орчинд 936 хүн хамрагдлаа.

Аяны хүрээнд:

1.Байгууллага бүрээс үндэсний бичгээр саадгүй уншиж, сайн хөрвүүлэгч албан хаагчийг оролцуулсан “Эх хэл-Бидний дархлаа” уралдааны тэргүүний уншигчаар- V сургуулийн багш Б.Золгэрэл

2. Үндэсний бичгээр хичээнгүй зөв сайхан бичигч “Бичгийн соёл-Бидний гоёл” цээж бичгийн аварга шалгаруулах уралдааны тэргүүн байрыг I сургуулийн багш А.Бадам

3.Аяны болзлын дагуу монгол бичгийг сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэхэд хамт олны дунд зохион байгуулсан ажлаараа ШШГХ-413 дугаар нээлттэй, хаалттай хорих анги шалгарч “Үндэсний бичиг соёлоо дээдлэн дэлгэрүүлэгч хамт олон” боллоо.

4.Эх хэлээ танин мэдүүлэх, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилго бүхий “Босоо бичигтэн” цахим подкастад ЕБ-ын I сургуулийн Монгол хэл бичиг, уран зохиолын багш Ж.Пүрэвдорж оролцлоо. Цахим орчинд 36-таалагдсан, 16-сэтгэгдэл, 5-хуваалцсан, үзсэн 682 нийт 739 хандалттай байна.

Цахим подкастаар үндэсний соёлын салшгүй чухал хэсэг болсон монгол бичиг, эх хэлээ хамгаалж, баяжуулах хойч үедээ сургахын төлөө хувь нэмрээ оруулж байгаа тухай сонирхолтой ярилцлага өрнүүллээ.

Бүх нийтээр монгол хэлний хэм хэмжээг дагаж мөрдөх, төрийн болон захиргааны албан хэрэг хөтлөлтийг монгол хэлний зөв бичих дүрэм, орчин цагийн утга зохиолын монгол хэлний хэм хэмжээнд нийцүүлэх, монгол хэл бичиг, кирил үсгийн дүрмээ сурч судлах, өвлөх, өвлүүлэхэд чухал ач холбогдолтой аян боллоо.

5.1.5 “ХАРААГИЙН АЯЛГУУ-11” ЯРУУ НАЙРГИЙН НААДАМ:

Өсвөр үеийн хүүхдүүдийн эх хэлний уран яруу хэллэг, үгийн баялгийг нэмэгдүүлэх, тэдний уран сэтгэмж, найруулан бичих чадварыг хөгжүүлэх, авьяас сонирхлыг нь дэмжих зорилгоор зохион байгуулсан “Хараагийн аялгуу -11” яруу

найргийн наадам 100 жилийн ойн хүрээнд “Түүх бүтээсэн нэгэн зуун “ сэдвийн хүрээнд зохиогдсон нь онцлог байлаа.

1 дүгээр шатанд 51 хүүхэд шүлэг ирүүлснээс 11 хүүхдийг 2 дугаар шатанд шалгаруулж, “Түүх бүтээсэн нэгэн зуун” сэдвээр шүлэг бичин оролцсноос

1-р байр: 3 дугаар сургууль 9-г ангийн сурагч Ж.Оюу-Эрдэнэ

2-р байр: Хэрх сургуулийн 12-б ангийн сурагч Г.Номиннарс

3-р байр: Түнхэл сургуулийн 9-а ангийн сурагч А.Навчаа нар тус тус шалгарлаа. Зочин шүүгчээр яруу найрагч, СТА С.Мөнхцэцэг ажиллалаа.

Хүүхдийн эх хэлний уран яруу хэллэг, үгийн баялгийг нэмэгдүүлэх, тэдний уран сэтгэмж, найруулан бичих чадварыг хөгжүүлэхэд энэхүү уралдаан чухал ач холбогдолтой боллоо.



Нийт 150,000 төгрөгийн төсөвтэй тус ажлыг зохион байгууллаа.

5.1.6 "100 ЖИЛ- 100 НОМ" СЭДЭВТ НОМЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ САРЫН АЯН:

Ном унших, номын тэмдэглэл хөтлөхийн ач холбогдлыг сурталчлан хүүхэд багачуудыг номтой нөхөрлүүлэх бүтээлч уран сэтгэмжийг хөгжүүлэх зорилготой "100 жил-100 ном" аяныг зохион байгууллаа. Аянд 147 хүүхэд хамрагдлаа.

Аянд идэвхтэй оролцсон:

I сургууль 7-б ангийн сурагч А.Мөнхжин

IV сургууль 6-б ангийн сурагч Э.Энхзул

I сургуулийн 7б ангийн сурагч Д.Хэрлэн нарыг шагнаж урамшууллаа.

Тэмдэглэл хөтөлснөөр ном уншаад мэдлэг мэдээлэл авч, бичих чадвараа хөгжүүлж, номын гол утга санааг сайтар ойлгоход туслах хамгийн үр дүнтэй арга юм. Нийт 741,000 төгрөгийн төсөвтэй тус ажлыг зохион байгууллаа.





5.1.7 “Англи хэлээр уншицгаая” сэдэвт ном уншлагын 1 сарын аян

Зөвхөн монгол хэл дээр бус гадаад хэл дээр унших уншигчдын сонирхлыг дэмжих, хүүхдүүдийн англи хэлний мэдлэгийг сайжруулах, фондод хадгалагдаж буй англи хэл дээрх ном, хэвлэлийг сурталчлах зорилгоор “Англи хэлээр уншицгаая” ном уншлагын сарын аянг зохион байгууллаа. Сарын аяны хугацаанд:

-“The world of books” уншсан сэдвийн хүрээнд гар зургийн уралдаан зохион байгуулж, 21 хүүхдийг хамрууллаа.

-ЕБ-ын 1, 2, 4, 5 дугаар сургуулиудад англи номын үзэсгэлэн гаргаж 240 гаруй сурагчийг хамрууллаа

-Сан хөмрөгт хадгалагдаж буй англи хэл дээрх номын цахим үзэсгэлэн 5 удаа гаргаж, 127 хандалттай ажиллалаа.

-Урилгат уншлагаар 150 орчим сурагчийг хамруулж, номын сангийн шинэ уншигчаар бүртгэж, номын сайн нөхөд болголоо.

-Идэвхтэй оролцсон уншигч хүүхэд, анги, хамт олныг шалгаруулж урамшууллаа.Үүнд:

Шилдэг оролцогчид:

Тэргүүн байр-1 дүгээр сургуулийн 5-б анги Т.Юмчин

Дэд байр- 1 дүгээр сургууль 5-б анги Б.Соёмбо

Гутгаар байр- 1 дүгээр сургууль 5-б анги Б.Оюунтунгалаг

Тусгай байр- 2 дугаар сургууль 5-а анги Б.Аранжиндорж, тусгай байр- 4 дүгээр сургууль 5-б анги Э.Хүрэлтулга тус тус шалгарлаа.

Шилдэг багшаар:


Тэргүүн байр- 1 дүгээр сургуулийн багш Т.Болортуяа

Дэд байрт-2 дугаар сургууль багш Т.Туяа

Гутгаар байрт- 4 дүгээр сургуулийн багш Д.Оюунтуяа нар шалгарлаа.

Шилдэг анги: 2 дугаар сургуулийн П.Алтантуяа багштай 5-а анги тус тус шалгарлаа.

Энэхүү аяны үр дүнд англи хэл анхлан суралцаж байгаа хүүхдүүдэд хэл сурах хүсэл, сонирхлыг нь нэмэгдүүлж, багш, сурагчдын талархлыг хүлээсэн шинэлэг, үр дүнтэй ажил боллоо.



Нийт 310,000

төгрөгийн төсөвтэй тус ажлыг зохион байгууллаа.

5.1.7 “АНГЛИ ХЭЛЭЭР УНШИЦГААЯ” СЭДЭВТ НОМ УНШЛАГЫН 1 САРЫН АЯН:

Зөвхөн монгол хэл дээр бус гадаад хэл дээр унших уншигчдын сонирхлыг дэмжих, хүүхдүүдийн англи хэлний мэдлэгийг сайжруулах, фондод хадгалагдаж буй англи хэл дээрх ном, хэвлэлийг сурталчлах зорилгоор “Англи хэлээр уншицгаая” ном уншлагын сарын аянг зохион байгууллаа. Сарын аяны хугацаанд:

-“The world of books” уншсан сэдвийн хүрээнд гар зургийн уралдаан зохион байгуулж, 21 хүүхдийг хамрууллаа.

-ЕБ-ын 1, 2, 4, 5 дугаар сургуулиудад англи номын үзэсгэлэн гаргаж 240 гаруй сурагчийг хамрууллаа

-Сан хөмрөгт хадгалагдаж буй англи хэл дээрх номын цахим үзэсгэлэн 5 удаа гаргаж, 127 хандалттай ажиллалаа.

-Урилгат уншлагаар 150 орчим сурагчийг хамруулж, номын сангийн шинэ уншигчаар бүртгэж, номын сайн нөхөд болголоо.

-Идэвхтэй оролцсон уншигч хүүхэд, анги, хамт олныг шалгаруулж урамшууллаа.Үүнд:

Шилдэг оролцогчид:

Тэргүүн байр-1 дүгээр сургуулийн 5-б анги Т.Юмчин

Дэд байр- 1 дүгээр сургууль 5-б анги Б.Соёмбо

Гутгаар байр- 1 дүгээр сургууль 5-б анги Б.Оюунтунгалаг

Тусгай байр- 2 дугаар сургууль 5-а анги Б.Аранжиндорж, тусгай байр- 4 дүгээр сургууль 5-б анги Э.Хүрэлтулга тус тус шалгарлаа.

Шилдэг багшаар:

Тэргүүн байр- 1 дүгээр сургуулийн багш Т.Болортуяа

Дэд байрт-2 дугаар сургууль багш Т.Туяа

Гутгаар байрт- 4 дүгээр сургуулийн

багш Д.Оюунтуяа нар шалгарлаа.

Шилдэг анги: 2 дугаар сургуулийн П.Алтантуяа багштай 5-а анги тус тус шалгарлаа.

Энэхүү аяны үр дүнд англи хэл анхлан суралцаж байгаа хүүхдүүдэд хэл сурах хүсэл, сонирхлыг нь нэмэгдүүлж, багш, сурагчдын талархлыг хүлээсэн шинэлэг, үр дүнтэй ажил боллоо.

Нийт 310,000 төгрөгийн төсөвтэй тус ажлыг зохион байгууллаа.

5.1.8 “МИНИЙ ШИРЭЭНИЙ НОМ-МИНЖИЙН ХАНГАЙ РОМАН” СЭДЭВТ ЦАХИМ ПОДКАСТ:

Мандал сум үүсэн байгуулагдсан түүхт 100 жилийн ойн хүрээнд, сумын түүхийг харуулсан бахархалт зохиол “Минжийн хангай” романаар “Миний ширээний ном-Минжийн хангай роман” сэдэвт цахим подкастаар номын санч Г.Одгэрэл, ахмад хуульч, уншигч Ж.Энхжаргалтай ярилцаж, уншигчдад сум орон нутгийн түүх, Д.Наваансүрэн зохиолчийн уран бүтээл, ном уншихын ач холбогдлын талаар сонирхолтой мэдээллийг хүргэж, сурталчиллаа.



Цахим орчинд:

Таалагдсан	Сэтгэгдэл	Хуваалцсан	Үзсэн	Нийт
116	53	27	4200	4396

СЭЛЭНГЭ АЙМГИЙН МАНДАЛ СУМЫН ТҮҮХТ 100 ЖИЛИЙН ОЙ "ТҮҮХ БҮТЭЭСЭН НЭГЭН ЗУУН" СЭДЭВТ ЦАХИМ ПОДКАСТ:

Энэ удаагийн подкастын зочноор 50 гаруй жил номын сангаар үйлчлүүлсэн тэргүүний уншигч, өндөр настан Д.Батдэлгэр уригдан оролцлоо.

Ахмад уншигчийн туршлага, номтой нөхөрлөсөн он жилүүдийн талаарх дурсамжтай сонирхолтой яриа өрнүүлсэн нь уншигчдыг номын амтанд шимтүүлэх, үлгэр дуурайлал үзүүлэх ач холбогдолтой ажил болж байна.



Цахим орчинд:

Таалагдсан	Сэтгэгдэл	Хуваалцсан	Үзсэн	Нийт
68	22	9	2000	2099

5.1.9 “МАНДАЛ СУМ-100 ЖИЛД” СЭДЭВТ АСУУЛТ, ХАРИУЛТЫН ЦАХИМ УРАЛДААН:

Мандал сумын түүхт 100 жилийн ойд зориулж Google form ашиглан орон нутгийн түүхийн талаарх иргэдийн мэдлэгийг нэмэгдүүлсэн асуулт хариултын уралдааныг цахимаар явууллаа. Уралдааны журмын дагуу 15 минутад 11 асуулт хариулах энэхүү уралдаанд 36 хүн хамрагдаж ялагчаар П.Одончимэг тодорлоо.

Сум орон нутгийн талаарх иргэдийг мэдлэгийг нэмэгдүүлсэн сонирхолтой уралдаан боллоо.

5.1.10 “НОМ БИД ХОЁР-100 ЖИЛД ХАМТДАА” СЭДЭВТ ГЭРЭЛ ЗУРГИЙН ЦАХИМ ҮЗЭСГЭЛЭН:

Сумын иргэд, хүүхэд багачуудыг номтой нөхөрлүүлэхэд уриалж, сурталчлах зорилгоор сумын түүхт зуун жилийн ойн хүрээнд “Ном бид хоёр зуун жилд хамтдаа” сэдэвт гэрэл зургийн цахим үзэсгэлэн зохион явууллаа.

Үзэсгэлэнд ирсэн нийт 27 бүтээлийг “Сэлэнгэ Мандал Номын сан” цахим хуудсаар олон нийтэд хүргэж, сурталчиллаа.

Тус уралдаанд ЕБ-ын IV сургуулийн 9-б ангийн сурагч Г.Нарангарав шөнийн тэнгэрт ер бусын гялтганах сонирхолтой оддын бөөгнөрлийг ажиг, тайлж мэдэхээр “Огторгуйн нууцууд” номыг авч уншин өөрийн асуултын хариуг олж авсан тухайгаа гэрэл зургаар сурталчилсан нь тэргүүн байр, Ахмад уншигч Л.Цэнд үндэсний бичигтэй ном зохиолуудыг уншиж, эх хэлээ сэргээх бодолтой байгаагаа хуваалцсан фото зураг дэд байр, “Миний хайртай ном” сэдэвт фото зураг гутгаар байранд тус тус шалгарлаа.

Гэрэл зургийн үзэсгэлэнд ирсэн бүтээлүүдийг шинэ ном болон өөрийн хамгийн их сонирхдог номоо тайлбартайгаар сурталчилсан нь иргэдийг номтой нөхөрлүүлэхэд чухал ач холбогдолтой ажил боллоо.

5.1.11 “ЗААВАЛ УНШИХ БҮТЭЭЛҮҮДЭЭС ХЭР САЙН МЭДЭХ ВЭ” СЭДЭВТ ЦАХИМ КОНТЕНТИЙН УРАЛДААН:

Уншигч хүүхэд залуус, иргэдийн дунд заавал унших бүтээлүүдийг сурталчлах, номтой нөхөрлөхөд уриалах зорилгоор “Цахим контент”-ийн уралдааныг зохион байгууллаа.

Уралдаанд 20 бүтээл ирсэнээс шаардлага хангасан 3 бүтээлийг шалгаруулж, тус бүр 110,000 төгрөгийн мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа. Уралдааны хүрээнд заавал унших бүтээлүүдээр цахим танилцуулга, брошюр бэлтгэн уншигчдад хүргэж, номын үзэсгэлэн, фото зургийн цахим үзэсгэлэн гаргалаа.



5.1.12 “НО-ДЭЛГЭЦ, YES-НОМ” ЦАХИМ ПОСТЕРЫН УРАЛДААН:

Дэлгэцийн донтолтын талаар мэдээлэл хүргэж, цахим хэрэглээгээ зөв зохицуулах, номтой нөхөрлөхийн ач холбогдлын талаар таниулах зорилготой “НО-ДЭЛГЭЦ, YES-НОМ” цахим постерын уралдааныг ахлах ангийн сурагчдын дунд зохион байгууллаа. Уралдаан 14 бүтээл ирснээс 1-р сургуулийн сурагч А.Хулангийн бүтээл шалгарлаа. Уралдаанд оролцогч хүүхдүүдийн гар утасны хэрэглээгээ хязгаарлах талаар оруулсан санаа нь үе тэнгийн найз нартаа зөв үлгэр дуурайлал үзүүлсэн бодит ажил боллоо.

5.2 2024 оны СОНА-ын ажлын хүрээнд Ном, хэвлэлийн танхимын сурталчилгааг зохион байгуулах:

Фондын эргэлтийг сайжруулах, ном, хэвлэлийг танилцуулах зорилгоор номын танхимын сурталчилгаагаар тойм яриа, чанга уншлагыг 77 удаа 1871 хүнд, номын үзэсгэлэнг 35 удаа 2101 хүнд нийт 112 удаагийн сурталчилгаагаар 3972 хүнд үйлчилсэн нь төлөвлөгөөний биелэлт 100 хувь хэрэгжсэн дүнтэй байна.

Номын сурталчилгааны төрөл, тоон мэдээ:

№	Үзүүлэлт	Хэдэн удаа	Хамрагдсан хүн
1	Тойм яриа, чанга уншлага	77	1871
3	Номын үзэсгэлэн	35	2101
Нийт дүн		112	3972

5.3 2024 оны СОНА-ын хүрээнд “Ном уншихын ач холбогдол” сургалтыг зохион байгуулах: “Ном уншихын ач холбогдол” сургалтад 1, 2, 3, 4, 5 дугаар Ерөнхий боловсролын сургуулиудын 246 хүүхдийг хамруулж, номын ач тус, номтой нөхөрлөхийн үр дүн, номыг хэрхэн зөв унших, номын тэмдэглэл хөтлөх талаарх мэдлэгийг нь нэмэгдүүлсэн.

Тоон мэдээ:

Зохион байгуулсан тоо	Оролцсон хүний тоо
6	246

Сурагчдыг номтой нөхөрлүүлэх, номыг бүтээлчээр уншуулах зорилготой “Ном уншлагын цаг”-ийг зохион байгуулж байна.

Тус арга хэмжээнд ЕБ-ын III сургуулийн Б.Адьяа багштай 6-б ангийн 16 сурагч, Н.Нямхүү багштай 4-в ангийн 35 сурагч карт нээлгэн давхардсан тоогоор 150 сурагч тогтмол уншлага үйлчилгээнд хамрагдаж байна.

Сурагчдын хувьд ном уншлагын цагт хамрагдснаар сууж сурах, анхаарал төвлөрүүлэлт сайжрах, тууштай зан байдалд суралцах олон эерэг дадлуудыг эзэмших боломжтой боллоо.

Хүүхдүүд 10-12 хуудастай үлгэрийн номоос эхлэн уншиж байсан бол өдгөө 70 гаруй хуудастай зурагт комик ном уншдаг болоод байна.

Энэхүү арга хэмжээнд хамрагдаж байгаа хүүхэд багачуудыг урамшуулах, идэвхжүүлэх зорилгоор 38.500 төгрөгийн амттанаар дайлж, 2 уншигчийг шинэ номоор урамшууллаа.

5.4 “Түүх бүтээсэн нэгэн зуун” сэдэвчилсэн ном зүйн бүртгэл хийх. Лавлагаа, татгалзлын бүртгэлийг хөтлөх: Лавлагаа мэдээллээр уншигчдыг хангах зорилгоор уншигчдын сонирхсон асуултад хариулахад лавлагаа болж чадах гарын авлага болон толь бичгүүд, фондод байгаа сүүлийн үед хэвлэгдсэн эх материалыг ашиглан 374 лавлагаанд хариулт өгч, татгалзлын дэвтэрт 139 ш номыг бүртгэлээ.

“Түүх бүтээсэн нэгэн зуун” сэдэвчилсэн номзүйн бүртгэлийг хийж, сумын түүх, орон нутгаас төрөн гарсан зохиолчидтой холбоотой ном, хэвлэл, цахим орчинд нийтлэгдсэн мэдээллийн бүртгэлийг хийж байна.

ЗУРГАА: ИРГЭДИЙГ НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ӨРГӨНӨӨР ХАМРУУЛЖ, УНШИГЧДЫН ТООГ НЭМЭГДҮҮЛЭХ СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД:

6.1 Уншигчдын хүрээг өргөжүүлж, ном олголтыг нэмэгдүүлэх:

Иргэдийг номтой нөхөрлүүлэх, номын сангийн уншигчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор ном тойрсон олон талт ажлуудыг зохион байгуулж, ном уншлагын клуб, дугуйланг ажиллуулж, байгууллагын нөөц бололцоог дайчлан ажиллаж байна. 2024 онд нийт 4500 шинэ уншигч, 21558 ирэгсэдэд, 35443 ш ном олгосон нь жилийн

төлөвлөгөөний биелэлт 100 хувьтай хэрэгжиж, өмнөх оны мөн үеийнхээс шинэ уншигч 120,2 хувь, ирэгсэд 163 хувь, ном олголт 189 хувиар өссөн дүнтэй байна.

Уншигч, ирэгсэд, ном олголтын төрөл:

№	Үзүүлэлт	Танхимын үйлчилгээ	Гэрээр	Явуулын үйлчилгээ	Бүгд
1	Шинэ уншигч	3324	1120	56	4500
2	Ирэгсэд	14323	6850	385	21558
3	Ном олголт	22781	12146	516	35443

Сүүлийн 5 жилийн харьцуулалт:



Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024	Хувь
Суудлын тоо	42	42	42	42	42	42
Уншигчдын тоо (байнгын /шинэ)	1105	439	1972	2044	4500	120,2%
Ирэгсэд	8888	1235	8003	8211	21558	163 %
Олгосон номын тоо	10359	1685	11315	12276	35443	189 %

“УРИЛГАТ УНШЛАГА” АЯН

Хүүхдүүдийг номтой нөхөрлүүлж, уншигчдын тоог нэмэгдүүлэх “Урилгат уншлага” аянд нийт сургуулийн 246 хүүхэд хамрагдлаа.

Зохион байгуулсан арга хэмжээ	Хамрагдсан анги хамт олон	Хэдэн хүүхэд
Номын сангийн үйл ажиллагаатай танилцаж, уншигчийн карт нээлгэн, байнгын уншигч болж, номтой нөхөрлөлөө.	1,2,4-р ЕБС	246 хүүхэд
Нийт	6 удаа	246 хүн хамрагдсан

Идэвхтэн уншигчдыг урамшуулах: 2024 онд Номын сангаас зохион байгуулсан идэвхтэй уншигч болох нийт 15 хүүхэд, 6 байгууллага хамт олон, 10 хүнийг шагнаж урамшуулахад нийт 2,865,800 төгрөгийг зарцуулсан.

№	Хийгдсэн ажил	Шагнал, урамшуулал	
		Хэдэн хүн шагнуулсан	Хэдэн төгрөгөөр
1	“Үндэсний номын баяр”-ын хүрээнд “100 жил-100 уншигч” арга хэмжээ	1 хүн, 3 хүүхэд, 3 байгууллага	880,000
2	Үндэсний бичиг соёл-номын өдөр”-ийн хүрээнд “Монгол бахархал-100 жилд” сэдэвт үзэсгэлэн өдөрлөг	1 тэргүүний уншигч, 1 анги хамт олон	400,000
3	Угийн бичгээ хөтөлж-ураг удмаа мэдэцгээе” сэдэвт сургалт, угийн бичгийн уралдаан	1 хүн	125,800
4	“Эх хэлний өдөр”-ийн хүрээнд “Хос бичигтэн болж-Зөв найруулж бичиж сурцгаая аян” сэдэвт 1 сарын аян	2 албан хаагч, 1 байгууллага	500,000
5	“Хараагийн аялгуу-10” хүүхдийн яруу найргийн наадам	3 хүүхэд, 1 хүн	150,000
6	“100 жил-100 ном” сэдэвт номын тэмдэглэл хөтлөх 1 сарын аян	3 хүүхэд	120,000
7	“Англи хэлээр уншицгаая” сэдэвт ном уншлагын 1 сарын аян	5 хүүхэд, 3 багш, 1 анги хамт олон	280,000
8	“Миний ширээний ном-Минжийн хангай роман” цахим подкаст		
9	“Мандал сум 100 жилд” сэдэвт асуулт хариултын цахим уралдаан	1 хүн	50,000
10	“Ном бид хоёр-100 жилд хамтдаа” цахим гэрэл зургийн үзэсгэлэн		
11	“Заавал унших бүтээлүүдээс хэр сайн мэдэх бэ?” цахим контентийн уралдаан	3 хүн, 3 хүүхэд	330,000
12	“НО-ДЭЛГЭЦ, YES-НОМ” цахим постерын уралдаан		
	Нийт 15 хүүхэд, 6 байгууллага хамт олон, 10 хүн		2,865,800

6.2 Ном уншлагын клуб, дугуйлан хичээллүүлэх: “Өсвөрийн номын санч” дугуйланд 13 хүүхэд хамрагдаж, номын санчийн ажил, номтой ажиллах мэдлэгээ нэмэгдүүлж байна.

ӨСВӨРИЙН НОМЫН САНЧДЫН УУЛЗАЛТ, СУРГАЛТ

Номын санчийн мэргэжил, номтой нөхөрлөхийн ач холбогдлыг сурталчлах зорилгоор “Өсвөрийн номын санчдын уулзалт, сургалт”-ыг зохион байгуулж, 13 хүүхдийг хамруулж, номын санчийн ажлын талаар мэдлэг олгож, мэдээлэл хүргэсэн ач холбогдолтой ажил боллоо.



ДОЛОО: ИРГЭДЭД ҮЙЛЧЛЭХ НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЦАХИМ ХЭРЭГСЛИЙГ АШИГЛАН ЗОХИОН БАЙГУУЛАХ, ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭГ ХӨГЖҮҮЛЖ, ЦАХИМ НОМЫН ФОНД, КОМПЬЮТЕР, ТЕХНИК ХЭРЭГСЛИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД:

7.1 Ном, хэвлэлийн цахим сурталчилгаа, мэдээллээр үйлчлэх, “Түүх бүтээсэн нэгэн зуун” сэдвийн хүрээнд орон нутгийн түүх, соёлын талаарх мэдээллийг оруулах, сурталчлах:

1.Номын сангийн үйлчилгээг цахим хэрэгсэл ашиглан зохион байгуулж, ном хэвлэлийн сурталчилгаа, цахим ном, үндэсний өв соёл, танин мэдэхүй, орон нутгийн түүх, соёлын талаарх мэдээллийг 108 удаа цахим хуудсаар хүргэж, 14456 хандалттай байгаа нь тайлант оны төлөвлөгөөний биелэлт 100 хувь хэрэгжсэн дүнтэй байна.

Ном, хэвлэлийн цахим сурталчилгааны тоон мэдээ:

“Цахим номын үзэсгэлэн, сурталчилгаа”	29
“Ном унших ач холбогдлын тухай зөвлөмж”	11
“Үндэсний бичиг, өв соёлыг сурталчлах” цахим булан	9
“Үлгэрийн цаг” цахим булан	7
“Дэлхийн сонгодог богино хэмжээний өгүүллэгүүд, сонирхолтой сургамжит зохиолууд”	11
“Миний сайхан Мандал сум” түүхийн цахим булан	41
Нийт 108 удаа 14456 хандалт	

2.Тусгай хэрэгцээт иргэдийн “Номын хөтөч” цахим группыг үүсгэж, номын сангийн үйлчилгээний танилцуулга, шинэ номын мэдээ, богино өгүүллэг, подкаст, сонсдог ном зэрэг 5 мэдээллийг тавьж, 50 гаруй хүнд хүргэлээ.

7.2.Номын цахим /электрон/ каталогиор үйлчлэх: Фондод хадгалагдаж буй 29,462 гаруй номыг бүрэн оруулсан Mandal.monbiblio.mn цахим каталогиор уншигчдад үйлчилж байна.

7.3 “Цахим номын фонд”-ын баяжилтыг нэмэгдүүлэх:

Номын сангийн цахим санг баяжуулах зорилгоор сумын “Мандалын мэдээ” сонины 2006-2010 оны дугааруудаас скайнердаж цахим сан үүсгэж байна.


Цахим номыг гэрээсээ үнэгүй унших “Номтой нөхөрлөө” бүлэг нь 746 дагагчтай, 546 номтой ажиллаж, 32 ш цахим номоор баяжилт хийлээ.



Гэрээсээ үнэгүй унших "Номтой нөхөрлөө"

Бүлэг

Public group · 429 members



Номын сан нь өндөр хурдны интернэт, шилэн кабельд холбогдоогүй бөгөөд Монголын Цахилгаан Холбооны агаарын утастай суурин интернэтийг 5 Mbps хурдаар авч ашигладаг. Тус багцын боломжид тулгуурлан тухайн онд 11607 уншигчдад интернэтийн үнэ төлбөргүй үйлчилгээг үзүүллээ.

7.4. “Цахим засаглал хөтөлбөр”-ийн хүрээнд номын сангийн үйл ажиллагааг цахимжуулах компьютер, техник хэрэгслийн тоог нэмэгдүүлэх:

1. Номын сангийн автоматжуулалтын Коха програмд нэгдсэн журмаар шилжиж байгаатай холбогдуулан Монбиблио програмд бүртгэлтэй тус номын сангийн сан хөмрөг болох 29,462 гаруй номтой дата баазыг үүсгэж, МҮНС-ийн арга зүйн хэлтэст хүргүүлсэн.

2. Албан хаагчдын ажлын багаж хэрэгсэл, ширээ сандал, компьютер техник тоног төхөөрөмж, бичгийн хэрэгслийг байгууллагаас боломжийн хэрээр хангаж, өнгө үзэмжтэй, тав тухтай байлгадаг бөгөөд 2023 оны үр дүнгийн нэмэлт санхүүжилтээр 2024 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 18 тоот хамт олны хурлын протоколд тэмдэглэгдсэн албан хаагчдын саналыг үндэслэн албан хэрэг хөтлөлтийн хэрэгцээнд хүчин чадал сайтай 4070,000 төгрөгийн үнэ бүхий зөөврийн компьютер 1ш-ийг худалдан авч, Аймгийн Засаг даргын дэмжлэгээр зөөврийн компьютер 1ш 2985,000, Соёлын яамны санхүүжилтээр зөөврийн компьютер 1ш 3070,000, олон үйлдэлт өнгөт принтер 1ш-ийг 724,900 тус тус хүлээн авч үйл ажиллагаандаа ашиглаж байна.

НАЙМ: ОРОН НУТГИЙН НОМЫН САНГУУДАД МЭРГЭЖИЛ, АРГАЗҮЙН ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД:

8.2. “Хараа” бүсийн номын санчдын сургалт зохион байгуулах: Номын сангийн салбарын тэргүүн туршлагаас суралцах, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр Сүхбаатар суманд байрладаг Нийтийн номын сангийн үйл ажиллагаатай танилцаж, туршлага судалж, цахим номын сангийн үйл ажиллагааны талаар харилцан ярилцсан.

8.3. Орон нутгийн номын сангуудад ажлын байрны аргазүйн зөвлөгөө өгөх: Ажлын байрны мэргэжил арга зүйн зөвлөгөөг давхардсан тоогоор 6 номын санчид 8 удаа өгсөн нь тухайн оны төлөвлөгөөний биелэлт оролцсон хүний тоо 100 хувиар биелэгдсэн үр дүнтэй байна.

№	Сэдэв	Хаана	Зөвлөгөө авсан	Зөвлөгөө өгсөн	Хамрагдсан хүний тоо
1	Номын нэг бүрчилсэн бүртгэл хөтлөх тухай	Цахимаар	2-р сургуулийн номын санч Т.Дуламсүрэн	Ахлах номын санч Б.Байгалмаа	1
2	СОНА-ын талаар	Нийтийн номын сангийн байранд	1-р сургуулийн номын санч М.Марта	Ахлах номын санч Б.Байгалмаа	2
3	“Угийн бичиг” хөтлөх талаар	Цахимаар	5-р сургуулт номын санч Т.Батхонгор	Ахлах номын санч Б.Байгалмаа	1
4	Номын тэмдэглэлийн уралдааны талаар	Нийтийн номын сангийн байранд	2-р сургуулийн номын санч Т.Дуламсүрэн	Номын санч С.Цэндсүрэн	1
5	Соёлын сэргэлтийн эрхийн бичгийн талаар	Нийтийн номын сангийн байранд	3-р сургуулийн номын санч Н.Долгоржав	Номын санч Г.Одгэрэл	2
6	Уншигчийн карт хөтлөх талаар	Нийтийн номын сангийн байранд	ШШГ-ын Хорих 413 –р анги	Ахлах номын санч Б.Байгалмаа	1
Нийт 4 хүнд 5 удаа					

ЕС: ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙГ ХАНГАХ СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД:

9.1 Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангаж ажиллан “Хөдөлгөөн эрүүл мэнд” хөтөлбөрийг хэрэгжүүлж, албан хаагчдын мэдлэгийг нэмэгдүүлэн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх: Албан хаагчдын эрүүл мэндэд анхааран, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах ажлын төлөвлөгөөг жил бүр 16 зүйлтэйгээр боловсруулж, хэрэгжилтийг хангаж байна.

Байгууллагын “ХАБЭА-н дүрэм”, “Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа хими, биологийн бүтээгдэхүүний нэгдсэн жагсаалт”, “Химийн бүтээгдэхүүнтэй зүй зохистой харьцах, хордлогоос урьдчилан сэргийлэх зөвлөмж”, “Химийн бүтээгдэхүүний хордлогод өртөж болзошгүй эрсдэл бүхий ажлын байр, албан хаагчдын нэгдсэн жагсаалт”-ыг тус бүр шинэчлэн гаргаж, хэрэгжүүлж байна.

Байгууллагын “Хөдөлгөөн эрүүл мэнд” хөтөлбөрийн хүрээнд албан хаагчдыг чийрэгжүүлэх, дасгал хөдөлгөөн хийх нөхцөлийг бүрдүүлж, эмчилгээ, сувилалд

хамруулах, дархлааг дэмжих, түр амрах, хооллох нөхцөлийг өөрсдийн боломжоор хангаж ажиллаж байна.

Албан хаагчдыг ажлын байрны эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Нийтийн номын сангийн захирлын 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/05 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар шинэчлэн баталсан “Мандал сумын Нийтийн номын сангийн албан хаагчид ажлын байранд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэглэм баримтлах анхааруулга, санамж”-ийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлж, албан хаагчид ажлын ээлж эхлэх бүртээ анхааруулга санамжтай танилцан гарын үсэг зурж ажлаа эхлүүлдэг.

“Ажлын байрны ХАБЭА-н үзлэг, хяналтын төлөвлөгөө”-г 5 зүйлтэйгээр боловсруулж, хяналтыг тогтмол зохион байгуулж, зөрчил дутагдлыг арилгуулж байна.

“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн аюулгүй орчинд ажиллах” хөтөлбөрийн хүрээнд албан хаагчдад ээлжит болон ээлжит бус “ХАБЭА-н зааварчилгаа”-г гүйцэтгэх ажил үүрэгт нь тохируулан тухай бүр бичгээр гаргаж танилцуулан, гарын үсэг, тэмдгээр баталгаажуулан, эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллаж байна. Мөн шинэ ажилтнуудад “Зааварчилгааны хяналтын хуудас”-аар ХАБЭА-н зааварчилгааг өгдөг.

Албан хаагчид, уншигч, үйлчлүүлэгчдийг болзошгүй эрсдэлээс сэргийлэх зорилгоор цахилгаан, ус, галын аюул болон бусад механик гэмтэл, бэртэлээс хамгаалах, халдварт өвчнөөс сэргийлэх талаарх анхааруулга, санамж зэргийг байгууллагын эд хэрэгсэл, хаалга, шал зэрэг зохих газруудад байх ёстой анхааруулгуудыг хэвлэж байрлуулсан.

Нийтийг хамарсан халдварт өвчин, ханиад томууны үед албан хаагчдыг дархлаажуулах, вакцинжуулах, нийтээр мөрдөх дэглэмийг баримтлах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлдэг.

Байгууллагын байрны доторх болон гадаах хашаа талбайн ариун цэврийг сахиж, шаардлагатай цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол зохион байгуулж, ковид-19 цар тахлын үед мэргэжлийн байгууллагаар ариутгал, халдваргүйтгэлийн ажлыг 1 удаа хийлгэж, бусад үед өөрсдийн боломжоор ариутгалыг тогтмол зохион байгуулж, жил бүр номын фондын номонд ариутгал цэвэрлэгээг 15 удаа төлөвлөгөөтэйгээр зохион байгуулдаг.

Улаанбаатар хотод Алерги мед эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэгт 5 албан хаагч, өөрсдийн хүсэлтээр 3 албан хаагч Сумын Нэгдсэн эмнэлэгийн урьдчилсан сэргийлэх үзлэгт тус тус хамрагдсан. Ариутгал, цэвэрлэгээ, болзошгүй эрсдэл, гэнэтийн эрүүл мэндийн тусламжид бэлэн байлгах эрүүл мэндийн бүтээгдэхүүний нөөцийг бэлэн байдалд байлгаж, одоогийн байдлаар нийт 504,793 төгрөгийн 811 ш бүтээгдэхүүний нөөцтэй байна.

Ариутгал, халдваргүйтгэлийн хэрэгслийн нөөц:

№	Материал	Ши рхэ г	Бо од ол	Нэгжи йн үнэ	Нийт үнэ	За рц уу лс ан	Үлд эгд эл	Үнэ
---	----------	----------------	----------------	-----------------	-------------	----------------------------	------------------	-----

1	Малгай удаагийн/	/Нэг	4		450	1 800	1	3	1 350
2	Халаат удаагийн/	/Нэг	1		4 000	4 000	1	0	0
3	Бээлий удаагийн/	/Нэг	100	2	22 500	45 000	10 0	0	0
4	Халуун бууруулах эм		1		2 500	2 500	0	1	2 500
5	Духны хэмжигч халуун		1		80 000	80 000	0	1	80 000
6	Жавельсин		300		150	45 000	30 0	0	0
7	Электрон даралтны аппарат		1		90 000	90 000	0	1	90 000
8	Улавч	/Нэг удаагийн/	25		120	3 000	0	25	3 000
9	Амны хаалт удаагийн/	/Нэг	200	4	15 000	60 000	20	80	24 000
10	Комбинзон удаагийн/	/Нэг	1		23 500	23 500	1	0	0
12	Шал угаах автомат хувин, алчуур		1		50 000	50 000	0	1	50 000
13	Гар ариутгагч Санитол /	/	2		16 000	32 000	2	0	0
Нөөцийн баяжилт 2021.04.02									
14	Гар ариутгагч Санитол /	/	2		16 000	32 000	2	0	0
15	Бээлий удаагийн/	/Нэг	50	1	32 000	32 000		50	32000
16	Ариун цэврийн цаас		42	1	25 000	25 000	42	0	0
Нөөцийн баяжилт 2021.04.30 “Шуурхай штаб”-аас									
17	Гар ариутгагч Санитол /	/	10		5 000	50 000	10	0	0
18	Ариун цэврийн цаас		12		600	7 200	12	0	0
Нөөцийн баяжилт 2021.05.21 “Шуурхай штаб”-аас									
19	Гар ариутгагч /Санитол /		20		5 000	100 000	18	2	10 000
20	Жавельсин		300	1	32 000	32 000	0	300	32 000
21	Бээлий удаагийн/	/Нэг	50	1	16 000	16 000	20	30	9 600
Нөөцийн баяжилт 2021.05.27									
22	Амны хаалт удаагийн/	/Нэг	250	5	100	25 000	0	250	25 000
23	KF-94 амны хаалт		50	10	800	40 000	0	50	40 000
Нөөцийн баяжилт 2021.09.06									
24	Ариун цэврийн цаас		42	1	25 000	25 000	30	12	7 143

25	Мананцарын буу	1		70 000	70 000		1	70 000
26	Санитол	1		23500	23500		1	23500
27	Парацетамол	2		400	800		2	800
28	Ибуденк	1		3900	3900		1	3900
	НИЙТ	1			919200	63	811	504793
		470				9		

АРАВ: АЛБАН ХААГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД:

10.1 “Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах” хөтөлбөр хэрэгжүүлэх:

БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧДЫН ҮР БҮТЭЭЛТЭЙ АЖИЛЛАХ ОРЧИН НӨХЦӨЛИЙГ ХАНГАХ:

- Албан хаагчдын ажлын багаж хэрэгсэл, ширээ сандал, компьютер техник тоног төхөөрөмж, бичгийн хэрэгслийг байгууллагаас боломжийн хэрээр хангаж, өнгө үзэмжтэй, тав тухтай байлгадаг бөгөөд 2023 оны үр дүнгийн нэмэлт санхүүжилтээр 2024 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 18 тоот хамт олны хурлын протоколд тэмдэглэгдсэн албан хаагчдын саналыг үндэслэн албан хэрэг хөтлөлтийн хэрэгцээнд хүчин чадал сайтай 4070,000 төгрөгийн үнэ бүхий зөөврийн компьютер 1ш-ийг худалдан авч, Аймгийн Засаг даргын дэмжлэгээр зөөврийн компьютер 1ш, Соёлын яамны санхүүжилтээр зөөврийн компьютер 1ш, олон үйлдэлт өнгөт принтер 1ш-ийг нийт 10,849,900 төгрөгийн техник, хэрэгслийг хүлээн авч үйл ажиллагаандаа ашиглаж байна.

- Албан хаагчдын “Амрах өрөө”-г тохижуулж, байгууллагын боломжоор ус буцалгагч, плитка тогоо, хоол хийх хэрэгсэл, буйдан, сандал, ширээ зэрэг тоног төхөөрөмж тавьж, цайны цагаар амрах, хооллох нөхцөлийг хангадаг бөгөөд 3 дугаар улиралд 200,000 төгрөгийн үнэ бүхий мини хөргөгч, 239,000 төгрөгийн үнэ бүхий ус буцалгагчийг авч ашиглаж байна.

- Зайлшгүй шаардлагаар илүү цагаар ажиллах болон цайны цагаар гарч хооллох боломжгүй үед ажилчдын өдрийн хоолыг ажил дээрээ хийж нэгдсэн журмаар хооллох, цай ундаар хангах ажлыг байгууллагаас зохион байгуулдаг. Жишээлбэл: Сумын 100 жилийн ойд зориулан гаргасан “Түүх бүтээсэн нэгэн зуун” 300 нүүр бүхий зурагт сэтгүүлийг эрхлэн гаргах ажлыг номын сангийн хамт олон гардан гүйцэтгэх ажил тухайн оны 5, 6, 7 дугаар саруудад үргэлжилж, өндөр ачаалалтай ажилласан тул хоол, цайг нэгдсэн журмаар байгууллага дээрээ зохион байгуулсан.

- Ажилчдыг хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх зорилгоор байрлуулсан “Теннисний ширээ” нь байнгын эрэлт хэрэгцээ ихтэй бөгөөд албан хаагчдын цайны цаг, чөлөөлт цагаараа тоглож, хөдөлгөөн хийх, хамтдаа цагийг өнгөрүүлэх, нийтэч уур амьсгал бүрдүүлэх, спортын ур чадвараа нэмэгдүүлэх ач холбогдолтой хэрэгсэл болдог.

- Албан хаагчдын ажлын хэрэгцээнд ашигладаг өдөр тутмын хувцасны нэг удаагийн ээлжийн хувцсыг үндэсний загвартайгаар 8 албан хаагчид 875,000 төгрөгийн өртөгөөр хийлгэж олгосон.

БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧДЫН НИЙГМИЙН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ:

- Байгууллага хамт олны зуны аяллыг зохион байгуулж, хамт олноороо “Хөвсгөл далай”-н аялалд явж, стресс ядаргаагаа тайлж, дурсамж бүтээсэн 3 өдрийг хамтдаа өнгөрүүлсэн.

- 2023 оны үр дүнгийн нэмэлт санхүүжилтээс хамт олны нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд зарцуулагдах 1676,300 төгрөгийн зардал болон үр дүнгийн урамшуулалд зарцуулах 1490,100 төгрөгийг 7 албан хаагчийг урамшуулахад хувилан зарцуулсан.

- “Тэрбум” мод хөтөлбөрийн хүрээнд албан хаагчдын хувийн аж ахуйг дэмжих үүднээс нийт 1200,000 төгрөгийн өртөг бүхий модны суулгацыг хандиваар авч 8 албан хаагчид хуваан тараалаа.

- Байгууллагын дотоод журамд заасны дагуу албан хаагчдад хувийн аж ахуй эрхлэх болон бусад шалтгаанаар цалинтай чөлөөг саадгүй олгож, илүү цагаар ажилласан 8 албан хаагч амралтаа нөхөж эдэлсэн.

- Байгууллагын албан хаагчдын “Орон сууцны судалгаа”, “Гэр бүлийн судалгаа”, “Банкны зээлийн судалгаа”, “Газар өмчлөлийн судалгаа”, “Шагнал, урамшууллын судалгаа”-г гаргаж, тухай бүр баяжилт хийж, Сумын түүхт 100 жилийн ойг тохиолдуулан байгууллагын 1 албан хаагчийг Соёлын яамны “Жуух бичиг”, 2 албан хаагчийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн тэргүүний ажилтан цол, тэмдэг, нийт 3 албан хаагчийг сумын ойн медалиар тус тус шагнуулсан.

- Байгууллагын албан хаагчдын цалин, урамшууллыг төрийн албаны болон хөдөлмөрийн хууль, тогтоомж, Засгийн газраас баталсан цалингийн шатлалын дагуу бүрэн олгож, байгууллагын төсвийн 78,6 хувийг зарцуулсан.

АРВАН НЭГ: БАЙГУУЛЛАГЫН АРХИВ, ТӨСӨВ САНХҮҮ, ДОТООД АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

11.1.Дотоод хяналтын ажлыг эрчимжүүлэх: Байгууллагын дотоод хяналтыг сайжруулах зорилгоор “Дотоод хяналт”-ын комиссыг Мандал сумын Нийтийн номын сангийн захирлын 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/27 тушаалаар шинэчлэн томилсон. Дотоод хяналтын комиссын гишүүд 1 удаа хуралдаж, 2024 оны төлөвлөгөө болон 2023 оны тайланг сонсож дүгнэлт хийж, уншигч үйлчлүүлэгчдээс орчин нөхцөл болоод номын санчдын харилцаа хандлагын судалгааг авч, дүгнэлээ. Дотоод хяналтын ажилтан нь номын сангийн үйл ажиллагааны ил тод байдал, эд хөрөнгийн ашиглалт бүрэн бүтэн байдал, ариутгал халдваргүйтгэл, уншигч үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж, үйлчилгээний орчин нөхцөлийн талаар судалгаа хийн, байгууллагын хяналтын камерын бичлэгт хяналт хийж, болзошгүй эрсдлээс сэргийлж байна. Одоогийн байдлаар ямар нэгэн зөрчил илрээгүй байна. Байгууллагад иргэдээс ирсэн өргөдөл, гомдол байхгүй, албан хаагчдаас ирсэн 4 ш өргөдөл, хүсэлтийг “Өргөдөл, гомдлын бүртгэлийн дэвтэр”-т бүртгэн тухай бүр шийдвэрлэж байна.


11.2.1 Хүний нөөцийн бүрдүүлэлт, ТАХ-ын хувийн хэрэг, цахим системийн бүртгэлийг хангах: Хүний нөөцийг бэлтгэх, мэргэжилтэй боловсон хүчнээр хангагдах зорилгоор 2 номын санчийг СУИС-ын Соёлын дээд сургуулиас зохион байгуулж буй “Номын сангийн үндэс” анхан шатны 3 кредитийн онлайн сургалтад хамруулж, сертификат эзэмшүүлж, 1 номын санчийг бакалаврын түвшний сургалтад хамруулж эхэллээ.



“Номын санч сонгож авах нээлттэй сонгон шалгаруулалт”-ыг 1 удаа зарлаж, сумын Хөдөлмөр эрхлэлтийн албанд хүсэлт гаргасан боловч мэргэжлийн номын санч олдохгүй мөн цаашид номын санч мэргэжлээр суралцаж, тогтвор суурьшилтай ажиллах хүн олдохгүй хүндрэлтэй нөхцөл байдалд ажиллаж байна.

Номын сангийн нийт албан хаагчдын мэдээллийг төрийн албан хаагчийн цахим бүртгэл, мэдээллийн системд бүрэн бүртгэж, Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 600 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар төрийн албан хаагчдын анкетыг шинэчилж, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 05-р дугаар тогтоол, 2019 оны 3-р тогтоолын дагуу, байгууллагын Захирлын 2023 оны А/03 тоот тушаалаар баталгаажуулан хувийн хэргийн баяжилт, бүрдүүлэлтийг тухай бүр хийж байна.

11.3 Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг хангах: Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн А/263 дугаар тушаалаар батлагдсан “Архивын байгууллагад дагаж мөрдөх галын аюулгүй байдлын дүрэм” болон Сэлэнгэ аймгийн Төрийн архивын 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн “Хэвлэмэл хуудас хийлгэх, хянуулах тухай” зөвлөмжийн дагуу дараах ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийг хангаж, Хэвлэмэл хуудасны дугаар буюу индекс өгөх зааврыг баримтлан байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтөд тусган ажиллаж байна.

-Байгууллагын АЛБАН БЛАНК-ыг Архивын ерөнхий газарт байгууллагын логотойгоор хэвлүүлэн хэрэглэж ирсэн.





Байгууллагын ЛОГО-г Logo design компаниар албан ёсоор хийлгэж, стандартын дагуу хэрэглэдэг.

-Байгууллагын бичиг баримтыг архивт журмын дагуу бүрдүүлж хадгаладаг бөгөөд аймгийн архивт зохих ёсоор хүлээлгэн өгч хадгалуулахдаа тушаал, шийдвэр зэрэг чухал хэрэгцээтэй бичиг баримтуудыг он оноор нь хувилан авч архивтай үлдээн хадгалдаг тул шаардлагатай бичиг баримтаа гарын дор хэрэглэх боломжийг бүрдүүлдэг.

-Байгууллагын ТЭМДЭГ-ийг журмын дагуу уйгуржин бичиг бүхий хэвлүүлж хэрэглэж ирсэн бөгөөд тэмдэг түших ажилтныг томилж түшүүлдэг.

-2025 онд төрийн албан хэрэгт уйгуржин бичиг хослон хэрэглэх шилжилтэд бэлтгэх зорилгоор Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас, түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага MNS 6395:2022 стандартын дагуу байгууллагын УЙГУРЖИН МОНГОЛ БИЧГИЙН ХЭВЛЭМЭЛ ХУУДСЫН ЭХ БЭЛТГЭЛ-ийг Архивын ерөнхий газарт хүсэлт хүргүүлэн эхийг бэлтгүүлж авлаа.



-Байгууллагын хаяг, хаягжилт, төрийн албан хаагчийн анкет, ажлын хавтас зэргийг бүрдүүлэх ажилд уйгуржин монгол бичгийг тусгаж, нэр хаягийг хос бичгээр үйлдэх ажлыг эрчимжүүлэн зохион байгуулахыг байгууллагын Захирлын 2023 оны А/31 тоот тушаалаар байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэн ажиллаж байна.

2024 онд байгууллагын 2023 оны үйл ажиллагааны бичиг баримтыг “Түр хадгалах хадгаламжийн нэгжийн баримт”, “Байнга хадгалах хадгаламжийн нэгжийн баримт”, “70 жилээр хадгалах хадгаламжийн нэгжийн баримт”-ыг архивын 20 нэгж болгон бүрдүүлж, байгууллагын архивын цахим программын судалгааг гаргаж сумын ЗДТГ-т хүргүүлж, архивын өрөөний чийгшил, баримт бичгийн хадгалалтад байнга хяналт тавьж, аймгийн Соёл, урлагийн газраас зохион байгуулсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах арга зүй”-н сургалтад 1 албан хаагч, сумын ЗДТГ-т зохион байгуулагдсан аймгийн архив, албан хэрэг хөтлөлийн цахим сургалтад 1 албан хаагч тус тус хамрагдаж,



Сумын гудамж, талбайн хаягжилт өөрчлөгдсөн тул албан бланкын эх хувийг засварлан аймгийн архивын тасгийн дарга Б.Хишигнямд хүсэлт гаргаж хэвлэмэл хуудасны эх загварыг хянуулж хэвлүүлэх зөвшөөрөл авлаа.

11.4 Санхүү, нягтлан бодох бүртгэлийн ажлыг хангах: Холбогдох хууль, журмуудын дагуу төсвийн зарцуулалтыг явуулж, тайлан мэдээг цаг хугацаанд нь гаргаж, өр авлага үүсгэлгүй ажиллаж, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээг журмын дагуу худалдан авч, “Шилэн данс”-нд 137 ш мэдээллийг оруулж, байгууллагын “Санхүүгийн ил тод байдал”-ын самбарт тайлант оны төсөв, санхүүгийн 16 мэдээллийг байрлуулан ил тод байдлыг хангаж, 2023 оны санхүүгийн баримтад хийгдсэн аудитын шалгалтаас эрсдэлгүй үнэлгээ авсан.

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 117 дугаар тогтоолын дагуу актлагдсан 5,021,257,70 төгрөгийн үнэтэй 11ш тоног төхөөрөмж, 2,946,581,95 төгрөгийн үнэтэй 15ш тавилга, эд хогшлыг 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр устгалд оруулж, “Тохилог хараа” ОНӨААТҮГ-т дуудлага өгч ачууллаа (Байгууллагын захирлын 2024 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/04 тоот тушаалаар устгасан).

Байгууллагын “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийг байгууллагын Захирлын 2023 оны А/36 дугаар тушаалаар шинэчлэн томилж, эд хөрөнгийн тооллогын ажлыг байгууллагын Захирлын 2023 оны А/37 дугаар тушаалаар зохион байгуулж, албан хаагчидтай хийх “Эд хөрөнгийн хариуцлагын гэрээ”-г шинэчиллээ.

Байгууллагын барилгын хувийн хэргийг “Барилга байгууламжийн хувийн хэрэг хөтлөх журам”-ын дагуу хөтөлж, зохих тэмдэглэлийг нөхөн тусгаж, бусад шаардлагатай баримтыг тусгай хавтсанд хийж бүрдүүлэн, Мандал сумын Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 01/256 дугаар албан бичгийн дагуу байгууллагын 3207СЭҮ улсын дугаартай UAZ фургон маркийн автомашины улсын бүртгэлийн дугаарыг холбогдох хууль тогтоомжийн дагуу цэнхэр дугаараар солиулах мөн тус автомашиныг түлш бага зарцуулдаг, суудлын машинаар солиулах хүсэлтээ аймгийн Төрийн өмчийн газарт тус тус хүргүүлсэн.

АРВАН ХОЁР: БАЙГУУЛЛАГЫН ОРЧНЫ НӨХЦӨЛИЙГ САЙЖРУУЛАХ СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД:

12.1.Сумын түүхт 100 жилийн ойг угтан байгууллагын орчны нөхцөлийг сайжруулан тохижилт, урсгал засварын ажлыг зохион байгуулж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх:

ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ТАВ ТУХЫГ ХАНГАХ

Байгууллагын цэвэр, цэмцгэр байдалд онцгой анхаарч ажилладаг бөгөөд үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжид нийцсэн цэвэр, тухтай орчныг бүрдүүлж ажилладагт уншигч, иргэд байнга талархалтай ханддаг нь манай байгууллагын давуу тал юм. Үүнд:

Дотоод тохижилт, үйлчилгээ:

- Уншлагын танхимуудад уншигчид хэрэглэх халуун, хүйтэн усаар тогтмол үйлчлэх ус буцалгагч, нэг удаагийн аяга, утас, нөөтбүүк цэнэглэх залгуур зэрэг ойр зуурын хэрэгцээт зүйлийг бэлдэж тавьсан, интернэт WI-FI чөлөөтэй үнэ төлбөргүй хэрэглэх боломжтой код нээлттэй, ариун цэврийн тохилог өрөөтэй бөгөөд цэвэрлэгээ, үйлчилгээг маш сайн хийдэг, үүдний зааланд зөөлөн сандал, буйдан,

ширээ, утас, нөөтбүүк цэнэглэх залгуур, сэтгүүл, сонин зэргийг боломжийн хэрээр хангалттай байрлуулж, цэцэгжүүлэлт сайн хийсэн тул байгалийн бяцхан таашаал авах боломжтойгоор уншигчид чөлөөтэй сууж амрах нөхцөлийг бүрдүүлсэн.

- Дотоод хаяг, хаягжилт сайн, кирил, уйгуржин бичиг, англи хэлээр хослон хэвлүүлсэн, цэвэр үзэмжтэй тул уншигч, үйлчлүүлэгчид ойлгомжтой, мэдээлэл авахад хялбар, жижүүр, номын санч нар уншигчдыг хүлээн авч чиглүүлэх ажлыг хариуцлагатай хийж, шаардлагатай мэдээллээр хангаж, нийтийн болон Хүүхдийн уншлагын танхим тус бүр чөлөөт сонголт бүхий номын фондтой тул уншигч өөрт шаардлагатай, таалагдсан номыг чөлөөтэй сонгож унших боломжийг бүрдүүлж, цаасан болон электрон каталог хослосон номын мэдээллийн баазтай тул уншигч хайсан номоо фондоос хялбар олох боломжтой зэрэг олон давуу талтай ажиллаж байна.



- Дотор тохижилтод нийт 1460,000 төгрөгийн үнэтэй 2 ш буйдан, 2 ш сэтгүүлийн ширээг хандиваар, 1970,200 төгрөгөөр 2 ш ус буцалгагч, 2 ш хивсэнцэр, мини хөргөгч, 2 ш шалавч, 4 ш цонхны хөшиг, 1 ш уншигчийн картын хайрцаг худалдан авч, архивын өрөөний тогны монтаж, суултуурын татуурга, гал хамгаалагч, хяналтын камерын станцыг тус бүр засахад 225300 төгрөгийг зарцуулсан.

Гадна тохижилт болон бусад засвар үйлчилгээ:

- Сумын 100 жилийн ойн хүрээнд байгууллагын орчны өнгө үзэмжийг сайжруулах үүднээс барилгын дээврийн хүрээнд 30 м лед гэрэл, байгууллагын өмнөх талбайдаа гэрэлт байгууламж хийх 105 м лед гэрэл, 5 ш урт чимэглэлийн гэрэл, шонтой гэрлийн шилэн бүрхүүл 9 ш зэргийг суурилуулахад 1719,000 төгрөг, 40смх200см хэмжээтэй уйгуржин монгол бичигтэй гэрлэн хаяг 596,000, гадаа байрлуулдаг ангилдаг хогийн сав хийлгэхэд 460,000 төгрөг, хогийн цэгийн блокон ханыг шохойдож, таг хийхэд 9000 төгрөг, үндсэн фонд болон архивын өрөөнд агааржуулах систем хийж, дотор өрөөний 4 ш хаалгыг засварлахад нийт 3172,500 төгрөгийг тус тус зарцуулсан.



- Байгууллагын хашаанд ургадаг 6 нэрийн 200ш орчим мод бутны зуны усалгаа, намрын арчилгаа, тайралтыг хийж, хашаа хайсыг нь сэргээн будаж, 5 ш мод нэмж тарьж, 8ш мандалд тарьсан 12 төрлийн гоёлын цэцгийг арчилж, ургуулж, өнгө үзэмжтэй зун, намрыг үдэж, хотын үзэмжид өнгө нэмсэн эко ногоон, цэвэр цэмцгэр орчинг бүрдүүлж чадсан.



Сантехникийн шугам хоолойн өнөөгийн нөхцөл байдал, засвар үйлчилгээ, өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах: Байгууллагын доторх сантехникийн шугам болон гадна байгууламжийн дулаан, цэвэр усны шугамын далд лоткид булагдсан 95 м шугам нь 2006 оноос их засвар хийгдээгүй, хагарч муудан усны алдагдал

гардаг, дотор сантехникийн шугам мөн маш муудсан хүндрэлтэй нөхцөлд ажиллаж байна.

Сумын Засаг даргын дэмжлэгтэйгээр 8105,000 төгрөгийн санхүүжилтээр байгууллагын байрны доторх халаалтын шугам, хоолойг хэсэгчлэн шинэчлэн засварлах ажлыг “Мандал Энерго” ОНӨТҮГ-аар хийлгэж, байгууллагын цэвэр усны тоолуурыг мэргэжлийн байгууллагаас баталгаажуулсан 75,900 төгрөгийн үнэтэй тоолуураар сольж, хүүхдийн уншлагын танхим, үүдний заал, “Амрах өрөө”-ны паар болон ариун цэврийн өрөөний цэвэр усны крант, суултуур, гар угаагуурын бохирын уян хоолой тус тус хуучирч муудсаныг засаж, шинээр сольж, шинэ паар, шугамуудыг будахад 98,000 төгрөгийг зарцуулж, цонх, хаалганы дулаалга, сантехникийн үзлэг зэргийг хийж өвөлжилтийн бэлтгэлийг хангаж байна.



Цэвэрлэгээ, үйлчилгээ:

▪ Сумын Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 тоот захирамж, 2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн А/339 тоот захирамж тус бүрийн хүрээнд байгууллагын хуваарьт 50м хүртэлх нийтийн эзэмшлийн талбай, авто болон явган хүний замын цасыг 1 удаа, хог хаягдлыг 1 удаа, байгууллагын Захирлын шийдвэрээр 4 удаа тус бүр цэвэрлэгээний ажлыг зохион байгуулж, цас орох бүрд цэвэрлэгээг тогтмол зохион байгуулж, халтиргаа гулгаа үүсэхээс сэргийлж, хог хаягдалгүй, цэвэр цэмцгэр орчныг бүрдүүлж, байгууллагын байрны дотор их цэвэрлэгээг 2 удаа зохион байгууллаа.



• Мандал сумын Минжийн хангайн 7 дугаар багийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 99 тоот албан бичгийн дагуу байгууллагын хашаанд 5 ширхэг мод нэмж тарьж, төрөлжсөн хогийн сав байрлуулж, хашаа хайсны өнгө үзэмжийг сайжруулж, 65,000 төгрөгөөр 12 төрлийн мандлын гоёлын цэцгийн үрийг тариалж, усалгаа арчилгааг тогтмол хийж ургуулж байна.



• Бохир ус тээвэрлэхэд “Цант Орхон” ОНӨААТҮГ, хог хаягдлыг ачуулахад “Тохилог Хараа” ОНӨААТҮГ, дулаан, цэвэр усны шугамын сантехникийн засварыг “Мандал энерго” ОНӨААТҮГ байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

АРВАН ГУРАВ: ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ, ОЛОН НИЙТИЙН АЖЛЫН ОРОЛЦООГ САЙЖРУУЛАХ СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД:

13.1.Дээд шатны байгууллага удирдлагаас өгөгдсөн хугацаатай үүрэг даалгаврыг биелүүлж, хэрэгжилтийг хангах, номын сангийн үйл ажиллагаанд холбогдох тайлан мэдээг тухай бүр гаргах: Засгийн газрын болон аймаг, сумын Засаг даргын мөрийн хөтөлбөр, аймаг, сумын хөгжлийн төлөвлөгөө, Үндэсний зорилтот хөтөлбөрүүд болон бусад холбогдох эрхзүйн баримтын хүрээнд зохион байгуулсан ажлын биелэлт, байгууллагын сар, улирлын ажлын мэдээ, тайлан, холбогдох судалгаа, статистик мэдээ, тайлангуудыг тухай бүр, хуулийн хугацаанд гаргаж, холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлж байна. Соёлын салбарын статистик мэдээ, тайланг хийх цахим сургалтад 2 удаа давхардсан тоогоор 4 хүнийг хамруулж, мэдээллээр хангагдсан.

13.2 Төв, орон нутгаас зохион байгуулж буй цаг үеийн шаардлагатай ажлуудад болон сумын 100 жилийн ойд зориулсан номыг эрхлэн гаргах ажилд хамт олноороо оролцох, нийгмийн хариуцлагаа биелүүлэх:

- **Сумын түүхийн дурсгалт, бахархалт газруудыг тогтоох ажилд оролцох:** Сэлэнгэ аймгийн Мандал сумын Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 3/216 дугаар албан бичгийн хэрэгжилтийг хангаж, Мандал сумын нутаг дэвсгэрийн 55 байршилд буй 152 ш соёлын үл хөдлөх дурсгалт зүйлсийг тогтоосон тул уг соёлын үл хөдлөх өвүүдийг Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 15, 16, 17 дугаар зүйлүүдэд заасан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Сумын Засаг даргын Соёлын өвийн талаар хэрэгжүүлэх бүрэн эрхийн дагуу “Сумын хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалт”-д оруулан баталж, хадгалалт, хамгаалалтыг хангах саналыг Сумын Засаг даргын тамгын газарт хүргүүллээ.

- **Сумын ЗДТГ-ын сонсголд мэдээлэл хийх:** Мандал сумын Засаг даргын тамгын газрын шинэ долоо хоногийн өглөөний сонсголд “Ном уншихын ач холбогдол” сэдэвт мэдээллийг 1 албан хаагч хийж, 60 орчим хүнд хүргэлээ. Мөн дээрх сонсголд “Сумын түүхэн дурсгалт газрууд” сэдвээр 1 албан хаагч мэдээлэл хийж 60 гаруй хүнд мэдээлэл хүргэлээ.

-**Явган алхалт:** Мандал сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 03/101 тоот албан бичгийн дагуу 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 09:00 цагт Соёмбот талбайд зохион байгуулагдах “Уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд эрүүл, аюулгүй хөдөлмөр эрхэлцгээе” уриатай явган алхалтад 5 албан хаагч жигд хувцастай, уриа лоозонтой оролцлоо.

-**Хариуцлагатай жижүүр:** Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх олон нийтийн ажилд оролцох байгууллагын бэлтгэл бэлэн байдлыг хангаж, сумын Засаг даргын тамгын газрын байранд хуурайшилтын онцгой үед ажиллах жижүүрийн үүрэг гүйцэтгүүлэхээр 2024 оны 06 сарын 01-ний өдрийн 08.00 цагаас 18.00 цаг хүртэл албан хаагчдыг хуваарилан ажиллууллаа.

-Номын санчдын анхдугаар чуулган:

Сэлэнгэ аймгийн номын санчдын анхдугаар чуулга уулзалтад байгууллагын 2 албан хаагч 2024.05.17-ны өдөр хамрагдлаа. Тус чуулганаар аймгийн хэмжээнд 60 орчим номын санчид оролцож, номын сангийн тулгамдсан асуудал, цаашид хэрхэн хөгжих талаар ярилцаж туршлага солилцлоо. Анхдугаар чуулган нь 35 дахь номын баярын хүрээнд болж буйгаараа онцлог байлаа.



-Нийгмийн эрүүл мэндийг дэмжих арга хэмжээ:
“Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил-2024” арга хэмжээнд байгууллагын 3 албан хаагч хамрагдаж, эрүүл мэндийн зөвлөмж үйлчилгээ авлаа.



-“Тэрбум мод” үндэсний

хөтөлбөрт оролцох: Мандал сумын Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/155 тоот албан бичиг болон мөн сумын Засаг даргын 2024 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн А/309 дүгээр захирамжийн хэрэгжилтийг тус бүр хангаж, 100 ш бургас модны суулгацыг 250,000 төгрөгөөр худалдан авч “Хараа гол”-ын эрэг дагуу тарьсан.



-Сумын Түүхт 100 жилийн ойн үндэсний баяр наадмын арга хэмжээнд оролцох: Сумын үндэсний баяр наадмын арга хэмжээний жагсаалд хамт олноороо үндэсний хувцсаар жигдрэн оролцлоо.



13.3 Сумын 100 жилийн ойд зориулсан “Түүх бүтээсэн нэгэн зуун” сэтгүүлийг эмхтгэн гаргах ажлыг зохион байгуулах:

- Нийтийн номын сан нь Сумын түүхт 100 жилийн ойд зориулсан 200 нүүр бүхий “Түүх бүтээсэн нэгэн зуун” сэдэвт сэтгүүлийг эрхлэн гаргах ажлыг зохион байгуулж, байгууллага, аж ахуйн нэгжүүд, алдартан гавьяатнууд, орон нутгийн үе үеийн удирдлагын ярилцлага, хөрөг, гар бичмэл, товч танилцуулгыг цуглуулах, түүхийн холбогдолтой болон байгалийн үзэсгэлэнт газруудын фото зургууд гэх мэт бүхий л материалыг цуглуулж эмхэтгэн, хэвлэлийн эх бэлтгэлд хүлээлгэн өгч хэвлүүлэв.

13.4 Соёлын салбарын хүүхэд хамгааллын бодлого, түүнийг хэрэгжүүлж, байгууллагын “Эцэг эхийн зөвлөл”-ийн үйл ажиллагааг сайжруулан, эрчимжүүлэх:

Байгууллагын “Эцэг эхийн зөвлөл”-өөс “Хүүхдээ сонсьё-II” аяныг байгууллагын хэмжээнд хэрэгжүүлж эхлэн, “Хүүхэд хүмүүжүүлэх арга” сургалтыг 1 удаа ажлын байранд зохион байгуулж, 6 албан хаагчийг хамруулж, байгууллагын захирлын 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/05 тоот “Хүүхдийн эрхийг хамгаалах эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга зүйн хэрэгжилтийг хангах тухай”

тушаалыг гаргаж, номын сангийн үйлчилгээнд хүүхдийн эрхийг хамгаалах ажлыг баталгаажуулан ажиллаж, сумын ЗДТГ-ын 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 03/149 дүгээр албан бичгийн хэрэгжилтийг хангаж, байгууллагын албан хаагчдын хүүхдүүд болон тэргүүний уншигч хүүхдүүдийг хамруулан “Хүүхдийн баяр”-ын арга хэмжээг зохион байгуулж, “Эцэг эхийн зөвлөл”-өөс 9 албан хаагчийн 13 хүүхдэд 585,000 төгрөгийн гарын бэлэг гардуулж, бяцхан хүлээн авалт, урлагийн тоглолтоор бэлэг барилаа. Мөн шинэ жил бэлгийн зардалд 13 хүүхдэд нийт 700,000 төгрөгийг зарцуулсан.



АРВАН ДӨРӨВ: ХУУЛЬ ЭРХЗҮЙН ХЭРЭГЖИЛТИЙГ САЙЖРУУЛЖ УДИРДЛАГЫН МАНЛАЙЛЛЫГ ХАНГАХ СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫН ХҮРЭЭНД:

14.1 Төрийн болон номын сангийн үйл ажиллагаатай холбоотой хууль, тогтоомжийн биелэлтийг хангаж иргэдэд үйлчлэх төрийн үйлчилгээг сайжруулах, албан хаагчдын ажлын хариуцлага, биелэлтийг сайжруулж, “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг сайжруулах нь” хөтөлбөрийн хүрээнд хууль эрхзүйн мэдлэгийг нэмэгдүүлэн, төрийн албан хаагчийн ёс зүйг сахиулж, авлига, ашиг сонирхлын зөрчил болон гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх:

Төрийн албаны хуулийг хэрэгжилтийг хангаж, удирдлагын манлайллыг хэрэгжүүлэн, сахилга хариуцлага, дэг журмыг чангатгаж, хамт олны эв нэгдлийг дээдлэн, иргэдэд ээлтэй төрийн үйлчилгээг бэхжүүлэх үүднээс Төрийн албаны болон бусад холбогдох хууль, тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон байгууллагын ажлын зохион байгуулалтыг сайжруулах, үр дүнг дээшлүүлэх зорилгоор “Удирдлагын баг”, “Мэргэжил-аргазүйн алба”, “Аж ахуйн алба”, “Тамшгаас хамгаалах штаб”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус байнгын комисс”, Дотоод хяналтын комисс”, “Баримт бичиг нягтлан шалгах комисс”, “Эцэг, эхийн зөвлөл”, “Ёс зүйн зөвлөл”, “Ариутгал халдваргүйтгэлийн баг” гэсэн ажлын хэсгүүдийн бүрэлдэхүүнтэйгээр хууль, эрхзүйн хэрэгжилтийг ханган ажиллаж, байгууллагын “Хуулийн мэдээллийн сан”-г нэмэгдүүлэн баяжуулж байна.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн дагуу Байгууллагын захирлын 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/08 тоот тушаалаар байгууллагын “Ёс зүйн зөвлөл”-ийг “Ёс зүйн дэд хороо” болгон өөрчлөн зохион байгуулж, албан хаагчдын ёс зүйн мэдлэг, чадварыг дээшлүүлж, “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 258 дугаар тогтоолын дагуу төрийн албаны ёс зүй, сахилга хариуцлага, дэг журмыг чанд сахиж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэн, хүний эрх, жендэрийн эрх тэгш байдлыг дээдлэн, алдаа

дутагдал гаргахгүй ажиллах талаарх мэдээллийг албан хаагчдад тогтмол хүргэн сануулж, боловсон хүчинтэй холбоотой тушаал шийдвэрт тогтмол тусган, албан хаагчдад “Ёс зүйн зааварчилгаа”-г томилолтоор ажиллах болон бусад шаардлагатай тохиолдолд ээлжит болон ээлжит бусаар тогтмол өгч хэвшин, байгууллагын “Ёс зүйн дэд хороо”-ны ажлыг эрчимжүүлж, баримт бичгийн бүрдлийг сайжруулан, тусгай хавтсанд хийж бэлэн болголоо.

Байгууллагын албан хаагчдын ажлын уялдаа холбоог сайжруулах, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, ажлын гүйцэтгэлд анхан шатанд нь хяналт тавих зорилготой Номын сангийн Мэргэжил -аргазүйн албаны номын санчдын болон аж ахуйн албаны албан хаагчдын "Эртэч уулзалт"-ыг зохион байгууллаа. Албан хаагчдын ажил үүргийн биелэлтийн үр дүнг тооцон “Эртэч уулзалт” арга хэмжээг 1 удаа зохион байгуулан улирлын ажлыг үнэлж, дүгнэн “Тайлангийн үр дүнгийн хурал”-ыг зохион байгуулж, ажлын явц, үр дүн, шинэ арга туршлагаа харилцан ярилцаж, 2024 онд “Уншигчаа дээдэлж, соёлч үйлчилгээг эрхэмлэе ” уриаг ажил үйлчилгээндээ эрхэм болгон ажиллах зорилт тавьж, байгууллагын албан хаагчдын ажлын байрны соёлжилт, дэг журмыг хангаж, хувцаслалт, хувийн соёлд тавигдах шаардлагын “Соёл” журмыг баталж, 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлэн ажиллаж байна.



Иргэдэд номын сангийн үйлчилгээг хүндрэл чирэгдэлгүй хүргэх, уншигчдын сэтгэл ханамжийг дээшлүүлэх зорилгоор “Эелдэг харилцаа, ээлтэй үйлчилгээ” уриан дор номын сангаас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Уншигчаа сонсьёе” аян, “Хөтөч номын санч”-ийн үйлчилгээгээр дамжуулан уншигчдадаа хүрч үйлчилж, “Үйлчилгээний ажилтны авир төрхийн шаардлагууд”-ыг дагаж мөрдөн, төрийн албан хаагчийн мөрдөх зарчим, журам, ёс зүйн талаарх мэдээллүүдийг албан хаагчдын өөрийгөө хөгжүүлэх хэрэгцээнд нь хувиран тарааж, мэдээллийн самбарт байрлуулан, үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор дуу, дүрсний нягтаршил сайтай 10ш өнгөт хяналтын камераар орчноо хянаж байна.

Уламжлалт “Цагаан сарын баяр”-аар хариуцлагатай эргүүл жижүүрүүдийг хуваарийн дагуу ажиллуулж сумын тамгын газрын 70367010 утсанд өдөрт гурван удаа мэдээгээ өгч ажиллалаа. Мөн Мандал сумын Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 01/124 тоот захирамжийн дагуу цаг үеийн байдалд тохируулан байгууллагын хариуцлагатай жижүүрийг 2024 оны 02 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн 2024 оны 03 дугаар сарын 24-ний өдрийг дуустал ажиллуулж, хариуцлагатай жижүүрүүд цаг үеийн мэдээг 08:30, 14:30, 20:30 цагт сумын шуурхай штабын 70367010 дугаарын утсанд өгч ажиллалаа.

Зохиогчийн эрхийн хуулийг дээдэлж, номын сангийн үйл ажиллагаа, ном уншлага, соёл олон нийтийн ажил явуулах, цахим мэдээлэл түгээхдээ оюуны өмчийг зөрчихгүй байхад анхаарч, албан хаагчдыг оюуны өмчтэй холбоотой гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахыг байгууллагын Захирлын 2023 оны А/30 дугаар тушаалаар албан хаагчдад үүрэг болгон ажиллаж, хэрэгжилтийг хангаж байна.

Байгууллагын хэмжээнд авлигын эсрэг үйл ажиллагааг зохион байгуулж, авлигын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, албан хаагчдын мэдлэгийг нэмэгдүүлэх, олон нийтэд мэдээлэл түгээх ажлыг зохион байгуулах 7 заалттай төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж, АТГ-аас бэлтгэсэн шторк, инфографик, нийтлэл, зурагт хуудас зэргийг байгууллагын Сэлэнгэ Мандал номын сан Facebook хуудсанд байрлуулж, олон нийтэд 5 удаа мэдээлэл хүргэж, авлигын эсрэг нөлөөллийн арга хэмжээ “Авлиггүй хамт олон” өдөрлөгийг 1 удаа, “Авлигын хор уршиг” эсээ бичлэгийн уралдааныг 1 удаа зохион байгуулж, идэвхтэй оролцсон албан хаагчдыг шагнаж урамшуулж, авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах “Шударга ёс, хөгжил дэвшилд 110” мэдээллийн самбар ажиллуулж, мэдээллийг 2 удаа шинэчлэн байрлуулж, албан хаагчдын дунд “Авлигын тухай сургалт, мэдээлэл”-ийг 1 удаа зохион байгуулж, 8 албан хаагчийг хамруулсан.

Дээрх ажлуудын үр дүнд багаар ажиллаж чаддаг, нэг санаа зорилготой, хамт олонч, нөхөрсөг уур амьсгал бүхий хамт олныг бүрдүүлж, албан хаагчдын ажлын хариуцлага, биелэлтийг хангаж, авлига, гэмт хэрэг, ёс зүйн зөрчлүүдээс урьдчилан сэргийлж ажиллаж байна.

14.2 Байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээллийг иргэдэд ил тод, шуурхай хүргэж, нийгмийн хариуцлагын хүрээнд иргэдэд аливаа эрсдэлээс хамгаалах мэдлэг олгох мэдээллийг тогтмол хүргэх: Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор батлагдсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”-ийн хэрэгжилтийг хангаж, цахим орчинд, Байгууллагын үйл ажиллагааны талаарх өдөр тутмын мэдээлэл болон СОНА-ын талаарх мэдээллийг Сэлэнгэ Мандал номын сан цахим хуудсанд 58 удаа тус тус оруулж 5618 хандалттай ажиллаж байна.

Байгууллагын үйл ажиллагааны талаарх өдөр тутмын мэдээлэл болон СОНА-ын талаарх мэдээлэл	58	5618
--	----	------

Мэдээллийн самбар-т, байгууллагын танилцуулга, уриа, номын сангийн үйлчилгээний журам, Номын сангийн холбогдолтой хууль дүрэм, байгууллагын захирлын тушаал, зөвлөгөө, зөвлөмж, шинэ номын мэдээлэл, сарын мэдээ тайлан зэрэг мэдээллийг 6 удаа шинэчлэн тавьсан.

Нийгмийн хариуцлагын хүрээнд иргэдэд аливаа эрсдэлээс хамгаалах мэдлэг олгох мэдээллийг тогтмол хүргэх: Сэлэнгэ Мандал номын сан цахим хуудсанд танин мэдэхүй, эрүүл мэндийн талаарх мэдээлэл, хүчирхийллийн эсрэг мэдээ мэдээллийг нийт 25 удаа иргэдэд хүргэж, 1274 хандалттайгаар ажиллаж байна.

Танин мэдэхүй, эрүүл мэндийн талаарх мэдээлэл	23	700
---	----	-----

Хүчирхийлэлд өртөх эрсдэлээс сэргийлэх зөвлөмж	2	574
--	---	-----

14.3 “Уншигчаа сонсьё” аяныг уламжлал болгон зохион байгуулж, хэрэглэгчийн үнэлгээний судалгааг гаргаж, судалгааны мөрөөр ажил зохион байгуулах: Байгууллагад иргэдээс ирсэн өргөдөл, гомдол байхгүй. Албан

хаагчдаас ирүүлсэн 4 ш өргөдөл, хүсэлтийг тухай бүр шийдвэрлэж, хариуг шуурхай өгч ажиллаж байна.

Уншигчдын санал, хүсэлтийг сонсох, номын сангийн үйл ажиллагаа, үйлчилгээний түвшинд үнэлгээ хийх, ажил сайжруулах үүднээс жил бүр уламжлал болгон “Уншигчаа сонсьё” аяныг зохион байгуулж, уншигч, иргэдээс санал хүсэлт, судалгааг авч үйл ажиллагаандаа тусган ажиллаж байна.

- Хэрэглэгчийн үнэлгээний судалгаа: Түүврээр 27 уншигч үйлчлүүлэгчээс, номын сангийн тохижилт үйлчилгээ, номын санч, туслах ажилчдын харилцаа хандлагын талаар судалгаа, санал хүсэлт ирсэн байна.

№	Асуулт	Хариултын тоо буюу нийт 5 хүний сэтгэгдэлээс эзлэх хувь		
		Тийм	хааяа	үгүй
1	Та номын сангаар тогтмол үйлчлүүлдэг үү	20 буюу 74.1 %	7 буюу 25.9%	
		Сайн	Дунд	
2	Номын санчдын үйлчилгээний талаарх таны бодол	22 буюу 81.5 %	5 буюу 18.5 %	-
3	Номын санчдын харилцаа, хандлагын талаарх таны бодол	Сайн 19 буюу 70.4 %	Дунд 8 буюу 29.%6	
4	Та уншихыг хүссэн номоо тухай бүртээ авч уншиж чаддаг уу	Чаддаг	Заримдаа	Чаддаггүй
5	Гэрээр ном олгох үйлчилгээгээр ном зохиолоо авч уншиж чаддаг уу	23 буюу 86.1%	3 буюу 11.2%	1 буюу 2.7 %
6	Номын сангийн удирдлагад хүргүүлэх таны санал	Номын сангийн ном уншлагын орчныг сайжруулах, тухтай сууж унших булантай болох		

- Санал хүсэлтийн хайрцаг: Санал хүсэлтийн хайрцгаар уншигчдаас 5 санал ирсэн.



- Сэлэнгэ Мандал Номын сан цахим хуудас: Мөн байгууллагын цахим хуудсанд уншигчдын сэтгэгдэл бичигдэж байна.

Шийдвэрлэсэн байдал:

№	Санал	Хүрсэн үр дүн
1	Нийтийн уншлагын танхимын тохижилтыг сайжруулах	Нийтийн уншлагын танхимд ном уншлагын кабинуд хийж байрлуулан, номын тавиурыг өөрчилж, танхимын дотор засвар тохижилт хийсэн.
2	Уншигчдад хэрэгцээт үйлчилгээг хүргэх	Уншигчдын цай уух боломжийг хангаж, “Мини буфет” ажиллуулж, халуун цай, кофе, бургер, жигнэмэг зэргээр үйлчилж байна.

ХАВСРАЛТ

1. Ном олголт

№	Номын сан	Стандарт хэмжээ	Үйлчилсэн тоо хэмжээ
26	Улаанбаатар ХоТНС	112500	147655
25	Орхон	112500	128656
24	Дорнод	55000	114621
23	Дархан АТНС	112500	76862
22	Дархан ХНО	55000	74684
21	Ховд	55000	63688
20	Хөвсгөл	55000	62671
19	Хэнтий	55000	62330
18	Архангай	55000	57749
17	Баян-Өлгий	55000	57400
16	Өмнөговь	55000	57293
15	ХүТНС	112500	50004
14	МҮНС	130000	49469
13	Дундговь	55000	43006
12	Сэлэнгэ	55000	35589
11	Сэлэнгэ Мандал	55000	35443
10	Төв	55000	35323
9	Баянхонгор	55000	31904
8	Өвөрхангай	55000	30847
7	Увс	55000	24356
6	Говь-Сүмбэр	55000	18847
5	Булган	55000	17662
4	Сүхбаатар	55000	17615
3	Дорноговь	55000	13280
2	Говь-Алтай	55000	9481
1	Завхан	55000	8808

2. Ирц

№	Номын сан	Тоо хэмжээ
26	Дорнод	82028
25	Улаанбаатар ХотHC	70461
24	Орхон	66676
23	Дархан ХНО	61526
22	Дархан АТНС	56950
21	МҮНС	49520
20	Ховд	46532
19	Хэнтий	43644
18	Баян-Өлгий	32100
17	Хөвсгөл	31581
16	ХүТНС	29004
15	Сэлэнгэ Мандал	21558
14	Архангай	20412
13	Өвөрхангай	19897
12	Өмнөговь	19383
11	Булган	19207
10	Сэлэнгэ	15610
9	Дундговь	14049
8	Төв	13633
7	Баянхонгор	13508
6	Сүхбаатар	11786
5	Дорноговь	9760
4	Увс	9180
3	Говь-Алтай	8765
2	Говь-Сүмбэр	7117
1	Завхан	6688

3.Байнгын уншигчид эзлэх ирцийн хувь, хэмжээ

№	Номын сан	Стандарт хэмжээ	Байнгын уншигч	Ирц
26	Дорнод	3800	82028	82028
25	Улаанбаатар ХотНС	7500	25115	70461
24	Орхон	7500	61465	66676
23	Дархан ХНО	3800	4617	61526
22	Дархан АТНС	7500	5456	56950
21	МҮНС	8000	12240	49520
20	Ховд	3800	2539	46532
19	Хэнтий	3800	6216	43644
18	Баян-Өлгий	3800	18801	32100
17	Хөвсгөл	3800	18880	31581
16	ХүТНС	7500	32999	29004
15	Сэлэнгэ Мандал	3800	5001	21558
14	Архангай	3800	2840	20412
13	Өвөрхангай	3800	662	19897
12	Өмнөговь	3800	4242	19383
11	Булган	3800	2995	19207
10	Сэлэнгэ	3800	3980	15610
9	Дундговь	3800	3080	14049
8	Төв	3800	2087	13633
7	Баянхонгор	3800	2645	13508
6	Сүхбаатар	3800	2986	11786
5	Дорноговь	3800	1150	9760
4	Увс	3800	9606	9180
3	Говь-Алтай	3800	7765	8765
2	Говь-Сүмбэр	3800	785	7117
1	Завхан	3800	3014	6688

4. Сан хөмрөгийн баяжилт

№	Номын сан	Тоо хэмжээ
26	Улаанбаатар ХоТНС	5707
25	Дархан АТНС	2360
24	МҮНС	2245
23	Төв	2119
22	Сэлэнгэ Мандал	1744
21	Өмнөговь	1170
20	ХүТНС	1011
19	Увс	837
18	Дархан ХНО	749
17	Хөвсгөл	643
16	Өвөрхангай	554
15	Ховд	540
14	Сэлэнгэ	518
13	Говь-Сүмбэр	507
12	Баян-Өлгий	499
11	Сүхбаатар	481
10	Булган	461
9	Баянхонгор	452
8	Хэнтий	426
7	Дундговь	420
6	Орхон	395
5	Дорнод	367
4	Дорноговь	349
3	Завхан	322
2	Говь-Алтай	243
1	Архангай	71

5. Сан хөмрөгийн баяжилтад худалдаж авсан номын тоо

№	Номын сан	Нийт баяжилт	Худалдаж авсан
26	Улаанбаатар ХоТНС	5707	1310
25	МҮНС	2245	908
24	Дархан ХНО	749	736
23	Хөвсгөл	643	518
22	Өмнөговь	1170	496
21	ХүТНС	1011	478
20	Өвөрхангай	554	413
19	Булган	461	373
18	Увс	837	361
17	Сэлэнгэ	518	344
16	Говь-Сүмбэр	507	289
15	Сүхбаатар	481	279
14	Ховд	540	252
13	Баянхонгор	452	249
12	Дорноговь	349	236
11	Баян-Өлгий	499	224
10	Орхон	395	198
9	Завхан	322	186
8	Хэнтий	426	185
7	Дундговь	420	171
6	Төв	2119	167
5	Сэлэнгэ Мандал	1744	157
4	Дархан АТНС	2360	146
3	Говь-Алтай	243	96
2	Дорнод	367	74
1	Архангай	71	71

6.Сан хөмрөгийн эргэлт

№	Номын сан	Олголт	Сан хөмрөг тоо	Эргэлтийн хувь
26	Дархан ХНО	74684	16610	450
25	Орхон	128656	36222	355
24	Дорнод	114621	73580	156
23	Хэнтий	62330	45727	136
22	Өмнөговь	57293	44871	128
21	Дархан АТНС	76862	61509	125
20	Сэлэнгэ Мандал	35443	30159	118
19	Дундговь	43006	42332	102
18	Төв	35323	36298	97
17	Баян-Өлгий	57400	60444	95
16	Хөвсгөл	62671	69188	91
15	Ховд	63688	76482	83
14	Сэлэнгэ	35589	47714	75
13	Говь-Сүмбэр	18847	13680	71
12	Баянхонгор	31904	51013	63
11	Өвөрхангай	30847	49615	62
10	ХүТНС	50004	90500	55
9	Булган	17662	36093	49
8	Архангай	57749	127199	45
7	Улаанбаатар ХоТНС	147655	390120	38
6	Сүхбаатар	17615	51924	34
5	Увс	24356	72993	33
4	Дорноговь	13280	40321	33
3	Говь-Алтай	9481	48358	20
2	Завхан	8808	56976	15
1	МҮНС	49469	2758687	2

7.Хүн амын хэдэн хувьд олголт хийсэн

№	Номын сан	Үйлчлэх хүн ам	Нийт олголт	Хүн амд эзлэх хувь
26	Архангай	20369	57749	295
25	Төв	17152	35323	218
24	Дорнод	47275	114621	210
23	Ховд	34173	63688	165
22	Орхон	106411	128656	126
21	Баян-Өлгий	45420	57400	125
20	Увс	31727	24356	123
19	Хөвсгөл	46541	63688	123
18	Дундговь	45900	43006	90
17	Булган	15357	19662	89
16	Говь-Сүмбэр	10876	18847	89
15	Сүхбаатар	20999	17615	84
14	Дархан АТНС	89130	76862	78
13	Өмнөговь	31205	57293	76
12	Хэнтий	28148	62330	75
11	Дархан ХНО	89130	74684	69
10	Завхан	16005	8808	67
9	Дорноговь	46443	13280	55
8	Говь-Алтай	18723	9481	54
7	Баянхонгор	32711	31904	48
6	Сэлэнгэ Мандал	26481	35443	43
5	Өвөрхангай	36481	30847	42
4	Сэлэнгэ	36399	35589	40
3	Улаанбаатар ХоТНС	1734848	147655	8
2	МҮНС	1734848	49469	3
1	ХҮТНС	1734848	50004	3

8.Лавлагаа

№	Номын сан	Лавлагааны тоо
26	Сүхбаатар	8678
25	Өмнөговь	5878
24	Улаанбаатар ХотНС	4203
23	Хэнтий	3386
22	Баянхонгор	1886
21	ХүТНС	1675
20	Дархан АТНС	1594
19	Дархан ХНО	1519
18	Дорнод	1048
17	Говь-Сүмбэр	820
16	Архангай	807
15	Завхан	511
14	Баян-Өлгий	451
13	Дорноговь	443
12	Хөвсгөл	401
11	Сэлэнгэ Мандал	374
10	Булган	362
9	МҮНС	328
8	Орхон	285
7	Сэлэнгэ	265
6	Увс	215
5	Төв	156
4	Ховд	135
3	Дундговь	121
2	Говь-Алтай	108
1	Өвөрхангай	32

9.Хүн амын хэдэн хувь нь байнгын уншигч

№	Номын сан	Хүн ам	Уншигч
26	Дорнод	47275	82028
25	Орхон	106411	61465
24	ХүТНС	1734848	32999
23	Улаанбаатар ХоТНС	1734848	25115
22	Хөвсгөл	46541	18880
21	Баян-Өлгий	45420	18801
20	МҮНС	1734848	12240
19	Увс	31727	9606
18	Говь-Алтай	18723	7765
17	Хэнтий	28148	6216
16	Дархан АТНС	89130	5456
15	Сэлэнгэ Мандал	26481	5001
14	Дархан ХНО	89130	4617
13	Өмнөговь	31205	4242
12	Сэлэнгэ	36399	3980
11	Дундговь	45900	3080
10	Завхан	16005	3014
9	Булган	15357	2995
8	Сүхбаатар	20999	2986
7	Архангай	20369	2840
6	Баянхонгор	32711	2645
5	Ховд	34173	2539
4	Төв	17152	2087
3	Дорноговь	46443	1150
2	Говь-Сүмбэр	10879	785
1	Өвөрхангай	36481	662

10 СОНА

№	Номын сан	Нийт
26	Улаанбаатар ХоТНС	1178
25	Дорноговь	443
24	Дархан АТНС	407
23	Сэлэнгэ	258
22	Хөвсгөл	248
21	Булган	177
20	Сэлэнгэ Мандал	168
19	Өмнөговь	162
18	Ховд	135
17	Баян-Өлгий	131
16	Хэнтий	127
15	Баянхонгор	113
14	Төв	110
13	Дархан ХНО	84
12	Орхон	84
11	Дорнод	83
10	Завхан	74
9	МҮНС	65
8	Архангай	61
7	Сүхбаатар	59
6	Дундговь	58
5	Говь-Сүмбэр	52
4	Увс	52
3	Говь-Алтай	48
2	Өвөрхангай	48
1	ХүТНС	43

11. Зөөврийн номын сан

№	Номын сан	Олгосон ном
26	Хөвсгөл	10524
25	Дархан АТНС	9455
24	ХүТНС	6340
23	Хэнтий	6270
22	Өмнөговь	4990
21	Баян-Өлгий	4949
20	Булган	4800
19	Дархан ХНО	4726
18	Сэлэнгэ	3456
17	Дорнод	3082
16	Увс	2182
15	Сүхбаатар	2163
14	Дорноговь	2132
13	Улаанбаатар ХоТНС	1912
12	Төв	1777
11	Орхон	1286
10	Ховд	1080
9	Архангай	891
8	Завхан	850
7	Дундговь	679
6	Баянхонгор	547
5	Сэлэнгэ Мандал	538
4	Өвөрхангай	478
3	МҮНС	463
2	Говь-Сүмбэр	368
1	Говь-Алтай	321

12. Номын санч сэтгүүлд өгүүлэл өгсөн байдал

№	Номын сан	Өгүүлэл өгсөн
1	Архангай	0
2	Баян-Өлгий	0
3	Баянхонгор	0
4	Булган	0
5	Говь-Алтай	0
6	Говь-Сүмбэр	0
7	Дархан АТНС	0
8	Дархан ХНО	0
9	Дорноговь	0
10	Дорнод	0
11	Дундговь	0
12	Завхан	0
13	МҮНС	0
14	Орхон	0
15	Өвөрхангай	0
16	Өмнөговь	0
17	Сүхбаатар	10
18	Сэлэнгэ	0
19	Сэлэнгэ Мандал	0
20	Төв	0
21	Увс	0
22	Улаанбаатар ХоТНС	0
23	Ховд	0
24	Хөвсгөл	0
25	ХүТНС	0
26	Хэнтий	0

Онооны зарчим:

Өгүүлэл өгсөн аймагт 10, өгөөгүй аймагт 0 оноо.

13. Тайлангаа цагтаа өгсөн байдал

№	Номын сан	Өгүүлэл өгсөн
1	Архангай	10
2	Баян-Өлгий	10
3	Баянхонгор	10
4	Булган	10
5	Говь-Алтай	5
6	Говь-Сүмбэр	10
7	Дархан АТНС	10
8	Дархан ХНО	10
9	Дорноговь	10
10	Дорнод	10
11	Дундговь	5
12	Завхан	10
13	МҮНС	10
14	Орхон	10
15	Өвөрхангай	10
16	Өмнөговь	10
17	Сүхбаатар	10
18	Сэлэнгэ	10
19	Сэлэнгэ Мандал	10
20	Төв	10
21	Увс	10
22	Улаанбаатар ХотНС	5
23	Ховд	10
24	Хөвсгөл	5
25	ХүТНС	10
26	Хэнтий	10

Онооны зарчим:

Цагтаа өгсөн аймагт 10, өгөөгүй аймагт 0 оноо.

14. Коһа нэвтрүүлэлт, манлайлал

№	Номын сан	Өгүүлэл өгсөн
1	Архангай	10
2	Баян-Өлгий	5
3	Баянхонгор	5
4	Булган	10
5	Говь-Алтай	8
6	Говь-Сүмбэр	5
7	Дархан АТНС	8
8	Дархан ХНО	8
9	Дорноговь	10
10	Дорнод	5
11	Дундговь	10
12	Завхан	8
13	МҮНС	10
14	Орхон	10
15	Өвөрхангай	5
16	Өмнөговь	10
17	Сүхбаатар	10
18	Сэлэнгэ	8
19	Сэлэнгэ Мандал	5
20	Төв	8
21	Увс	10
22	Улаанбаатар ХоТНС	10
23	Ховд	10
24	Хөвсгөл	8
25	ХүТНС	8
26	Хэнтий	10

Онооны зарчим:

Давтан сургалт авч идэвхтэй хандсан аймагт 10, идэвхтэй байгаа байгаа аймагт 8, эхний сургалтаас хойш холбогдоогүй аймагт 5 оноо.

15. Үндэсний тогтмол хэвлэлийн өгүүллэгийн санд мэдээ өгсөн байдал

№	Номын сан	Олгосон ном
10	МҮНС	3774
10	Дундговь	372
10	Хөвсгөл	292
10	Орхон	289
10	Сүхбаатар	187
10	Өмнөговь	164
10	Ховд	142
10	Өвөрхангай	122
10	Дархан АТНС	117
10	Дорнод	107
10	Баянхонгор	87
10	Хэнтий	68
10	Баян-Өлгий	28
10	Увс	13
0	ХүТНС	0
0	Булган	0
0	Дархан ХНО	0
0	Сэлэнгэ	0
0	Дорноговь	0
0	Улаанбаатар ХоТНС	0
0	Төв	0
0	Архангай	0
0	Завхан	0
0	Сэлэнгэ Мандал	0
0	Говь-Сүмбэр	0
0	Говь-Алтай	0

Онооны зарчим:

Мэдээлэл ирүүлсэн аймагт 10, ирүүлээгүй аймагт 0 оноо.

Дүгнэлт

Энэхүү тайлангийн эмхэтгэл 22 дахь жилдээ эмхэтгэгдэн уншигч таны гарт хүрч байна. Энэ хугацаанд номын сангуудын тайлангаас бусад номын сангийн үйл ажиллагааны талаар нүдээр үзээд харагддаггүй зүйлсийг харж, өөрийн үйл ажиллагаандаа дүгнэлт хийн, хэрэгжүүлэх, нэвтрүүлэх зүйлсийг олж авдаг гол хэрэгсэл болжээ.

Тийм ч учраас тайлангийн эмхэтгэлийг чамбай хийхийг бид гол зорилгоо болгон ажилладаг бөгөөд энэ зорилгын үүднээс 2021 онд *“Номын сангийн үйл ажиллагааны тайлан боловсруулах аргазүйн зөвлөмж”*-ийг улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа нийтийн номын сангуудын тайлан боловсруулалт, статистик дүн шинжилгээний чанарыг сайжруулахаар боловсруулан хүргүүлж, жил бүр түүнийг сануулж буй боловч аймаг, нийслэлийн номын сангууд уг зөвлөмжийн дагуу тайлан мэдээгээ ирүүлэхгүй байгаа нь тайланд дүн шинжилгээ хийх, нэгтгэхэд хүндрэл учруулж байгааг анхаарах хэрэгтэй байна.

Баримт бичигт дүн шинжилгээ хийж, үйл ажиллагаагаа төлөвлөх нь аливаа салбарын тулгуур, чухаг аргуудын нэг бөгөөд номын сангийн салбарынхан ч мөн адил энэ аргыг эрхэмлэсээр байгаа нь бусад салбар, дэлхий дахинтай хөл нийлүүлэн алхсаар буйн жишээ юм.

Мөн бичгийн тайлан болон статистик тайлангийн тоон мэдээнүүд зөрүүтэй байгаа нь тайлангийн боловсруулалт, үйл ажиллагааны үнэн бодит байдалд эргэлзэхэд хүргэж байна. Тиймээс тайлан бичих үүрэг бүхий албан хаагчдын хоорондын уялдааг хангаж, удирдлагууд уг тайланг хянаж илгээж байх нь салбарын болон улсын статистик мэдээнд үнэн бодит хувь нэмрийг оруулсан хэрэг болно.